

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
КҮНЗИЙН ИНСТИТУТ

ISSN: 2313-6170
Key title: Orçuulgazuj

ОРЧУУЛГАЗҮЙ IV

(Яруу найргийн орчуулга)

Эрхлэн нийтлүүлсэн: Г.Элдэв-Очир

Улаанбаатар хот
2015 он

DDC
418.02'015
O-497

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
КҮНЗИЙН ИНСТИТУТ

ОРЧУУЛГАЗҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ЦУВРАЛ
№04(422)

Ариутган хянах зөвлөл

Эрхлэгч:

Нарийн бичгийн дарга:

Гишүүд:

М.Чимэдцэеэ (доктор, дэд профессор)
Г.Элдэв-Очир (доктор, дэд профессор)
Э.Равдан (ШУ-ны доктор, профессор)
Го.Аким (доктор, профессор)
С.Эрдэнэмаам (доктор, профессор)
Л.Чулуунбаатар (доктор, профессор)
Г.Буяннэмэх (доктор, профессор)
О.Чинбаяр (МОЭ-ийн ерөнхийлөгч)
Ш.Эгшиг (доктор, дэд профессор)
К.Окада (Токиогийн ГСИС, доктор, профессор)
Б.Баярмэнд (ӨМИС-ийн МСС, доктор, профессор)
В.В.Мароши (Новосибирскийн УБИС, доктор, профессор)
Мари Доминик Эвен (ФҮШУСТөв, доктор, профессор)
Хоу Ваньжуан (Бээжингийн их сургуулийн
Монгол судлалын төвийн зөвлөх, профессор)

Санаачлагч:

Хянан засварласан:

Хуудасны хэмжээ:

Хэвлэлийн хуудас:

Хэвлэсэн тоо:

Хэвлэлийн газар:

МУИС, ШУС, ХУС, Орчуулгазүйн профессорын хамтлаг
Г.Элдэв-Очир
А4
23,26 хх
300ш
“Удам соёл” ХХК

ISBN 978-99973-7324-3

**NATIONAL UNIVERSITY OF MONGOLIA
INSTITUTE OF CONFUCIUS**

ISSN: 2313-6170
Key title: Orčuulgazuj

TRANSLATION STUDIES IV

(Translations of Poetries)

Compiled by: G.Eldev-Ochir

Ulaanbaatar
2015

**NATIONAL UNIVERSITY OF MONGOLIA
INSTITUTE OF CONFUCIUS**

TRANSLATION STUDIES

RESEARCH SERIES

№04(422)

Editor:

Chimedtseye.M (National University
of Mongolia, Mongolia)

Secretary:

Eldev-Ochir.G (National University
of Mongolia, Mongolia)

Editorial Boards:

Ravdan.E (National University of Mongolia,
Mongolia)

Akim.G (Ph.D, Professor, Mongolia)

Erdenemaam.S (Mongolian State University of
Education, Mongolia)

Chuluunbaatar.L (National University of Mongolia,
Mongolia)

Buyannemekh.G (National University of Mongolia,
Mongolia)

Chinbayar.O (President of the Mongolian Translators
Union, Mongolia)

Egshig.Sh (National University of Mongolia,
Mongolia)

Okada.K (Tokyo University of Foreign Studies,
Japan)

Bayarmend.B (Inner Mongolia University,
P.R.China)

Maroshi.V.V (Novosibirsk State Pedagogical
University, Russia)

Marie-Dominique Even (French National Center for
Scientific Research, France)

Hou Wanzhuang (Center of Mongolian studies of
Peking University, P.R.China)

Founder:

Professors Team for Translation Studies, Division of
Humanities, School of Arts and Science, National
University of Mongolia

Edited by:

Eldev-Ochir.G

Graphic designer:

Paper size:

A4

Number of pages:

Number of prints:

Press:

ГАРЧИГ

Өмнөтгөл үг

ОРЧУУЛГАЗҮЙ

Ш.Эгшиг	Хятадын эртний яруу найраг орчуулах нь	7
Ц.Магсар	Яруу найргийн орчуулгын уран чанарын тухайд	19
Ц.Дэлгэрэхцэцэг, Н.Билэг	“Ваби”, “Саби” нь япончуудын гоо сайхныг үзэх үзлийн илрэл болох нь-Хайкү шүлгийн жишээгээр-	27
Д.Цэдэнжав	Монгол ардын дууг орос хэл рүү орчуулах асуудалд	54
Л.Чулуунбаатар	Алтайн хэл шинжлэлийн нэрт эрдэмтэн Густав Жон Рамстедт	58
Ж.Нэргүй	Сергей Есенинийг би хэрхэн орчуулав	63
Т.Болдбаатар	Монгол дахь хаикү шүлгийн орчуулга ба монгол хаикү	73
Н.Мөнх	МНТ-ы ан амьтан, жигүүртэн шувууны нэр бүхий хүний нэрийн франц орчуулга	85
Н.Гэрэлмаа, Фатма Албаярак	“Монголын нууц товчоон” дахь нэгэн шүлгийн түрк орчуулгын тухай	97
Б.Аззаяа	Монгол хэлнээ орчуулагдсан түркийн уран зохиолын тухай	105

ОРЧУУЛГЫН ШҮҮМЖ СУДЛАЛ

Г.Аким	“Алтан бөлзөг зүүсэн арван мойног хуруу”-ны паян	110
Г.Буяннэмэх	<<Ролан(д)ы(н) дуулал>>-ын монгол орчуулгын тухайд	120
Д.Бүрнээ	Зохист аялгууны онол ба монгол орчуулга	130
А.Цэрэнчулуун	Хайнрих Хайнегийн Лорелай шүлгийг монгол хэлнээ орчуулсан нь	138
Н.Оюун-Ундраа, Н.Оюунзаяа	Б.Явуухулангийн “Туулын шугуй” шүлгийн англи болон орос орчуулгын утга дүйлгэц	148
М.Амартайван	Нэгэн шүлгийн дөрвөн орчуулгыг шүүн тунгаахад	159

ОРЧУУЛГАЗҮЙН САН ХӨМРӨГӨӨС

Б.Ринчен	Энэтхэг яруу найргийн амт үнэрийг үлдээхсэн гэж...	170
Э.Равдан	Стилистика и ее отношение к переводу	177

CONTENTS

Preface

TRANSLATION STUDIES



Egshig.Sh	Translation features of Chinese classical poetry	7
Magsar.Ts	About artistic value of poetry translation	19
Delgerekhtsetseg.Ts, Bileg.N	In Search of “Wabi”, “Sabi” : The Japanese Aesthetics in Haiku Poetry	27
Tsedenjav.D	Translation of Mongolian folk songs in Russian	54
Chuluunbaatar.L	Gustav John Ramstedt, the well-known scholar of Altai linguistics	58
Nergui.J	How I translated Sergei Esenin	63
Boldbaatar.T	Translation of Haiku in Mongolia and Mongolian Haiku	73
Munkh.N	French Translation of Anthroponyms of the Secret History of Mongols containing the names of animals and birds	85
Gerelmaa.N, Fatma Albayrak	Turkish translation of the poems in the “Secret History of Mongols”	97
Azzaya.B	Translation of Turkish literature works in Mongolian	105

TRANSLATION CRITICISM



Akim.G	A story of “Ten crooked fingers with gold rings”	110
Buyannemekh.G	Mongolian translation of Roland Anthem	120
Burnee.D	Kavyadarsha and Mongolian translation	130
Tserenchuluun.A	Translation of German writer Heinrich Heine’s Lorelei verse in Mongolian	138
Oyun-Undraa.N, Oyunzaya.N	Equivalence in Translation of English and Russian versions of “The Grove of the Tuul” poem by Yavuukhulan.B	148
Amartaivan.M	Analysis of four translations in Mongolian of poem “Azaleas” by Kim Sowol	159

FROM THE TREASURE OF TRANSLATION STUDIES

Rinchen.B	To leave the taste and smell of Indian poems...	170
Ravdan.E	Стилистика и ее отношение к переводу	177



ОРЧУУЛГА ЗҮЙ



ХЯТАДЫН ЭРТНИЙ ЯРУУ НАЙРАГ ОРЧУУЛАХ НЬ

Ш.Эгшиг¹ (МУИС, ШУС)

Товч утга: Хятадын эртний яруу найргаас орчуулах нь эртний соёлт Хятад орны яруу найргийн гайхамшигаас монгол түмэндээ танилцуулах нэгэн гүүр болох юм. Энэ өгүүлэлд хятадын эртний яруу найрагт хэдий үеийн шүлэг зохиолууд багтах, хятад яруу найргийн онцлог, чухам хэдий үед хятадын шүлэглэлзүйн зарчим-дүрэм нь бүрэлдэн тогтсон хийгээд хятад шүлгийг монгол хэлнээ орчуулан буулгахад хятад шүлгийн тогтсон зарчим ба онцлогийг монгол шүлгийн онцлогт тааруулан яруу нийлэмжтэйгээр, хэлбэрийг хадгалж, утгыг алдагдуулахгүйгээр хэрхэн зохистойгоор буулгах, орчуулагч нь өөрөө эх хэлээрээ шүлэг зохиодог байх, орчуулах шүлгийн талаар сайтар судлах, тайлбар зүүлт хийх нь зүйтэй болох талаарх саналаа дэвшүүлэв.

Түлхүүр үг: сонгодог яруу найраг, шүлгийн цохилго, шүлгийн хэмнэл, шад, бадаг, шүлэглэлт ном, ордны дуулал, зохист аялгуу

Хятадын эртний яруу найраг их алдартай хэмээн хүмүүс хэлцдэг ч чухам ямарын учир хятад хийгээд дэлхий дахинаа тийм их үнэлэгддэг болохыг сайн мэдэхгүй ч байж болох юм. Хятад хэл бага сага сурсан бид мэтийн хүн хааяа бас судалгаа хийх, өгүүллэг бичих гээд эрхгүй ямар нэгэн шүлэг яруу найраг орчуулах хэрэг гардаг юм. Тэгээд л шүлгээ үзээд, ойлгож ухаарч дийлэхгүй бол тухайн шүлгийн орчин цагийн хятад хэлээр хийсэн хадмал тайлбар сэлт үзээд л, тийм юмгүй бол хуучин шинэ олон толиос шүүрдэж байгаад л нэг иймэрхүү утгатай бололтой гээд хэдэн үг холбож, бас болоогүй шүлгийн хэв загварт оруулаад биччихсэн тохиолдол бий. Тэгж хийсэн “орчуулга” маань хожим үзэхэд утга агуулгын хувьд санаа нь илэрсэн хэдий ч, жинхэнэ яруу найраг биш байдаг. Үүний учир бол орчуулагч нь яруу найрагч биш, бас шүлэгзүйн дулимаг мэдлэгтэйн улмаас юм. Чингэхээр хятадын эртний сонгодог яруу найргийн уламжлал, онцлогоос энд товч дурдсу.

Хятадын эртний шүлэг яруу найраг “Шүлэглэлт ном”-оос эхэлнэ. Энэ бол эртний шүлгийн цоморлиг бөгөөд баруун Жоу (西周 НОТӨ1044-771 он) улс хийгээд Хавар намрын (春秋时期, НОТӨ 770-476 он) улсын дуу шүлгийг хамарна. Байлдаант (战国, НОТӨ 475-221 он) улсын үед өмнө зүгийн Чу улсын “Чу улсын уянга”, Хань (汉朝, НОТӨ202—НОТӨ220 он) улсын үед эмхэтгэсэн “Ордны дуулал” нь түрүү үеийн шүлэг дуулалд

¹ МУИС, ШУС, ХУС-ын ази судлалын тэнхимийн багш, доктор, дэд профессор

хамаарна. Тан (唐朝 618—907) улсын үеэс яруу найргийн өөр нэгэн хөгжлийн үе эхэлсэн ба “Ордны дуулал”-д суурилсан дөрвөн шадат тасархай бадаг (绝句), найман шадат хэмжээт шүлэг (律诗) зонхилж ирсэн юм. Хэмжээт шүлэг нь төвшит аялгуугаар (平声) холбоц хийн, өгүүлбэр тус бүрийн төвшитгөсөн аялгуу (平仄) ба эн зэрэгцүүлэл (对仗) нь ая данг тохируулах тодорхой журмын дагуу зохиогдоно. Сүн (宋朝 960—1279) улсын үед оргилдоо хүрсэн Сүн улсын дуулал (宋词) яруу найргийн бас нэгэн чухал хэлбэршил бөгөөд дууллын тогтсон хөг эгшгийн нэрийдлээр (词牌) дамжуулан ая тааруулан зохиож, дуулж хуурдах боломжтой болдог байв. Хятадын эртний шүлэг яруу найргийн хөгжлийн хамгийн сүүлийн үе бол Юань улсын дуурилаг (元曲) юм. Энэ найргийн төрөл уламжлалт хөг эгшиглэнт холбоцыг мөнөөхөн хэрэглэсээр байсан боловч Юань улсын үед дэлгэрсэн ший жүжгийн нөлөөгөөр аажимдаа нөлөө нь буурч, цаашид дахин өмнөх шигээ хөгжих явцгүй болсон гэж үздэг билээ. Эртний яруу найргийн бүхий л үед шүлгийг тодорхой дүрмээр зохиролтой зохиох, ая дант холбоцоор холбох тухай тэмдэглэсэн байдаг. Энэ бол хятад хэлний түүхэн онцлогтой холбоотой асуудал юм.


Хятад хэлний анхны үгийн утга тайлсан толь бол “Эряа” (尔雅) бөгөөд Хань улсын түүхэнд орсон күнзийн суртлын сонгодог зохиолуудын нэг юм. Хожим Тан улсын үед түшмэл сонгох шалгаруулалтад эртний бичгийн шалгалтын гол ном болсон байдаг. Энэ толь хожмын хятад үгийг авиан судлалын үүднээс тайлбарлах тользүйн гол үндэс суурь нь болсон юм.




Хятадын анхны толь бичиг “Эряа” (尔雅)

Үүнээс даруй хэдэн зууны хойно “Нийлэмжит яруу авиа” (切韵) (мөн ‘Найралт холбоц’, ‘Яруу эгшиглэл’ хэмээн орчуулж болохоор) хэмээх нэгэн зүйл үеийн дуудлагын толь бичиг Суй улсын тогтнож байсан 601 онд гарсан аж. Нийт 11500 ханз үсэг орсон, 193 авиа холбоцыг 4 хөгөөр ялган хувааж, ханз үсгийн дуудлагыг тэмдэглэсэн байдаг. 1008 онд энэ толь бичгийн ханзыг

нэмэгдүүлэн, “Дэлгэрүүлсэн яруу авиа” (广韵) нэрт 26194 ханз багтаасан толь, 1037 онд 53525 үсэг цуглуулж хийсэн “Яруу авиан чуулган” (集韵) гарсан нь бүгд анхны “Нийлэмжит яруу авиа”-ны тольтой ижил зарчмаар буюу огцом огших (反切) авианы хоёр нийлэмжээр ханз үсгийн авиан дуудлагыг тэмдэглэсэн ханзаар авиа галиглах аргаар бүтээгдсэн толь бичгүүд байв. “Нийлэмжит яруу авиа” –нд анхлан хятад хэлний авиаг ханз үсгээр галиглах аргыг нээсэн явдал бол хятад хэлний түүхэнд эргэлтийн шинжтэй үйл явдал болсон гэж үздэг юм. Учир нь ханз үсэг бол дүрс үсэг тул түүнийг хараад хэрхэн дуудагдах талаар тогтоосон дүрэмгүй үед хэрвээ мэдэхгүй ханз үсэг тохиолдвол, хэрхэн дуудахаа мэдэхгүйд хүрнэ. Харин бичиг үсэг нь авиан тогтолцоотой бусад хэлэнд хүн хэдийгээр үгийн утгыг нь мэдэхгүй ч байсан ядахнаа тухайн үгийг дуудаж уншиж болно доо. Чингэхээр ханз үсгийг дуудах аргыг нээсэн явдал бол өнөөгийн бидний хэлж заншиж байгаа “инновац” хэмээх ‘шинэлэг төгөлдөршил’ шиг хэмжээний их үйл явдал байжээ. Үүнийг хамгийн энгийнээр тайлбарлавал, 東 хэмээх ханзны дуудлагыг хүн бүрийн мэдэх 德 ба 紅 гэсэн хоёр ханзны дуудлагаар тэмдэглэхэд уг 東 ханзыг дуудах гэж буй хүн 德 буюу эхний ханзнаас (d-e) тухайн ханзны үе эхлэх (d) эхний авиаг, хоёр дах ханзны (h-ong) үеийн төгсгөл болох (-ong) сүүлийн авиаг тус тус салгаж аваад (d-ong) гэж нийлүүлж дуудахад, мэдэх гэж буй ханзны үеийн дуудлага үүсэн дуудагдах юм. Үе бүтээх эхний ба сүүлийн авиаг ‘огцом огших’ (反切) хэмээх үе бүтээх авиа гэж нэрийдсэн байдаг.



“Нийлэмжит яруу авиа” (切韵)



Яруу авиан холбоцын хүснэгт

Дээр өгүүлсэн толь болон авиан холбоцын хүснэгтэнд суурилсан авиа эгшгийн тэгшит ба ташуу аялгуу (хувирах аялгуу)-ны тухай ойлголт нь ханз үсгийн буюу үеийн хөг айзмын тухай ойлголтоор баяжиж, энэ нь шүлгийн бүтэцтэй зохих шижмээр холбогддог юм. Шүлэгт буй тэгшит ба ташуу (平仄 авианы нэгэн хэвийн үргэлжлэх аялгуу-тэгшит аялгуу ба авианы өөрчлөлттэй аялгуу- ташуу аялгуу) аялгууны найрал нь тодорхой хэмнэл цохилгыг бий

болгож байдаг. Энэ нь шүлгийн хэмнэл болно. Эртний хятад хэлний 4 янзын хөгжмнэл нь хэлний авианы өндөр нам, өгсөх уруудах, урт богиныг заадаг. Тэгшит аялгуу нь нэгэн хэвийн тэгш өөрчлөлтгүй, ташуу нь нугарч солигдсон өөрчлөлттэй авиан аялгуу юм. Өгсөх, буурах, хураамжит аялгуу бол ташуу аялга, харин ямар ч өөрчлөлтгүй нэгэн хэвийн нь тэгшит аялгуу болно. Энэ дөрвөн янзын авианы байдлаас дөрвөн хөгийг ялган таньж байгаа хэрэг юм. Ханз үсгийг нэгхэн үе бүрдүүлдэг, чингэхээр тэрхүү нэг үеийг нэг эсвэл хоёр нийлэмж холбоц бүрдүүлнэ. Чухамхүү тэр нь эгшиг гийгүүлэгчийн бүрдэл бөгөөд дундад эртний хятад хэлэнд гийгүүлэгч ба эгшгийн хүснэгтийг дээр өгүүлсэн авиа тэмдэглэсэн толиос уламжлан зохиосон байдаг. Авиаг тийм эрт цагт одоогийн шинжлэх ухааны үндэстэй ялгасан байдаг нь тун гайхамшигтай. Үеийн дуудлага эхлэх 36 гийгүүлэгчийн хүснэгт, мөн үеийн төгсгөл 43 эгшгийн хүснэгтийг зохион бий болгожээ. Энд жишээ болгон, зөвхөн гийгүүлэгч авианы хүснэгтийг анхны хятад эх ба англичилсан байдлаар дор орууллаа.

[illegible]

36 гийгүүлэгч авиан хүснэгт

The 36 initials, with LMC values^[27]

		Tenuis 清	Aspirate 次清	Voiced 濁	Sonorant 清濁	Tenuis 清	Voiced 濁
Labials 唇	重唇音 "heavy lip"	幫 p-	滂 p ^h -	並 ph-	明 m-		
	輕唇音 "light lip" ^[g]	非 f-	敷 f ^[h] -	奉 fh-	微 u ^[i]		
Coronals 舌	舌頭音 "tongue-head"	端 t-	透 t ^h -	定 th-	泥 n-		
	舌上音 "tongue up"	知 tr-	徹 tr ^h -	澄 trh-	娘 nr ^[g]		
Sibilants 齒	齒頭音 "tooth-head"	精 ts-	清 ts ^h -	從 tsh-		心 s-	邪 sh-
	正齒音 "true front-tooth" ^[i]	照 tʃ-	穿 tʃ ^h -	牀 (t)ʃh ^[k]		審 ʃ-	禪 ʃh-
Velars 牙	牙音 "back-tooth"	見 k-	溪 k ^h -	群 kh-	疑 ŋ-		
Gutturals 喉	喉音 "throat"	影 ʔ-			喻 h-	曉 x-	匣 xh-
Lateral	半舌音 "half tongue"				來 l-		
	半齒音 "half front-tooth"				日 r ^[i]		

36 гийгүүлэгч авиан хүснэгт (англичилсан байдал)

Ингээд шүлэг зохиох хүн “Нийлэмжит яруу авиа”-ны толиос (найралт холбоцын) үеийн хоорондоо зохиролтой нийлэмжит яруу авиа дуудлагыг, өөрөөр хэлбэл, ханз үсгийг шүлэг тэрлэх тодорхой дүрмийн дагуу үгийн утгыг бодолцон байж шүлэг зохиодог байжээ. Шүлэг тэрлэх дүрэм нь тухайлбал, тэгшит ба ташуу аялгууны нийцлээс ургуулан гаргасан дүрэм байдаг. Тухайлбал, таван үгийн хэмжээт шүлгийн эхний шадын эхний хоёр ханз үсэг нь тэгшит байвал тэгш, харин эхний хоёр ханз үсэг нь ташуу байвал ташуу таван үгийн хэмжээт шүлэг гэнэ. Долоон үгийн үет шүлгийн эхний шадын хоёр дахь үсэг нь заавал тэгшит байж байж, тэгшит эхлэлтэй болно. Мөн үүнтэй адил ташуу эхлэлт долоон үгийн үет шүлгийн эхний шадын хоёр дахь үг нь заавал ташуу аялгуут ханз байх ёстой гэх мэтээр цаашид бусад шадуудын нийлэмж зохиролтой ба зохиролгүйг жагсаан заасан байдаг. Тэгэхээр шүлэгч хүн зайлшгүй тэдгээр зохицлынх нь дагуу л ханз үсгийн авианы дуудлагыг шинжих хэрэгтэй болдог байна.

“Хос уянга” (对联) хэмээх хятадын бэлгэдлийн соёлыг мянган жил тээсэн шүлгийн хэлбэр бас бий. Энэ нь хоёр мөрт шүлэг бөгөөд дээд доод мөрийн харгалзах үе нь ямагт нэг төрлийн үгээс бүтнэ. Жишээ нь, нэр үг бол нөгөө мөрийн харгалзах үг нь нэр үг, үйл үг бол үйл үг, тэмдэг нэр бол тэмдэг нэр байх ёстой, шүлэглэлийн үүднээс хос уянгын дээд мөрний сүүлийн үг ташуу аялгаар, сүүлийн шадын сүүлийн үг нь тэгш байх ёстой гэсэн дүрэмтэй. Хос уянгыг баяр ёслол, тэмдэглэлт үйл явдлын үед хэрэглэхдээ голдуу хаалга, гэгээвч, дэлгэцийн хоёр талаар босоогоор нь байрлуулахдаа баруун талд эхний мөрийн үг, зүүн талд сүүлийн мөрийн үгсийг байрлуулдаг.

Хятадын сонгодог бүтээлүүд угтаа мөнөөх л шүлэглэлзүйн тогтсон дүрмийг ягштал баримталсан байдаг ба тэрхүү сор болсон бүтээлүүдээс монгол хэлнээ манай нэрт гүүш нар хөрвүүлэн буулгахдаа мөнөөх уран яруу, найралт шинжийг нь бас буулгах тал дээр ихээхэн анхаарч иржээ.

“МУИС-ийн профессор багш, нэрт манжич Шаарийбуу багш маань нангиадын яруу найргийн шижир тунгаамал болсон "Шүлэглэлт ном" хэмээх сонгодог их цомгийг манж, хятад, япон хэлнээс тулган орчуулж дуусгажээ.”² Үүнийг хийхэд арав гаруй жилийн хүч хөдөлмөрөө зориулсан тухай шавь Баярсайхан нь бичиж үлдээсэн юм.

Ц.Базаррагчаа багштан бээр хятадын орчин үеийн яруу найргаас орчуулахын зэрэгцээ мөн хятадын эртний найргаас сорчлон дуун хөрвүүлсэн билээ. “Шүлэглэлт ном” 1999 он, Чүй Юанийн “Самуурлаас салан одохуй” найраглалыг 2012 онд орчуулсан нь 2014 онд хэвлэгджээ. Яруу найргийн орчуулга хийхээс гадна орчуулгын судалгаанд нэлээд их анхаарч, ялангуяа Б.Явуухулангийн “Ли Бай” –н шүлгийн орчуулгын номд шүүмж дүгнэлт хийсэн, “түүний орчуулгын зохиолууд нь дорнын бичлэгийн аястай үгийн утгын харьцааг нээн илэрхийлэн, зохиолч яруу найрагчийн хувиар уран яруу дүрслэлт мэтгэлгээгээр шигтгэж урладаг онцлогтой. Үг хэллэгийн хувьд уламжлалт “мой, муй, мүй” гэсэн нөхцлүүдээр шадын сүүлийг төгсгөсөн болон монгол хятад шүлэглэх горимыг чанд баримталж, бичлэг туурвилзүйн онцлогийг анхааран “амой” зэрэг үгсээр уран сайхнаар цохилго, хөг аялгыг голлож уламжлалыг шүтэн дуун хөрвүүлж бүтээдэг нь ажиглагдаж байна.”³ гэж “ХХ зууны монгол зохиолчид” цувралын 37-д Д.Цэвээндорж Ц.Базаррагчаагийн яруу найргийн орчуулгын онцлогийнх нь талаар цохон дурдсан байна.

М.Чимэдцээ багштан хятадын уран зохиолын орчуулгын судалгааг дорвитой хийж, Хятадын сонгодог уран зохиолын дээж цувралаар Күнзийн “Шүүмжлэл өгүүлэл”, “Их суртахуй”, “Сүнзийн дайтахуйн ухаан” зохиолуудыг орчуулан, хэвлүүлэн гаргасан билээ. Эдгээр зохиолууд нь мөнөөх хятад сонгодог бичгийн хэлний найралт холбоц, нийлэмжит авианы зарчмыг тусгасан байдаг хийгээд орчуулгад нь энэхүү уран яруулаг байдлыг хадгалж, эх хэлнээ яруу тансаг орчуулсан байдаг юм.

Мөн доктор, профессор Д.Болдбаатар бол хятадаас монгол хэлэнд орчуулагчдын сүүлийн үеийн нэртэй зүтгэлтэн гэж үзэхээс аргагүй юм. Тэрээр орчин үеийн тользүйн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулж буй төдийгүй “Журамт бүсгүй Лү Би Лянь”, “Мөрөн голын шулам хүүхэн”, “Чонон сүлд”, “Турван улсын үлгэр” хэмээх роман, үргэлжилсэн үгийн зохиол, Монголын Радиоогийн нэвтрүүлэгт орсон “Дү Фүгийн шүлгүүд” “Сун улсын яруу найрагч Жоу Бан Яны бүтээлүүд” зэрэг орчуулгын найрууллууд бэлтгэсэн байдаг юм. Түүний киноны орчуулгад гарах хятадын эртний яруу найргийн орчуулга нь ихээхэн уянгалаг чихэнд чимэгтэй болох нь кино үзэж буй хүнд өөрийн эрхгүй мэдэгддэг. Учир нь шүлэг яруу найргийн тансаг уянгалаг, хөгжимлөг болохыг зүгээр нүд гүйлгэн унших бус, харин тод чанга унших эсвэл сонссоноор илүү мэдрэгддэг талтай тул үүнийг эртний үйл явдалт, түүхэн кино, жүжиг зэргээс сонсож яруу тансгийг нь шагших боломжтой юм. Чухам ийм орчуулгыг өнөө

² М.Баярсайхан, “Зуу дахь хавраа угтаж буй МУИС-ийн хүндэт профессор”, “Өдрийн сонин”- ы 2009.01.16. №011-д http://smic.num.edu.mn/index.php?option=com_content&view=article&id=355

³ Цэвээндорж Д, “ХХ зууны Монгол зохиолчид” цуврал-37 Цэвээндоржийн Базаррагчаа /Намтар уран бүтээл, судлал шүүмж, орчуулга / Улаанбаатар, 2003, 58-р тал.

цагт “зөвхөн” Д.Болдбаатарын орчуулгын киноны дуу авианаас сонсон таашааж болно.

Я.Ганбаатар багштаны түүх, уран зохиол, яруу нийтлэлийн бүтээлийн цуваа тасардаггүй бөгөөд түүний орчуулгын бүтээлүүдэд хятадын богино өгүүллэг ба сонгодог яруу найргийн орчуулга давамгайлдаг. Зүгээр нэг орчуулаад өнгөрөхөөс илүүтэй, тухайн орчуулгыг хятад шүлэг, яруу найргийн онцлог болох “гурван мэдрэхүйн хүртээмж”-ит чанарыг (унших, сонсох, харах гурван мэдрэмжийг хятад хэлний онцлог болох үсэг бичигтэй нь холбон тайлбарладаг.) нь монгол хэлнээ буулгах хэрийн хүн барьж аваад хийчихгүй тэрхүү яруу найргийн орчуулгаа бусад хэлний орчуулгатай нь хадаж хэвлүүлсэн “Нангиадын сонгодог яруу найраг” хэмээх бүтээл нь судлаач, суралцагсдад тун их тустай бүтээл болсон юм. Хятадын яруу найргаас орчуулсан дуун хөрвүүлэгч Б.Явуухулан, Ч.Чимэд, Ц.Сүрэнжав, Г.Мэнд-Ооёо гээд олон хүний тухай болон өвөрлөгч нарын яруу найргийн орчуулгын талаар энд ярьж болох ч энэ нь орчуулгын тойм, шүүмж төдий болох тул гол сэдэв рүүгээ эргэн орё.

Хятадын эртний шүлгийн онцлогийг ярихад шүлгийн айзамзүй, бадаглалзүй, эгшиглэлзүйн⁴ талаас нь тухайн үндэстний шүлгийн ерөнхий нийтлэг чанарыг тогтоож болох юм. Монгол шүлэг нь дөрвөн шадат бадаглал голлосон, гурав ба хоёр шадат бадаглал удаалсан ба өргөлтөт шүлэг мөн тул тооны ч, чанарын ч аль алины шинжийг хадгалсан шүлэгтэй хэмээн эрдэмтдийн дийлэнх нь үздэг.

Гадаад хэлээс шүлэг орчуулахад монгол хэлний яруу тансаг байдал хийгээд хэлний бүтэц нь ямар ч саад бэрхшээлгүй, гагцхүү орчуулагчийн авьяас билэг хийгээд боловсрол мэдлэг л мэдэх хэрэг гэдгийг Б.Ринчен доктор нэгэнтээ өгүүлэл⁵-дээ дурдсан билээ. Дорнын их яруу найрагч Б.Явуухулан бээр орчуулгын шүлэг бол “эргүүлж дэвссэн хивс”, “шилэн бүрхүүл дор орсон анхилуун цэцэг”, “өнгө нь онгосон дорно дахины торго”⁶ хэмээгддэг гэж яруу найраг орчуулах нь ямархуу амаргүй ажил болохыг зүйрлэн хэлдгийг яруу найргийн судалгааны бүтээлдээ оруулсан нь санамсаргүй хэрэг биш юм. Тэрбээр мөн яруу найргийн орчуулгад эрхэмлэвэл зохих дөрвөн зүйл⁷ буй нь,

1. Санааг тод буулгах;
2. Дүр, зураглалын өвөрмөц нарийнийг хадгалах;
3. Шүлгийн өнгө аяс, хөгжмийг хадгалах;
4. Шүлгийн хэлбэрийг хадгалах хэрэгтэй гэсэн юм.

Яруу найргийн эх хэлэн дэх шад ба бадгийн бүтэц, шадан дахь үеийн тоо, өргөлт, нугалбар зэргийг мөнхүү монгол хэлнээ буулгахдаа аль болохоор

⁴ С.Дулам, Ц.Хасбаатар, Шүлэг судлал, Уран зохиолын онолын үүд, УБ, 169-191 тал.

⁵ Б.Ринчен, Шүлэг орчуулах эрдэм, “Орчуулгазүй” Эрдэм шигжилгээний цуврал, №3, УБ, 2014, 151-156 тал

⁶ Б.Явуухулан, IV Яруу найргийн орчуулгын асуудалд, “Яруу найраг Миний амьдрал” Улаанбаатар, 1983, 149-р тал.

⁷ Б.Явуухулан, IV Яруу найргийн орчуулгын асуудалд, “Яруу найраг Миний амьдрал” Улаанбаатар, 1983, 151-р тал.

хадгалахыг эрмэлзэж эх шүлгийн бүтцийг хадгалах нь уншигч судлагч түмэн олноо хүндэтгэсэн төдийгүй шүлгийн эхийн анхны байдлыг мэдрэхэд нь тустай болно. Б.Ринчен докторын бас нэгэн санал⁸ бол өргөлттөт үеийг урт эгшгээр, өргөлтгүй үеийг ерийн эгшигт үеэр орчуулбал монгол хэлнээ буулгах бас нэгэн арга хэмээн үзсэн байдаг.

Өвөрмонголын эрдэмтэн Ш.Мэргэний зэрэг хамгаалсан зохиол⁹ -д В.Инжиннашийн “Хөх судар”-аас “... үзтэл иргэн үгс сүүл даран хэлж, монгол үг толгой холбон өгүүлэх, төвд үг түргэн дөтийг эрхэлж, манж үсэг тус тааруулан зохиожухуй” гэсэн хэсгийг эш татжээ. Ш.Мэргэний судалгаа бол хятадын эртний шүлгийн нэгээхэн цогц шинжтэй орчуулгын судалгаа бөгөөд энэ судалгаанд монгол хүн хятад хэлээр зохиосон шүлгийг сонгон авч судлахдаа хятад шүлгийн ерөнхий зарчим, онцлогуудыг мөн шингээсэн тул сэдэвт маань бас авцалдана. Эртний монгол өвөг дээдэс маань гадны хэлийг шүлэг зохиох хэмжээнд хүртэл эзэмшээд, бүр хятадын яруу найраг бичих уламжлалт хэв зарчмаар өчүүхэн ч торолгүй хүний сэтгэлийн нарийн нандин чавхдасыг дуугаргах бүтээл хийж байсан байна. Ийм сайхан эхийг аялгуу сайхан монгол хэлнээ мөн л тэр сэтгэлийн доторхи чавхдасыг хөндөхөөр орчуулчихвал сайхансан.

Юань улсын Баян жанжины “Зарлигаар мөрний өмнөдийг хураамжилсан нь” шүлгийг жишээ болгон авч харъя. Шүлгийг Б.Буян орчуулж, “Юань улсын үеийн монголчуудын хятадаар бичсэн шүлгийн сонгомол”¹⁰ номд оруулжээ.

奉使收江南

feng shi shou jiang nan

Зарлигаар мөрний өмнөдийг хураамжилсан нь

伯颜

bo yan

Баян жанжин

剑指青山 / 山欲裂,

jian zhi qing shan / shan yu lie

Хөхөмдөг уулыг сэлмээр заахуйя / уул хагармаар болжээ.

马饮长江 / 江欲竭

ma yin chang jiang / jiang yu jie

Хөх мөрнөө хүлгээ услахуйя / мөрөн ширгэхүйд хүрчээ

精兵 / 百万 / / 下江南

jing bing / bai wan // xia jiang nan

Зуун түмэн / шилдэг цэрэг // мөрний өмнөдөд буухуйя

干戈 / 不染 / / 生灵血

⁸ Б.Ринчен, Шүлэг орчуулах эрдэм, “Орчуулгазүй” Эрдэм шигжилгээний цуврал, №3, УБ, 2014, 155 тал

⁹ Шагдарсэрэнгийн Мэргэн “Их Юан гүрний үед хятад хэлээр зохиол бичиж байсан монгол яруу найрагчдын бүтээлийн хятад эх ба монгол орчуулгыг харьцуулан судлах нь”, МУИС, МХСС, УБ, Битпресс ХХК, 2009, 86 тал.

¹⁰ Buyan B. Yuwan ulus-un üy-e-yin mongyolcud-un kitad-iyar bičigsen silüg-ün songyumul. Öbür mongyol-un baγačud keüked-ün keblel-ün qoriy-a, Tüngliyo, 1994, 5-г tal-a дам эшилсэн: Шагдарсэрэнгийн Мэргэн “Их Юан гүрний үед хятад хэлээр зохиол бичиж байсан монгол яруу найрагчдын бүтээлийн хятад эх ба монгол орчуулгыг харьцуулан судлах нь”, МУИС, МХСС, УБ, Битпресс ХХК, 2009, 85-86 тал.

gan ge / bu ran // sheng lin xue

Жадны үзүүр / зэвсгийн дээр // амьд цус бялтсангүй.

Энэ шүлэг нь 7 үет 4 шадат шүлэг байна. Шүлгийн нэг, хоёр, дөрөвдүгээр шадын төгсгөлд сүүл холбожээ. Нэг ба хоёрдугаар шад нь дундаа болон сүүл холбосон бөгөөд дундах холбоц нь нэг үгийг давтан давтан (нэгдүгээр шадад 山山, хоёрдугаар шадад 江江 гэж үг давтсан бөгөөд эдгээр нь дундаа нугалбараар зааглагдсан байна.) оруулсан нь маш уран бөгөөд сонсголонтой болгосон, эхний хоёр шад ба сүүлийн хоёр шад нь хоор хоорондоо ижил нугалбартай, тиймээс шүлгийг уянгалуулан уншихад чихэнд чимэгтэй, хэлэхэд бас усны урсгал мэт амар. Шүлгийг эрдэмтэн Буян орчуулсныг үзвэл эхний хоёр, сүүлийн хоёр шадыг тус тус толгой холбосон ба ижил нугалбараар хувааж орчуулсан байна. Эхний хоёр шад мөн дундын холбоцтой байгаа ба шадын үгийн тоо бүгд долоо долоо байгаа нь орчуулагчийн чадвартайг үзүүлж байгаа хэрэг. Үеийн тоог тааруулах эсэх дээр хэрхэн хийсэн нь шүлгийн орчуулгын бас нэг үзүүлэлт болно. Шинэ үсгээр байгаа энэ орчуулгын эх бус, монгол бичгээрх эхийг нягтлах нь илүү зохимжтой. Өөрөөр хэлбэл, Б.Ринчений эхийн байдлыг алдагдуулахгүй байх гэснийг хэрхэн хийснийг монгол бичгээр хийсэн орчуулгаас нь нягтална хэмээсэн хэрэг юм. Энэ шүлгийн орчуулгын шад доторхи үеийн тоо жигд бус байв. Монгол шүлэг үет шүлэг гэгддэг боловч европын хэлүүдээс орчуулж ирсэн ная гаруй жилийн дотор европ шүлгийн хэмжээг тэр хэвээр нь буулган орчуулсан нэг ч шүлэг гараагүй¹¹ талаар их гүүш, судлаач Го. Аким нэгэнтээ илтгэсэн байдаг. Тэгэхээр хятадын эртний шүлгийг мөн үе тааруулан орчуулна гэвэл бараг бүтэхгүй мэт, учир нь дээд ба дундад эртний хятад хэлний уугуул хятад үгс нь дан ганц үет ханз үсгээр илрэн гардаг тул 3, 4, 5, 7 гэх мэт үеэр шадалсан шүлгийг нэг үг нь бараг ихэнх нь хоёроос дээш үет үгээс бүтэх монгол хэлэнд буулгахад яагаад ч үеийн тоог адилтгах арга байхгүй, харин харьцааг хадгалах тухай ярьвал арай дээр болох юм.

Эртний шүлгийг орчуулах хүн дээрх мэт шүлэглэлийн онолын ерөнхий ойлголтыг мэдэж байх, өөрөө эх хэлээр шүлэг зохиодог байх гэх мэт эрдэм төгс байвал орчуулга нь харьцангуй сайн болох буй заа. Чингэвч бас нэг асуудал бол эртний шүлэг орчуулахдаа болж өгвөл тухайн цаг үеийн монгол хэлээр нь буулгачихвал бүр ч уран сайхан болох мэт санагдана. Гэвч энэ бол орчин үеийн орчуулагч нарын хувьд тийм ч боломжтой биш нь ойлгомжтой. Бидний одоогоор олдоод буй монгол бичгийн дурсгал гэхэд дундад эртний монгол хэлний дурсгал байна. Хожим үүнээс эртний дурсгал олдвол нэн сайн болох юм. Уламжилж ирсэн эртний энэтхэгийн зохист аялгууч Дандины “Зохист аялгууны толь” монгол хэлнээ орчуулагдсан нь эртний шүлэг орчуулагчид ихээхэн тустай гарын авлага болох нь дамжиггүй. “Зохист аялгууны толь” ашиглах түүнээс үг олж тааруулах, илт өгүүлэх нэртэй адил үг хэрэглэх гэх мэтээр төвд хэлээс орчуулж байсан их гүүш, дуун хөрвүүлэгч нараас сурах зүйл их бий. Энэ дашрамд нэгэн зүйл тэмдэглэхэд, “Зохист аялгуу” хэмээх энэ үг 601 онд

¹¹ Хатагин Го.Аким, “Монгол шүлгийн айзам үүсгүүрийг орчуулгын онолын үүднээс тодорхойлох оролдлого”, Яруу найргийн орчуулгын түлхүүр, УБ, 2006, 75-р тал.

Хятадад зохиогдсон “Нийлэмжит яруу авиа” хэмээх авианы дуудлагын тольтой адил шүлэг “найруулах” тэр санааг илтгэж байгаа нь ихэд сонирхолтой санагдав. Дандины аж төрж байсан үеийг эрдэмтэд янз янзаар тэмдэглэдэг ч нэлээд баримт түшсэн таамаглал нь түүнийг долдугаар зууны сүүлийн хагаст¹² энэхүү зохиолоо туурвисан гэдэг. Тэгэхээр Хятадад долдугаар зууны эхний хагаст, Энэтхэгт сүүлийн хагаст яруу холбоцын талаархи толь гарч байжээ. Чухам тэр үед дорно дахинд яруу найраг, шүлгийн онол ба зарчмууд хэдийн боловсорч, үр дүнд нь тэдгээр толь бичиг зохиогдсон болж таарч байна. Тухайн үеийн дорно дахины бие биеэс хамааралгүй ч байж болох хоёр өөр соёлт оронд нэгэн зууны дотор яруу аялгууны зохист нийцлийн тухай зохиол бүтээл ийнхүү гарч, үүний хамтаар шүлэг зохиох дүрэм нь бас тодорхой болж боловсорсны дараахан нь оршин тогтносон Хятадын Тан улсын үе бол дайн дажингүй түүхэн тогтвортой үе байсан нь соёл, утга зохиол цэцэглэн хөгжих нөхцлийг бүрдүүлжээ. Чухам ийм тохироо бүрдсэн хөрсөн дээр Тан улсын сонгодог яруу найраг хөгжиж, олон олон яруу найрагч нийт дөчин мянга гаруй шүлгээ туурвиж үлдээжээ. Тан улсын шүлгээс эдүгээ түүвэрлэн хэвлэсэн байдлыг үзэхэд, үгийн болон үйл явдлын талаархи тайлбар сэлтгэйгээ орчин цагийн хятад хэлнээ буулгасан хадмал орчуулгатайгаа хэвлэгддэг. Учир нь эдүгээгийн хятадын бичиг зохиолын хэл ба эртний хятадын бичгийн хэлний хоорондох ялгаа зааг ихтэйн улмаас эртний зохиолыг эхээр нь уншаад ойлгохгүй байдал үүсдэг тул заавал ингэж орчин цагийн хятад хэлнээ тайлбарлан буулгадаг. Тэгэхээр эртний зохиолын орчуулга хийх хүн мөнөөх зохиолын зохиогдох үед холбогдох үйл явдал, эртний үгийг орчуулахдаа сац тайлбарлаж, дагалт зүүлт хийж байвал илүү ойлгомжтой болох юм гэж бодогддог хэлэх юун. Бас нэгэн зүйл бол эртний шүлэг туурвих үеийн хятад үгийн авиа дуудлага орчин цагийн хятад хэлний авиан дуудлагаас ялгаатай байсныг заавал харгалзан үзэх ёстой юм. Хятадын болон барууны эрдэмтэд дээд эртний ба дундад эртний үеийн дуудлагыг нөр их хичээл зүтгэлээр сэргээн тогтоосон юм. Тэдний гол төлөөлөгчид бол Бакстер (William H. Baxter), С.А. Старостин, Карлгрен (Bernhard Karlgren), Сагарт (Laurent Sagart), Пүлейблэнк (Edwin G. Pulleyblank), Манж Чингийн эрдэмтэн Чень Ли (陈澧), Хятадын Ван Ли (王力), Ли Фангуй (李方桂) нар билээ. Ялангуяа Шведийн эрдэмтэн Карлгрен хятадын нутгийн аялгуунууд ба “Дэлгэрүүлсэн яруу авиа” (1008 он) –г судалсан судалгаандаа тулгуурлан 1922 онд хамгийн анх бүрэн хэмжээний хятад хэлний эртний дуудлагыг сэргээсэн бүтээл¹³ –ээ гаргасан билээ. Чингэхээр хятадын эртний яруу найргийг тухайн үеийн дуудлагаар нь сэргээн сонсвол, орчин цагийн дуудлагаас ихээхэн өөр байх юм. Чухам тэр үеийн хөг, хөгжимлөг нь одоогийн хятад хэлээр сонсохоос ангид бол үүнийг нь ч бас орчуулгандаа тусгаж болох эсэх дээр орчуулагч нь ч бас бодолцох ёстой болох юм. Тухайлбал, Тан улсын Дү Фү, Ли Байн шүлгийг орчин цагт задгай үет үгсээр

¹² Ван Мандуга, 1. “Зохист аялгууны толь”-ийн зохиогч, Таван зүйлийн үсэг хадмал “Зохист аялгууны толь”, Үндэстний хэвлэлийн хороо, Бээжин, 2012, 4-р тал.

¹³ Karlgren Bernhard “The reconstruction of Ancient Chinese”, T’oung Pao, Vol.21, 1922, 1-42 pp.

сүүл холбон яруу сайхнаар уншлаа ч гэсэн, Тан улсын үеийн хятад хэл тэр үед битүү үет үг олонтой байсан шүү хэмээн бодохоор яав ч одоогийнхоор сонсохоос өөр сонсогдох ба гол нь хятад шүлэг сүүл холбодог тул төгсгөл нь одоогийнх шиг эгшиглэнт уужуу бус, ихээхэн таслагдсан зогсоц ихтэй сонсогддог байсан байх гэж төсөөлөгдөнө.

Ерөнхийдөө хятадын эртний яруу найргийн онцлог нь дараахь байдалтай юм.

- Үеийн нарийн зохиролтой, түүнийг нь толь бичгээр 1400 жилийн тэртээгээс журамласан.
- Ихэвчлэн 5 ба 7 үеэр шадлаж эсвэл нугалбар хийдэг. 3, 4, 5, 7, түүнээс дээш хэдэн ч үеэр шадлах боломжтой.
- Сүүл холбодог, бас дундын ба толгой холбоц мэр сэр тааралддаг.
- Хөгийн тэгшит ба ташуу аялгуугаар айзам цохилгыг тааруулдаг.
- Эртний шүлэг тухайн үеийн хэлний дуудлагаа үндэслэн яруу уянгалаг, ялангуяа сүүл холбоц нь өнөөгийн үеийн дуудлагаар сүүл дарсан гэж үзвээс эндүүрэл болно.

АНУ-ын Индианнагийн Их сургуульд эртний хятад хэлээр докторын зэрэг хамгаалсан Жёфри Вотерс¹⁴ (Geoffrey R. Waters 1948–2007)-ын “Хятадын сонгодог яруу найргийг орчуулах талаархи тэмдэглэл” өгүүлэлд хэдэн зүйлийг тэмдэглэн хэлжээ. Эдгээрийг дурдвал,

- Хятадын сонгодог яруу найргийг эх хэлээр нь уншиж ойлгох нэг хэрэг, орчуулах хүн нь өөрөө эх хэлээрээ шүлэг тэрлэдэг байвал уншиж мэдэрснээ жинхэнэ шүлэг болгон орчуулан буулгаж чадна. Өөрөөр хэлбэл, хятадын яруу найргийг дахин өөр хэлнээ амилуулах үйл юм.
- Яруу найргийг орчуулахаасаа өмнө тэр яруу найргийн талаар судалгаа, шинжилгээ хийж олон дахин нягталсны дараа орчуулж шүлэг болгон бичих;
- Яруу найргийн эрх чөлөө (яруу найрагч шүлгийн хэмнэлд тохируулан хэлний тогтсон хэм хэмжээг өөрчлөх, тонгоруулах зэрэг эрх чөлөө) зөвхөн яруу найрагчид байхаас бус, орчуулагчид байхгүй гэдгийг санаж байх;
- Яруу найргийг орчуулаад давхар түүнд дурдсан үйл явдал ба бусад дүрслэл нь юу илэрхийлсэн талаар нь тайлбар зүүлт нэмж бичих;
- Хятад яруу найргийн хатуу тогтсон хэмнэл, хэмжээг аль болох хадгалж орчуулах;

¹⁴ http://www.cipherjournal.com/html/waters_forum.html

- Нэрт орчуулагч дуун хөрвүүлэгчид сонгодог бүтээлийг орчуулсан байсан ч мөн дахин орчуулахад гэмгүй. Энэ нь тухайн сонгодгийн бас нэгэн давтагдашгүй орчуулга болно.

Жёфри Вотерс-ын тэмдэглэлд ерөнхийдөө энэхүү өгүүллийг бичигчийн хэлэх гэсэн санааг хэлчихжээ. Дүгнэлтийг үүгээр орлуулан, өгүүллээ төгсгөсүгэй.

摘要：翻译中国古诗词是给外国人介绍中国古典文诗词的一条桥梁。在这篇文章（文章题目：论中国古诗词翻译）中提到中国古代诗词是属于中国历史哪个朝代的、中国诗歌的特点是什么、在中国作诗规则是何时形成好的、把中文诗歌翻译成蒙古语时如何将具有中国特色的诗词翻译到蒙古文诗词的特点，不失诗意、诗型以及节奏等问题。对诗歌翻译人的要求第一、拥有母语作诗能力，第二、对每一首要翻译的古诗进行一定的详细研究。将这一切考虑周全后才能成功翻译古诗。

ЯРУУ НАЙРГИЙН ОРЧУУЛГЫН УРАН ЧАНАРЫН ТУХАЙД

Ц.Магсар¹⁵ (МУБИС)

Товч утга: *Яруу найргийн орчуулга сэргээж эхэлж байгаа өнөө цагт түүний уран чанарт анхаарах асуудал чухал бөгөөд энэ талаар ямар үзэл онол байдаг тухай энэхүү өгүүлэлд цухас тайлбарлажээ. Мөн чанарын шаардлагад хамаарах ямар үзүүлэлтүүд гол ач холбогдолтойг тэмдэглэн, тэдгээр нь яруу найргийн гипер утгын түвшинд хэрхэн ямар байдлаар хадгалагдах ёстой, энэ талаар судлаачид юу гэж үзсэн тухай товч танилцуулжээ.*

Түлхүүр үг: *яруу найраг, орчуулга, чанар, үзүүлэлт, гипер утга*

Яруу найргийн орчуулгын асуудлаар эсрэг тэсрэг үзэл онолууд, заримдаа бие биенээ үгүйсгэсэн байр суурь байдаг нь эргэлзээтэй мэт боловч сонирхолтой. Эдгээр үзэл онолууд эцсийн дүндээ дараах хоёр эерэг хандлагаар ялгардаг: 1. Орчуулгын шүлэг найраг анхдагч эхтэйгээ адилхан гоо зүйн мэдрэмж, сэтгэгдлийг уншигчид шууд төрүүлдэг байх тухай. 2. Орчуулгын шүлэг найраг үндэсний утга зохиолд шинэлэг зүйл оруулж өмнө байгаагүй дүр дүрслэл, яруу төгөлдөр илэрхийллийг уншигчдад таниулдаг байх тухай. Гэвч үндэстнүүдийн соёл, сэтгэлгээ ялгаатай байдаг хүчин зүйлсээс хамааралтай шалтгаанаар орчуулгын практикт дээрх хоёр эерэг хандлагын нэг нь заавал сөрөг талдаа давамгайлсан нөхцөл байдлыг үүсгэж, орчуулгын бүтээлд ямар нэгэн хэмжээгээр чанарын хомсдол бий болж байдаг онцлогтой. Эхний хандлага нь анхдагч эхээс холдох, зохиож орчуулах буюу зоргоор орчуулах зам руу хөтлөх гээд байдаг бол хоёр дахь нь үндэснийхээ уран зохиолын хэлийг “эвдсэн”, тухайн хэлтэн уншигчдын эх соёл, гоо зүйн хөрсөнд хавьтахааргүй, ийм учраас хүн шимтиж уншихааргүй харь хөндий яруу найргийг бий болгох гээд байдаг байна. Энэ бүхний эцсийн зангилаа нь орчуулгын уран чанарын хэмжүүр дээр ирж төвлөрдөг.

Орчуулгын функциональ (буюу коммуникатив) онолоор орчуулагдахгүй зохиол гэж үгүй, түүний дотор орчуулах боломжийн хувьд харьцангуйд тооцогддог яруу найргийн зохиол ч үгүй гэж үздэг нь нэг талаас маргаантай асуудал боловч нөгөө талаас ямарваа мэдээллийг дамжуулснаар нь орчуулгын үүргийг хэмждэг ерөнхий зорилготой уялдуулбал уг үзэл онолыг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй болдог байна. Энд мөн л чанарын тухай ойлголт гол үзүүлэлт болно. Уран чанараа алдсан л бол яруу төгөлдөр орчуулгын тухай яриа байж таарахгүй. Яруу найргийн орчуулга ямар нэг хэмжээгээр уран чанар заавал шаардана. Учир нь яруу найргийн бүтээл бусад олон хэлбэрийн үгийн урлагийн бүтээлээс илүү чанд дархлаатай, ихэнхдээ л зохиогчийн дотоод ертөнцөөс

¹⁵ МУБИС, доктор, профессор

ундарсан, ийм болохоор зохиогчдоо ууссан дүрслэл болоод дүрийн бүтэцтэй. Зүй нь орчуулгадаа ч энэ шинж чанар бүрэн хадгалагдах учиртай.

Гэвч орчуулгын шүлэг найргийн уран чанарыг шинжих, судалж шүүмжлэх төрлийн ажил дутмаг бол чанарын үнэлгээ орчуулгын практикаас хоцроод байх магадлалтай. Тийн үнэлгээгүй байсаар байгаад сайн муу нь мэдэгдэхгүй нэг хэсэг орчуулга дэлгэрч, тэдгээрээс магадгүй чанар муутай нь уншигч олонд илүү танигдсан байх харамсалтай ч гэмээр үр дагаварт хүрсэн байж мэдэх ажээ. Жишээ нь, Шекспирийн 77-р сонетын орос орчуулгын хэд хэдэн хувилбар байдгаас дээр дурьдсан хоёр хандлагын тод жишээ болохуйц төгсгөлийн мөрийг орчуулсан огт хоёр өөр хувилбарыг зохиолч, орчуулга судлаач Геннадий Панченко цахим хуудсандаа байрлуулжээ:

"These offices, so soft as thou wilt look,
Shall profit thee and much enrich thy book." (Шекспир)

"К сим службам чаще взор свой обращая,
Добудешь пользу, ум обогащая." (В.Тяптины орчуулга)

"Как часто эти найденные строки
Для нас таят бесценные уроки" (С.Маршакийн орчуулга)

Энэхүү эрс ялгаатай хоёр хувилбарын эхнийх нь анхдагч эхээ барьсан, муу ч биш үнэлгээтэй орчуулга юм байна. Харин хоёр дахь нь анхдагч эхийн хэлбэр, утгыг ихээхэн оросжуу төрхтэй болгосон чөлөөт хэлбэрийн орчуулга аж. Судлаачийн үзсэнээр Шекспирийн сонетуудыг С.Маршак орчуулахдаа ерөнхийдөө ийм чөлөөт хувилбарыг илүү давамгай хэрэглэсэн бөгөөд харьцуулж судалж үзэхэд анхдагч эхээс дүр дүрслэлийн ердөө 23,4%, үйл явдлын 14,5% нь орчуулгадаа буусан байдал ажиглагджээ(8). Гэтэл 77-р сонетын орчуулга Маршакийн хувилбараар илүүтэй тархсан гэдгийг олон уншигчийн санал сэтгэгдэл харуулсан байна.

Эндээс яруу найргийн орчуулгад чанарын үзүүлэлт, тоон үзүүлэлт хоёр хэр хол зөрөх магадлалтайг харж болно. Бид энд чанарын үзүүлэлтэд нөлөөтэй зарим хүчин зүйлийг товчоолон таниулахыг зорив. Үүний тулд яруу найргийн орчуулгын тоон болон чанарын ойлголтод ямар үзүүлэлтийг нь хамруулж болохыг судлаачдын санал онолоос түүвэрлэн авч үзвэл дараах хэдэн шинж байдлыг давын өмнө анхаарч үзүүштэй байдаг байна.

Тоон үзүүлэлтүүд:

- Үгийн тоо анхдагч эхтэйгээ таарч байгаа эсэх;
- Орчуулагчаас аль хэр нэмсэн буюу гэсэн;
- Үг орчуулгадаа хэл зүйн хэлбэрээ хадгалж чадсан эсэх (Жишээ нь, тэмдэг нэр тэмдэг нэрээрээ орчуулагдсан эсэх г.м.);
- Европ хэл хоорондын шүлгийн орчуулгад бол үеийн тоо болоод шүлгийн үе-өргөлтийн шинжийг нь хадгалсан эсэх гэх мэт.

Чанарын үзүүлэлтүүд:

- Шүлгийн гоо зүй (хэмжээ, хэмнэл, бүтэц, найруулга г.м.) алдагдсан эсэх;
- Утга эндүүрсэн эсэх;
- Үгийн утгын өнгө эхэд байгаатай нийцүү (буюу адекват) чанартай болж чадсан эсэх;
- Яруу найргийн хэлээр орчуулагдсан эсэх;
- Яруу найргийн хэлээр орчуулагдсан бол дүрслэн илэрхийлсэн байдал нь оновчтой, анхдагч эхдээ нийцтэй болсон эсэх;
- Өгүүлбэрийн байгууламж, мөр, шад, бадгийн логик алдагдсан эсэх;
- Орчуулагчаас субъектив зүйл нэмсэн эсэх гэх мэт.

Эдгээрээс чанарын зарим нэг үзүүлэлтийг онцлон авч тодруулж тайлбарлая. Жишээ нь, “яруу найргийн хэлээр орчуулах”-ын тухайд гэвэл уран зохиолын хэлийг дотор нь танин мэдэхүйн болон найруулгын талаас нь хоёр өөр түвшинд авч үзэж болно. Энгийн түвшин буюу эхийн хэл гэж байна. Шүлгийг өгүүлэмжид нь шимтэн, доторх баримт мэдээллийг нь дамжуулахыг нэн тэргүүнд зорьж эхийн хэлээр нь орчуулж болно. Тэр нь хадмал шинж илүү давамгайлсан, эс бөгөөс хүүрнэл хэлбэр лүү ойртсон орчуулга болно. Үүнээс гадна, яруу найргийн хэл гэж байна. Толь бичигт байгаа “нүцгэн” үг, мөн эхэд байгаа тухайн тодорхой утгаа олсон үг шүлэг найрагт өнгө төрхөө засаж “гоёмсог хувцас өмсдөг” байна. Иймд яруу найргийн хэлээр орчуулна гэдэгхөрвүүлж буй хэлнээс шилж сонгосон үг утгас нь дүрслэн илэрхийлэх байдал, сэтгэл хөдлөлийн шинж, хэл найруулгын ярууслаг чанараараа анхдагч эхдээилүү ойр очиж дүйцэх арай өөр түвшний орчуулга гэсэн үг. Чухам энэ л түвшнийг орчуулгад хадгалж гэмээ нь зохиол амин сүнсээ алдаж гээлгүй орчуулагдахын урьдач нөхцөл бүрдэнэ. Жишээ нь, Пушкины “Хөшөө дурсгалаа босгов би” шүлгийг орчуулсан Д.Урианхайн хувилбараас тоон үзүүлэлт алдагдсан ч найруулгын ярууслыг гаргасан дараах мөрүүдийг харж болно.

И славен буду я, доколь в подлунном мире
Жив будет хоть один пиит

Ялгуун саран дор ядаж ганц найрагч үлдэхэд
Яруу алдрын суу миний нэрийг дагана!

Хвалу и клевету приемли равнодушно
И не оспаривай глупца

Магтаал гүтгэлэг хоёуланг чихний үзүүрээр өнгөрөө,
Маргаад нэмэргүй тэнэгтэй үг бүү тэрс!

Яруу найргийн орчуулгын чанарыг дордуулдаг, ерөнхийдөө нийтлэг ажиглагддаг нэгэн үзэгдэл бол орчуулагчаас нэмсэн субъектив зүйлс юм. Ийм

байдлын ихэнх шалтгаан нь голдуу шүлэгт хэмнэл үүсгэх юмуу толгой холбох гэснээс үүдэлтэй байдаг. Жишээ нь, орос хэлнээс “кот учёный”(европын зарим үндэстний үлгэр домгийн баатар; “сэцэн муур”, “эрдэмт муур”, “муур багш” гэх мэтээр орчуулуштай) гэдгийг “эрээн муур”, “хар муур” гэж орчуулбаас уг үг өөр өнгө төрхтэй болон зохиолын обьектив утгыг орчуулагчийн субъектив хандлага санаа зоргоороо өөрчилж эхэлнэ гэсэн үг.

Тоо ба чанарын эдгээр болоод бас бус олон үзүүлэлт байвч харамсалтай нь тэдгээрийг барьж суугаад орчуулга хийж болдоггүй ажээ. Гол учир нь хэл, соёл, сэтгэлгээний зөрөөнөөс болоод яруу найргийн орчуулгад бүх үзүүлэлтийг адил тэнцүү хадгалан хөрвүүлэх боломж байдаггүй. Тоон талаа хөдөлбөргүй барья гэвэл чанар талдаа алдагдалтай, чанар талаа барья гэвэл тоон талдаа алдагдалтай байдаг. Аль нь гол юм бэ гэдэг асуулт гарч мэднэ. Тодорхой зорилгоос хамаараад аль нь ч гол байж болно. Жишээ нь, эрдэм шинжилгээний ажлын зорилгоор шүлэг, найрагт хадмал орчуулга, эсвэл хүүрнэл орчуулга чухал болж магад. Гэхдээ л уншигч олонд зориулж орчуулж байгаа бол ямар ч тохиолдолд, зарим тохиолдолд тоон үзүүлэлтэд гарцаагүй баригдах тийм өвөрмөц бүтэц зохиомжтой шүлгийн орчуулга ч гэсэн чанарын шаардлагад заавал захирагдана.

Шүлэг найраг уншигчид хүрэхдээ анхдагч мэдээлэл нь “яруу найраг” хэмээх эхийн үүргээрээ гоо зүйн мэдээлэл байдаг байна. Гоо зүйн мэдээлэл дамжиж байх үед бүтээл (бүтээлийн цаана зохиолч, түүнийг орчуулсан орчуулагч) уншигч хоёрын хооронд яруу найргийн харилцаа үүснэ. Ийм яруу найргийн харилцаа үүсэхгүй л бол гоо зүйн мэдээлэл дамжихгүй, эсвэл, ерөөсөө тийм мэдээлэл байхгүй байна гэсэн үг. Цаад эхдээ байсан гоо зүйн мэдээлэл орчуулгадаа байхгүй буюу буурсан байдалтай байвал орчуулгын чанар алдагджээ гэсэн үг юм.

Чанар ба гипер утгын холбоо хамаарал

Яруу найргийн хэлний гол шинж юу вэ? Эх бүтээгч хэлний нэгж буюу үгсийн сангийн нэгж тодорхой утгатай. Харин яруу найргийн хэл нь хэд хэдэн тодорхой утга нийлж гипер утга (hypersense) буюу үг хоорондын гипер холбооны өөр нэг шинэ түвшин үүсгэдэг аж. Гипер холбоо нь эхийн бүхий л элементүүдийн нийлэгжсэн түвшинд үүснэ. Тэр түвшиндээ нийцсэн хэмнэл, найруулга, анирлаг, авианы зохицолтой байна. Орчуулгад ийм гипер утга, гипер холбоо хадгалагдах учиртай.

Үүнээс үүдээд яруу найргийн орчуулгад дүйцэл буюу эквивалентын асуудал энгийн хүүрнэмж буюу хүүрнэл зохиолоос арай өөрөөр тавигдах үндэстэй. Эрдэмтэд яруу найргийн орчуулгад буй дүйцлийн янз бүрийн түвшний талаар судалж тэмдэглэсэн зүйлс байна. Жишээ нь, А.Швейцер утгын (семантикийн) ба хэрэглээний (прагматикийн) дүйцэх чанар гэж ангилсан байна. Хэрэглээний дүйцэл гэдэг нь гипер түвшний асуудал юм. Хэрэглээний дүйцэх чанар биелэлээ олохын тулд орчуулагчаас илүү их бүтээлч хандлага шаардана. Энэ тохиолдолд орчуулга зөвхөн нэг янзын хэв маягт баригдах аргагүй (11). Үүнтэй нэгэн адил Ю.Найда формаль дүйцэх чанар (анхдагч эх

рүүгээ чиглэсэн), динамик дүйцэх чанар (рецептор буюу орчуулгыг хүлээн авч буй хэрэглэгч рүү чиглэсэн) гэж ангилсан байна. Энэ нь орчуулагчийн зүгээс “тухайн зохиолч орчуулагдаж буй тэр хэлээр энэ зохиолыг бичвэл яаж бичих байсан бэ” гэсэн үзлээр хандаж үгсийн сан, хэл зүйн хувиргал (модификаци) хийж орчуулах тухай асуудал юм.(6).

Товчоор хэлбэл гипер утгын түвшний орчуулгад үг утгасыг оноолтоор нь дүйцүүлэх боломжгүй хэрнээ оновчтой орчуулагдсан үр дүнтэй байдаг. Гэтэл үг утгасыг ягштал баримталсан орчуулга байх атал гипер утгын түвшиндээ харин ч оновчгүй болж, тэр бүү хэл утга гажсан тохиолдол байдаг байна. Учир нь яруу найргийн үг ихэнх төлөв үзэлд суурилсан, өөрөөр хэлбэл, бодит утгаа гээчихсэн, эсвэл, гээхэд амархан байдаг. Харин гипер утгын түвшний орчуулгыг чөлөөт орчуулгатай эндүүрч хэрхэвч болохгүй юм. Гипер утгын түвшний орчуулга харин ч чөлөөт биш. Анхдагч эхэд буй ярууслыг орчуулж буй эхэд мөн чанараа хадгалсан байдлаар нь “ингэж л хөрвүүлнэ”, эс бөгөөс “ингэж л хувиргана” гэсэн туйлын чанд хэлбэрийг олохын тулд орчуулагч ихээхэн авьяас чадвар гаргаж, эрэл хайгуул хийж, цаг зав, хөдөлмөрөө зарцуулна гэсэн үг юм.

Гипер утгыг зохиомлоор үүсгэсэн байж болох уу?

Монгол орчуулгын түүхэнд эхийг дагнан орчуулах төдийгүй зохиомжлон орчуулах, орчуулгаа өөрийнхөөрөө баяжуулах чөлөөт хэлбэрүүд түгээмэл байсан уламжлалтай. Ийм баримтуудыг самгарди, төвд, хятад хэлнээс орчуулж байсан эртний уламжлалаас авахуулаад “Эрдэнийн сан Субашид”-ыг тайлбараар баяжуулан орчуулсан Лувсанчүлтэмийн хувилбар, орос хэлнээс давамгай орчуулах болсон ХХ зуунд А.С.Пушкины “Загасчин загас хоёрын үлгэр” (“Алтан загасны үлгэр”)-ийн Ц.Дамдинсүрэнгийн орчуулга гэх мэт монгол хөрсөнд нутагшуулсан орчуулгын бүтээлүүдээс харж болно. Эдгээрт тухайн зохиолын үзэл санааг уншигчдад илүү дөт хүргэхийн тулд түүнд нь нийцсэн гипер утга үүсгэсэн байж болзошгүй. Ийнхүү зохиомжлон орчуулах нь уг зохиолын “макро” түвшинд хийж буй модификаци буюу хувиргалын нэг хэлбэр бөгөөд бие даасан гипер утгын тухай баримт түшиж ярихын тулд эдгээр орчуулгын зохиолыг судлах шаардлагатай юм. Орчуулгын ийм хувилбар нь улс түмнүүдийн хоорондох соёлын диалог хөгжиж өргөжих тааламжтай хөрс, мөн үндэсний уран зохиолоо гадаад уран зохиолын сэдвээр баяжуулах үр өгөөжтэй нэгэн арга зам билээ.

Болхидуу хувиргалын тухайд

Яруу найргийн орчуулга ихээхэн нарийн чимхлүүр ажиллагаа шаарддаг байна. Үгийн утгын оноолтоос эхлээд шүлгийн хэмжээ хэмнэлийг оновчтой гаргаж, шүлэглэл нь найруулгын чанд хэлбэр маягаа олох хүртэл эрэл хайгуул болдог энэ их ажил хэдий нягт нямбай байвч алдаа онооны аль алийг дагуулж таарна. Харин шүлгийн уран чанарын олон үзүүлэлтээс зарим тодорхой нь илэрхий доголдож, харахад шүлэг мэт байвч цаад эхтэй нь харьцуулбал утга эндүүрч будилсан, ерөөсөө ойлгоогүйгээс буруу ташаа орчуулсан, үг утгасын гүнд ороогүй чанар дорой орчуулга, заримдаа орчуулга гэхэд ч хэцүү зүйлс

нэлээн байдаг. Үүнд үнэлгээ өгч, үүнийг сайжруулахын тулд орчуулгын шүүмж, судлалыг мэргэжлийн түвшинд хөгжүүлэх шаардлагатай байгаа юм. Орчуулагчид орчуулгын ур чадварыг хэлэлцдэг мэргэжлийн сэтгүүлтэй болсон нь тун сайн хэрэг. Ялангуяа орчуулгын шүүмж хөгжвөл, цаашлаад шүүмж судлалыг сургалттай холбож уялдуулбал орчуулгын уран чанарыг дээшлүүлэхэд тустай сайн хөшүүрэг болж чадна. Харамсалтай нь өнөө хэр энэ ажил сайн сэргээгүй л явна. Ийм шүүмж судлалыг зөвхөн монгол хэлэнд орчуулж буй орчуулгын бүтээл төдийгүй, монголын уран зохиол, монгол яруу найргийг гадаадын хэлэнд орчуулж буй ажлын чанар байдлыг шинжлэх зорилгоор хөгжүүлэх нь ялгаагүй чухал. Нэг жишээ дурьдахад, Б.Явуухулан, Д.Нацагдоржийн шүлгийн орос орчуулгууд уран чанараар туйлын муу, хэлний болоод соёл-сэтгэлгээний хувиргалууд нь болхи болсон байдаг. Гэтэл сор болсон эдгээр зохиолчдынхоо бүтээлээр бид монголын уран зохиолыг гадаад ертөнцөд сурталчилсаар ирсэн, бас анхдагч мэдээлэл орос хэлээр тархаж байсан нь ч цөөнгүй. Б.Явуухулангийн “Би хаана төрөө вэ” шүлгийн:

“Тэнхээт хүлгийн дөрөөг эзэгнэнхэн төрлөө би:
Тэлмэн жороо морины шанхны үзүүрийн чичиргээнд –
Тэнгэрийн салхинаас бусдыг дээрээ гаргаж үзээгүй
Тэнэгэр говийн сүрэг онгон хулангийн нуруунд
Тэнхээт хүлгийн дөрөөг эзэгнэнхэн төрлөө би”

хэмээх охь болсон дөрвөн мөрийг дараах байдлаар анх орос хэлэнд орчуулж байжээ.

“По степи беспредельной рассыпались дикие кони –
Словно бубен гигантский, земля под копытами стонет.
Сквозь пустыню гобийскую мчатся куланы стрелою –
Жарким ветром оседлан, несется табун к водопою.
Да, владыкой коней ветрогривых на свет я родился!”

Энд утгын оноолт, шүлгийн гоо зүй, найруулгын ярууслын тухайд яривал “бараадахааргүй” гэж дүгнэмээр. Ийм байдлаар түүний “Мөнгөн хазаарын чимээ”, “Намрын мөнгөн өглөө” шүлгүүд, Д.Нацагдоржийн “Миний нутаг”-ийн зарим орос хувилбарыг(оросоос гадна орчин үед идэвхижсэн өөр бусад хэлний орчуулгыг ч анхаарууштай,²)тийн болхи хувиргалын жишээнд оруулан үзэж болно. Болхи хувиргал болбоос яруу найргийг гутааж буй явдал бөгөөд чухамдаа шүлэг найргийг орчуулж болох болохгүйн дэнсэн дээр асуудлыг шийдэгдэхдээ хүрвэл ямартай ч энэ гарцаар л явамгүй билээ.

Дүгнэлт

1. Монгол орчуулгын яруу найраг түүхэн хугацаандаа шүлэг орчуулах шинэлэг өвөрмөц арга барилуудаастуршсан, нэвтрүүлсэн, өөриймшүүлсэн гэх мэт эрэл хайгуулын баялаг сан хөмрөгтэй болжээ. Үүнийгээ орчуулагчид өөрсдөө энд тэнд тэмдэглэн үлдээсэн байх нь ч олонтаа. Жишээ нь, тэд утгын өнгө аяс нь таарсан үг хэллэг хайх ч юмуу, шүлгийн үе, нугалбар тааруулахын тулд зохистой үгийнх нь эрэлд хатаж их ажил болдог тухай сонин баримт ярьцгаадаг. Тэгвэл энэ бүхэн болоод ер нь орчуулгын үйл, орчуулагчийн ажлын онцлогтой холбоотой баримт сэлт, арга хэрэглэгдэхүүнийг судалж цуглуулах нь орчуулга хөгжих урьдач нөхцөл болно гэдэг үндэслэлээр орчин цагийн “мэргэд гарахын орон”-ы лаборатори, сургамжийн сан бүрдүүлэх зорилгыг дэвшүүлбээс ихэд буянтай үйлс болно.
2. Өнөөгийн практикаас харахад орчуулгын шүүмж болоод судлал хангалтгүй түвшинд байгаагаас, мөн шүүн хэлэлцэхгүй болохоор чанар муутай орчуулга олширсноос ерөнхийдөө орчуулгын шүлэг муу байдаг гэсэн ойлголт уншигчдын дунд тогтож, тэр бүү хэл найруулга, зохиомжоор тааруухан шүлгийг “орчуулгын шүлэг шиг” гэж үнэлэх явдал түгээмэл ажиглагддаг. Энэ бол яруу найргийн орчуулгын чанарын доройтлыг харуулж байгаа нэг дүр зураг юм. Иймд уран зохиолын мэргэшсэн орчуулагчдын зорилгыг нэгтгэж, хэрэв олон нийтийн байгууллага байгаа бол тэдгээрийн чиг үүргийг нэгэн зүгт хандуулан чухамхүү чанарт төвлөрүүлж, үүнтэй уялдаатай орчуулгын шүүмж судлалыг өргөн дэлгэр хөгжүүлэх хэрэгтэй байна.

Ном зүй

1. Аким Г. “Яруу үгт, утга сайт бичиг”-ийг дуун хөрвүүлэх дуршил. “Орчуулгазүй” сэтгүүл, 2014, №3
2. Дэлгэрмаа Г. “Үлэмжийн чанар”-ыг нулимж болохгүй. “Орчуулгазүй” сэтгүүл, 2014, №3
3. Левик В.В. О точности и верности // Перевод – средство взаимного сближения народов. М., 1987
4. Магсар Ц. Критический анализ поэтических переводов (Явуухулан на русском языке). “Гадаад хэлний сургалтын асуудлууд: онол, аргазүй, орчуулга”. МУБИС-ийн ГХС-ийн ЭШБ. УБ., 2012.
5. Магсар Ц. Шүлэг хөрвүүлэх бичихээс тамтай. “Өнөөдөр” сонин, 2000.08.01.
6. Nida E.Ch. Toward a Science of Translating, Leiden, 1964
7. Nida E.Ch. The Theory and Practice of Translation, 1969
8. Панченко Г.А. www.litlib.net
9. Ринчен Б. Шүлэг орчуулах эрдэм. “Орчуулах эрдэм-2”, УБ., 1972
10. Швейцер А.Д. Эквивалентность и адекватность перевода // Тетради переводчика – Вып. 23. М., 1989
11. Швейцер А.Д. Текст и перевод. М., 2009

12. Цэдэнжав Д. Лингвостилистические аспекты перевода с монгольского языка на русский. Улан-Удэ: изд-во БГУ, 2010
13. Эрдэнэмаам С. Зарим орчуулгын тухай (шүүмж, эргэцүүлэл), МУБИС-ийн ЭШБичиг “Лавай”, 2012, №8

Резюме

В статье “К мастерству поэтического перевода” говорится о том, что на современном этапе, несмотря на возрождение поэтического перевода, накапливается масса проблем, ставящих во главу угла востребованность его качественного анализа. Автор обосновывает необходимость поднятия качественного уровня художественного, в том числе, поэтического перевода. С этой целью он ссылается на мысли известных мировых переводоведов относительно поэтического перевода, иллюстрирует те главные показатели, которые относятся к количественным и качественным характеристикам данного вида перевода.

“ВАБИ”, “САБИ” НЬ ЯПОНЧУУДЫН ГОО САЙХНЫГ ҮЗЭХ ҮЗЛИЙН ИЛРЭЛ БОЛОХ НЬ – Хайкү шүлгийн жишээгээр –

Ц.Дэлгэрэхцэцэг¹⁶, Н.Билэг¹⁷ (МУИС, ШУС)

Товч агуулга: Японы хайкү шүлгийг орчуулга болон шүлэг зохиогдсон түүх зэрэгтэй нь уялдуудан судалж үзэхэд байгаль ертөнцийн үзэгдлээр төлөөлөн хүмүүний амьдралын утга учир, баяр гуниг, гоо сайхан зэрэг бүхий л зүйлийг илтгэж буй нь харагдана. Энэ утгаараа хайкү шүлэг нь япончуудын гоо сайхныг үзэх “Ваби”, “Саби” ойлголтын өвөрмөц нэгэн төлөөлөл болж байна.

Түлхүүр үг: хайкү шүлэг, “Ваби”, “Саби”, ертөнцийг үзэх үзэл, гоо сайхныг үзэх үзэл

Япончуудын ертөнцийг үзэх үзэл, гоо сайхныг үзэх үзэл нь “Ваби” (侘), “Саби” (寂), “Юүгэн” (幽玄) зэрэг тулгуур ойлголтоос бүрддэг. Дэлхий дахинд эдгээр ойлголт нь япон үгээрээ хэрэглэгддэг бөгөөд “Ваби” нь мөнх бус, түр зуурын, хоосон, үнэмлэхүй гоо үзэсгэлэнг, “Саби” нь байгалийн өнгө ба насжилтыг, “Юүгэн” нь нууцлагдмал, нарийн утга учиртай гоо үзэсгэлэнг илтгэдэг. Энэхүү гурван ухагдахуун япончуудын гоо зүйн үзлийн цөм хэсэг болдог байна. “Ваби”, “Саби” нь Японы уламжлалт соёл урлагтай гүн холбоотой байдаг ажээ. Цайны ёслол, японы цэцэрлэг, ваар, шавар эдлэл мөн уран зохиол тэр дундаа хайкү шүлэгт тусгалаа олсон байдаг байна. Япон хэл, соёлыг судалж буй хүмүүс энэхүү соёлын тулгуур ойлголтын талаар тодорхой хэмжээнд мэдэж, ойлгож байх шаардлагатай гэж хэлж болох юм. “Ваби”, “Саби” гэдэг үг нь утгаасаа эхлээд ойлгоход төвөгтэй ба хүн бүр олон янзаар ойлгож, тайлбарладаг, ялангуяа гадаадын хүмүүст бол оньсого мэт зүйл учраас энэ талаар дэлхийн олон орны судлаачид сонирхон судалсан байдаг.

Энэхүү өгүүлэлд “Ваби”, “Саби” нь Мацүо Башё, Ёса Бүсон, Кобаяши Исса зэрэг Японы алдарт хайкү зохиогчдын шүлэгт хэрхэн илэрч буйд дүн шинжилгээ хийхийг зорилоо. Монгол хэлнээ орчуулагдсан зарим шүлгийн орчуулгад дүн шинжилгээ хийхийн зэрэгцээ англи хэлтэн улс гүрний япон хэл, соёлын судлаачид “Ваби”, “Саби”-г хэрхэн ойлгож, тайлбарлаж, буулгаж буйг англи хэлнээ хөрвүүлсэн зарим шүлгийн орчуулгад ажиглалт хийсний үндсэн дээр ажиглахыг оролдлоо. Хайкү шүлэг 16-р зууны дунд үеэс “Ваби”, “Саби”

¹⁶ МУИС, ШУС, ХУС-ын ази судлалын тэнхим, доктор, дэд профессор

¹⁷ МУИС, Япон судлалын анги төгсөгч, орчуулагч

үзлийг түгээн дэлгэрүүлэх нэгэн хэлбэр болжээ. Хайкү шүлгээр дамжуулан “Ваби”, “Саби” үзлийг түгээх хэлбэр нь хамгийн энгийн бөгөөд хүртээмжтэй байсан тул өнөөдрийг хүртэл хадгалагдан ирсэн төдийгүй улам боловсронгуй болсоор иржээ. Бид 50 хайкү шүлгийг сонгон авч, япон ба англи хэлнээс хийсэн орчуулгыг ажиглан, хайкү шүлгэнд “Ваби”, “Саби” хэрхэн илэрч буйд анализ хийж үзлээ.

Аливаа үндэстний үзэл бодол, ертөнцийг үзэх үзэл нь тухайн улс орны хүмүүсийн шашин шүтлэгтэй гүн холбоотой байдаг. “Ваби”, “Саби” гэгч япончуудын гоо сайхныг үзэх үзэл бурхны шашны Зэн урсгалаас үүдэлтэй байдаг. Зэн-буддизм Хятад, Японд маш эрчимтэй хөгжсөн урсгал бөгөөд, өдгөө барууны ертөнцөд ч өөрийн гэсэн байр суурьтай байгаа төдийгүй дорно дахинд өвөрмөц сэтгэлгээний нэгэн чухал чиглэл болдог байна. Зэнгийн анхны их багшаас буддизмын мөн чанар юу болохыг асуухад: “Ямар ч ариун нандин зүйл үгүй **хов хоосон**” гэж хариулсан гэдэг. Зэн-г, хамгийн товчоор, бурхадын номлол ба бичигдэж барлагдсан ариун сударт бус, гагц өөрийн дотоод оюун билигт найдаж гэрээрэх учиртайг заасан, Буддагаас (магадгүй Бодидармаагаас хойш) гагцхүү шууд хэлбэрээр дамжиж ирсэн сургаал хэмээн ойлгож болно.”¹⁸ “Зэн бол амьдралын аахар шаахар зүйлд баригдахгүй, сэтгэлээ хүсэл шуналаар зовоохгүй явж, хязгааргүй эрх чөлөөг жинхэнэ утгаар амсч танихын урлаг юм.”¹⁹ Зэн-гийн үүднээс гэгээрнэ гэдэг нь аливаа баяр хөөр, айдас, шунал хүслээс өөрийгөө үүрд цэвэрлэж, туйлын амар амгаланг олох, түүнийхээ үрээр бүхий л хорвоогийн мөн чанар хоосон болохыг ухаарах явдал юм. Зэн урсгал болон “Ваби”, “Саби” нь хоорондоо салахын аргагүй шүтэлцээ холбоотой. “Ваби, “Саби”-гаар Зэн-г ойлгох боломж нээгдэх бол Зэн нь “Ваби”, “Саби”-г бий болгоход сэтгэлийн тэнхээ, тэмүүлэл өгдөг байна. Махаяна урсгалын үзэлд хорвоо ертөнцөөс тусгаарлагдаж энгийн амьдралруу шилжих санааг өөртөө агуулсан “Ваби”, “Саби” нь эерэг чанартай байдаг. Махаянагийн гол сургаал бол үг хэлээр жинхэнэ ойлголтыг хүлээж авах боломжгүй, харин “Ваби”, “Саби”-гийн жинхэнэ төрхийг аливаа үг хэлээр хүлээж авах биш харин бие сэтгэлээрээ мэдрэх нь хамгийн зөв арга гэж үздэг. Саймон Брауны тэмдэглэснээр “Ваби”, “Саби” нь хүмүүсийг янз бүрийн хэрэггүй бодолд автсанаас амьдралд өрнөж байгаа бүхнийг тэвчин хүлцэж, мэдрэмжээрээ амьдрах санааг агуулдаг”²⁰ хэмээжээ. Ийнхүү “Ваби”, “Саби” нь буддизмын Зэн урсгалын нэгэн илэрхийлэл болж байна. Байгалийн, хувирамтгай, өвөрмөц биетүүдээр хүрээлэгдэх нь биднийг жинхэнэ ертөнцтэй холбоо тогтоож, сэтгэл санаа үймсэн байдлаас ангижрахад тус болдог. Нөгөөтэйгүүр “Ваби”, “Саби” нь хамгийн энгийн зүйлийг сонирхож, түүний гоо сайхныг олоход сургадаг. “Ваби”, “Саби” нь элэгдсэн, хуучирсан бүхнээс сайхныг нь олж харахаас эхлэн бидний амьдралыг харах өнцгийг өөрчилдөг байна. Барууныхан аливаа юмыг төгс төгөлдөр, мөнхийн, тэгш хэмтэй байлгахыг хүсдэг бол Дорныхон

¹⁸ Г.Аюурзана, “Зэн буддизм: Амьдралаас ангижрахуй”, УБ., 2010, х. 5-6.

¹⁹ Г.Аюурзана, “Зэн буддизм: Амьдралаас ангижрахуй”, УБ., 2010, х.6.

²⁰ Simon G. Brown. “Practical Wabi Sabi”, UK, 2007 .

эсрэгээрээ эмх цэгцгүй, өө сэвтэй, элэгдсэн юмсыг байгаа чигээр нь хүлээн авдаг талтай.

“Ваби”, “Саби” гэдэг үгс угтаа хамт хэрэглэгддэггүй байсан бөгөөд тус тусдаа бие даасан утгатай аж. Цаг улиран өнгөрч, хүмүүний хорвоо ертөнцийг харах чиг өнцөг өөрчлөгдсөнөөр энэ хоёр бие даасан үг хамт хэрэглэгдэх болсон байна. Мөн энэ хоёр үгийн аль аль нь гоо сайхныг илэрхийлэх үг байгаагүй ажээ. “Ваби”, “Саби” гэх хоёр үгийг тус тусд нь авч үзье. “Wabi” (侘) нь япон хэлний “wabu” (侘ぶ) буюу гунигтай байх, ганцаардах, сэтгэл санаа зовних гэсэн үйл үгээс нэр болж хувирсан хэлбэр юм.²¹ Нийгмээсээ холдож байгаль дунд ядуу тарчиг, хоосон амьдарч ганцаараа шаналахыг илэрхийлнэ. Аяндаа “Ваби” нь ядуу хоосон, дутуу дулимаг дундаас сэтгэлийн таашаалыг олж авах гэсэн үзлийг илэрхийлдэг болсон байна. Мөнх бус байдал, үнэмлэхүй гоо сайхныг бас илтгэдэг. Японы эртний “Ман-ёошүү” (万葉集) хэмээх алдарт шүлгийн цоморлигт “wabishi” (わびし), “wabu” (わぶ) гэх үгс гардаг ба аль аль нь хайр дурлал бүтэлгүйтсэнээс болж шаналж буй байдлыг илэрхийлдэг байснаас биш гоо сайхны үнэлэмжийг илэрхийлдэггүй байжээ. “Ваби” нь санаснаар болдоггүй, уйтгар гунигаар дүүрсэн амьдралтай байсан ч тэр дундаас амьдралд дурлах сэтгэл төрөн гарч, дээр нь намар, өвлийн улирал нэмэгдэж эгэл жирийн гоо сайхан, сэтгэл санаанаас урган гарсан гоо үзэсгэлэнгийн мэдрэмж болж хөгжсөн байна. Өөрөөр хэлбэл, угтаа үзэн ядаж байгаа, дургүйцэл, харууссан байдлыг илэрхийлж байсан “Ваби” нь дундад зууны (中世) үед дутуу дулимаг гоо сайхныг илэрхийлэх шинэ ойлголт болон өөрчлөгджээ. Дундад зууны үед Буддын шашны Зэн урсгалын нөлөө газар авч, хүмүүс тэргэл сараас илүү үүлэн дунд орсон бүдэгхэн харагдах сарыг шимтэн ширтэх болжээ. Ингэснээр бүрэн бүтэн бус, төгс биш зүйлийн гоо сайхныг нээж чадсан байна.²² Буддизм Японд орж ирснээс хойш хүмүүс ил тод байгаа баялгаас илүүтэйгээр дотоод сэтгэлийн, оюун санааны цогцоос амьдралын жинхэнэ бодит байдлыг олохыг эрмэлзэж эхэлсэн. Цайны ёслол анх бий болохдоо буддын шашины Зэн урсгалын үзэл бодлын нөлөө ихтэй байсан тул “Ваби” гэдэг ойлголтыг эрхэмлэдэг болжээ. “Ваби” гэж юу вэ гэвэл гаднаа гялалзсан биш харин даруухан, навсарсан зүйлийг илүүд үзэж түүн дотроос үзэмжийн төгөлдрийг хайж олох гэсэн ойлголт юм.”²³ Улмаар “Ваби” нь японы цайны ёслолын (茶道) “Ваби цай” (侘び茶) хэмээх ойлголт бий болоход нөлөөгөө үзүүлж хурдацтай хөгжсөн байна.

“Sabi” (寂) нь “sabu” гэх хуучрах, элэгдэх, уусах, зэврэх гэсэн үйл үгийн нэршсэн хэлбэр юм. Эртний гоо сайхныг тодорхойлох зэвэрсэн, хуучирсан, уйтгар гунигтай байдлыг өөртөө агуулна. Дундад зууны үеэс “Ваби”-тай зэрэг хөгжиж гоо сайхны ойлголт хэмээн тооцогддог болжээ. Элэгдсэн, зэвэрсэн юм улам сайхан болж, байгаагаасаа илүү үзэсгэлэнтэй болж ирэхийг “Саби” гэнэ. “Саби” бол хүний сэтгэлийн гүнээс гарсан, цаг хугацаа өнгөрөх тусам элэгдэж

²¹ 松本明監修「大辞泉」小学館1995、p. 2856.

²² “Encyclopedia: Nipponica” 2011, p.822.

²³ <http://tarxi.blog.gogo.mn/read/entry235309>

буй оюун санааны хэлхээ ойлголт билээ.²⁴ Мөн байгалийн өнгө зүс хэрхэн өөрчлөгдөж байгаа байдал, хөгшрөлт, насжилт зэргийг илтгэдэг. Энэ гоо сайхны ойлголт нь японы яруу найраг тэр дундаа хайкү шүлэгт их хэрэглэгддэг байна. Ийнхүү, “Ваби Саби” нь төгс бус, түр зуурын, гүйцэд биш, энгийн, даруу юмсын гоо үзэсгэлэнг илтгэдэг байна. “Ваби Саби”-г дараах үгээр илэрхийлж болно: эгэл, сэтгэлд дотно, энгийн даруу, засварлаагүй, дутуу дулимаг, хөндөгдөөгүй, түр зуурын гэх мэт. Нэгэн судлаачийн тэмдэглэснээр “Ваби”, “Саби” бол эрээн бараан амьдралаас сайхныг нь олж харан, муу муухайг тэвчин хүлцэж, үхэх төрөхийн ертөнцөд байгалийн хуулийг даган уналт, сэргэлтийн аль алийг хүлээн авах ойлголт юм” гэсэн байна.²⁵ “Ваби”, “Саби” бол тайлагдах гэж тэвчээртэй хүлээж буй тайван амгалан, даруухан, нуугдмал гоо үзэсгэлэн. Сэтгэл татам боловч ил тод биш, урт хугацааны турш дэргэд байгаа, тайлж чадаагүй гоо үзэсгэлэн юм. Бидний өмнө ил байгаа хэрнээ гоо үзэсгэлэн нь дотроо байгаа оршихуй.

Дорно дахины яруу найргийн өвөрмөц нэг хэлбэр бол Японы хайкү билээ. Хайкү (俳句) бол Японы богино мөрт шүлгийн нэр бөгөөд 15-р зууны үед танка²⁶ шүлгийн (短歌) нэгэн хувилбар болон үүсэж, 16-р зууны дундуур бие даасан төрөл болжээ. Хайкү шүлэг нь өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой, гол төлөв таваас долоон үгээр бүтэх бөгөөд найман үгтэй байх нь ховор тохиолдоно. “Хайкүгийн гурван мөрийн үеийг тодорхойлоход 5-7-5 буюу эхний мөр 5 үетэй, хоёр дахь мөр 7 үетэй, гурав дахь мөр 5 үетэй байна. “Хайкү шүлгийн утга санааг ойлгохын тулд жилийн улирлын байдал, өнгө аястай холбож бодвол амархан ойлгогддог ажээ. Ер нь япон яруу найрагт шүлгийн бүтэц нь мөрийн жигд хэмнэл бөгөөд толгой буюу сүүл холбох шаардлага байдаггүй. Хайкү шүлгийг үүсгэн бүтээгч нь японы сонгодог яруу найрагч Мацүо Башё (松尾芭蕉) билээ. Башёгийн уран бүтээлд хайкү жинхэнэ бодит хэлбэр, шүлэглэх ёс гуримаа олсон байдаг. Японы яруу найргийн түүхэнд “Башёгийн сургууль” буюу өөрийн барилыг дагагч олон яруу найрагч төрүүлсэн энэ уран бүтээлч 1644-1694 оны хооронд амьдарч байжээ.”²⁷ Башё хайкү хэлбэрийн яруу найргийн мэргэжлийн багш байсан бөгөөд японы яруу найрагт хайкү хэлбэрийн шүлгийг цэцэглэлтийн дээд шатанд гаргаж чаджээ. Тийм учраас Мацүо Башё гэдэг нэр бараг япон яруу найраг гэсэнтэй адил ойлгогдох болж түүний “Хуучин цөөрөм” гэдэг хайкү гарсан цагаасаа эхлэн япон яруу найргийн “үлгэр жишээ шүлэг” болжээ. Өөрөөр хэлбэл хайкү шүлгийн ойлголтын суурь загвар болсон гэж үздэг.

Хайкү шүлгэнд дөрвөн улирал их чухал байр суурь эзэлдэг. Харамсалтай нь бид жилийн турш хамгийн дуртай улирлаа сонгож амьдарч болохгүй. Өвлийн хамгийн хүйтэн үе, зуны хамгийн халуун үеийн амьдрал тийм ч таатай биш. Гэхдээ жилийн дөрвөн улирлын өнгө аясыг өөртөө шингээсэн хайкү нь тэр

²⁴ “Encyclopedia: Nipponica” 2011. p.224.

²⁵ http://translationclub.blogspot.com/2013_11_01_archive.html

²⁶ “Танка” нь Японы яруу найргийн анхны хэлбэр. VII зууны үед бие даасан төрөл болсон. 5-7-5-7-7 үеэр бичигдэх 31 үе задгай шүлэг. Үгчлэн орчуулбал “Богино дуу” болно.

²⁷ “Дэлхийн шилдэг яруу найраг : Японы яруу найраг”, УБ., 2005, х.15

чигээрээ амьдралыг тусгасан байдаг. Гуравхан мөрөнд амьдрал шингэсэн байдаг нь хайкүгийн хамгийн гайхалтай шинж чанар гэж хэлж болно. Тиймээс улирлын үг хайкү шүлгэнд заавал байна. Түүнчлэн хайкү шүлгэнд агшин зуур гэнэтийн болж өнгөрсөн байгалийн үзэгдлийг хөгтэй, даажигнасан маягаар бичсэн байдаг бөгөөд үг дундуур нь заагтай, тасалсан хэлбэртэй байдаг байна.

Ингээд “Ваби”, “Саби”-гийн утга өнгө аясыг агуулсан зарим хайкү шүлэгт ажиглалт хийж үзье.

1. 樅の木の花にかまはぬ姿かな (Basho - 1685)

Kashino kino hanani kamawanu sugatakana

An oak tree –

A loof from flowers

Its figure looks. (орч: T.Saito & W.R.Nelson)²⁸

Интоорын цэцгийг ажих ч үгүй

Ихэмсэгхэн зогсох нь

Идэрмэг ганц нарс аж. (орос хэлнээс орчуулсан Ж.Лхагваа)²⁹

Энэ нь хаврын улирлыг илтгэсэн хайкү байна. Башё 1685 онд кимоно наймаалдаг чинээлэг, хайкү шүлэгч Мицүи Шүүфүүгийн (三井秋風) очихдоо энэхүү хайкүг бичжээ. Гэрт нь очиход баян тансаг амьдрах бус анир чимээгүй, амгалан байдалд дурлаж тайван амьдарч байгааг нь хараад нарс модны мөчиртэй зүйрлүүлж энэ шүлгээ бичжээ. Хаврын сайхан цэцэгс үзэмжээрээ хэний ч сэтгэлийг булаамаар байвч тэр дунд байгаа харлаж буй ганц нарсны мод тэр цэцэгсээс ч илүү сэтгэлд ойр дотно санагдана. Ямар ч гоо чимэг өөртөө зүүгээгүй мөртлөө энгийн хоосон байдал нь “Ваби” чанарыг агуулж байна. Олон сайхан цэцэгсийн дунд байхаар өөрөө ч гэсэн өөрчлөгдөөд гоё болох биш, үргэлж байсан байдлаараа одоо ч хүртэл байгаа, магадгүй он цагийн аясаар хуучирч хатаж байгаа нь “Саби” чанарыг илтгэж байгаа аж. Башё-д Мицүи баян хүний хувьд өөрийн хөрөнгө мөнгөөрөө илүү тансаг амьдралыг бий болгож болох байсан ч жирийн амьдралын хэв маягийг сонгосон нь гайхалтай санагдаж ийнхүү шүлэглэсэн болов уу.

2. 柳散り清水かれ石ところどころ (Buson - 1743)

Yanagichiri shimizu kare ishi tokorodokoro

The willow's bare

The stream's dry

Here and there, stones. (орч: T.Saito & W.R.Nelson)³⁰

Буграг булгарчээ

Горхи ширгэжээ,

Нүцгэн чулууд... (орос хэлнээс орчуулсан Г. Аюурзана)³¹

²⁸ Takafumi Saito, William R. Nelson “1020 Haiku in Translation: The Heart of Basho, Buson and Issa”, p.16.

²⁹ “Дэлхийн шилдэг яруу найраг : Японы яруу найраг”, УБ., 2005, х.32.

³⁰ Takafumi Saito, William R. Nelson “1020 Haiku in Translation: The Heart of Basho, Buson and Issa”, p.177.

³¹ “Дэлхийн шилдэг яруу найраг: Японы яруу найраг”, УБ., 2005, х.117.

Намрын улирлыг илтгэсэн хайкү. Бүсөн нь яруу найрагч Сайгёо (西行) - гийн жигтэйхэн шүлэглэж магтсан байдаг нэгэн горхины хөвөөн (遊行柳) дээр очтол тэнд байдаг мөнөөх алдарт уд мод нь ч нүцгэрч, “урсаж” байсан гол горхи нь ч ширгэж, чулуу нь энд тэнд ил харагдаж байжээ. Энэ бол уйтай намрын дүр төрхийг илэрхийлсэн шүлэг юм. Хорвоогийн жамаар юм ирж буцдаг байдлыг тодорхой харуулсан байна. Нэгэнтээ гоо сайхан цогц байсан зүйл тэр чигээрээ булгарч, хатаж, нүцгэрсэн байдал нь “Саби” чанарыг илтгэж байна. Харин шүлэг нь бүхэлдээ “Ваби” чанарыг агуулж байгаа талтай. Учир нь аливаа юм хорвоогийн жамаар уусч алга болсон ч эгэл даруу байдлыг хадгалж байгаа хэрнээ хөнгөн гунигт автуулж байгаа учраас тэр болов уу.

3. 落花とふ時の外には生きられず (Seishi - 1955)

Rakka tobu tokino sotonniwa ikirarezu

Blossoms in the air -

Unable to stay longer

and still escape time. (орч: T.Kodara & A.H.Marks)³²

Цэцэг хагдран унах нь хорвоогийн жам

Цэл залуу нас улиран одох нь хүний жам. (япон хэлнээс орчуулсан Б.Амаржаргал)

Хаврын улирлыг илтгэсэн хайкү. Сакүра цэцэг унаснаар агаарт дэлбээ нь нисэж байна. Тэр нисэх хөдөлгөөн нь цагийн аясаар хагдран унаж байгааг илэрхийлнэ. Энэ нь зөвхөн цэцэг ургамалд ч биш хүмүүн бидэнтэй холбоотой. Бид цаг хугацаанаас зугтаж чадахгүй. Япончуудын хайрлаж явдаг сакүра цэцэг бүтэн дэлгэрсэн байхдаа гоё ч тэдний хувьд унаж байгаа нь илүү сайхан санагддаг гэлтэй. Учир нь энэхүү гоо сайхныг харах байдал “Ваби”, “Саби” аль алинтай нь холбогдож, түрхэн зуурын амьтай зүйл салхинд туугдаж алга болж байгаа нь гоо үзэсгэлэнтэй санагддаг байна. Зохиогч ургамал цэцэг ч, хүмүүн бид ч өгөгдсөн цаг хугацаанд амьдарч цэцэглэж унаж байдаг бөгөөд энэ бүхэн үүрдийнх биш түрхэн зуурынх учраас илүү нандин санагдаж шүлэглэсэн болов уу.

4. 古池や蛙飛び込む水の音 (Basho - 1686)

Furuike ya kawazu tobikomu mizuno oto

An old pond –

A frog dives in

Water sound. (орч: T.Saito & W.R.Nelson)³³

Хуучин цөөрөм,

Мэлхий үсэрч

Ус цалгилаа (орч: А.Долин)³⁴

³² “The Essence of Modern Haiku: 300 Poems by Seishi Yamaguchi”, Mangajin, 1993, p.134.

³³ Takafumi Saito, William R. Nelson “1020 Haiku in Translation: The Heart of Basho, Buson and Issa”, p.18.

³⁴ Д.Мандах “Япон уран зохиолыг монгол хэлнээ орчуулсан туршлага, зарим шинэлэг асуудал”, УБ., 2010, х.103.

Намрын улирлыг илтгэсэн хайкү. Башёгийн энэ хайкү японы богино шүлэгт шинэ эрин үеийг нээсэн гэдэг. Яруу найрагч хавар цаг цөөрмийн дэргэд сууж байтал нам гүмийг эвдэн ус цалгих дуу дуулдаж мэлхий үсэрчээ. Энэ агшин зуурын юмыг Башё олж хараад шүлэглэсэн байна. “Хэрэв цочоох чимээ гарахгүй бол хязгаар эцэсгүй нам гүмийг хэн ч анзаарахгүй. Зэн-гийн үүднээс, нам гүм, чимээ анир хоёр хамтдаа ертөнцийг бүхэлд нь илтгэнэ. Нам гүм бол ахуйн аар саар хүсэл шуналаас нэгэнт ангижирсан дотоод сэтгэлийн бэлгэдэл. Гэвч тэр нам гүмийг танихад чимээ хэрэгтэй. Нөгөө талаас энэ хайкү-цаг хугацааны тухай эргэцүүлэл. Эртний цөөрөм бол үүрдийн, тийш үсэрсэн мэлхий бол зуурдын гэсэн санааг бэлгэдэж байна. Шүлэгт өнө мөнхийн болоод агшин зуурын мөн чанар нэг дор илэрхийлэгджээ. Гэхдээ мэлхий үсэрснийхээ дараа ахиад л нам гүм, ахиад л өнө мөнхийн чанарт яруу найрагч шургав. Тэр юунд ч автаж, хаашаа ч хэлбийлгүй, бүхнийг буй байгаагаар нь л харж өгүүлж байна”³⁵ гэж Г.Аюурзана тэмдэглэжээ. Ихэнх хайкү шүлгийн загвар шиг зохиогчийн дүрслэл нь байгалийн жижигхэн нэг хэсгийг аваад түүнийг дүрсэлсэн байдал нь цаанаа маш ихийг илтгэж байна. Хуучин цөөрөм нь жирийн нэгэн хуучин японы цэцэрлэгт байгаа цөөрөм байж болох ч биднийг хүрээлж буй өнө мөнхийн зүйлийг ч илэрхийлж байх магадлалтай. Мэлхийний гаргаж буй дуу чимээ амьдралаас үхэл рүү шилжиж буй агшиныг илэрхийлсэн байж болох юм. Үүнээс “хуучин цөөрөм” гэх энгийн нэгэн илүү дутуу чимэггүй газар гэдгээрээ “Ваби”, анир чимээгүйгээс чимээтэй, буцаад анир чимээгүйрүү шилжиж байгаа гэдэг утгаараа, мөн “хуучин цөөрөм” гэдгээрээ “Саби” чанарыг агуулж байна гэж ойлгож болох юм.

5. よしあしの日も行水や古暦 (Buson - 1768)

Yoshiashino himo yukimizu ya furugoyomi

Good days, bad days

Flow like water –

An old calendar. (орч: T.Saito & W.R.Nelson)³⁶

Уйтай дуутай өдрүүд

Урсах голын хамт өнгөрөн одоход

Хуучин хуанли л үлдэнэ. (япон хэлнээс орчуулсан Б.Сэлэнгэ)

Өвлийг илэрхийлсэн хайкү. Өдөр хоногууд өнгөрч, өнөөдөр хэлсэн хийсэн бүхэн өчигдөртэй хамт алга болно. Өнөөдөр орсон цас маргааш гэхэд хайлсан байна. Үүнд хуучрах, зэврэх гэсэн утгаар “Саби” чанар агуулагдаж байна. Мөн голын ус шиг түргэн хугацаанд урсан алга болдог өдөр хоногуудыг би зогсоож чадахгүй, надад үлдэх юм энэ хуанли л байна гэсэн бага зэргийн гунигийг илэрхийлж мөн хүлээн зөвшөөрч байгаа нь “Ваби” болох юм.

6. あかあかと日はつれなくも秋の風 (Basho - 1689)

Akaakato hiwa tsurenakumo akino kaze

³⁵ “Японы Утга Зохиолын Симпозиум”, х.62.

³⁶ Takafumi Saito, William R. Nelson “1020 Haiku in Translation: The Heart of Basho, Buson and Issa”, p.228.

Red and bright
The pitiless sun
And yet the autumn wind. (орч: T.Saito & W.R.Nelson)³⁷
Хурц улаан нар
Тодоос тод гэрэлтэвч, цаанаа л жихүүн
Намрын салхи (орос хэлнээс орчуулсан Г.Аюурзана)³⁸

Намрын тухай өгүүлсэн хайкү. Хятадын Тан улсын яруу найргийн аргаар бичигдсэн энэхүү шүлэг нь урт удаан халуун зун үргэлжилсний эцэст “одоо намрын улирал болчихоод байхад ямар ч өөрчлөлтгүйгээр халж” байгаа санааг өгүүлжээ. “Гэхдээ намар болсон гэсэн шиг намрын салхи үлээж хөнгөн гуниг төрүүлнэ.”³⁹ Энэ хайкү он цаг, улирлын өөрчлөлтийг өгүүлж байна. Намрын салхи сэтгэл гэгэлзүүлж жаахан уйтгар нэмэх ч түүний зэрэгцээ намрыг тэсэн ядан хүлээж буйг илтгэснээр “Ваби” , “Саби” чанарыг гаргаж байна гэж үзэж болох юм.

7. この道や行く人なしに秋のくれ (Basho - 1694)

Konomichiya ikuhito nashini akino kure
This road
No travelers pass along –
Autumn dusk. (орч: T.Saito & W.R.Nelson)⁴⁰
Зөрж өнгөрөх хүн үгүй
Уйтай намрын
Урт зам. (япон хэлнээс орчуулсан Б.Амаржаргал)

Намрын хайкү. Энэ шүлгийг зарим хүн “Надтай адил хайкү шүлгийн замыг дагах хүн байхгүй” гэсэн ганцаардлаасаа болж шаналж буй” гэж ойлгодог. Гэхдээ Башёгийн зохиосон шүлгээс “Ваби саби”-г олж харья гэвэл “ганцаардлаасаа болж шаналах” биш “ганцаараа байгаадаа баярлах” ч байж болох юм. Заавал “энэ зам” гэдэг хэсгийг “хайкүгийн зам”, “ганцаардал”-ыг “гунигтай” гэх мэт баригдмал байдлаар ойлгох нь учир дутагдалтай. Зохиолч “Хэн ч алга. Энэ сайхан байгаль дунд орж алсыг харна гэдэг юутай сайхан билээ!” гэж инээмсэглэнгээ алхаж байгаа нь төсөөлөгдөнө. Ганцаараа байна гэдэг муу хэрэг биш, харин ч ганцаараа байх нь тайвнаар байгаль дэлхийтэйгээ харьцаж, сэтгэлийн таашаал авах боломжийг нээж өгч байна. Угтаа энэхүү дотоод сэтгэлийн байдал нь “Ваби” , “Саби”-гийн мөн чанарыг илтгэж байгаа болов уу.

8. 屋根ひくき宿うれしさよ冬ごもり (Buson - 1769)

Yanehikuki yado ureshisa yo fuyugomori
With its low roof
Happy am I with this house –

³⁷ Takafumi Saito, William R. Nelson “1020 Haiku in Translation: The Heart of Basho, Buson and Issa”, p.151.

³⁸ “Дэлхийн шилдэг яруу найраг : Японы яруу найраг”, УБ., 2005, х.113.

³⁹ 「古典日本文学29: 松尾芭蕉集 上」筑摩書房、1976、p.192.

⁴⁰ Takafumi Saito, William R. Nelson “1020 Haiku in Translation: The Heart of Basho, Buson and Issa”, p.153.

Winter hibernation. (орч: T.Saito & W.R.Nelson)⁴¹

Хуучин муу намхан дээвэртэй ч

Хоргодох гэр минь байхад

Хүйтэн өвөл ч жаргалтай. (япон хэлнээс орчуулсан Б.Сэлэнгэ)

Өвлийг илтгэх хайкү. Зохиогч өөрийн муу намхан гэрийнхээ муудсаныг нь өгүүлж, хүйтнийг тэсвэрлэх аргагүйгээ дөвийлгөж бичиж болох байсан боловч харин ч эсрэгээрээ “байгаа нь их юм” гэсэн санааг гаргажээ. Хуучирч муудсан гэсэн санаагаараа “Саби”-гийн элемент байгаа бөгөөд тэх ядуухан амьдралдаа сэтгэл хангалуун байгаа утгаараа “Ваби”-г гаргажээ.

9. 枯れ枝に鳥のとまりけりや秋の暮 (Basho - 1680)

Kareedani karasuno tomarikeri akinokure

On a leafless branch

A crow –

Autumn dusk. (орч: T.Saito & W.R.Nelson)⁴²

Хоосон цулгуй мөчир дээр

Хон хэрээ суух нь

Намрын орой санж. (орос хэлнээс орчуулсан Ж.Лхагваа)⁴³

Намар. Зохиогч усан будгийн зургийн сэдвийг бодоод зохиожээ. Энэ хайкүг олон яруу найрагч, орчуулагчид “Хүний сэтгэлийн харанхуйлал, уйтгарт дүр төрхийг уран сайхны нарийн, өндөр дээд мэдрэмжээр илэрхийлсэн” гэж дүгнэсэн байдаг. Г.Аюурзана “...Энгийн бөгөөд гайхамшигтай. Илүү юу ч үгүй. Нүцгэн мөчир гэхийг бодоход намар нилээн орой байж. Орой, намрын үдэш. Нам гүм ганц агшин. Бараан мөчир, хар шувуу, үдэш бүхий л орчлон өнгөө алджээ. Байгалийн төрхөнд хүний сэтгэлийн хязгааргүй гүн гуниг шингэжээ. Хэрээ биш яруу найрагч ганцаардсан нь мэдэгдэнэ”⁴⁴ гэж тэмдэглэсэн байдаг. Бодит оршихуй талаас нь харвал навсгар хэрээ, цулгуй мөчир нь “Саби”-г илтгэж байгаа бол шүлэг тэр чигтээ ганцаардал, уйтгар гунигийг илэрхийлж байгаа нь “Ваби” чанарыг агуулж байна.

10. 老鹿の眼のただふくむ涙かな (Iida -)

Ojikano meno tadafukumu namidakana

Empty tears seen

in the eyes of

the old deer (орч: D.Jackson)⁴⁵

Цагтаа чи залуу явсан

Цагийн аясаар тэд ч бас хөгширнө

Хөгшин буга минь чи юунд уйлаам. (япон хэлнээс орчуулсан Б.Амаржаргал)

⁴¹ Takafumi Saito, William R. Nelson “1020 Haiku in Translation: The Heart of Basho, Buson and Issa”, p.225.

⁴² Takafumi Saito, William R. Nelson “1020 Haiku in Translation: The Heart of Basho, Buson and Issa”, p.136.

⁴³ “Японы утга зохиолын симпозиум: илтгэлийн эмхтгэл”, УБ., 2005, х.34.

⁴⁴ “Дэлхийн шилдэг яруу найраг III боть: Японы яруу найраг”, УБ., 2005, х.103.

⁴⁵ 「御詠えシリーズ第二集: 俳句の美」2010、p.24-25.

Намрыг илтгэсэн хайкү. Яруу найрагч намар нэгэн хөгшин бугыг олж хараад өөрийгөө харж буй мэт санагджээ. Тэр буга нь нүдэндээ нулимстай байсны дээр залуу бугатай нөхөрлөх гэж араас нь давхисаар байгаад хэт ядарчээ. Энэхүү бугыг хараад яруу найрагч бүхий л амьтай зүйлийн хувь тавиланг ойлгож ухаарчээ. “Ваби”, “Саби” чанар хүн амьтны хувь тавиланг ойлгосонд оршино. Нэг нь ирж нөгөө нь буцдаг хорвоод түрхэн зуур амьдрах юм даа гэсэн санааг өгүүлж байна.

11. 猿を聞く人捨子に秋の風いかに (Basho -)

Saruwo kiku hito sutegoni akino kaze ikani

Those who listen for the monkeys:

What of this child

in the autumn wind?⁴⁶ (орч: Barhill)

Хүүхдийн уйлах чимээ сонсогдоно...

Намрын жихүүн салхинд

Хаягдсан хүүхэд хөөрхий (япон хэлнээс орчуулсан Б.Амаржаргал)

Зохиогч Фүжи голын эргээр алхаж яваад хаягдсан өрөвдөлтэйгээр уйлж буй хүүхдийг олж харжээ. Эцэг эх нь хүнд хорвоогийн зовлонг дааж тэсэлгүй хүүхдээ хэсэгхэн зуур амьдраад өнгөрөх шүүдрийн дусал мэт амьдар гээд хөсөр хаясан нь энэ үү гэж бодоод эмзэглэжээ. Тэр хүүхэд өнө мөдгүй намрын салхинд туугдах гэж буй мэт харагдсан тул халааснаасаа идэх юм гаргаж ирээд энэ мөрүүдийг уянгалуулжээ. Яагаад ийм юм болсон юм бол? Эцэг нь хүүхдээ үзэн ядаж эсвэл эх нь үл ойшоосон явдал уу? Гэхдээ ингэж бодож болохгүй. Энэ бол зүгээр л тэнгэрээс заяасан хүүгийн хувь заяа биз ээ.

12. いかのぼりきのうの空の有り所 (Buson - 1769)

Ikanobori kinouno sorano aridokoro

A kite flies –

In the same place

As in yesterday's sky. (орч: T.Saito & W.R.Nelson)⁴⁷

Тэнгэрт хөөрөх цаасан шувуу

Тэр л байрандаа

Тэр нэгэн өдрийн тэнгэрийг санагдуулна (япон хэлнээс орчуулсан Б.Сэлэнгэ)

Өвлийн хайкү. Яг одоо нүдний өмнө цаасан шувуу хийсч байна. Хүйтэн жавартай өдрийн гэрэлд салхины аясаар гунигтайхан найгаж байна. Үүнийг хараад өчигдрийн тэнгэр санаанд оров. Гэтэл тэр өчигдрийн тэнгэр хаачив? Байхгүй юм бол одоо харж байгаа өнөөдрийн тэнгэр маргааш хаачих юм бол? Өчигдрийнх ч өнөөдрийн ч тэнгэр тэгээд тэрний дараагийн өдрийн тэнгэр хаачихыг ч бид мэдэхгүй. Гэхдээ одоо байгаа цаасан шувууг хөдөлгөх салхины

⁴⁶ <http://matsuobasho-wkd.blogspot.com/2012/07/kodomo-children.html>

⁴⁷ Takafumi Saito, William R. Nelson “1020 Haiku in Translation: The Heart of Basho, Buson and Issa”, p.40.

аясыг би мэдрээд өчигдөр ч өнөөдөр ч энэ газар дээр бат оршино гэсэн санааг илтгэж байна.

13. 寂として客の絶間のぼたん哉 (Buson - 1774)

Sekitoshite kyakuno taemano botankana

Calm and alone

In the intervals between visitors

A peony. (орч: T.Saito & W.R.Nelson)⁴⁸

Ирсэн зочид буцаж

Ганцаар суух зуур

Цээнэ цэцэг нүдэнд өртлөө. (япон хэлнээс орчуулсан Ж.Лхамаа)

“Зочид ирээд хөл хөдөлгөөн ихтэй байгаад явсны дараа арай л гэж нэг тайван болтол өнөөг хүртэл анзаарч харж байгаагүй цээнэ цэцгийг хараад гайхав” гэсэн шүлэг нь хүмүүний амьдралын баярт, гунигт аливаа үйл явдал болоод л өнгөрнө, тэр дунд тохиох зуурдын агшин амьдралын мөн чанарыг илтгэнэ хэмээх “Ваби”-гийн гоо сайхныг илэрхийлж байгаа болов уу .

14. 秋の哀わすれんとすれば初しぐれ (Buson - 1782)

Akino aware wasurento sureba hatsushigure

Autumnal sadness

Just about to forget as I was –

The first winter shower. (орч: T.Saito & W.R.Nelson)⁴⁹

Намрын хөнгөн гуниг цээж дүүрээд

Нэгэнтээ мартюу гэтэл

Нэг мэдэхнээ өвлийн бороо шивэрчих юм (япон хэлнээс орчуулсан

Б.Сэлэнгэ)

Намрын улирал яагаад ч юм уйтгар гунигийг өгүүлнэ. Өнгөрөн одох цаг хугацааны доторх үйл яг л усны шувууд улиран одохтой адил нэгэн гунигийг үлдээх шиг санагддаг. Намрын улирал өнгөрсөн бүхнээ дурсахад тохирсон цаг үе ч юм шиг. Энэ нь намрын улирлын гоо сайхан хүний сэтгэлд шингэж байгаа явдал юм. Гэтэл таатай ч юм шиг үгүй ч юм шиг энэ гунигаас ангижрах гэтэл энэ жилийн анхны бороо шивэрч, буцаад хөнгөн гунигт автчих юм гэсэн санааг өгүүлжээ. “Хацүшигүрэ” (初時雨) нь өвлийн улирлыг илтгэсэн үг бөгөөд тухайн жилд орох хамгийн анхны бороог илтгэнэ.

15. うらやましう美しうなりて散る紅葉 (Shikou-)

Urayamashiu utsukushiu narite chiru momiji

How enviable -

Turning beautiful then falling -

Maple leaves.⁵⁰ (орч: Timothy L. Kackowski)

Гоо үзэсгэлэнгийн дээдийг олоод

⁴⁸ Takafumi Saito, William R. Nelson “1020 Haiku in Translation: The Heart of Basho, Buson and Issa”, p.106.

⁴⁹ Takafumi Saito, William R. Nelson “1020 Haiku in Translation: The Heart of Basho, Buson and Issa”, p.230.

⁵⁰ [http://www.takase.com/Japanese Calligraphy/Haiku/H3021_Haiku_by_Shiko.htm](http://www.takase.com/Japanese%20Calligraphy/Haiku/H3021_Haiku_by_Shiko.htm)

Гонсойх ч юмгүй унаад өгдөг
Агч модны навчинд атаархана би.⁵¹ (орос хэлнээс орчуулсан Ж.Лхагваа)
Чамд би юутай атаархана вэ
Гоо сайхны оргилд хүрээд
Унах юм, чи, навч минь!⁵² (орос хэлнээс орчуулсан Г.Аюурзана)

Байгалийн жамаараа ирээд буцдаг энэ навч ямар ч харамсах зүйлгүйгээр унаад өгөх нь улам түүнийг үзэсгэлэнтэй болгож байна. Навч цэцэглэж байхдаа сайхан. Үнэхээр гоо үзэсгэлэнгээ хүмүүст гайхуулаад мэдүүлснээс цааш дахиж ургах юм хойно гомдох зүйл үгүй. Юмны оргилд хүрсэн байхад дараа нь яасан ч гэсэн хамаагүй. Тэрхүү сайн сайхныг мэдэрсэн хүн буцаад унахад ямар ч алдах юмгүй. Өөрөөр хэлбэл гоо сайхны дээд оргилд хүрчихээд хорвоог орхих нь яруу найрагчийн туйлын зорилго. Магадгүй, тэр оргилд хүрсэн хүн амьдрах шаардлагагүй болдог биз ээ.

16. 学問のさびしさに堪へ炭をつぐ (Yamaguchi – 1924)

Gakumonno sabishisani tae sumiwo tsugu
Bearing up under
the loneliness of study,
I add fresh charcoal.⁵³ (T.Kodaira & A.H.Marks)
Эрдэм номын гунигт автан
Тэвчээр алдан
Галлахаар өндийв. (япон хэлнээс орчуулсан Б.Амаржаргал)

Зохиогч Токиогийн их сургуульд хууль сурдаг байсан бөгөөд нэгэн түрээсийн байранд суудаг байлаа. Хууль сурах нь яагаад ийм их ганцаардах сэтгэлийг төрүүлнэм бэ. Гэхдээ ингээд байж болохгүй, зорилгодоо хүрэхийн тулд юуг ч тэвчиж даван гарах хэрэгтэй. Тиймээс зохиогч босоод галдаа нүүрс хийж дулаацав. Энэхүү шүлэгт хүний амьдралын бэрхшээл зүдгүүр нь аз жаргал мөн хэмээх “Ваби”-гийн утгыг илтгэж буй санагдана.

17. 春立つや新年ふるき米五升 (Basho – 1648)

Haru tatsu ya shinnen furuki kome goshoo
The beginning of spring
For the new year,
Five sho of rice from last year. (орч: R.H.Blyth)
Хавар бүх дэлхийг өөрчлөв
Хуучин юмнаас үлдсэн нь гэвэл
Таван дү будаа л байв. (орос хэлнээс орчуулсан Ж.Лхагваа)

Ядуу ч гэсэн хуучин оноос үлдсэн таван дү будаагаараа шинэ оныг угтаж байгаа нь нэг талаараа аз завшаан юм гэсэн санааг илтгэжээ. Ядуу зүдүү амьдралаас үүдэх гуниг, бага ч гэсэн байгаа зүйлдээ сэтгэл хангалуун байх баяр нэгэн зэрэг мэдрэгдэж буйгаараа “Ваби”, “Саби”-гийн утга агуулагдаж байна.

⁵¹ “Дэлхийн шилдэг яруу найраг : Японы яруу найраг”, УБ., 2005, х.40.

⁵² “Дэлхийн шилдэг яруу найраг : Японы яруу найраг”, УБ., 2005, х. 115.

⁵³ “The Essence of Modern Haiku: 300 Poems by Seishi Yamaguchi” Mangajin, 1993, p.1.

18. 風に散り風吹きたえて落花哉 (Buson - 1776)

Kazeni chiri kaze fuki taete rakkakana

Scattering in the wind

Even when the wind dies

Falling cherry petals. (орч: T.Saito & W.R.Nelson)⁵⁴

Сэвэлзэх салхины аясаар

Сэм сэмхэн унах интоорын цэцэгс

Салхи намдсаныг ч үл тоон чимээгүйхэн унасаар (япон хэлнээс орчуулсан Б.Сэлэнгэ)

Салхи сэвэлзсэнээр сакүра газарт унана. Харин салхи байхгүй болсон ч сакүра анир чимээгүй унасан хэвээрээ. Энэ бол байгалийн жамыг харуулсан хайкү юм. Гадны нөлөө байхгүй ч цаг нь болсон бол унах нь ойлгомжтой. Тэр утгаараа “түр зуурын” чанарыг агуулж “Ваби”, “Саби”-г илтгэж байна.

19. 牡丹散て打かさなりぬ二三片 (Buson - 1769)

Botan chirite uchikasanarinu nisanben

Peony petals

A few fallen –

One on another. (орч: T.Saito & W.R.Nelson)⁵⁵

Сарсайтал цэцэглэсэн цээнэ цэцгийн дэлбээ

Хэд хэдээрээ унан

Хоёр гурваараа давхаралдан бууна. (япон хэлнээс орчуулсан Ж.Лхамаа)

Саяхан сүртэй цэцэглэж байсан цээнэ цэцэг гэнэт нурж унаж буй мэт хоёр гурваараа доош уналаа. Аливаа юмны амь ямар богино байдгийг гайхаж бичсэн байж болох юм. Мөн цээнэ цэцэглэхдээ ч, унахдаа ч үнэхээр үзэсгэлэнтэй гэдгийг биширсэнээрээ “Ваби” чанарыг илтгэж байгаа болов уу.

20. おもしろうてやがて悲しき鵜舟かな (Basho - 1688)

Omoshiroute yagate kanashiki ubunekana

Amused for a while

Then sad –

Cormorant boats. (орч: T.Saito & W.R.Nelson)⁵⁶

Өвөгт хар галуугаар загас бариулахад

Хэсэгтээ л сэтгэл хангалуун байх авч

Удалгүй уйтгар гунигт автах юм. (япон хэлнээс орчуулсан Ж.Лхамаа)

Саргүй шөнө өвөгт галуугаар загас бариулах нь үнэхээр хөгжилтэй, сонирхолтой ажил боловч дууссаны дараа эрэгтээ эргээд ирэхэд юу гэмээр ч юм нэгэн гуниг төрнө. Магадгүй тэр нь барьсан загасныхаа хувь тавиланг бодоод гэмтэй санагдсандаа байж болох, эсвэл хөгжилтэй байсан ажил удаан үргэлжилсэнгүй гэх бодлоос болсон ч байж магадгүй юм. Үнэхээр үзэсгэлэнтэй.

⁵⁴ Takafumi Saito, William R. Nelson “1020 Haiku in Translation: The Heart of Basho, Buson and Issa”, p.49.

⁵⁵ Takafumi Saito, William R. Nelson “1020 Haiku in Translation: The Heart of Basho, Buson and Issa”, p.106.

⁵⁶ Takafumi Saito, William R. Nelson “1020 Haiku in Translation: The Heart of Basho, Buson and Issa”, p.75.

Гэхдээ гунигтай, тэр нь нулимс гарах хэмжээний гуниг биш боловч ямартай ч гуниг мөн. Хүний сэтгэл гэдэг их сонин. Нэг баярлаж байснаа гэнэт гуниглана. Саяхан цэцэглэж хөгжиж байсан юм нэг мэдэхэд алга болсон байдаг. Сэтгэл нэг л хоосон мэдрэмж төрж байгаа нь “Ваби”, “Саби” чанар болж байна.

21. 雄鯨の愛の泪や星あかり

Okujirano aino namida ya hoshiakari

A crying bull whale

Tears of love

in the starlight (D.Jackson) ⁵⁷

Үгүй дээ би тэсэхгүй нь

Үгүйлсэн сэтгэлээ нууж чадахгүй нь

Сарны гэрэл доорх миний нулимсыг

Сайхан чи минь харж байгаа болов уу? (япон хэлнээс орчуулсан Б.Амаржаргал)

Зохиогчийн санаанд од түгсэн шөнийн тэнгэр доор уйлж буй халимны нулимс нэгнээ үгүйлсэн хайрын нулимс гэж буусан байна. Уйтгар гуниг сэтгэлийг тэр чигээр нь бүрхэж байна. Магадгүй тэр нулимс нь зохиогчийн өөрийн нулимс ч байж болох юм.

22. 父母のしきりに恋し雉の声 (Basho - 1688)

Chichihahano shikirini koishi kijino koe

For my father, mother

How I pine -

A pheasant's call. (орч: T.Saito & W.R.Nelson) ⁵⁸

Гургуулийн өнчин дуу

Гуниг зүрхэнд шивнэж

Аав л ижийг минь бодогдуулав. (орос хэлнээс орчуулсан Ж.Лхагваа)

Хавар. Анир чимээгүй модны дунд байсан Башё уйлах гургуулийн дууг сонсоод аав ээжийгээ дурссан ажээ.

23. 虹立つも消ゆるも音を立てずして

Niji tatsumo kiyurumo otowo tatezushite

The rainbow comes

And then the colors disappear

Not making a sound (D.Jackson) ⁵⁹

Солонго чи гарахдаа чимээгүй ирдэг ч

Баяр баяслыг бидэнд авчирдаг

Харин алга болохдоо чи

Уйтгар гунигийг бидэнд үлдээдэг (япон хэлнээс орчуулсан Б.Амаржаргал)

Зохиогч солонго татан, арилж буй байдлыг хараад энэхүү хайкүг бичжээ. Солонго ямар ч чимээ аниргүйгээр ирээд буцдаг. Гэхдээ юу ч хэлээгүй мөртлөө

⁵⁷ 「御詠えシリーズ第二集：俳句の美」2010、p.30-31.

⁵⁸ Takafumi Saito, William R. Nelson “1020 Haiku in Translation: The Heart of Basho, Buson and Issa”, p.6.

⁵⁹ 「御詠えシリーズ第二集：俳句の美」2010、p.54-55.

үзэмжит гоо сайхнаа харуулахдаа биднийг маш их баярлуулдаг ч явахдаа бас юу ч хэлэхгүйгээр одож биднийг гуниглуулна. Гоо сайхан зүйл чимээ аниргүй байдлаар илрэхдээ хамгийн сайхан байж магадгүй юм гэдэг нь угтаа “Ваби” юм болов уу.

24. 雪の朝独り干鮭を噛み得たり (Basho - 1680)

Yukino asa hitori karazakewo kami-etari

A snowy morning

All I've got is dried salmon

To chew all alone⁶⁰ (Sharon Hahn Darlin)

The morning of snow,

I find myself chewing alone

Strips of dried salmon. (Yuasa)

The snowy morning -

Being alone, I am happy

Eating dry salmon (Peipei Qui)

Цас будрах нэгэн өглөө

Ганцаараа би загас иднэ

Аяа, юутай сайхан

Цас будрах нэгэн өглөө

Ганцаараа би загас иднэ

Аяа, юутай гаслантай (япон хэлнээс орчуулсан Б.Амаржаргал)

Энэ шүлэгт ямар нэгэн тодорхой тайлбаргүйгээр энгийн хоёр үзэгдлийг оруулсан нь шүлгийг улам учир битүүлэг, сонирхолтой болгож байна. Зохиогчийн санааг ямар ч байдлаар ойлгож болох юм. Тэрээр цас орж байгаа учраас гадагшаа гарч найзуудтайгаа уулзаж чадахгүй, гэртээ ганцаараа хатсан загас идэхээс өөр аргагүй байгааг хэлж байгаа эсвэл цас орсноор гэртээ ганцаараа тайван хоолоо идэх боломжтой болсноо хэлж байж ч мэдэх юм. Зүгээр л өглөөний хоолоо идэнгээ цонхоор цас унахыг хараад юм зажилж чадаж байгаадаа баярлаж байгаа байж бас болох юм. Тиймээс орчуулагчид олон янзаар орчуулсан байгааг дээрхээс харж болно. Мөн шүлэгт буусан дүрслэлүүд энгийн бөгөөд нийтлэг чанартай байгаагаараа “Ваби”-г агуулж байна гэж үзэж болох юм. Түүнчлэн “ганцаараа” гэдэг үг нь энгийн дүр зургийг ойлгуулахад чухал үүрэг гүйцэтгэх тул шүлгийн амин сүнс болно. Энэ үг дүрслэлийг улам өнгөлж “Саби”-гийн элемент болж байна.

25. わが歩む落葉の音のあるばかり (Sugita -)

Waga ayumu ochibano otono arubakari

The only sound

The crush of fallen leaves

As I walk⁶¹ (D.Jackson)

⁶⁰ <http://washokufood.blogspot.jp/2008/04/basho-issa.html>

⁶¹ 「御詠えシリーズ第二集：俳句の美」2010, p.72.

Алхаад би явж байлаа

Аяархан гэгч нь чимээ дуугарлаа

Гайхан чих тавин сонстол

Газарт хэвтэх навчсын чимээ байлаа. (япон хэлнээс орчуулсан Б.Амаржаргал)

Өвөл. Зохиогч ойд ганцаараа гүн бодолд автан алхаж байтал нэг юм анзаарав. Гарч байгаа чимээ зөвхөн газарт унасан навчны дуу байлаа. Энэ нь зохиогчийн ганцаардлыг улам нэмсэн бололтой. Энэхүү нам гүм, гунигтай байдал нь “Ваби”, “Саби”-г илтгэх аж.

26. 椎の花人もすさめぬ匂かな (Buson - 1776)

Shiino hana hitomo susamenu nioikana

Pasania flowers –

Their smell

Not loved by people. (орч: T.Saito & W.R.Nelson)⁶²

Ший модны цэцэгс

Ойр тойрон үнэр түгээх авч

Хүмүүс төдийлөн дургүй. (япон хэлнээс орчуулсан Ж.Лхамаа)

Ший модны цэцэгсийн зовлон. Олноороо ургаж үнэрээ түгээдэг боловч хүмүүс үнэрт нь тийм ч дуртай биш. Хэт хурц үнэртэй, өнгө зүсээрээ ч хүний нүдэнд төдийлөн өртөөд байдаггүй. Энэ бол магадгүй байгалиасаа заяасан тавилан ч юм уу нуугдмал гоо үзэсгэлэн ч байж болох юм.

27. ふられたる其夜かしこし川千鳥 (Buson - 1768)

Furaretaru sonoyo kashikoshi kawachidori

Jilted I was –

That night so properly plaintive

The river plovers. (орч: T.Saito & W.R.Nelson)⁶³

Бүтээгүй дурлалдаа гансарч

Битүү гунигт автсан шөнө

Бүүвэйн дуу аялах мэт усны шаазгай (япон хэлнээс орчуулсан Б.Сэлэнгэ)

Хэт их гунигт автаж хорвоо ертөнцийг үзэн ядаж байх үед усны шаазгай дуугарч сэтгэлийг бага ч болов уу тайвшруулав. Бас л байгальтайгаа харьцаж тайтгарал авч буй санаа юм. Дэндүү их гунигт автсан ч амьдрал үргэлжилж байгаа, нэг юмыг алдсан ч нөгөөг нь олж авдаг тийм л хорвоо. Тиймээс алдсан юмандаа харамсахгүйгээр урагш нэг алхам алхаж ирээдүй рүү тэмүүл гэсэн санааг агуулж байгаа болов уу.

28. 悲しさや釣の糸ふく 秋の風 (Buson - 1773)

Kanashisa ya tsurino ito fuku akino kaze

Ah, grief and sadness !

The fishing-line trembles

⁶² Takafumi Saito, William R. Nelson “1020 Haiku in Translation: The Heart of Basho, Buson and Issa”, p.107.

⁶³ Takafumi Saito, William R. Nelson “1020 Haiku in Translation: The Heart of Basho, Buson and Issa”, p.228.

In the autumn breeze. (Орч: Blyth)

Уйтай намрын салхинд

Чичрэх уурганы утас

Гэгэлзэх миний сэтгэл (япон хэлнээс орчуулсан Б.Амаржаргал)

Энэ шүлэгт зохиогч өөрөө гунигтай байна гэхээсээ илүү намрын салхинд хөдөлж буй уурганы утсыг харах нь гунигтай байна гэх санааг агуулж байна. Нутгаасаа гараад хэдэн арван жил өөрийн төрсөн нутаг, аав ээжийн талаар бичээгүй, яриагүй. Гэвч хөгширсөн тэрээр нутагтаа зориулсан ганцаардал, сэтгэлийнхээ хөдлөлийг ийнхүү өгүүлсэн ажээ.

29. ひごろ憎き鳥も雪の朝哉 (Basho - 1690)

Higoro nikuki karasumo yukino asakana

Ordinarily detested

Are the crows

But on a snowy morning -. (орч: T.Saito & W.R.Nelson)⁶⁴

Өвлийн өглөө анхны цасан дээр

Өөдгүй хэрээ ч

Өнгө засчээ (орос хэлнээс орчуулсан Ж.Лхагваа)

Цастай өглөө бүх юм цоо шинэ, цэвэр тунгалаг мэт санагдаж ямагт таагүй сэтгэгдэл төрүүлж байдаг хэрээ ч гэсэн энэ өглөө давгүй харагдаж байна гэсэн санааг агуулжээ. Энэ нь бид аливаа юмыг дандаа нэг талаас, туйлширсан бодлоор хардгийг илэрхийлж байгаа болов уу. Зөвхөн нэг талаас хараад байлгүй сайн муу аль алиныг нь харж ойлгох хэрэгтэй. Тиймээс ч энд үргэлж зэвүүн харагддаг байсан хэрээний сайхныг нь олж харсан тул “Ваби”, “Саби” -гийн элемент оршиж байгаа болов уу.

30. 鶯の鳴とばかりにつぎ穂哉 (Issa -1808)

Uguisuno naku to bakarini tsugiho kana

Just hearing a nightingale

Is enough...

Grafting a branch (орч: David Lanoue)

Аяа, юутай их чимээ вэ

Алтан гургалдайн дуугарах дуу

Шаржигнан сонсогдох мөчрүүд (япон хэлнээс орчуулсан Б.Амаржаргал)

Исса алтан гургалдайн дууг сонсох төдийд модонд мөчир залгаж суулгах зэрэг хаврын бэлтгэл ажилдаа орох эрч хүчийг олж авсан байна. Хүн байгальтайгаа дотно байж, нэг нэгэндээ дэм болж буй санааг агуулж байна. Хэрэв бид байгальтайгаа илүү дотно байсан бол эд баялагаас илүүтэйгээр сэтгэлийн таашаалыг бие биенээсээ ийнхүү олж мэдрэх биз ээ.

⁶⁴ Takafumi Saito, William R. Nelson “1020 Haiku in Translation: The Heart of Basho, Buson and Issa”, p.203.

31. 朝顔は下手の書くさへあはれなり (Basho - 1687)

Asagao wa hetano kaku sae aware nari

Morning glory:

Even when painted poorly,

It has pathos (Tr. Barnhill)

Even when painted poorly

The morning glory

Is touching . . . (paraverse by Elaine Andre)

Хэдий тааруухан зурагдсан ч

Ангирын хөл цэцэг (ипомея)

Юутай сэтгэл татам бэ (япон хэлнээс орчуулсан Б.Амаржаргал)

Башё өөрийн шавь болох Рансэцү-гийн зурсан зургийг шүүмжилж бичсэн шүлэг. Багш шавь хоёрын хооронд нууцлах, нэрэлхэх зүйл байхгүй гэсэн санааг гаргасан шүлэг юм. Ангирын хөл цэцгийг зуръя гэвэл хэн ч дажгүй зурж чадна. Тааруу хүний зурсан зураг санаанд оромгүй байдлаар сайхан харагддаг тал бий. Хүүхдийн зурагт юу хамгийн их сэтгэл татдаг вэ гэхээр сэтгэл нь маш их шингэсэн байдаг болохоор тэр юм. Зураад сурчихсан мэргэжлийн хүнд чадвар, техник нь байсан ч сэтгэл байхгүй болохоор ямар хэрэг байна гэсэн санааг өгүүлсэн юм болов уу.

32. 紅葉してそれも散行桜かな (Buson - ?)

Momijishite soremo chiriyuku sakurakana

Turning red

Its leaves also scatter –

A cherry tree.⁶⁵

Улаанаар туяарч

Удаанаар унах юм навчис нь

Улаан сакүра (япон хэлнээс орчуулсан Б.Сэлэнгэ)

Сакүрагийн мод бусад модтой харьцуулбал арай хурдан шарлаж намар ирснийг дуулгадаг. Улайж шарлаад гуниг төрүүлдэг мод хавар ирэхээр дахин цэцэглэж өнгөндөө орох юм. Хүний амьдралд ч мөн адил уруудах үе нэг бий, бас цэцэглэж дээш гарах нэгэн үе бий. Энэ шүлгэнд тэр аяараа “Ваби”, “Саби” шингэжээ.

33. 白梅に明くる夜ばかりとなりけり (Buson -)

Shira-umeni akuru yo bakari to narini keri

It is now the moment

When white plum blossoms

Lighten into dawn (орч: Crowley)

Шөнийг гэрэлтүүлэх

Цагаан үмэ (лис) цэцэглэх цаг

Хаяанд ирлээ (япон хэлнээс орчуулсан Б.Амаржаргал)

⁶⁵ Takafumi Saito, William R. Nelson “1020 Haiku in Translation: The Heart of Basho, Buson and Issa”, p.184.

Хавар цаг. Яруу найрагч Бүсөний сүүлчийн шүлэг. 12-р сар болж байсан ч яруу найрагчийн сэтгэл аль хэдийнээ хавар луу чиглэсэн байлаа. Өвөл дуусч цагаан лис цэцэглэж эхэлж байгаа нь харанхуй шөнийг гэрэлтүүлнэ. Хаашаа ч харсан лис цэцэг. Орой л болчихвол цэцэг гэрэлтэх гээд байна. Өөр юм үлдсэнгүй. Энэ шүлэгт улиран одсоны уйтгар гуниг, ирээдүйн гэрэл гэгээрүү тэмүүлсэн итгэл найдварын аль аль нь шингэжээ.

34. うきわれをさびしがらせよ 閑古鳥 (Basho - 1691)

Ukiwarewo sabishigaraseyo kankodori

Melancholic I am –

Deepen this solitude

Cuckoo bird. (орч: T.Saito & W.R.Nelson)⁶⁶

Хөхөө шувуу чи

Энэ урвуу дорой намайг

Жаахан ч гэсэн ганцаардуулаач. (япон хэлнээс орчуулсан Ж.Лхамаа)

Зун. Ганцаардлыг хүсэмжилсэн хайкү. “Хөхөө шувуу минь, энэ гунигт дуугаараа хорвоо ертөнцөд цөхрөн ганцаардаж буй намайг гунигт автуулаач. Би тэр гунигийн дотор шингэмээр байна” гэсэн санааг гаргаж байгаа болов уу. Би нэгэнтээ ганцаардаж байна, гэхдээ би амар амгалан баймаар байна гэж хүсэж байгаа бололтой.

35. 閑かさや岩にしみ入蟬の声 (Basho - 1689)

Shizukasa ya iwani shimiiru semino koe

Stillness –

Into the rocks

Sinks the voice of cicadas. (орч: T.Saito & W.R.Nelson)⁶⁷

Чив чимээгүйн дунд сонсогдох

Хүрэлзгэний дуу

Хаданд шингэнэ. (япон хэлнээс орчуулсан Ж.Лхамаа)

“Сэми” (蟬) гэгч хорхой нь зуны үед үүрнээсээ гарч чангаар дуугардаг. Халуун байх тусам дуу нь чангардаг этгээд амьтан юм. Гадаад хүний чихэнд таагүй, ядаргаатай сонсогдож болох ч япон хүний хувьд их таатай, сэтгэлд дотно мэдрэмж төрүүлдэг байна. Хэрвээ энэ амьтан байхгүй бол зун болсон юм шиг мэдрэмж огт төрдөггүй гэлтэй. Чив чимээгүй байсан чинь гэнэт сэми-гийн дуу гарлаа. Тэр дуу нь хаданд шингэж мөнөөх анир чимээгүй байдал эргэж ирлээ гэсэн санааг илэрхийлэх гэсэн болов уу.

36. 古巣ただあはれなるべき隣かな (Basho - 1686)

Furusu tada aware naru beki tonari kana

The old nest

Will be so very lonely without

⁶⁶ Takafumi Saito, William R. Nelson “1020 Haiku in Translation: The Heart of Basho, Buson and Issa”, p.81.

⁶⁷ Takafumi Saito, William R. Nelson “1020 Haiku in Translation: The Heart of Basho, Buson and Issa”, p.84.

My neighbour⁶⁸ (орч: Gabi Greve)

Алсын замд гарсан хөршөө

Хөгшин миний бие

Ямар их санагалзана вэ (япон хэлнээс орчуулсан Б.Амаржаргал)

Зохиогчийн дотно хөрш болох Сооха (宗波) Киото хот руу шашин мөргөлийн аялалд явжээ. Башё амьдралын мөрөө хөөн одсон бяцхан үр нь үүрээ орхин явж өөрөө ээж шувуу нь юм шиг санагдаж үүнийг зориулж бичжээ. Байгаа үед нь үнэ цэнийг нь сайн мэдрэхгүй байсан ч явахаар нь ямар их хань болж байсныг нь ухаарсан хэрэг буй за.

37. ふた葉三葉ちりて日くる紅葉かな (Buson - 1782)

Futaba miba chirite hikururu momijikana

Leaves, two or three, fall

Then sunset –

A crimson maple tree. (орч: T.Saito & W.R.Nelson)⁶⁹

Навчис унана, нэг хоёроороо

Нар жаргана, намрын орой

Нилдээ улааран харагдана агч мод (япон хэлнээс орчуулсан Б.Сэлэнгэ)

Агч модны гоо үзэсгэлэн хүний сэтгэлд шингэн орж сэтгэл зүрхийг эмзэглүүлдэг. Өөрөөр хэлбэл улайж шарласан навчисны сайхан нь хаа нэгтээ үргэлж гунигийг мэдрүүлдэг. Нов ногоон байсан мод намар болоход улайж сайхан ч тун удахгүй хоосон мөчир болно гэж бодохоор хөнгөн гуниг төрнө. Гэхдээ түүнийг улам гоё, нандин болгож байгаа нь түрхэн зуур орших чанарт нь байгаа ажээ.

38. 昼顔に米搗き涼むあはれなり (Basho -1681)

Hirugaoni kometsuki suzumu aware nari

By the noonflower

A rice-pounder cools himself:

A sight so moving⁷⁰ (Орч: Barnhill)

Алтан агийн үзэсгэлэнг

Бишрэн суух

Будаа цайруулагч хүн (япон хэлнээс орчуулсан Б.Амаржаргал)

Будаа цайруулагч өдөржингөө ажиллаад их ядарчээ. Тэгээд амсхийхээр сүүдэрт суугаад духныхаа хөлсийг арчиж байлаа. Хашааны хажуугаар нарны халууныг үл тоон ургасан цэцгийг эрэгтэй ч сайн анзаараагүй, цэцэг ч түүнийг огт анзаараагүй байв. Гэхдээ тэр цэцэг яагаад ч юм будаа цайруулагч эрийн сэтгэлийг татаж, цэцгийн зүг ширтэж хараагаа салгаж чадахгүй болжээ.

⁶⁸ <http://wkdhaikutopics.blogspot.com/2007/08/loneliness-sabishisa.html>

⁶⁹ Takafumi Saito, William R. Nelson “1020 Haiku in Translation: The Heart of Basho, Buson and Issa”, p.183.

⁷⁰ <http://matsuobasho-wkd.blogspot.com/2012/06/aware.html>

39. 花ちるや末代無智の凡夫衆 (Issa - 1819)

Hana chiru ya matsudai muchino bonpushuu

Cherry blossoms scatter--

The ignorant masses

Of these latter days⁷¹ (орч: David Lanoue)

Цэцэгс хагдрах мөчийг

Ухамсарлаж ойлгохгүй

Хүмүүс (япон хэлнээс орчуулсан Б.Амаржаргал)

Ургаад дэлгэрсэн байхдаа гоо үзэсгэлэнгийн дээд байдаг сакүра цэцгийн хагдран унахын гоо сайхныг хүмүүс мэддэггүй. Одоогийн нийгэмд Сакүра цэцэг ч мөн түр хугацааны зүйл. Юу ч түүнийг өөрчилж чадахгүй. Эд хөрөнгө, зугаа цэнгэл ч бас үүрдийн бус зуурдын зүйл мөн. Бид ирэхдээ юу ч авчраагүй бол буцахдаа бас юуг ч авч явахгүй.

40. 世の人の見付ぬ花や軒の栗 (Basho - 1689)

Yono hitono mitsukenu hanaya nokino kuri

Rarely noticed –

Chestnuts in bloom

Beside the eaves. (орч: T.Saito & W.R.Nelson)⁷²

Саравчин доорх

Туулайн бөөр цэцгийг

Хүмүүс хаа нэг анзаарна. (япон хэлнээс орчуулсан Ж.Лхамаа)

Туулайн бөөр цэцэг газарт байхдаа төдийлөн анхаарал татдаггүй. Хүмүүс ч түүнийг тогтож тоож хардаггүй. Модны сүүдэрт нуугдаж буй энэхүү даруухан цэцгийг хажуудаа байлгаж усалж, хайрлаж буй гэрийн эзний нийгмээс тусгаарлагдсан, тайван уужуу байдлыг өгүүлсэн хайкү юм. Нүдэнд тод үзэгдэх зүйл биш бараг харагдахгүй, анзаарагдаагүй юмны гоо сайхныг олж харж байгаа нь үүнээс харагдаж байна.

41. 花みな枯れてあはれをこぼす草の種 (Basho -)

Hana mina karete awarewo kobosu kusano tane

Flowers all withered,

Spilling their sadness:

Seeds for grass (орч: Barnhill)⁷³

Цэцэгс хагдарч

Хатсан навчис нь газарт унана

Аяа, юутай гаслантай (япон хэлнээс орчуулсан Б.Амаржаргал)

Өвлийн улирал ирснээр цэцэгт хүрээлэнгийн сайхан цэцэгс бүгд хагдарч байна. Унаж буй цэцгийнх нь үрийг харвал мөнөөх гайхалтай цэцэг байсан төрх

⁷¹ <http://haikuguy.com/issa/haiku.php?code=216.10a>

⁷² Takafumi Saito, William R. Nelson “1020 Haiku in Translation: The Heart of Basho, Buson and Issa”, p.83.

⁷³ <http://matsuobasho-wkd.blogspot.com/2012/06/aware.html>

нь санагдаж, удахгүй дахиад тийм цэцэг болно гэдэг нь бодогдож сэтгэл гэгэлзэнэ. Одоо байгаа төрх нь дэндүү гунигтай ч цаг хугацаа өнгөрөхөөр буцаад нөгөө гоо үзэсгэлэнгээ олж авна. Энд бас сэтгэлийн тэнхээ, найдвар, хүсэл шингэсэн байна.

42. 限りある命のひまや秋の暮れ (Buson - 1782)

Kagiriaru inochino himaya akino kure

A while of

My limited life –

The autumn sunset. (орч: T.Saito & W.R.Nelson)⁷⁴

Амьдрал мөнх бус

Амсхийх энэхэн зуур

Аажуухнаар шингэх намрын нар (япон хэлнээс орчуулсан Б.Сэлэнгэ)

Завгүй явж явж нэг түр амсхийе гэтэл намрын нар шингэчих юм. Намрын нар гарч ирсэн ч буцаад шингэнэ. Хүн төрөөд үхнэ. Тэр бол хүн хүний мэддэг зүйл. Завгүй ажиллаж, завгүй зугаацаж, завгүй амьдарсаар нэг түр амрая гэтэл “нар шингэчих” тийм богино амьдрал. Энэ ч утгаараа “Ваби”, “Саби” -г агуулж байна.

43. さびしさのうれしくも有秋の暮れ (Buson - 1776)

Sabishisano ureshikumo ari akino kure

In the solitude

There is pleasure too –

Autumnal sunset. (орч: T.Saito & W.R.Nelson)⁷⁵

Ганцаардал ч сэтгэлийг минь чимнэ

Гагцхүү намрын жаргах нар байгаагүй бол

Гунигтай хорвоо байхсан (япон хэлнээс орчуулсан Б.Сэлэнгэ)

Уйтгар гуниг хааяа сэтгэлийн тэнхээ ч бас болдог. Байнга аз жаргалтай байгаад байвал аз жаргал гэдэг зүйлийн учир утгыг сайн ойлгохоо болино. Уйтай намрын орой байхгүй байсан бол хорвоо дэндүү уйтгартай байх байсан. Тиймээс ч гуниг хүний амьдралыг чимж өгдөг байх гэсэн санааг илэрхийлсэн гэж бодож байна. Гуниг гэдэг өөрөө аз жаргалгүй байхыг хэлж байгаа мэт боловч аз жаргалыг мэдрэхийн тулд гунигийг ч бас мэдрэх нь хүний хорвоогийн жам биз ээ. Тийм учир “Ваби”, “Саби” үүнд утгаа яг олсон мэт санагдана.

44. 汲みて知るぬるみに昔なつかしや (Issa - 1795)

Kumite shiru nurumini mukashi natsukashi ya

Drawing water

It's tepid...

Nostalgia for olden times (Орч: David Lanoue)

⁷⁴ Takafumi Saito, William R. Nelson “1020 Haiku in Translation: The Heart of Basho, Buson and Issa”, p.182.

⁷⁵ Takafumi Saito, William R. Nelson “1020 Haiku in Translation: The Heart of Basho, Buson and Issa”, p.166.

Бүлээн ус

Хуучны өдрүүдийг минь санагдуулж

Дулаахан мэдрэмж төрүүлнэ (япон хэлнээс орчуулсан Б.Амаржаргал)

Исса энэ хайкүг Шикоку аралд байрлах Мацүяма руу явж байхдаа Башёгийн нэгэн шүлгийг (te o irete shiru/ kame no mizu) сийлсэн чулуун хөшөөг хараад бичжээ. “Нацүкашии” (懐かしい) гэдэг үгийг шууд буулгах бас хэцүү. Энэ нь ихэвчлэн хуучин болсон, эсвэл өнгөрсөн жаргалтай сайхан зүйлээ эргэж санаад дулаан мэдрэмж авч байгаа сэтгэлийн илэрхийллийг хэлдэг.

45. 故里や酒はあしくとそばの花 (Buson - 1774)

Furusato ya sakewa ashikuto sobano hana

My hometown –

Though the sake is not good

Buckwheat flowers. (орч: T.Saito & W.R.Nelson)⁷⁶

Төрсөн нутаг минь

Тийм ч амттай архи биш ч

Дэргэд минь сагадын цэцэг (япон хэлнээс орчуулсан Б.Сэлэнгэ)

Японд уулархаг газар сагадын цэцэг ургадаг бөгөөд түүний гурил нь гурилтай хоол, банш зэрэгт хэрэглэгддэг. Олон газар энэ амттай хоолоороо цуутай байдаг. Зохиогч төрсөн нутгаа санагалзаж байгаа нь харагдаж байна. Эр хүний хувьд архи уух нь ядаргаагаа тайлах, зугаацах гэх мэтээр чухал үүрэг гүйцэтгэдэг боловч төрсөн нутгийн хоол байхад архи байхгүй ч байсан болно гэсэн санааг өгүүлж байгаа болов уу.

46. 雁やのこるものみな美しき (Ishida - 1943)

Karigane ya nokoru mono mina utsukushiki

A flock of wild geese -

The things I leave behind

Are all so beautiful ⁷⁷ (орч: Gabi Greve)

Зэрлэг галууны сүрэг,

Ард минь үлдэх хэн бүхэн

Үзэсгэлэнтэй. (япон хэлнээс орчуулсан Б.Амаржаргал)

Ишида Хакёод 1943 оны 9 сарын 23-нд цэрэгт татагдах талаар албан бичиг ирэв. Тэр үед зохиогч ард үлдсэн гэр бүл, найз нөхдөө бодон алсын замд гарлаа. Оройн тэнгэрт зэрлэг галууны сүрэг нисээд бөөн дуу шуугиан болж байгаад алга болов. Энэ дуу Хакёогийн мэдэрч буй уй гуниг, түүний ард үлдсэн бүхний гоо сайхныг сэтгэлдээ шингээж буйг илэрхийлж байгаа аж. Ард үлдээсэн бүхнээ тэр улам бүр хайрлах болж, тэр бүхэн нь өмнөхөөсөө ч илүү үзэсгэлэнтэй харагдаж байлаа. Түүний уй гуниг гуаглан алга болж буй зэрлэг галуунуудын дүр зурганд шингэсэн байна. Хүн өөрт нь байгаа юмаа алга

⁷⁶ Takafumi Saito, William R. Nelson “1020 Haiku in Translation: The Heart of Basho, Buson and Issa”, p.163.

⁷⁷ <http://wkdhakutopics.blogspot.com/2007/08/loneliness-sabishisa.html>

болсных нь дараа ойлгож, үнэ цэнийг нь мэдэрдэг гэдэг. Нүдний өмнө харагддаггүй байсан тэр гоо үзэсгэлэн уусан алга болохдоо дүрээ нээдэг “Ваби” юм болов уу.

47. どむみりとあふちや雨の花曇 (Basho - 1694)

Donmirito ouchi ya ameno hanagumori

A bead tree, dull-looking –

Clouds of cherry blossoms

On a rainy day. (орч: T.Saito & W.R.Nelson)⁷⁸

Сакүра цэцэгс

Мананд хучигдан харагдах

Юутай уйтай. (япон хэлнээс орчуулсан Ж.Лхамаа)

Сайхан өнгөтэй цэцэгс дэлгэрсэн байхад дээр нь манангаар бүрхэгдсэн тэнгэр яагаад ч юм их гунигтай харагдана. Мөдхөн бороо орох гэж байгаа нь байдлыг улам ч гунигтай болгох шиг. Аялалд яваад ядарсан Башё байгалийн энэ байдлыг хараад санаа алдаж бичсэн шүлэг юм.

48. 大螢ゆらりゆらりと通りけり (Issa -)

Obotaru yurari-yurari to torikeri

A beautiful firefly

Nonchalantly

Passes by (D.Jackson)⁷⁹

Гэрэл цацруулсан гэрэлт цох

Гялтганан гялтганасаар

Нисэн одлоо (япон хэлнээс орчуулсан Б.Амаржаргал)

Түүхэн талаас үзвэл япончууд гэрэлт цоход их дуртай байсаар иржээ. Түүний энгийн гоо үзэсгэлэн нь японы яруу найрагт их гардаг юм. Гэрэлт цохнууд зуны дулаан үдэш, мөн таатай сайхан дурсамжуудыг санагдуулдаг. Энэ шүлэгт том том гэрэлт цох ийш тийш хөнгөн, удаан нисэж байхыг илэрхийлсэн нь зохиогчийн сэтгэлийг зуны харанхуй тэрхэн агшинд маш их хөдөлгөжээ. Бидний нүдний өмнө байгаа өчүүхэн зүйл хүртэл сэтгэлийг санаанд оромгүйгээр хөдөлгөж чаддаг.

49. 橋なくて日くれんとする春の水 (Buson - 1775)

Hashi nakute hi kurentosuru haruno mizu

No bridge and

The sun about to set –

Water in spring. (орч: T.Saito & W.R.Nelson)⁸⁰

Нарны тусгалыг зааглах гүүргүй болоод ч тэр үү

Алтан нарны бүхий л цацрагийг өөртөө шингээх

⁷⁸ Takafumi Saito, William R. Nelson “1020 Haiku in Translation: The Heart of Basho, Buson and Issa”, p.83.

⁷⁹ 「御詠えシリーズ第二集：俳句の美」2010、p.29.

⁸⁰ Takafumi Saito, William R. Nelson “1020 Haiku in Translation: The Heart of Basho, Buson and Issa”, p.48.

Хаврын гол. (япон хэлнээс орчуулсан Ж.Лхамаа)

“Гадуур зугаалж явтал нэг голтой тааралдав. Хаврын гол сайхан урсаж байлаа. Дээгүүр нь ч харсан, доогуур нь ч харсан, гүүр гэх юм байхгүй байлаа. Хүний сүүдэр ч харагдахгүй газар байна даа гэж бодтол алсад нэг айлын гэрэл харагдтал хаврын нар аль хэдийнээ шингэснийг анзаарав. Голын усанд тусах гэрэл ч уусч алга болж байв”⁸¹ гэсэн санааг агуулжээ. Байдлыг их энгийнээр илэрхийлж аялалын нэгээхэн хэсгээ дурдсан байна. Аялагчид голыг гатлах гүүр байгаагүй ч, сайхан унтах байр сав байгаагүй ч, ганц хундаглачих архи байгаагүй ч түүнд санаа зовох юм байхгүй байв. Түүнд онгон байгальд голын усны урсгалыг сонсож, шөнийн тэнгэрт харагдах сарыг ширтэн хэвтэх нь таатай аж. Энэ утгаараа байгаль дундаа орж гоо сайхныг нь биширч байгаа санааг илэрхийлснээр “Ваби” оршиж байгаа юм.

50. 露の世は露の世ながらさりながら (Issa - 1819)

Tsuyuno yowa tsuyunoyonagara sarinagara

The world of dew is indeed

The fleeting world of dew –

And yet, and yet. (орч: T.Saito & W.R.Nelson)⁸²

Амьдрал гэдэг шүүдэр,

Шүүдрийн дусалхан байг,

Гэлээ ч гэсэн дээ...⁸³ (орос хэлнээс орчуулсан Г.Аюурзана)

Намар. Яруу найрагч Иссагийн амьдрал үхэл хагацлаар дүүрэн байв. 1763 онд төрсөн тэрээр гурван настайдаа төрсөн эхээ алдаж, найман насандаа хойд эхтэй болж эрэгтэй дүүтэй болжээ. Хойд эхдээ тийм дуртай байгаагүй Исса арван дөрөвтэйдээ хайрт эмээгээ алджээ. Ганцаардсан тэрээр өөрийн гэртээ байхаасаа дургүйцэж гадуур их тэнэдэг болж, хойд эх нь гаргаж буй үйлдэлд нь дургүйцсэний үр дүнд аав нь түүнийг холын Эдо (одоогийн Токио) руу явуулжээ. Аав нь 1801 онд нас барсны дараа хойд эхтэйгээ өв хөрөнгөө булаацалдаж сүүлд нь талыг нь авч чаджээ. 49 насандаа эх нутаг руугаа буцаж эхнэр авч хэсэг аз жаргалтай амьдарсан боловч эхний хүүхэд нь төрмөгцөө нас баржээ. Хоёр жилийн дараа охин төрсөн ч нэг жилийн дараа өвчнөөр явжээ. Эрт дээр үеэс хорвоо ертөнцийг хэмжиж болохгүй, хэмжээлшгүй, мөнхийн бус гэдэг утгаараа шүүдрийн дусалтай зүйрлүүлж иржээ. Шүүдэр өглөөний нар гарахаас өмнө алга болдог богино амьдралтай. Хүний амьдрал ч бас тийм биш гэж үү? Зохиогч мөнхийн бус хорвоо гэдгийг нь ойлгож байгаа боловч үхэл хагацлын шаналал ертөнцийг шүүдрийн дусалхан шүү дээ гэж өөртөө ойлгуулсан ч зовоосоор байх юм гэсэн утга санааг илэрхийлсэн байна. “Түрхэн зуурын” гэдэг санаагаараа “Ваби” чанарыг илтгэж байна. Хорвоо бол мөнх бус гэдгийг би ухамсарлаж байна, даанч зовлон намайг орхихгүй юм гэснээр “Саби” бий болж байна. “Ваби”, “Саби” нь хөгшрөлт, зовлон, үхэл хагацлыг ойлгож хүлээн

⁸¹ 「古典日本文学31: 与謝蕪村集、小林一茶集」筑摩書房、1976、p.28.

⁸² Takafumi Saito, William R. Nelson “1020 Haiku in Translation: The Heart of Basho, Buson and Issa”, p.197.

⁸³ “Дэлхийн шилдэг яруу найраг : Японы яруу найраг”, УБ 2005, х. 114.

авахыг ч хэлнэ. Зохиогч өөртөө ойлгуулах гэж хичээж байгаа ч уйтгарт автаж байгаа нь бас л “Ваби”, “Саби”-г илтгэж байгаа юм болов уу.

Ийнхүү, японы алдарт яруу найрагчдын бичсэн зарим шүлэг ба тэдгээрийн орчуулгад ажиглалт хийж үзсэнээр дараахи дүгнэлт, эргэцүүлэлд хүрлээ:

- “Ваби”, “Саби” бол зүгээр нэг үг биш юм. Энэ бол гарт баригдаж, нүдэнд үзэгдэхгүй япончуудын ертөнцийг үзэх үзэл. Хүн өөртөө болон эргэн тойронд байгаа юмандаа сэтгэл хангалуун байх нь ховор. Харин шинэ ба хуучин эд зүйлс, сайхан ба муухайд, өнгөрсөн, одоо ба ирээдүйд, ер нь энэ ертөнцийн юм бүхэнд гоо сайхан оршдог гэсэн утгыг агуулж байна. Энэ утгаараа хүмүүст ийнхүү гоо сайхныг ойлгуулах, мэдрүүлэх арга хэлбэр, үзэл бодол гэж хэлж болно. Хорвоо ертөнцийн сайн сайхныг шагшин магтсан гэгээн үзэл юм.
- “Ваби”, “Саби” нь аливаа зүйлийг сайн талаас харах үзэл. Дутагдал, муу муухай зүйлээс гоо сайхныг олж мэдрэх философи мөн. Иймдээ ч нэг л шүлгийн орчуулгад “уйтгар гуниг”, “аз жаргал” хоёр ижил утгаар бууж байгаа тохиолдол цөөнгүй байна. Энэ үзэл бол хөгжил цэцэглэлт, сайн сайхны төлөө эрмэлзлийн үндэс. Иймээс “Ваби”, “Саби”-гийн тухай дэлгэрүүлэн судалж түгээх нь хүмүүсийн дотоод ертөнцийг гэгээрүүлэхэд бага ч болов тус нэмэр болох мэт санагдана.
- “Ваби”, “Саби” нь Японы яруу найрагт хэрхэн тусгалаа олсны нэг тод жишээ нь хайкү шүлэг мөн болох нь харагдлаа. Иймд хүмүүст энэхүү үзлийг ойлгуулан түгээх хамгийн дөт замын нэг нь хайкү шүлэг болно. Цаашид хайкү шүлгийг япон хэлнээс орчуулж хэвлэн түгээх явдал нь “Ваби”, “Саби” үзэл, япончуудын оюуны соёлыг таниулахад чухал ач холбогдолтой гэж үзэж байна.
- Хайкү шүлгийг орчуулга болон шүлэг зохиогдсон түүх зэрэгтэй нь уялдуудан судалж үзэхэд байгаль ертөнцийн үзэгдлээр төлөөлөн хүмүүний амьдралын утга учир, ололт амжилт, баяр гуниг, гоо сайхан зэрэг бүхий л зүйлийг илтгэж буй нь харагдлаа. Энэ утгаараа хайкү шүлэг нь япончуудын гоо сайхныг үзэх “Ваби”, “Саби” ойлголтын өвөрмөц нэгэн төлөөлөл болж байна гэж үзэж болох юм. Иймд харийн хэл, соёлыг судалж буй бидний хувьд япончуудын ертөнцийг үзэх үзэл, тэр дундаа гоо сайхныг таашаах үзлийг улам гүнзгийрүүлэн судалж үзүүштэй юм.

Ном зүй

1. Г.Аюурзана, “Зэн буддизм: Амьдралаас ангижрахуй”, УБ., 2010.
2. “Дэлхийн шилдэг яруу найраг III боть: Японы яруу найраг”, УБ., 2005.
3. Д.Мандах, “Япон уран зохиолыг монгол хэлнээ орчуулсан туршлага, зарим шинэлэг асуудал”, УБ., 2010.
4. “Японы утга зохиолын симпозиум: илтгэлийн эмхтгэл”, УБ., 2005.
5. Andrew Juniper, “The Japanese Art of Impermanence”, 2003.
6. Encyclopedia: Nipponica 2001, 1986.

7. Encyclopedia: Nipponica 2011, 1988.
8. Robin D. Gill “Mad in Translation: A Thousand Years of Kyoka, Comic Japanese Poetry In the Classic Waka Mode”, 2009.
9. Simon G. Brown. “Practical Wabi Sabi”, UK, 2007.
10. Takashi Kodaira, Alfred H. Marks “The Essence of Modern Haiku: 300 Poems by Seishi Yamaguchi” Mangajin, 1993.
11. Takafumi Saito, William R. Nelson “1020 Haiku in Translation: The Heart of Basho, Buson and Issa”, 2010.
12. 「御誂えシリーズ第二集：俳句の美」
13. 「古典日本文学 31：与謝蕪村集、小林一茶集」筑摩書房、1976.
14. 「古典日本文学 29：松尾芭蕉集 上」筑摩書房、1976.
15. 松本明監修「大辞泉」小学館、1995.

Abstract

In this article we aimed to analyze some Japanese haiku to explore Wabi Sabi contents in association with the poems’ historical background and compared the translations to Mongolian and English. We have found out a lot of feelings in human life such as sadness loneliness happiness and beauty in each haiku. Haiku is the great and the ideal way to express Wabi Sabi.

МОНГОЛ АРДЫН ДУУГ ОРОС ХЭЛ РҮҮ ОРЧУУЛАХ АСУУДАЛД

Д.Цэдэнжав⁸⁴ (МУБИС)

Түлхүүр үгс: универсали, реали, ардын ёс заншил, дуу хуур, дууны агуулга, үзэл санаа, хэлбэр

Аливаа улс үндэстэн эрт дээр үеэс бие биеийн хэлийг судлан, түүх, соёл, шинжлэх ухаан, уран зохиолтой холбогдол бүхий бичиг зохиолыг орчуулан ашиглаж, өөрсдийн түүх соёлын өв, оюуны сангаа баяжуулсаар иржээ. Хоёр буюу хэд хэдэн хэлний үзэгдлийг харьцуулан үзэхэд аль алинд нь байдаг адил төстэй ерөнхий ухаарал арвин байхын зэрэгцээ тухайн ганц хэлэнд л байдаг, бусад хэлээр орчуулахад бэрхшээлтэй онцгой зүйлс бий. Хэлэнд байгаа ерөнхий зүйлийг судлаачид хэлний нийтлэг буюу универсали хийгээд онцгой зүйлийг нь реали гэж нэрлэдэг. Энэ нь нийгэм соёлын болон газар нутгийн ялгаа, хүн ардын ахуй амьдрал, зан заншлын өвөрсөц хэвшилтэй холбоотой. Ийм реалийн нэг бол монголын ардын дуу, түүний дотор уртын дуу билээ.

Монгол ардын уртын дуу бол монгол ардын дууны сонгодог хэлбэр даруй мөн бөгөөд дэлхий дахинд ардын дууны шинж төлөвтэй харьцуулан үзэхэд нэн өвөрмөц, гайхам сонин, чухам Монголын урлал юм. Монголын уран зохиолыг өөр хэл рүү орчуулах явцад тохиолдох бэрхшээлийн нэг бол монгол ардын дуунд агуулагдсан монгол хүний сэтгэлгээ, гоо сайхны таашаал, ертөнцийг үзэх үзэл, байгальтайгаа харьцах харьцааг дамжуулан илэрхийлэх явдал байдаг.

Орчуулагч нар ардын дууг тухайн эх зохиолын үйл явдал, үзэл санаанд нь тохируулан орчуулж иржээ. Үүний жишээ болгож Ч.Лодойдамбын “Тунгалаг Тамир” романд орсон ардын дууны орчуулгыг авч үзье.

Уг зохиолын гол баатар Төмөрийн дүрийг товойлгон гаргасан уран сайхны хэрэгслийн нэг бол түүний дуулдаг ардын дуу “Эрдэнэ засгийн унага” юм. Энэ дууг Төмөр Түгжилтэй цуг явж байхдаа дуулдаг:

“Хэсэг явсны дараа Төмөр дуулж хоёул зэрэгцэн дорно зүг хатируулав. Төмөр нам бөгөөд дургисан бүдүүн хоолойгоор:

Эрдэнэ засгийн унага юу даа
Эрвэлзэж хийсэн жороо доо хөө
Элсэн манхан нутагтайдаа хөө
Эмгэн буурал ээжтэйдээ хөө
Төв засгийн унага юу даа
Тонолзож хийсэн жороо доо хөө

⁸⁴ МУБИС, НХУС, доктор, профессор

Тонж хоёр сэтгэлийг хөө
Сална гэж л санасангүй дээ”

гэж шуранхайлан дуулж явахад энгэрээр үлээсэн салхи дээлийг нь хөөргөж нисэх гэж дэгдэж байгаа бүргэд шиг харагдаж байлаа”/Т.Т.х.68/. Гэтэл орчуулга нь: “Затем они поехалирядом. /П.Т.с.57./” гэсэн байна.

Энд зохиолч жирийн монгол хүний сэтгэлгээ, гоо сайхны таашаал, ертөнцийг үзэх үзэл, байгальд хандах хандлагыг Төмөрийн дүрээр чадмаг илэрхийлсэн байна.

Гэтэл энэ ардын дууг орчуулалгүй орхисон нь эх зохиолын найруулга, гол баатрын дүрийг орчуулгадаа бүдэгүүлж, зохиолчийн санааг бүрэн дамжуулж чадсангүй. Энэ нь дараа дараагийн үйл явдлын орчуулгад сөрөг нөлөө үзүүлжээ. Жишээ нь, Төмөр баригдаад шоронд сууж байхдаа ч энэ дуугаа дуулж, Дулмаадаа мэдээ дамжуулдаг. Дулмаа ч хайрт ханийнхаа дуулах дуртай энэ дууг амьдралын хүнд хэцүү үед дуулж өөрийгөө зоригжуулдаг. Дууны энэ залгамж холбоо орчуулгад алдагдсан байна.

Тус романд монгол ардын ёс заншил, дуу хуур, амьдралын хэв маяг өргөн тусгагдсан байдаг. Зохиолын эхний нүүрэнд ардын гурван дууны хэсгээс татал /эртний ном зохиолд товчит толт ч гэсэн байдаг/ оруулсан нь зохиолын ерөнхий утгыг товчлон илэрхийлэх арга бөгөөд үүнийг орчуулганд дараах байдлаар буулгажээ:

Хоёр хангайн нутаг
Хүрэнтэж найгаад байна.
Хошууны олон Тамир

Санагдахуйяа янзтай (Ардын дуу).[3, 12] гэсэн хэсгийг нь орчуулалгүй орхиж, дараачийн хоёр дууны хэсгийг М. Тарасовагийн орчуулгаар тавьжээ:

Тунгалаг Тамирын зүлгэнд нь
Зүйлийн өнгийн маань цэцэг
Дуртмал хурц нарны гэрлээр
Тогтож ядан ганхана.
Дасаж таньсан нөхөдтэйгөө
Даамай амраг хүүтэйгээ
Дандаа ханилдаг ч болоосой
Дандаа жаргадаг ч болоосой (Ардын дуу)[3, 12] гэсэн хэсгийг
“Шумят воды Тамира,
Пронизанные светом,
Серебряные травы
Поют, обнявшись с ветром.
Но отцветает клевер
На берегу Тамира,
А сердце хочет верить,

Что не разлюбит милый” (Народная песня)»[6,10] (в переводе М.Тарасовой) гэсэн байна. Дууны үгийг орчуулагч М.Тарасова орос хэлтэй уншигчдын таашаалд нийцүүлэн орос яруу найргийн хэлбэрт оруулжээ.

Дараагийн дуу нь:

Эрэвгэр багахан хүрнийгээ
Эцнээ гэж санасангүй
Энэхэн хоёр сэтгэлийг
Гажна ч гэж санасангүй” (Ардын дуу) [3, 12] гэснийг
“Не думал я, что мой гнедой
Собьёт себе копыта,
Что клятва и тобой и мной

Будет позабыта...” (Народная песня).[6,10] гэж орчуулсан нь дууны утга агуулга төдийгүй, шүлэглэсэн хэлбэрийг нь дамжуулсан нь монгол ардын дууны үзэл санаа, агуулга, хэлбэрийг орос хэлээр илэрхийлэх боломж байдаг юм байна гэж бодмоор.

Хоёрдахь ном нь мөн л ардын дууны таталаар эхэлж байна:

Уужим талбай байвч
Устай намгийг нь мэдээрэй.
Учирсан амраг байвч

Ухаан сэтгэлийг нь таниарай (Ардын дуу) [3, 309] гэснийг А.Дамба-Ринчино гуай:

“И в степи можно встретить болото.

И любимого надо хорошо знать” (Из народной песни) [6,248] гэж өөрөө орчууландууны үгийн товч утгыг гаргахдаа үргэлжилсэн үгээр илэрхийлжээ. Хоёр дахь дууны:

Сайр шандын усыг
Шавхаад шавхаад барахгүй.
Сайн хүний үрийг

Дараад дараад дийлэхгүй (Ардын дуу) [3, 309] гэсэн үгийг А. Дамба-Ринчино гуайн орчуулганд

“Родник невозможно вычерпать” (Народная поговорка)[6,248] гэж буужээ. Энд орчуулагч ардын аман зохиолын нэг хэлбэр— ардын дууг аман зохиолын өөр хэлбэр болох зүйр цэцэн үгээр орчуулан агуулгыг нь дамжуулахыг хичээжээ.

Гурав дахь дууны:
Жороо баахан улааныг
Жолоогий нь дөмөөд мордоорой.
Зорьсон газар холхон шүү
Зоригоо битгий мохоорой (Ардын дуу) [3, 309] гэснийг
“Долог путь до цели,

Будь отважен до конца” (Из народной песни)[6, 248] А.Дамба-Ринчино гуай гэж орчуулжээ. Энд орчуулагч дууны агуулгыг голлон анхаарч хэлбэр талыг үгүйсгэжээ.

Монгол судлаач, орчуулагч нар монголын утга зохиолыг орос хэлнээ орчуулж байгааг түүхийн үүднээс хоёр чиглэлд хуваан үздэг ажээ / О.Э. № 2. х.66/. Үүний нэг нь эрдэм судалгааны хэрэглээнд зориулсан эх бичигтээ үлэмж ойрхон голдуу монгол ардын аман зохиол, эртний утга зохиолыг орчуулсан

эрдэм шинжилгээний орчуулга, нөгөө нь монголын уран зохиолыг өргөн олон уншигчдад танилцуулахад зориулсан уран сайхны орчуулга юм.

Монгол ардын дууны эрдэм судалгааны орчуулга нь тухайн зохиолын найруулга, үйл явдлын хэлхээ, баатруудынх нь онцлогт таарах эсэх нь эргэлзээтэй. Манай зохиолчид өөрийн уран бүтээлдээ ардын дууг ашиглан олон сайхан дүр бүтээдэг. Гэтэл нэг ардын дууг зохиол тус бүрийн үзэл санаанд тохируулан өөр өөрөөр орчуулаад байж болохуу? Ер нь ардын дууг орчуулах ямар арга зам байна вэ? Та бүхэн энэ талаар санал бодлоо хуваалцана уу.

Литература:

1. Адьяа О. Орчуулга: онол, туршлага, сургамж / О. Адьяа - Улаанбаатар, 2008.
2. Дүгэрсүрэн Т. Чадраабалын Лодойдамба(1917 - 1970). Жизнь и творчество: автореф. дис. ... канд. филол. наук / Т. Дүгэрсүрэн; Ин-т Востоковедения. – М, 1979. – 26 с.
3. Лодойдамба Ч. Тунгалаг Тамир / Ч. Лодойдамба // Монголын уран зохиолын дээжис, - Улаанбаатар. 1997. - Т. 30. – 632 с.
4. Сдобников В. В. Теория перевода /В. В. Сдобников, О. В. Петрова. - М.: Восток-Запад, 2006. – 444 с.
5. Чадраабалын Лодойдамба. Прозрачный Тамир / Ч. Лодойдамба. - М. : Прогресс, 1981. – 496 с.

Аннотация: Художественный перевод сближает народы и в то же время утверждает культурную самостоятельность и их национальное своеобразие. Передача компонентов национального колорита монгольских народных песен, связанных с образом жизни народа, представляет большие трудности из-за яркой национальной специфичности. Автор просит делиться своим мнением по этому вопросу.

АЛТАЙН ХЭЛШИНЖЛЭЛИЙН НЭРТ ЭРДЭМТЭН ГУСТАВ ЖОН РАМСТЕДТ (1873-1950)

Л.Чулуунбаатар⁸⁵ (ӨМИС-ийн зочин профессор)

Товч агуулга: Финляндын нэрт эрдэмтэн Густав Жон Рамстедт 1950 оны 11 сарын 25 нд таалал төгссөн боловч түүний монгол судлал болон алтайн хэлшинжлэлийн судлалд оруулсан аугаа их өв сан нь хожмын судлаачдад одоо ч гэсэн үр шимээ өгсөөр байна. Монголчуудын дунд амьдарч нилээд хэдэн жилийг өнгөрөөн, монгол хэлний талаар жинтэй бүтээл гаргаж, монгол судлаачдын ноён оргилуудын нэг болсон гадаадын монголч эрдэмтэн бол бас л гарцаагүй тэр юм. Мөн тэрээр монголчуудын тусгаар тогтнолын үйл хэрэгт өөрийн хувь нэмрийг оруулж, зуучийн үүрэг гүйцэтгэн Хаант Орос улсаас буу зэвсгийн тусламж олоход Монголын төлөөлөгчдөд тусалсан хүн бол бас л тэр байсан юм.

Түлхүүр үг: Алтайн хэлшинжлэл, Густав Жон Рамстедт, Зүүнш зорчсон долоон аян, харьцуулсан авиан зүй, элчин сайд

Монгол оронд ирж, монголчуудын дунд амьдран, хэлийг нь сурч, зовлон жаргалаа хуваалцан, амьдралыг нь ойлгон сайхан дурсамжийн ном бичсэн гадаадын монголч эрдэмтэн цөөхөн тоотой байдаг юм. Тэдний нэг бол монголчуудын дунд амьдарч нилээд хэдэн жилийг өнгөрөөн, монгол хэлний талаар жинтэй бүтээл гаргасан хүн бол Финляндын монголч эрдэмтэн Густав Жон Рамстедт юм. Оросууд бол Густав Йон Рамстедт гэж бичдэг бөгөөд Шведээр бол Gustav John Ramstedt хэмээн бичдэг болохоор би энд Жон хэмээн бичлээ. Энэ аугаа хүний мэндэлсний 140 жилийн ой 2013 оны 10 сарын 22-нд болж өнгөрсөн бөгөөд энэ ойгоор нь түүний Хэрмис, Монгол, Туркестан, Халимагаар аялсан аялалын ном “Зүүнш зорчсон 7 аян” хэмээх номыг орчуулан гаргах санаатай байсан билээ. Энэ номыг тал хэсгийг би өөрөө орчуулж өөр нэг хүнд 4 жилийн өмнө за зүй болоод өгсөн боловч миний хэсэг дууссан ч түүнийх эс дууссан тул мөн 2012-2013 оны хичээлийн жилд бас 2 залуу багшид санал тавьж тэд бас амласнаа эс биелүүлсэний учир ойгоор нь гаргах гэсэн санаа хоосон санаа болж, одоо би өөрөө гүйцээхээр үргэлжлүүлэн орчуулж байна. 9 жилийн дараа түүний мэндэлсний 150 жилийн ойгоор нэн их далайцтай эрдэм шинжилгээний хурал, бүтээл гарна гэдэгт бат итгэлтэй байна. Гэвч номыг орчуулж дуусахаас өмнө монгол судлаач нар болон эрдэмийг эрхэмлэгч авгай нартаа мэдлэгт нэмэр болох болов уу хэмээн түүний тухай болон номынх нь тухай товчхон өгүүлэл бичиж гаргахаар шийдсэнээ толилуулсугай.

⁸⁵ МУИС, ШУС, ХУС-ын доктор, профессор

Рамстедтийн энэ ном анх Фин хэлээр “Сэйтсэман реткеа итаан” буюу “Зүүнш зорчсон долоон аян” нэртэйгээр Хелсинкэд 1944, 1946 онд 244 хуудастай зураг чимэглэл, газрын зургийн хавсралттайгаар хэвлэгдсэн хийгээд хоёрдахь удаа 1953 онд, гуравдахь удаа 1961 онд хэвлэгдсэн байна. Сүүлийн хэсэгт нь монголын янз бүрийн олон дуунуудын орчуулгийг хавсаргасан байв. Энэ номын швед орчуулгыг Мари Нумэлен хийсэн бөгөөд “Сжү ресор и өстерн 1898-1912” нэртэйгээр зураг чимэглэлгүй 1961 онд Стокгольмд Natur och Kultur цувралд 217 хуудастайгаар хэвлүүлсэн байна. Энэ хэвлэлд профессор Бжорн Коллиндер товч өмнөх үг бичсэн бөгөөд мөн монгол ардын аман зохиолын Рамстедтийн нэг фин хувилбарыг шведээр орчуулан оруулсан боловч бусдыг нь үлдээсэн байна. Ер нь бараг бүгдийг оруулалгүй орхисон байна. Англи орчуулгыг Америкийн монголч эрдэмтэн Жон Кругер олон жилийн зузаан анд, номын журмын садан профессор Ало Рауны фин хувилбартай нь нарийн нямбай харьцуулан нягтлан шалгасны дараа швед хэлнээс 1977 онд орчуулсан билээ. Доктор Раун фин хувилбарт байгаа зарим мөр, өгүүлбэр швед хувилбарт орхигдсоныг оруулах санал тавьсан ёсоор ямар нэгэн онцгой тэмдэглэгээгүйгээр орчуулгын эхэд оруулсан байна. Фин эхэд байхгүй зарим үг хэллэг, өгүүлбэр байгаа хийгээд зарим нэгэн үл ялиг алдаа байгааг нарийн ажиглан дурьдаж Швед болон Фин эхийг ашиглах хүмүүст зориулж санамж болгон өгүүлсэн байдаг юм. П.Алтогийн хийсэн зарим нэгэн засвар бол хянах явцдаа онцгой тэмдэглэгээ хийлгүйгээр орчуулгад холиод оруулчихсан үл мэдэг адил бус зүйлүүд болон 3-р хэсгийн зохиогчийн зарим тайлбарыг Ж.Кругер орчуулгадаа байх нь илүү тохироно хэмээн санаж шилжүүлж оруулсан бөгөөд бусдаар бол зохиогчийн бичсэн бүлгүүдийг тэр хэвээр нь орчуулсан байгаа болой. Номын бүх бичвэрийг орчуулахдаа ялангуяа 6-р бүлэг дээр их удсан шалтгаанаа Азийн тухай мэдлэгээ жаахан нэмэгдүүлэх шаардлагаар ингэсэн юм хэмээн дурьджээ. Энэ нь орчуулгадаа хайнга хуумгай хандалгүй нарийн нягт нямбай хандсаны гэрч баримт болох болой. Тийм болохоор Ж.Кругерийн энэ англи орчуулга нилээд сайн бүрэн хэмжээний орчуулга болсон хэмээн үзээд монгол хэлээр орчуулж байгаа минь энэ болой.

Энэ ном бол Алтайн хэлт ард түмний хэлийг судлан шинжлэгч томоохон хэл шинжлэлтэн хэн бүхэнд ихээхэн амьд, сонирхолтой тайлан мэдээ төдийгүй Фин-Уйгар хэлт ард түмнийг судлаач оюутан, мөн тэрчлэн Төв Азийн Турк, Монголчуудыг сонирхон судлаач нарт сайн мэдлэг олгох болно. Уг номоо Рамстедт авгай Их сургуульдаа багшлахаа больж 70 насандаа тэтгэвэрт гардаг тэр жилээ буюу 1943 оны Хиристосын баярын үеэр ямар нэгэн тэмдэглэгээ тайлбаргүйгээр хэвлэлийн газрын хурдан бичээчид хэлж бичүүлсэн юм хэмээн доктор Алто баталдаг байна.

Энэ дурсамжийн номд Монгол хүртэл зорчсон 1898 оны аян (Өргөө хүртэлх аян, Өргөө хотод, 1899 оны зун, Хоёрдахь өвөл (1900), Уудам хээр талд, Тэмцлийн дуунууд (чимээ), Тройцксавскт, Финланд хүртэлх аян, Халимагийн нутгаар аялсан минь, 1903 онд өвөг монголчуудын мөрөөр аялсан нь, 1909 оны Монголд зорчсон аян, 1912 оны Монголд зорчсон аян хэмээх монгол нутгаар аялсан хийгээд монголчуудтай шууд холбоотой бүлгүүд байгаа болой. Энэ

дурсамжийн ном дотроо өрнөдийн хүний гярхай ажигч зангаар олон зүйлийг сайтар тайлбарлан бичсэн байх бөгөөд одоо бидний мэдэхээ байсан олон зүйлийг сонссон, үзсэн, ажигласандаа тулгуурлан бичсэн байх болой. Ганцхан жишээ дурьдахад тарвага болон өвчтэй тарвагны тухай одоо ч гэсэн бидний мэдэх хэрэгтэй зүйлийг бичсэн байгаа нь доорх болой.

Намрын сүүлээр үүрэндээ өвлийн нөөц болгож, хөөс хураана. Тэгээд тарвага ичдэг амьтан болохоор монголчуудын хөөрхий цахиур буу удтал түүнийг авлаж чаддаггүй. Хэдийн тийм боловч өвөл тарвагыг ичээнээс нь ухаж авах явдал байдаг. Бас заримдаа урхи тавьж агнах нь бий. Ийм аргаар голдуу зун л урхи тавина. Монгол хүн цаас, хадаг зэрэг юухан хээхнийг уурга, шилбүүр, саваа мод зэрэгт холбоод тарвага гарч ирэх үед сэнс мэт хөдөлж байхаар тавьдаг. Аймхай болохоор тарвага их сэрэмжтэй байх бөгөөд хяраад юмуу босоод хачин эргэлдэх зүйлийг гайхан аждаг. Тэгээд л хэд хошгилоод нүх рүүгээ алга болдог. Хэрэв хошгиролт нь чанга, тод байвал эрүүл тарвага байдаг. Хэрэв түүний эсрэг ер хошгирохгүй, чимээгүй нүх рүүгээ эргэж, удаан хөдөлж байвал мэдээж хэрэг ихэнхдээ өвчтэй тарвага байдаг.

Ингэж монголчуудын амьдралын гүнд орж судалгаа хийн монголчуудыг дэлхий дахинд эгэл сайхнаар танилцуулсан, дэлхийн монголч эрдэмтэдийн ноён оргилуудын нэг хийгээд Хельсинкийн Их Сургуулийн профессор, Финийн ШУ-ны академийн гишүүн, Алтайн хэлнүүдийн болон Монгол хэлний нутгийн аялгуу судлалын үндэслэгчийн нэг Густав Жон Рамстедт 1950 оны 11 сарын 25 нд таалал төгссөн юм. Түний таалал төгссөн нь дэлхийн шинжлэх ухааны салбарт хүнд гарз боллоо хэмээн нэрт эрдэмтэн Н.Поппе эмгэнэлийн өгүүлэлдээ дурьдсан байдаг. Рамстедт эрдэмтэний хувьд ШУ-ны аугаа их өвийг үлдээсэн бөгөөд тэр аугаа ажлынх нь бүрэн дүүрэн үр шимийг нээн гаргах хэцүү бөгөөд хариуцлагатай үүргийг бидэнд бас үлдээсэн билээ. Рамстедт Финляндийн Таммисаарид төрсөн юм. Турку хотод ахлах сургуулиа төгссөний дараа Хелсинкийн Их Сургуульд элсэн орж профессор Э.Н.Сеталагийн удирдлагын дор Фин-Уйгар хэлнүүдийг суралцсан байна. Тэр цагт тэрээр дорно дахин судлаач аугаа их эртэмтэдийн нэг болно гэдгээ төсөөлөөгүй байсан байж магадгүй юм. Рамстедтийн шинжлэх ухааны анхны ажил Херемис (Мари) хэлийг судалсанаар эхэлсэн юм. 1898 онд Волгийн хязгаарт аялан очиж Хермис аялгууны үнэлж баршгүй материал, цуглуулгыг хийсний үр дүнд толь гарган, авиан зүйн үнэт судалгаа хийсэн юм. Түүний хийсэн авиан зүйн маш нарийн тэмдэглэгээ нь Фин-уйгар хэлнүүдийн судалгаанд маш чухал хувь нэмэр болсон юм. Тийм хэдий ч тэрээр Фин-Уйгарын судалгаанд хараахан ороогүй байсан билээ. Хелсинкид байх Фин-Уйгарын нийгэмлэг, Алтайн судлалыг эрчимжүүлж, залуу судлаачдыг Төв Азийн орнуудад явуулахаар шийдээд байсан тэр цагт Рамстедт нийгэмлэгийн ерөнхийлөгч профессор Отто Доннерийн хараанд өртөж, түүнийг Монголд судалгаа хийлгэхээр илгээсэн байна. Харамсалтай нэг явдал нь Монголд хийсэн түүний цуглуулгын ихэнх хэсэг нь Сибирийн төмөр замаар буцах үед нь алдагдсан бөгөөд Монголд дахин аялж цуглуулга хийхээс өөр замгүй болгосон юм. Тэрээр Байгаль орчмийн нутаг болон Монгол нутагт 3 жилийг өнгөрөөсөн байдаг. Гэвч өөртөө авч үлдсэн зарим материалдаа

түшиглэн 1902 онд “Халх-монгол хэлний хувиргалын тухай” хэмээх сэдвээр эрдэмийн зэрэг хамгаалсан юм. Судалгааныхаа үр дүнд хоёр гайхамшигтай өгүүлллийг хэвлүүлсэн байдаг. Үүнийн нэг нь 1908 онд оросоор хэвлэгдсэн “Монгол бичгийн хэл ба Халхын хүрээний аман аялгууны харьцуулсан авиан зүй” хэмээх нэртэй Халх монгол хэлний авиа зүйн судалгаа байсан бөгөөд Монгол хэлнүүдийн харьцуулсан судалгааны анхных нь бас байсан юм. Энэ нь бас Монгол судлалын салбарт түүхэн болон харьцуулсан судалгааны анхных нь байсан юм. Мөн бас монгол ярианы хэлийг орчин цагийн хэл шинжлэлийн аргаар судалсан судалгааны бас анхдагч нь байсан юм. Нөгөө нэг бүтээл нь өгүүлбэр зүйн хувьд онцгой их ач холбогдолтой, харьцуулсан болон түүхэн аргаар судалсан Монгол бичгийн хэл болоод Халх аялгууны тийн ялгалын нөхцөлийн талаарх өгүүлэл юм. Рамстедт бас монгол ардын туулийн тухай бүтээл хэвлүүлж, Позднеевийн монголд баатарлаг тууль байхгүй гэдэг үзлийг няцаасан билээ. 1904 онд монголч эрдэмтэн Андре Руднев хамт Төв болон Зүүн Азийг судлах оросын судалгааны экспедицийн бүрэлдхүүнд орж, Халмигийн нутгаар судалгааны ажил хийсэн юм. Монголд дахин аялах хугацаандаа олон хүнтэй дотно анд болсоны дотор XIII Далай лам Түвдэнжамцын элч төлөөлгч бөгөөд цаншив лам, Буриадын нэрт эрдэмтэн Агваан доржтой танилцаж, Төвдөд уригдсан цөөн гадаад хүний нэг болж байсан байна. Гэвч түүнд Төвдөд аялах боломж гараагүй юм. 1911 онд Богд хаант Монгол улсын төлөөлөгчид тусгаар тогтнолоо баталгаажуулахад хэрэгтэй тусламжийг Хаант Орос улсаас гуйхаар Санкт Петербург хотод очихдоо Монголд амьдарч байсан, монгол хэл сайн мэдэхийнх нь хуьд Рамстедтийг зуучлагч болж өгнө үү хэмээн гуйсан байна. Тэдний хооронд маш сайн зуучилсаны үрээр 15000 ширхэг орчин үеийн буу зэвсэг дагалдах хэрэгслийн хамт Монголын төлөөлөгчид хүлээн авсан байна. 1912 онд Рамстедтийг монгол Нийслэл хүрээнд байхад тэр үеийн удирдагчид Да лам Цэрэнчимэд, Ханд чин ван, Хайсан гүн нар Өвөрмонгол болон Урианхайн хязгаарыг Монгол улсын бүрэлдхүүнд багтаах үйл хэрэгт туслах зуучаар ажиллаж өгөхийг гуйсан байна. Рамстедт хариуд нь Дэлхийн том гүрэн болон АНУ, Франц, Герман, Англи, Япон улсуудаас дэмжлэг олох хэрэгтэй хэмээн зөвлөж байсан байдаг. Тэр үед Орос, Япон хоёр Өвөрмонголыг Хятадын бүрэлдхүүнд үлдээхээр нууц гэрээ байгуулсаныг Рамстедт хараахан мэдээгүй байсан хэрэг юм.

1917 онд Финлянд улс тусгаар тогтноход Японд суух анхны элчин сайдаар Рамстедт томилогдсон байна. Япон хэл мэдэхгүй байсан боловч Хелсинкээс усанд онгоцонд суухдаа япон хэлний сурах бичиг авч суусан бөгөөд 14 хоног аялаад Японы эрэгт газардахдаа японоор ярьж буусан байна. Тийм болохоор энэ эрч хүчээрээ япон хэлийг маш түргэн хугацанд сурсан байдаг. 1920-1929 элчин сайдын хажуугаар Токиогийн Эзэн хааны Их Сургуульд зочин багшаар уригдан ажиллаж байсан бөгөөд Кунио Яамагита (Kunio Yanagita), Изуру Шимура (Izuru Shimura), Киосукэ Киндайчи (Kyōsuke Kindaichi) болон Шимпей Огура (Shimpei Ogura) нарын судалгааны ажилд үлэмж их нөлөө үзүүлсэн байна. Тэрээр бүр эрт 1891 онд Финляндад байхдаа эсперанто хэл сурсан бөгөөд Финляндын Эсперантогийн нийгэмлэгийн тэргүүн болсон байна.

Японд байхдаа ч эспорантогийн хөдөлгөөнөө үргэлжлүүлж, Японы эспорантогийн хүрээлэнг удирдаж байсан байдаг. 1919-1930 он хүртэл Японд Финляндын элчин сайдаар суусан тухайгаа “Япон дахь Элчин сайд” хэмээх дурсамжийн ном бичсэн юм. Түүнийг бас Алтайн хэлний бүлэгт багтах турк, монгол, тунгус, солонгос, япон хэл судлаачдын анхдагч манлайлагч гэж хэлж болох бөгөөд харьцуулсан судалгааны олон бүтээл туурвисан билээ. 1939 онд Солонгос хэлний зүйн том бүтээл туурвиж япон, солонгос хэлийг Алтайн хэлний бүлэгт оруулсан болно. 1917-1919 болон 1930-1934 онд Хельсинкийн Их сургуульд багшилж байлаа. 1943 онд 70 насандаа тэтгэвэрт гарсан боловч мөн энэ оноос Фин-Уйгарын нийгэмлэгийн тэргүүлэгчээр ажиллах болсон юм. Түүний алтайн хэлний судлалд хийсэн үлэмж их ажлынх нь үр дүн болж “Алтайн хэлшинжлэлийн удиртгал” хэмээх ном бий болсон бөгөөд түүндээ алтайн хэлнүүдийн үг зүйн судалгааг маш нарийвчлан хийсэн байдаг. Мөн алтайн хэлнүүдийн хэлзүйн харьцуулсан болон түүхэн судалгааг насан эцэслэтлээ хийсээр байсан билээ. Тэрээр хойт туйлд харанхуй шөнө зам заагч алтан гадас одон мэт монгол судлал, алтайн хэлнүүдийн судлалд үлэмж их бүтээлээрээ тод гялалзан гэрэлтэх эрдэмийн алтан гадас одон байсан билээ.

Summary

Gustav John RAMSTEDT professor at the University of Helsinki, president of the Finno-Ugrian Society, member of the Finnish Academy of Sciences, and the founder of Mongolian dialectology and Altaic linguistics, died on November 25, 1950. Ramstedt was born in Ekenäs in Southern Finland. Ramstedt spent three years in Transbaikalia and Outer Mongolia. His explorations in Mongolia resulted in two excellent publications. In 1911 the Mongolian delegation in St.Petersburg asked Ramstedt to act as mediator with Imperial Russian government to support the Mongolian Independence from Chinese Empire. He managed to confirm the Russians of the good will of Mongolian representatives and they supplied 15.000 modern rifles to the Mongolians to start the uprising against the Chinese rule in Mongolia. Ramstedt is one of the earliest esperantist in Finland, learning it in 1891. He became chairman of the Finnish Esperanto Society. During his stay in Japan, he joined Esperanto-movement there, led by Japanese Esperanto Institute. Ramstedt was a pioneer in the study of numeral etymologies of a number of Asian language families (Turkic, Mongolian, Tungusic, as well as the possible isolate Korean). He also did extensive work on the general etymological history of Korean.

Ном зүй

1. G.J.Ramstedt, “Seven journeys eastward 1898-1912” translated by J.R.Krueger, Bloomington, Indiana, 1978
2. N. Poppe, GUSTAV JOHN RAMSTEDT *Exegi monumentum*, *Harvard Journal of Asiatic Studies*, Vol. 14, No. 1/2. (Jun., 1951), pp. 315-322.
3. www.wikipedia

СЕРГЕЙ ЕСЕНИНИЙГ БИ ХЭРХЭН ОРЧУУЛАВ

Ж.Нэргүй⁸⁶ (МУ-ын “Төрийн хэлний зөвлөл”)

Оросын уянгын яруу найргийн ханхүү Сергей Александрович Есениний яруу найргийг шимтэн уншдаг, зүрх сэтгэлээрээ уяран хайрлаж явдаг та бүхэндээ алтнаас үнэтэй цагаа хайхралгүй хүрэлцэн ирсэн явдалд баярлаж буйгаа юун түрүүн илэрхийлье!

Монгол Улсад анх удаа Сергей Есениний шүлэг, найраглалуудын орчуулгын талаар эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж байгааг молхи орчуулагч шал өөр, тэс ондоо хэл, соёл, урлагтай талын Монголд нутагшиж эхэлж буйн илрэл гэж ойлгож байна. Сергей Есенинийг Монголд ийнхүү нутагшуулахад манай үе үеийн их гүүш нар цаг тухай бүртээ өөрийн гэсэн хувь нэмрээ жаал жаалхан ч гэсэн оруулсныг хамгийн түрүүнд цохон дурьдаж, номын агаарт дүрст лагшингаа аль хэдийн хураасан заримынх нь дурсгалыг эргэн нэг санаж сэтгэл дотроо маанийн зургаан үсэг шивнэе. Харин өдгөө амьд сэрүүн, уран бүтээлээ туурвин гялалзаж яваа нэртэй, нэргүй олон дуун хөрвүүлэгч нарынхаа соён гэгээрүүлэх ариун үйлсэд өндөр амжилт хүсье ээ.

Ингээд энэхүү хурлыг зохион байгуулагчдын зүгээс дуртгасан захиснаар илтгэл гэдэг юмыг анх удаа тавьж үзэхээр эрдэм ихэт, сүр хүчит та нарынхаа өмнө зориглон гарлаа. Ингэхийн тулд хамгийн эхлээд Сергей Есениний маш товчхон намтар хийгээд түүний уран бүтээлийн талаар хэдэн үг хэлэх нь зүйтэй биз ээ.

Нэг. Есениний товч намтар хийгээд, түүний уран бүтээлийн талаар хэлэх хэдэн үг

Оросын нэрт яруу найрагч Сергей Александрович Есенин 1895 оны есдүгээр сарын 21-нд одоогийн Рязань мужийн Рыбновын районы Константиново тосгоны тариачин Александр Никитич, Татьяна Федоровна нарын ууган хүү болон төржээ. Гурван насандаа морь унаж сурч, таван насандаа уншиж, бичиж сурч, есөн наснаасаа шүлэг бичиж эхэлсэн гэж тэрбээр энд тэнд бичин үлдээсэн намтрынхаа товч төдий зурвасуудад дурьдсан байдаг юм. Тэрбээр голчлон ээжийнхээ аав, ээж хоёр дээр өсөж, авга ах нарынхаа хатуу чанга гараар хүмүүжжээ. 1909 онд тосгоныхоо бага сургуулийг төгсөөд, шашны сургуульд элсэн гурван жил суралцжээ. Гэвч түүнийгээ хаян гарч, эцгийгээ даган хар ажил хийхээр Москвад ирсэн авч, эзэдтэйгээ муудалцсаны улмаас тун удалгүй буцсан байна. Урьдчилан дурдахад, шашны сургуульд суралцсан жилүүд хийгээд шүтлэг ихтэй өвөө, эмээ хоёрынхоо нөлөөгөөр шашин бурханы сэдэвтэй маш олон тооны шүлэг, найраглал бичсэн байдгийг та бүхэн надаас илүү сайн мэдэх биз ээ.

⁸⁶ МУ-ын Төрийн хэлний зөвлөлийн ажлын албаны дарга, орчуулагч

1913 оны гуравдугаар сард дахиад Москвад ирж И.Д.Сытин гэгчийн нөхөрлөлийн Хэвлэх үйлдвэрт дагалдан хянагчаар орсон байна. Тус хэвлэх үйлдвэрт хянагчаар ажиллаж байхдаа дотносон нэгэн үе гэргий нь болж явсан А.Изряднова “...Хэдийгээр тэрбээр бөглүү тосгоноос ирсэн ч гэлээ хөдөөний залуутай огтхон ч төсгүй байсан юм. Хүрэн өнгийн костюм, цардмал босоо захтай цамц өмсөж, ногоон торгон зангиа байнга зүүсэн алтан шаргал үстэй тэр хүү яг л хүүхэлдэй шиг хөөрхөн амьтан байлаа. Өөрийгөө яруу найрагч хэмээн боддог ч, хэн нь ч түүнийг тоохгүй болохоор дандаа л сэтгэлээр унасан харагдах агаад аав нь түүнийг шал дэмий юм эрээчлээ гээд нэг нүдээрээ ч үзэхгүй. Жаахан л зав гарвал элдвийн юм уншаад үл салах бөгөөд өчүүхэн цалингаа ном, сэтгүүлүүд худалдан авахад л зарцуулчихна...” хэмээн дурсан бичсэн байдаг.

Сытины хэвлэх үйлдвэрт ажиллаж байхдаа тариачин яруу найрагч И.Суриковын удирддаг “Шанявскийн ардын их сургууль”-ийн хичээлд сууж нэр хүндтэй зохиолчдын лекцийг сонсон, залуу яруу найрагчидтай танилцан үерхэх болж, 1915 оны нэгдүгээр сард “Новь” сонин, “Парус”, “Заря” сэтгүүлүүдэд шүлгүүдээ анх хэвлүүлжээ. Гэвч түүний авъяасыг ихэмсэг, эрхэмсэг Москвагийн уран зохиолын хүрээнийхэн үл тоомсорлоод байсан тул нийслэл Петроград азаа үзэхээр очсон даруйдаа л бүхний хайрыг татаж, хамаг бүхнийг донсолгоод хаячихсан байдаг. Петроград ирээд Есенин А.Блок, А.Белый, Н.Клюев нартай дотно танилцаж амжсанаас уран зохиолын өсөлтөд нь хамгийн их нөлөө үзүүлсэн нь Вологод мужийн “тариачин угшилтай” яруу найрагч Николай Клюев юм. Орос зан заншил, утга соёлын өв, амьд үгсийн гүн бат мэдлэгтэн, ардын, хуучны хэв маягаар гайхалтай бичдэг Клюев тэр үед яруу найргийн дөрвөн ч түүврээ гаргачихсан байжээ. Харамсалтай нь, Есенин, Клюев хэмээх хоёр том найрагчийн нөхөрлөл тийм ч дардан замаар үргэлжлээгүй билээ.

1917 оны аравдугаар сарын хувьсгал гарах үед Николай хааны Армийн цэргийн эмнэлгийн батальонд алба хааж байсан тэрбээр эзэн хаанд зориулсан магтуу бичээгүйнхээ улмаас сахилгын батальонд хуваарилагдаж, галын шугаман дээр байсан агаад, удалгүй тэндээсээ оргож хаа ч юм, нэгэн тосгонд очоод суучихсан байдаг. Чухам тэр үеийнхээ сэтгэгдлийг өөрийнхөө хамгийн том, хамгийн уянгалаг найраглал “Анна Снегина”-д дүрслэн шүлэглэсэн байдаг. 1918 онд тэрбээр Москвад буцан ирж, аль ч нийгмийн өөрчлөлтийн зурвас үед бишгүйдээ л нэг олширдог урлаг, соёлын урсгалууд, тухайн үеийн бол модернистууд, символистууд, футуристууд, акмеистууд гэх мэтийн янз бүрийн урсгалуудын нэг болон гарч ирсэн яруу найргийн имажинист урсгалд хамагдан оржээ. Дашрамд дурдахад, имажинист урсгал гээч нь аливааг яг байгаагаар нь дүрслэн урнаар буулгах натурализмын нэг хэлбэр бөгөөд тухайн үед шоолж байснаар, тэрхүү урсгалынхан “сүсэгтнүүд эрхиэ хаанаас нь ч эхлээд эргүүлж болдгийн адил шүлгүүдээ эхнээс нь ч, сүүлээс нь ч хамаагүй уншиж болох”-оор урладаг байсныг бодоход тун чадварлаг найрагчид байсан бололтой. Харин Сергей Есенин тун удалгүй Клюев, Мариенгоф, Шершеневич, Ивнев зэрэг имажинист урсгалын “онолчид”-той эвдрэлцээд салан одож, өөрийнхөө л сэтгэл зүрхний тушаалаар, өөрийнхөө л зүрхний хөгийг цааснаа буулгах болсноос

хойш түүний хамгийн төгс төгөлдөр бүтээлүүд “Перс аялгуу” бүлэг шүлгүүд, “Анна Снегина” найраглал нь төрөн гарсан байдаг.

Тэрбээр эх орон, байгаль эх, хайрын уянгын хийгээд шашны сэдэвтэй олон зуун шүлэг бичиж үлдээснээс гадна “Евпатий Коловратын тухай дуун” (Энэ найраглалд Бат хааны өөдөөс цэрэглэн боссон ардын баатрын тухай гардаг), “Марфа Посадница”, “36-гийн дууль”, “Агуу их аян дайны дуу”, “Өөдгүй амьтсын эх орон”, “Пугачев”, “Инония”, “Анна Снегина” зэрэг найраглалууд, “Жалга”, “Цагаан усны нутаг” тууж, хэд хэдэн үгүүллэг, олон арван тэмдэглэл, нийтлэл, уран зохиолын талаархи бодрол үгүүллүүд туурвисан байдаг.

Түүний нулимс мэлтрэм уянгалаг, заримдаа дэндүү гэмээр задгай, зүрхшээнгүй модернизм (Тухайлбал, “Янагийн дуу нисэх хаврын өглөөгүүр би чинь ягаан морь унаад давхиад өнгөрөх нь энэ үү?” гэдгийг нь эргэн саная) хослосон яруу найраг, дэндүү “хөдөө тосгонлиг” аяс хэнбугайн ч зүрхийг “суга татаад” хаячихдаг билээ. Чухамхүү энэ “хөдөө тосгонлиг” аяс нь, “нулимсан заяат, энэрэнгүй хүмүүн” сэтгэлийг хугачин, нугачин дарах нь гарцаагүй хувьсгал, техникийн зууны довтолгоог урьдчилан харсан нь түүнийг егүүтгэх гүн ангалыг бэлдээд өгчихсөн байдаг. Нэгдүгээрт, гарцаагүй авъяаслаг, уянгалаг гэдгийг нь амаа олохгүй магтавч ачир дээрээ атаа жөтөөндөө хөтлөгдөөд галзуурах дөхсөн тэр үеийн зохиолч, яруу найрагчид, хоёрдугаарт, дээрхи шалтгааны хажуугаар бас бүхий л уран бүтээлээ Октябрийн хувьсгалд зориулдаггүй гэсэн шалтаг давхцаад түүнийг бүр ч хавчин гадуурхаж эхэлсэн юм. Тийм хүмүүсийн тоонд хувьсгалын үзэл сурталчдаас гадна сүүлд алдрын оргилд хүрсэн пролетарийн яруу найрагч Владимир Маяковский, зохиолч Дмитрий Фурманов, Константин Федин байтугай, ихэмсэг, эрхэмсэг түшмэл зантай, сэхээтний яруу найрагч Александр Блокийг ч оруулж болно. Тийм баримтууд жил ирэх тусам ил гарсаар байна. Ринчиний Чойном төр, нийгэмтэйгээ тэрсэлдэх болсон нь ч гэсэн мөн л тухайн үеийн Монголын зохиолч, яруу найрагчдын атаа жөтөөтэй холбоотой байдаг. Ер нь ихийг мэддэг, онол заалгасан нь үнэн ч гэлээ түшмэл зантай сэхээтнүүд цаг үе бүрийнхээ уран бүтээлчдийн яргачид байдгийг дашрамд дурдъя. Гэтэл яруу найраг гэдэг бол сэхээтний давхаргынх биш, ард түмнийх байдаг гэдгийг Есенин, Чойном хоёр батлаад өгчээ.

Түүнийг хорвоогоос хальснаас нь хойш бараг 30 жилийн турш шинэ нийгэмд таарахгүй ёс суртахуунтай хүн, “Гутранги үзэлтэн” гэсэн албан ёсны нэр хоч зүүгээд, 1926-1955 онд бүтээлийг нь өргөнөөр (“Массовым тиражом” гэж нэрлэдэг хэвлэл) хэвлэхийг хориглож, ялангуяа, дунд сургуулийн сурах бичигт оруулдаггүй, сургуулийн үдэшлэг, концертонд ч шүлгийг нь унших, романс голдуу дуунуудыг нь дуулахыг зөвшөөрдөггүй, зөвшөөрөгдсөн хэмжээнээс нь, (Өөрөөр хэлбэл, гэм хоргүйхэн шиг эх нутгаа магтсан шүлгүүдийг нь ч юм уу, Ленин, Октябрийн хувьсгалыг дэмжсэн бүтээлүүдийг нь л олон нийтэд түгээх) илүүтэйгээр сурталчилсан хүнийг тэр үеийн ЗХУ-ын Эрүүгийн хуулийн 58-р зүйлээр яллаж байсан юм билээ. Манай нэрт гүүшүүд өмнө нь тун цөөхөн шүлэг орчуулсан нь ч үүнтэй л холбоотой гэж би боддог.

Зарим үед сормуус норгом ариухан уянгатай атлаа зарим үед боож үхэх бор шидмэс эрээд гүйж явмаар сэтгэлийн их гутралаар дарамтлагдсан Есенинийг ганцхан хүрээнд хашин ойлгоход хэцүү. Түүний амьд үгс, ардын цэцлэлүүд өнөө ч гэсэн гайхалтай содноороо гайхагдсаар байна. Ганцхан жишээ дурдахад л, түүний “Анна Снегина” хэмээх найраглалд нь гардаг “Ни шатко ни валко, как встарь” гэсэн зүйр үгийн утгыг 2010 оны 8-р сарын 15-ны өдөр Оросын Google.ru вэбсайт руу орж хайхад урьд нь 7135 удаагийн хайлт тохиолдсон байлаа. Аль эсвэл өөр нэгэн жишээ татъя. Есениний ямар шүлгийн ямар мөрүүдийг яаж унших нь зүйтэй, хаана нь цохилттой байх ёстойг ч ЗХУ-ын ШУА-ийн Хэл, зохиолын Хүрээлэнгийн хуралдаанаар авч хэлэлцэж байжээ.

Эндээс харахад Сергей Есенин ардын, хуучны үгийг гайхалтай чадварлаг хэрэглэдэг, өвөрмөц яруу найрагч байсан нь тодордог.

Италийн эсэргүүцлийн хөдөлгөөний партизаныуд тулалдааны дараа түүдгийн дэргэд амсхийж байхдаа Есениний “Нохойн тухай дууль”-ийг нь ардын дууны аянд оруулаад дуулдаг байсан тухай ч дурсамж үлджээ. Ямар замаар тэр “галзуутай эмгэнэлийн шүлэг” нь хаа холын италичуудад хүрчихдэг байна аа? Сайн шүлэг жигүүртэй байдгийн жишээ энэ буюу.

Хоёр. Орос хэл хийгээд Есенинтэй танилцсан түүх минь

Энэ талаар ярихын өмнө би хэрхэн орос хэлтэй болсон тухайгаа хэдхэн үг хэлчихье. Өчүүхэн би бол мэргэжлийн орчуулагч хүн биш. Бага насаа яривал “хөдөөгийн хөөсөн мантуу”. Горькийн Утга зохиолын дээдийг байтугай, Багшийн дээдийн хэл, уран зохиолын багшийн анги ч төгсөөгүй л нэг муу “самоучка”. Харин наймдугаар анги төгсөөд одоогийн Беларусьт Ус, сувгийн техникумын хуваарь авсан маань миний амьдралын хамгийн дээд хишиг байлаа. Түүн дээр нэмээд аз болоход, зөвхөн аравдугаар анги төгссөн хүүхдийг л тэр хими, физик, онолын математикийн хичээл голчлон ордог Ус, сувгийн ангид нь наймдугаар ангийн боловсролын үнэмлэхтэй биднийг одоо яах вэ гэдгийгээ шийдэж ядаад Минскийн Барилга, уран барилгын техникумын захирал, цаашлаад бүр Беларусийн Боловсролын яам нь ч бүтэн сар үсээ үгтээсэн юм. Энэ бол 1973 оны намар байлаа. Тэрнийг нь далимдуулаад бид ч өөр мэргэжлийн ангид орохгүй гэхчээд унтаад байсан билээ. Энэ хооронд янз бүрийн түвшинд янз бүрийн олон яриа хэлэлцээр болсныг нь дурдаад яахав, ямар ч байсан уг техникум зөвхөн есхөн монгол хүүхдэд зориулж 40 жилийнхээ түүхэнд анх удаа ус, сувгийн мэргэжлийн нэгдүгээр курс нээсэн юм. Гэтэл нэгдүгээр курсэд нь зориулсан хичээлийн программ байхгүй байсан тул хоёрдугаар курсэд дэвшин суралцах хүртэл маань “Аргаа ядсан хүн адуу үргээнэ гэгчээр” голдуу орос хэл, хими, физик л заасаар өнгөрсөн билээ. Тухайн үеийн ЗХУ-д суралцахаар очсон монгол оюутнууд ганцхан жилийн орос хэлний бэлтгэл хийдэг байсан бол биднүүс тэгж хоёр жилийн орос хэлний бэлтгэл шахуу юм хийсэн нь надад гайхалтай завшаан болжээ.

Одоо тэгвэл Сергей Есенинтэй хэдийд танилцсанаа хэлбэл, наймдугаар ангийн орос хэлний сурах бичиг дээрээс түүний “Белая береза” гэдэг богинохон шүлгийг нь анх олж үзсэнээр эхэлжээ. Нэг л нүд сохлом сайхан гэрэл гялалзсан, сэрүү татсан цасан цагаан агаар цангинасан шүлэг байна гэж бодсоноо ч одоо

санаж байна. Тэгээд нэг өдөр тэрнийг нь орчуулаад үзмээр санагдсан, тэгээд орчуулчих шиг болсон, гэхдээ тэр маань 40 жилийн дараа л нэг юм санаанд минь хүрснийг мэдэрсээн.

Орост явж очоод Есениний түүврийг сурагласан чинь олддоггүй ховор эд байлаа. Ташкентад бол бүр ч нүдний гэм. Би ч нялх байсныг хэлэх үү, хаагуур сураглахаа мэдэхгүй. Тэгсэн атал овоохон орос залуучууд нь болохоор түүнийгээ уншаад шүлсийг минь гоожуулаад байх юм. Минскт очоод сурагласан чинь бас л байдаггүй ээ. Олж чадахгүй хоёр ч жил болов. Нэг өдөр харин номын дэлгүүрийн үүдэнд “Есениний түүвэр удахгүй гарна. 10 кг хаягдал цааш тушаасан баримт авчирсан хүнийг оочерт бичиж байна” гэсэн зарлал наачихсан байлаа. Тэгээд л оюутны байранд хаягдсан дэвтэр, номууд цуглуулж эхэлсэн юм даа.

Сургуулиа төгсөж ирээд сурагласан чинь Есениний орчуулга гэдэг нь бас л олддоггүй эд гэнэ ээ. Цэдэндорж нь ч гэнэ үү, Цэндгомбо нь ч гэнэ үү нэгнийх нь орчуулсан шүлгүүд байдаг л гэх, олддоггүй ээ. Нямсүрэн маань л жаахан халчихаараа “Яруу найрагч байна гэдэг...” гээд хааяа нэг уншина. Ялангуяа энэ хорвоогийн эхнэрүүдэд гомдсон үедээ шүү дээ. “Яруу найрагчийг гэртээ очиход янаг нь харин өөр хүнтэй хэвтэж байвал” ч билүү, юу ч билээ, тийм нэг шүлэг. “Энийг чинь хэн орчуулсан юм бэ?” гэхээр “Явуухулан” гэнэ. Тэр нь ч айхтар сүйдтэй санагдсангүй. Явуухулангийн чухам ямар номон дээр нь байдгийг би одоо хүртэл олж үзээгүй л явна. Бас Жамбалгарав маань “Качаловын нохой”-г уншина. “Хүдэр минь дээ, чи хөлөө надад хайрлаач” гээд л. Жим гэдэг нохойд Хүдэр гэдэг монгол нэр өгчихөж. Би бодно: “Хүний ч бай, нохойны ч бай нэрийг орчуулдаг л юм байх даа” гэж. 90-ээд оны эхээр Эрэнцавын Алтангэрэл гэж нэг багш Есенинийг орчуулсан, хэвлүүлэх юмсан гээд л яваад байх болов. Тухайн үедээ нэг таарахад уншиж өглөө. Нэг л биш ээ. Сүүлд хэвлэгдсэнийг нь ч мэдээгүй юм. 4-5 жилийн өмнө яруу найрагч Хишиг-Ундрал нэг жижигхэн хүрэн номоо өглөө. “Сонгох цаг” цувралаараа гаргасан Сергей Есениний тухай эмхэтгэл юмсанж. Э.Оюун, С.Баясгалан, М.Равдандаш нарын орчуулгууд оржээ. Үзсэн болсхийгээд хадгалчихав.

Есенинийг ер нь орчуулах болно гэж хэзээ ч бодож явсангүй. Ноднин зун л гэнэт Нямбуугийн Нямдоржийн нутгаар яваад, Онон мөрнийхөө хөх модон гүүрэн дээрээс хархираат түргэн урсгалыг нь ширтээд зогсож байхдаа л онгод гээч нь орсон юм байлгүй гэнэт, “Орчуулаад хаячихъя” гэсэн бодол төрсөн юм. Ирсэн оройноосоо л өдөр шөнөгүй сууж байгаад 10 хоноход яс мод нь босчихсон байлаа. Харин хэвлүүлэх зардал эрээд 4 сар болох хоорондоо жаал, жуул янзалсаан. Энэ дашрамд дурдахад, анхны маань тэр орчуулгын түүврийг хэвлүүлж өгсөн Монголын соёл, яруу найргийн академийн Мэнд-Ооёо, Мөнхнаран хоёртоо дахиад нэг талархал дэвшүүлье.

Уг түүврээ хэвлэлд өгөх гэж явж байхдаа нэг өдөр би уран зохиолд хязгааргүй элэгтэй, Монголын бараг л овоо гэсэн бүх яруу найрагчдын олигтойхон шүлгүүдийг цээжээрээ уншдаг, Нямсүрэнтэй ганцхан удаа уулзсаныгаа тэнгэрийн хишиг гэж санаж явдаг Санжжавын Отгонбаатар гэдэг хуурай дүүтэйгээ таарлаа. Тэр бол Баянгол дүүргийн IV хороолол дахь Орон

сууцны “Хөх Асар” компанийн сантехникийн слесарь залуу л даа. “Есенинг орчуулчихаад явж байна” гэсэн чинь “Өө, Нэргүй ах аа, надад бүх түүвэр нь байгаа шүү дээ” гэж байх юм. “Худлаа хэлээд л, тэр Цэдэндоржийнх нь ч байгаа юу?” гэсэн чинь, “Байлгүй яах юм бэ. Цэндгомбынх нь ч юм уу, мэдэхгүй, хавтас нь салчихсан, дээр үеийн нэг нимгэхэн түүвэр байгаа. Алтангэрэлийнх ч байгаа” гэдэг байна шүү. Авчраад өглөө, уншлаа. Тэр өдөртөө шахуу буцаагаад өгчихлөө. Орчуулахынхаа өмнө олж уншаагүй минь аз л гэж бодсон. Тэгсэн бол “Миний Дагестан”-ыг монгол хүн бичсэн мэт буулгасан тэр агуучуулын барилд баригдчих байсан ч юм билүү гэж хэзээ хойно нь айсан. Отгонбаатарын сайхан сэтгэлээр авчирч өгсөн тэр ном миний 40 жил зүүдэлж ирсэн Есениний уянга нь ч, үг нь ч биш байсан юм. Одоо болтол тэр орчуулга Цэдэндоржийнх нь юм уу, Цэндгомбынх нь юм уу, би мэдэхгүй л явна. Гэхдээ би ингэж хэлснээрээ өөрийгөө л магтаж байгаа юм биш, орос хэлтэй хүмүүс захаас аваад байдаг юм чинь, өөрсдөө харьцуулаад үзнэ биз л гэсэн санаа өгч байгаа хэрэг юм шүү.

Ер нь би орос хэлнээс л орчуулга хийдэгтээ нүүр бардам явдаг хүн. Яагаад гэвэл, манайхны орос хэл сайн мэддэг гэж бодож явдаг хэн нь ч тэр цаад орос эхийг нь олоод, эсвэл үй түмээрээ л байдаг аль нэг орос вэбсайтаас орос эхийг нь татаж аваад миний орчуулгатай тулгаад хяначихаж болно шүү дээ. Гэтэл англи, герман, францаас орчуулга хийдэг хүмүүст орос хэлтнүүдийг харьцуулбал тийм олон “хянагч” байхгүй болохоор “амар”. Тэгээд ч тухайн хэлнээс уран зохиолын бүрэн төгс орчуулга хийж чаддаг болтол дор хаяад 20 жил уг хэлийг үзэх хэрэгтэй байдаг юм даа.

За ингээд, Есениний шүлгүүдийг хэрхэн монголчилсон талаархи хэсэг рүүгээ оръё. Шүлгийнх нь номыг дэлгэж тавиад шууд л эхнээс нь явсан. Өөрөөр хэлбэл, 15-16 настай үеийнхээс нь. Тийм нэг онц гайхмаар санаагүй цагаан шүлгүүд атлаа өглөөний нар хараад нэг нүдээ аньхийгээд зогсож байгаа жаахан хүүхдийн хөхрөөн шиг жин жин хийсэн аялгуутай гэгээн шүлгүүд ямар ч түүврийнх нь эхэнд л байж байдаг юм чинь тосон дээгүүр гулгаж байгаа юм шиг л нульхийгээд явчихсан. Цашаагаа тэгээд морио зайдан унаад хоёр хөлөө савчуулаад шүүдэр туучаад, хашгичаад давхиж яваа юм шиг шүлгүүд нь бол бүр ч бидний монголчуудын л хүүхэд ахуйн дурсамж гэсэн үг. Хэрвээ та нар анзаарсан бол, шүлгүүдийн бичигдсэн он, сарыг нь ч алдалгүй яг л дарааллаар нь орчуулгын түүвэртээ оруулсан байгаа. Өөрөөр хэлбэл, яг л Есениний өөрийнх нь яруу найрагч болсон үе шатуудыг ч би мөн л тэр 10-хан хоногт туулаад өнгөрсөн байгаа. Энгийн шүлгүүдээс нь эхэлж уйтгар гуниг, гутрал цөхрөлийг нь мөр алдалгүй дагасан болохоор уянга, хийгээд хэлбэр хийц нь ч хадгалагдсан гэж бодож байна.

Гэхдээ баримталсан хоёрхон зарчим маань гэвэл:

1. Есениний гайхамшигтай тансаг үгүүдийг яг л тэр чигээр нь монголчлохыг хичээсэн.
2. Тухайн шүлгэнд сонгон хэрэглэсэн үгсэд нь тохируулаад уянгыг нь хадгалахыг хичээсэн.

Тухайлбал,

“Выткался на озере алый свет зари.

На бору со звоном плачут глухари” гэдгийг үгчлээд:

“Нууран дээр үүрийн улаан туяа туслаа.

Сойрын дуу нарсан төгөлд хангинатал уйллаа” гэвэл хэдийгээр шүлэг маягтай юм болж байгаа ч гэсэн өнөөх л “подстрочный текст” нь болчихно. Харин:

“Нуурын цаанаас үүрийн туяа улсхийн гийхэд

Сойрын дуу нарсан төгөлд уйтайяа мэгшинэ” гэхихээр нэгд, “выткался” гэдэг үгнээсээ болоод хамаагүй илүү хөдөлгөөнийг бий болгочихоод, үүрийн туяа хачин их хурдтайгаар гийж буйн дүрслэлийг төлөөлнө. “Манхайн цайна” гэхээр цагаан гэгээ нь илүү болчихно, харин “улсхийн гийхэд” гэхихвэл мөнөөхөн “алый свет” гэдгийгээ давхар илэрхийлэхээс гадна, “уйтайяа мэгшинэ” гэдэгтэйгээ сүүл холбогдоод арай илүү зөөлрөөд, арай илүү уянгалаг болчихсон байх аа гэж бодож байна.

Есениний үгийн сонголт гэдэг бол гайхалтай. Үгээр дамжуулж уянгаар тоглодог шүү дээ. Үг гэдэг маань авиа. Түүнээс өмнөх, хойнох ямар ч яруу найрагч Есенинээс давах уянгат үгийн мастерууд биш байсан болохоор л оросууд түүнийг бурханчлаад байдаг юм. Тухайлбал, “Есенин гэдэг нэрээ “есень, весень, осень, осинь” (хавар, намар, улиас) болгоод хэдэн арван хувилбараар тоглоод байдаг байсан” гэсэн дурсамжууд уншиж байснаа санаж байна. Тэгвэл уянгыг нь гаргахын тулд орос үгийн мэдлэг гэхээсээ илүүтэй аялгууны мэдлэг, хэллэгийн дадлага, дуудлагын мэдрэмж илүү хэрэг болдгийг та бүхэн мэдэх биз ээ. Тийм болохоор Есенинг орчуулахдаа шүлгүүдийг нь оросоор нь л дандаа амандаа үглээд сууж байдаг байлаа.

Тийнхүү би орчуулж эхэллээ.

Хамгийн эхний хүндрэл “Ты такая же простая, как все” гэдэг шүлэг дээр нь таарсан. Өөрөөр хэлбэл, тэр шүлгийн

“Твой иконный и строгий лик

То часовням висел в рязанях” гэдэг нэг шад дээр. “Рязань” гэдэг үгийг би ямар учиртайг урьд нь эргэцүүлдэг л байлаа. Ер нь ямар ч үндэстэн, ард түмний хүний ч нэр, газар, усны ч нэр цаанаа л нэг учиртай байдаг шүү дээ. Ухаандаа, Москва гэдэг бол Чулуун бэхлэлт гэсэн үг, Чернобыль гэдэг бол хар шарилж гэсэн үг. “Хар шарилжит” гэдэг газар аваачаад барьчихсан Атомын цахилгаан станц дэлбэрэх нь ойлгомжтой шүү дээ. Улаанбаатар гэдэг үг ч юу дагуулаад байгааг ноднин намар Өнөөдөр сониноор анхааруулсны минь учир тэр.

Ингээд өнөөх “рязань” гэдэг үгийг хайгаад хамаг толь бичгээ онгичлоо. Ц.Дамдинсүрэн гуайн “Орос-монгол толь” бол орчуулагч нарт жижигддэг л дээ. Хэдийгээр үгнүүдийнх нь монгол оноолт гайхалтай сайн ч гэлээ, нөөц нь дэндүү чамлагддаг юм. Ийм болохоор надад янз бүрийн салбарын, том жижиг 20 орчим орос тайлбар толь байдаг юм. Тэдгээрийгээ ч хангалттай гэж аархдаг байлаа,

мөнгө төгрөг ч хүрэлцэхгүй болохоор Далийн толь худалдаж авч чаддаггүй юм. Гэтэл надад байгаа хэдэн словарь дээр маань өнөөх үг чинь алга аа. Тэр үед би гэрийн Интернет холбуулаагүй байсан болохоор Далийн толь руу орчих боломж байсангүй, гарч Интернетэд хайя гэхээр тэнгэр уйлагнасан нэг хачин өдөр. Тэр шүлгийг түр орхичихъё гэхээр шар хөдлөөд болдоггүй, өнөөх онгодын хүлэг нь ч үүрсээд алга болох юм билүү. Аргаа бараад орос хэлний гоц мэдлэгтэн профессор Баясгалан гуай руу утасдлаа, “гар” нь ч хариулдаггүй, “гэр” нь ч байдаггүй. Айж, айж Аким гуай руу утасдлаа. “Ёстой мэдэхгүй юм байна” гэлээ. “Ажил дээр чинь Далийн толь байдаг л биз дээ, хараад өгөөч?” гэсэн чинь “Юу гэж энд байж байхав дээ, гэрт л байгаа. Чи манайх руу утасдаад, Дулмаа эгчээрээ харуулчих” гэж байна. Аким гуайн гэргий Дулмаа эгч бол насаараа орос хэл заасан багш юм чинь, гэр лүү нь залгалаа. Дорхноо л Дулмаа эгч утсаа авлаа, сөөнгөдүүхэн хоолойгоороо “Хэн бэ?” гэж байна. Учраа хэллээ. “Тэгье, тэгье” гэж байна. Гурван минутын дараа тэсэлгүй залгасан чинь “Үзчихлээ, нэг л тийм давжаавтар алим юм уу даа, бас ард нь китайские яблоки, райские яблоки гэж байна” гэхээр баярласан гэж жигтэйхэн. “Тэгэлгүй яахав дээ, наадхи чинь тэгвэл Диваажингийн алим гэсэн үг байна. Есенин, Людмила Зыкина хоёрын нутаг диваажин л байж таарна шүү дээ” гээд л. Нээрээ ч Христийн шашны зарим архад, бурхадын хөргийг эмжсэн усан үзэм ч юм уу, давжаа алим ч (манайхан бол арнийтаг гэдэг дээ) юм уу, нэг тиймэрхүү юмнууд байдаг нь санагдаад явчихав. Үнэн алдартны сүм хийдүүд Алимны баяр гээд л баахан алим тараадаг баярын өдрийг тэмдэглэдгийг ч уншсанаа санах.

Тийнхүү “Чи үнэндээ бусдын л адил жив жирийн...” гэсэн шүлэгт нь:

“Диваажингийн алимаар эмжсэн бурхадын хөрөгтэй

Тэнгэр мэт төв ширүүн царай чинь юутай ижилхэн” гэсэн мөрүүд буусан юм.

Бас “Гой ты, Русь, моя родная” гэдэг шүлэгт нь байдаг

“Пахнет, яблоком и медом

По церквям твой кроткий Спас” гэсэн хоёр мөрөн дээр гацаж орхив. Яахаараа сүм хийдүүдээр нь зөгийн бал, алимны үнэр сэнгэнээд байдаг билээ? Манайд бол арц, хүжний л үнэр сэнгэнэдэг шүү дээ гэж бодоод. Тэнд ч гэсэн бас арцархуу юм баагиулаад, бойпороо савчуулаад л явж байдаг шүү дээ гэж бодлоо. Тэгээд шашны хэллэгийн тайлбар толь нээгээд үзсэн чинь Улаан өндөгний баяр гэдэг шиг Алимны баяр, Зөгийн балны баяр гэж бас байдаг юмсанж. Христийн шашны гурван том баяр тэр гэнэ. Өндөг үнэртдэггүй, харин нөгөө хоёр нь л сэнхийтэл үнэртдэг болохоор нь сүмийн өвөрмөц орчинг тийнхүү гаргаж. Ингээд “Хурай, хурай, унаган төрөлх орос нутаг минь” гэдэг тэрхүү шүлгийнх нь дээрхи мөрүүдийг

“Зөгийн бал алимны үнэртэй холилдон сэнхийх

Зөндөөн олон сүм хийдээр чинь Спас бурхан ирийнэм” гэж монголчлоод доор нь бас тайлбар бичлээ. Тийм баяр байдаг гэдгийг нь шүтлэг өөртэй монголчууд минь ч мэдэж аваг гээд.

Ер нь ямарваа ном гаргана гэдэг бол толгой доторхийгоо л бусадтай хуваалцаж байгаа хэрэг хэмээн молхи бичээч би мунхагладаг билээ. Буян гэж

санавал тэр л биз, үгүй бол тэр л биз. Манайхан чинь мөнгө тараасан улстөрч, тав давсан бөх хоёрыг л буянтай улс гэж үздэг болчихсон юм чинь, бараг л үгүй байхаа даа.

“Черный человек” гэдэг бэсрэг найраглал нь “Хар хүн” гэж л манайхны толгойд буудаг. Үүнийг би “Сүг сүүдэр” гэж монголчилсныг хүмүүс гайхаад байдаг юм. Тэгвэл “Хар хүн” гэж юу юм бэ? Энэ бол царай зүсний тодотгол биш. “Хар хүн” гэж “Эр нөхөр” гэсэн ганцхан утга л монгол хэлэнд бий. Бас негр хүнийг хэлж болох. Гэхдээ яг “Черный человек” гэдэг нь манайхны төсөөлдгөөр тийм нэг хорон санаатай хүн нь мэдээж боловч тийм хүнд монголчууд “Хар хүн” гэсэн нэр хоч өгдөггүй. Тэгэхээр найраглал доторхийг нь гайгүй сайн ухааж үзэхээс гадна, зовлонт найрагчийн туулсан замыг ч бас мөшгих хэрэгтэй болно. Эцэст нь ямар гаргалгаа хийж болох вэ гэхээр, нэг талаас, атаа жөтөөндөө хөтлөгдсөн авъяасны хагастангууд, мөрийг нь мөшгиж, мөчийг нь тоолж сүүдэр мэт дагаж явсан тэр үеийн бичээчингүүд, Октябрийн хувьсгалыг магтан дуулаачингууд, хар санаатангууд, Дэлхийн хувьсгалын дайнч уриагаар зэвсэглэсэн үзэл суртал хийгээд ёс суртахууны номлоочингууд, нөгөө талаас болохоор хайр сэтгэлийн ч, уран бүтээлийн ч боогдмол эрх чөлөөндөө галзуурах шахсан Есенин өөрөө бус уу? Архины цагаан солио тусаад, нүдэнд нь дандаа хий юм харагдаад, тэр бүхнээс жаахан ч гэсэн холдохын тулд эмнэлэгт хэвтсэнийг нь ч дурсаж болно. Найраглалын нэрийн гол санаа, тайлал нь ч “сүүдэр, сүг, сүнс”, толинд туссан өөрийнх нь дүрс л байдаг.

Есениний орчуулгын түүврийн хоёр дахь хэвлэлд би “Анна Снегина” найраглал, 10-аад шүлгийг нэмж оруулсныг та бүхэн анзаарсан биз ээ. Ялангуяа “Анна Снегина” бол гайхалтай орос ахуйтай, гайхалтай уянгалаг, хамгийн том бүтээлүүдийнх нь нэг.

Гэтэл урьд нь хийгдсэн нэг монгол орчуулгад үгүй ядахнаа тополь гэдгийг л лав тоорой мод гээд буулгачихсан байдаг. Гэтэл тэр чинь улиангар шүү дээ. Улиангар гэдгийг мэдэхгүй байж болно, харин Оросын төв хэсэгт тоорой байдаг эсэхийг мэдэхгүй орчуулагч байсан нь жаахан тиймхэн. Аль эсвэл “Никогда я не был на Босфоре” гэдгийг “Босфорт би хэзээ ч очиж үзээгүй” гээд орчуулчихсан юм бас таарлаа. Иймэрхүү маягаар орчуулж байгаа нөхцөлд Сергей Есениний уянга хэрхэн монгол руу буух вэ дээ гэдэг хатуу үгийг энэ зуур нэг хавчуулчихъя.

“Анна Снегина”-д

“И вот, я опять в дороге.

Ночная июньская хмарь.

Бегут говорливые дроги

Ни шатко ни валко, как встарь” гэдэг гайхалтай сайхан дөрвөн мөр байдаг юм. Энүүхэн дөрвөн мөрийн сүүл холбохдоо “хмарь, встарь, дрога” үгүүдийг хэрэглэсэн нь одоо нэгэнт ойлгогдохоо больсон юм байна. Дээр дурьдаад өнгөрснөөр “Ни шатко ни валко, как встарь” гэдэг үгийн утга Далийн толинд ч бүрнээрээ байхгүй учир тосгоны ахуйгаас даанч их холдсон оросууд интернет рүү 7000 гаруй удаа утгыг нь хайж орсон байснаас гадна “ни шатко ни валко” гэдэг хоёр үгийн дунд таслалтай байх эсэх дээр бүрэн тайлбар өгөөгүй л

байна. Энэ нь уг чанартаа бол “Арай ядсан, аргацаасан” гэсэн утгатай гэдгийг Интернетийн тусламжтайгаар л олж мэдлээ. Харин арынх нь “встарь” гэдэг бол “дивангарвын” гэсэн үг.

Ингээд уг 4 мөрийг

“Зургаан сарын сүүдгэр шөнө

Замдаа би дахиад л гарлаа.

Дөрвөн дугуйтай хөнгөн тэргээр

Дээхэн цагийнх шиг дэндэгнүүлж гарлаа” гэж буулгалаа.

Цааш явъя:

Сергей Есенинд ганцхан сонет, ганцхан акростих буюу эхлэл үсгийн шүлэг байсныг ч мөн олж хоёр дахь түүвэртээ орууллаа. Сонетын хувьд бол ийм хийцтэй европ шүлгийн өргөлт, цохилтын дэс дараатай хатуу дүрэм монгол шүлэгт тохирдоггүй болохоор ерөнхийдөө монгол шүлэгтэй л адилхан юм болголоо.

Харин “Рюрику Ивневу” гэсэн нууц түлхүүртэй акростихийг монгол руу буулгахад их хэцүү байсныг дурдахаас аргагүй.

МОНГОЛ ДАХЬ ХАЙКУ⁸⁷ ШҮЛГИЙН ОРЧУУЛГА БА МОНГОЛ ХАЙКУ

Т. Болдбаатар⁸⁸(МУИС, ШУС)

Товч утга: Тус өгүүллийн эхэнд Монголд⁸⁹ хаикү шүлгийн талаарх ойлголт ямар хэмжээнд байгаа талаар товч дурдана. Удаад нь японы хаикү шүлгийг монгол хэлнээ орчуулсан болоод орчуулж байгаа байдал, мөн монгол хэлээр зохиогдсон хаикү шүлгийг япон хэлнээ хэрхэн буулгасан байдлыг тодорхой жишээгээр авч үзнэ. Ингэхдээ тухайн хэлнээс нь шууд болон дам орчуулахын ялгаатай талыг онцолж үзэх болно. Мөн хаикү шүлгийн нөлөөгөөр бий болсон яруу найргийн шинэ төрөл жанрын талаар танилцуулна. Эцэст нь дүгнэлт хийхийн зэрэгцээ хаикү шүлгийг орчуулах тал дээр баримталбал зохих журмын талаар санал дэвшүүлсэн болно.

Түлхүүр үг: Хаикү шүлэг, орчуулга, монгол хаикү

1. Оршил

Хаикү шүлгийн талаар сонирхох хандлага сүүлийн жилүүдэд илт ажиглагдах боллоо. Өмнө нь хэвлэгдсэн ном өгүүллээс монгол хэл дээр уншиж танилцахаас гадна гадаад хэл дээр унших явдал ч байна. Тэрчлэн гадаад хэл, тухайлбал англи хэлнээс орчуулан бусад сонирхогчидтойгоо хуваалцах нь элбэг ажээ. Түүгээр ч зогсохгүй монгол хэл дээр хаикү зохиохын зэрэгцээ гадаад хэлнээ орчуулан олон улсын тэмцээн уралдаанд ч оролцсон тухай мэдээ байна⁹⁰.

Ийм хэмжээнд хүртэл хаикү шүлгийг сонирхон оролдох болсон нь сайшаалтай хэрэг боловч хайкү шүлгээр илэрхийлсэн мэдрэмжийг орчуулгаар дамжуулан үнэн зөвөөр хүлээн авч, хүртээж чадаж байна уу гэдэг асуудал байгааг бас бодолцох хэрэгтэй юм. Уншигчдын таашаан үздэг япон хаикүгийн эх нь чухам ямар шүлэг байв, монгол хаикүг гадаад ертөнцөд танилцуулахад зохиогчийн өгүүлэх гэсэн утга санаа орчуулгаар дамжин гуйвсан байх асуудал байна уу, хайкү шүлгийн талаарх ойлголт мэдлэг нь ямар хэмжээнд байгаагаас хамаарсан монгол хаикүгийн чанарын асуудал гарах уу гэсэн асуултууд зайлшгүй тавигдах буй заа.

Энэ удаа хаикү шүлгийн орчуулгад гарч буй зарим анхаарал татам асуудлыг тодорхой жишээн дээр хөндөх бөгөөд ялангуяа уг эх хэлнээс нь бус,

⁸⁷ Энэ үгийг өнөөг хүртэл “Хайку”, “Хайкү” гэхчлэн бичиж ирсэн нь япон хэлний дуудлагаас зөрүүтэй байна. Иймд хамгийн ойролцоо бичигдэж дуудагдах талыг нь бодолцон “Хаикү” гэж галиглах нь зүйтэй юм. Япон үгийг монгол кирилл үсгээр хэрхэн галиглах талаар Т.Болдбаатар (2007) дэлгэрэнгүй бичсэн байгаа.

⁸⁸ МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын Ази Судлалын Тэнхимийн докторант, ахлах багш.

⁸⁹ Энэ үгийг зөвхөн Монгол Улсын хэмжээнд хязгаарлаж авч үзэв.

⁹⁰ <http://tsagaanharatsai.blogmn.net/97352/haikun-kukai-uraldaanuud-.html> visited 29/04/2013

өөр хэлнээс дамжуулан орчуулахын дутагдалтай талыг тодруулан харуулахыг зорьсон болно.

Өгүүллийн хэмжээ хязгаартайн улмаас хаикү шүлгийн онцлог, хэм хэмжээний талаар тухайлан тайлбар хийгээгүй болохоо энэ ташрамд тэмдэглэе.

2. Хаикү шүлгийн талаарх ойлголт

Хаикү шүлгийн талаар хамгийн анх танилцуулсан хүн бол Б.Явуухулан (1964) юм. Тэрээр “Японы хайку 3 мөр 17 үет шүлэг юм. Нэг хайку гол төлөв 5-7 үгээр бүтэх бөгөөд 8 үгтэй байх нь ховор тохиолдоно. Ер нь япон яруу найрагт шүлгийн бүтэц нь мөрийн жигд хэмнэл бөгөөд толгой буюу сүүл холбох шаардлага байдаггүй.”⁹¹ гэсэн бөгөөд нэлээд хэдэн хаикү шүлгийг орос хэлнээс орчуулан танилцуулсан юм. Мөн монгол хаикү зохиох оролдлого бас хийж байжээ. Хаикүгийн улирлыг илтгэх үгийг онцгойлон үзсэн байдаг.

Ж.Лхагваа (1973) японы уламжлалт танка шүлэг болон хаикү, орчин үеийн яруу найргийн дээжийг орос хэлнээс орчуулсан билээ. Мөн хаикүгийн түүхийн талаар тайлбарлахын зэрэгцээ бүтцийн талаар “Хайку нь 17 үетэй...”⁹² гэсэн. Д.Одонхорлоо (1987) Ёса Бүсон, Саигёо, Мацүнага Тэитокү нарын шүлгийг орос хэлнээс орчуулсан юм. “Хайку бол 3-н мөрт шүлэг бөгөөд 5-7-5 гэсэн 17-н үеэс бүтнэ...”⁹³ гэжээ.

Социалист нийгмийн үед зөвхөн дээрх гурав л байсан бөгөөд орос хэлний материал дээр л тулгуурласан байдаг. Харин 1990-ээд оноос эхлэн япон хэлнээс шууд орчуулах болжээ. Б.Сэржав (1990) Монголд анх удаа япон хэлнээс хаикү орчуулсан⁹⁴ юм. Кимүра Аяко (1998) хаикүгийн хэмнэл гэдэг ойлголтыг тайлбарласан ба улирлын үгийг онцолсон билээ. “Хаикү болон танка шүлэгт мөр гэдэг юм байхгүй... Тав долоо тав гэсэн бүтэцтэй.”⁹⁵ гэсэн нь онцлууштай. Г.Аюурзана (2002) хаикү шүлгийн тухай тайлбарлан ямар мэдрэмж төрж буй талаар бичсэн. Бүтэц болон улирлын үгийг онцолсноос гадна монгол хаикүг танилцуулсан юм. “17-хон үед багтаан бодол сэтгэлээ бичих ёстой... Гэхдээ Башёгийн хайкүнд 2 дахь мөр нь 9-н үеэс бүтсэн мөр байдгаас үзвэл хэлбэр чухал биш”⁹⁶ гэж үзсэн байна. Б.Энэбиш (2002) японы эртний вака, хаикү, орчин үеийн яруу найргийг орос хэлнээс орчуулжээ⁹⁷. Д.Болдбаатар (2004) Ман-ёогийн найрагчид Нүкада-но Оокими, Оотомо-но Якамочи болон Оно-но Комачи нарын вакаг 4-н мөртөөр, Мацүо Башоо, Кобаяши Исса, Ёса Бүсон нарын хаикүг 3-н мөртөөр орчуулсан⁹⁸ байна. Харин тэрээр ямар хэлнээс орчуулсан нь тодорхойгүй. Япон хэл үү, хятад хэл үү? С.Хүрэлбаатар (2005) хаикүгийн улирлын үг, тогтсон хэмнэлийн тухай тайлбарласан. Англи, орос

⁹¹ Б.Явуухулан. “Японы хайку хэмээх сонгодог яруу найргаас”, Цог сэтгүүл.УБ.,1966. №1. 85-р тал

⁹² Ж.Лхагваа. “Японы яруу найраг”. УБ.,1974.31-р тал

⁹³ Д.Одонхорлоо. “Зохист аялгуу ” сонин.УБ.,1987.

⁹⁴ Б.Сэржав. “Дорно дахины судлалын асуудал” сэтгүүл.УБ.,1990.№1.136-р тал

⁹⁵ Кимүра Аяко. “Яруу найрагч Такүбоку ба япон шүлгийн онцлог”, Ил товчоо сонин.УБ.,1998.10.15-10.24.№32/304/

⁹⁶ Г.Аюурзана. “Зуслангаас үүдсэн хайкүны тэмдэглэл”, Дурлалгүй ертөнцийн блюз тэргүүтэн хүүрнэл зохиолууд. УБ.,2002.194-196-р тал

⁹⁷ Б.Энэбиш. “Японы яруу найраг”. УБ.,2005. 103-105-р тал

⁹⁸ Д.Болдбаатар. “Японы яруу найраг”. УБ.,2005. 138-140-р тал

орчуулгад баримталдаг журмыг бас танилцуулсан байна. Эцсийн дүндээ яруу найргийн орчуулга боломжгүй зүйл гэж үзсэн. “Хайкү бол 5-н үеэр эхэлж, 7-н үе болоод 5-н үер төгсдөг.”⁹⁹ гэсэн. Д.Цэдэв (2005) хаикүг тайлбарлан орчуулгын тухайд жишээ татан харьцуулсан байдаг. “Хайку нь япон хэлний 5-7-5 гэсэн үеэр бүтдэг шүлэг юм.”¹⁰⁰ гэсэн. Г.Мэнд-Ооёо (2005) хаикүг тайлбарлахын зэрэгцээ орчуулсан зарим хүмүүсийг танилцуулсан. “Кимура Аяко монгол хэлээр хайку орчуулсан...”¹⁰¹ гээд доорх шүлгийг танилцуулсан.

Хацар даган бөмбөрөх

Халуун нулимсны минь дуслын тоогоор

Элс атган бэлэглэсэн хүнийг насандаа би мартаггүй.

Дашрамд тэмдэглэхэд, Кимура Аякогийн орчуулсан уг шүлэг нь хаикү бус танка юм. Хаикү бол 3-н мөрт гэдгээс үүдсэн эндүүрэл гарсан болов уу.

Г.Аюурзана (2005) хаикү, эртний нангиад шүлгийг зэн-гийн үүднээс тайлбарласан нь бас бий¹⁰². М.Шагдарсүрэн (2007) Кадокава Харүкигийн хаикү шүлгийн түүвэр “JAPAN”-ыг япон хэлнээс орчуулсан¹⁰³. Д.Мандах (2010) хаикүгийн талаар авч үзсэн судалгааны нэг сэдэвт бүтээл гаргасан. Хаикүгийн орчуулга болон монголын уран зохиолд үзүүлсэн нөлөөний талаар бас өгүүлсэн байдаг¹⁰⁴.

Одоо цагт дээрх хүмүүсийн орчуулга болон тайлбараар дамжуулан хаикү шүлгийн талаар ойлголт мэдлэгтэй болж байгаа гэж үзэж болох юм. Мэдээж зөвхөн монгол хэлээр бичсэн материалаас гадна гадаад хэл дээр ч уншиж ойлголт авч буй нь тодорхой юм.

Харин гадаад дотоодын эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавьж хаикүгийн талаар авч үзсэн судлаачид цөөнгүй байх боловч явцуу хүрээнд тавигдсанаараа тэгтлээ олны хүртээл болж чадаагүй мэт ажиглагдсан.

Б.Явуухулангийн үеэс өдгөө хүртэлх үеийнхний хаикүгийн талаар олж авч байсан мэдлэгийн эх сурвалжийг хэлнийх нь талаас доорх байдлаар ангилж болмоор байна. Үүнд:

1) Орос хэлээр дамжуулан олж авсан мэдлэг. Ардчилсан хувьсгалаас өмнөх үед В.Н.Маркова¹⁰⁵ болон А.А.Долин¹⁰⁶ нарын орчуулан гаргасан Башоогийн шүлгийн түүврийг бараг цорын ганц гарын авлага болгож байсан бололтой байдаг.

2) Монгол хэлээр олж авсан мэдлэг. Б.Явуухулан, Ж.Лхагваа, Г.Аюурзана нарын эссэ өгүүллэгүүдийг одоо ч уншсаар байна.

⁹⁹ С.Хүрэлбаатар. “Алгаа хазах мэт адармаатай хайкүгийн орчуулга”, Японы яруу найраг. УБ.,2005. 118-119-р тал

¹⁰⁰ Д.Цэдэв. “Японы хайку, монгол яруу найрагийн ертөнц”, Японы утга зохиолын симпозиум.УБ.,2005. 33-39-р тал

¹⁰¹ Г.Мэнд-Ооёо. “Монгол хөрсөнд соёолж буй япон яруу найраг”, Японы утга зохиолын симпозиум.УБ.,2005. 54-56-р тал

¹⁰² Г.Аюурзана. “Япон яруу найраг дахь зэн-буддизмын сэтгэлгээ”, Японы утга зохиолын симпозиум.УБ.,2005. 61-64-р тал

¹⁰³ М.Шагдарсүрэн. “Япон хайкү”.УБ.,2007.

¹⁰⁴ Д.Мандах. “Японы сонгодог яруу найргийн орчуулгын асуудалд -Хайкү шүлгийн орчуулгын жишээн дээр”.УБ.,2010.

¹⁰⁵ В.Н.Маркова. “Басё. Стихи”, Художественная литература.Москва.1985.

¹⁰⁶ А.А.Долин. “Мацуо Басё”, Стихи проза.Санкт-Петербург.2002.

3) Англи хэлээр дамжуулан олж авсан мэдлэг. Голчлон интернетээр мэдээлэл олж авч байна.

4) Япон хэлээр олж авч буй мэдлэг. Олон арга хэрэгслээр мэдээлэл олж авч байна.

5) Бусад хэлээр дамжуулан мэдлэг мэдээлэл авч байгаа болно.

3. Хаикү шүлгийн орчуулга

Хаикү шүлгийн орчуулгын тухайд авч үзэхдээ 1-рт япон хаикүгийн монгол орчуулгын талаар ярих ёстой. Ингэхдээ япон хэлнээс нь шууд орчуулан буулгасан уу, эсбөгөөс өөр бусад хэлнээс дам орчуулан буулгасан байна уу гэдгээр тус тус үзэх юм. 2-рт монголд зохиогдсон монгол хаикүгийн япон орчуулгыг бас авч үзэх ёстой бөгөөд ингэхдээ мөн адил шууд болон дам орчуулга гэдэг талаас нь үзнэ.

Тус өгүүлэлд сэдвийнхээ хүрээний дагуу зөвхөн япон ба монгол хаикүгийн орчуулгын талаар дурдах болно. Мэдээж бусад хэл дээр зохиогдсон хаикүгийн монгол болон тухайн хэлний орчуулгын асуудлаар хожим хэлэлцэх үе ирэхийг үгүйсгэхгүй.

(1) Япон хаикүгийн орчуулга

Эхлээд япон хэлнээс шууд орчуулсан жишээ авч үзье. Японы хаикүгийн нэрт зохиолч Мацүо Башоогийн нэгэн шүлэг.

Шизүкаса я ива ни шими-ирү сэми но коэ

Б.Сэржавын орчуулга

Цаглашгүй орчлонгийн энэхэн зай нам гүм

Царцаан царгиа аниргүйг эвдэхүйеэ

Цахир хаднаа дуу нь шингээд тасалдангуй¹⁰⁷

Японы хаикү шүлэг нь үгэндээ маш харам. Илүүц зүйлгүй товчхон байхыг шаарддаг. Дээрх орчуулгыг ажиглахад нэг мөр нь л гэхэд бараг япон бүтэн эхтэй тэнцэх хэмжээний үг хэмнэлтэй байх юм. Гэхдээ бид орчуулгын асуудлаар ярихдаа сайн муу гэж дүгнэхийг урьтал болголгүйгээр тухайн орчуулагч уг эх шүлгийг ойлгож мэдэрснээ монгол хэлээр ингэж илэрхийлжээ гэдэг талаас нь харж үзэх нь зүйтэй болов уу. Энэ нь заавал тухайн шүлгийн орчуулга байх албагүй бөгөөд эх шүлгийн сэдэлтээр үүсмэл шинэ шүлэг зохиожээ гэж үзэх нь илүү онох мэт санагдана.

Тэгвэл бас өөр нэгэн орчуулгыг ажиглая. Д.Болдбаатарын орчуулга:

¹⁰⁷ Д.Цэдэв. “Японы хайку, монгол яруу найрагийн ертөнц”, Японы утга зохиолын симпозиум.УБ.,2005. 36-р тал

Анир чимээгүйд
Асга хаднаа шингэх нь
Жирхрэн дуу болой¹⁰⁸

Энд япон, монгол хэлний хэлзүйн ижил төсөөтэй шинжийг дурдах нь зүй болов уу. Хоёр хэлний хэлзүйн дагавар нөхцөл нь нилээд тохиолдолд таардаг бөгөөд харилцан оноолт хийн орчуулах боломжтой байдаг. Энэ үүднээс авч үзвэл Д.Болдбаатарын орчуулгад доогуураа долгионт зураастай хэсгүүд нь уг эхийн утгатай бага зэрэг зөрж байгаа юм.

Эхийг үг нөхцөл бүрээр нь оноосон хадмал орчуулгатайгаар дахин танилцуулъя.

Шизүкаса я ива ни шими-ирү сэми но коэ
(аниргүй еэ... хад-наа шингэн-орох цикада-гийн дуу)

Одоо дам орчуулгын жишээ авч үзье. Дам орчуулга гэхээр япон хаикүг өөр хэл рүү орчуулсныг монголчилно гэсэн үг юм. Одоогоор орос болон англи хэлнээс дам орчуулсан жишээ ажиглагдаж байна. Ялангуяа сүүлийн үед англиас орчуулах хандлага илт ихэсч байна. Бас хятад хэлнээс дам орчуулсан байх магадлалтай.

Башоогийн шүлэг бөгөөд монголд танигдсан хамгийн алдартай шүлэг гэж хэлж болох нэгэн шүлэг.

Фүрү-икэ я кавазү тоби-комү мизү но ото
Энэ шүлгийн олон орчуулга байдаг. Б.Явуухулангийн орчуулга:

Хуучин цөөрөм уруу
Хөөрхий мэлхий дэвхрэхэд
Усны чимээ гарав¹⁰⁹

Өмнө дурдсан хэлзүйн ижил шинжээр авч үзэх юм бол дээрх орчуулгын доогуураа долгионт зураастай хэсгүүд нь уг эхээс зөрүүтэй байна. Орос хэлнээс буулгасан орчуулгын жишээ болно. Гэхдээ “хөөрхий” гэсэн утга илэрхийлсэн орос эх олдохгүй байгаа ба орчуулагч толгой холбох үүднээс нэмэн оруулсан бололтой.

Г.Аюурзанын орчуулга 1
Хуучин цөөрөм,
Мэлхий үсэрч
Ус цалгилаа¹¹⁰
Орос эх нь:

¹⁰⁸ Г.Мэнд-Ооёо. “Японы яруу найраг”. УБ., 2005. 138-р тал

¹⁰⁹ Б.Явуухулан (1964). “Японы хайкү хэлбэрийн шүлгийн тухай”, Японы яруу найраг. УБ., 2005. 16-р тал

¹¹⁰ Г.Аюурзана (2000). “Зуслангаас үүдсэн хайкүны тэмдэглэл”, Японы яруу найраг. УБ., 2005. 112-р тал

Этот старый пруд!
вот нырнула в воду лягушка -
доносится всплеск...¹¹¹

Г.Аюурзанын орчуулга 2

Хөгшин цөөрөм...
Усанд мэлхий үсэрлээ
Аниргүйн дунд цүлхийв¹¹²

Орос эх нь:

Старый пруд.
Прыгнула в воду лягушка.
Всплеск в тишине.¹¹³

Г.Аюурзанын орчуулга 3

Эртний цөөрөм...
Мэлхий үсрэв,
Усны чимээ.¹¹⁴

Англи эх нь:

Old pond...
a frog leaps in
water`s sound.¹¹⁵

Г.Аюурзана орос, англи хэлнээс дам орчуулахдаа япон эхэд тун дөхөж очсон. Мэдээж япон хэлнээс орчуулаагүй тул энэ үгийг ингэж буулгажээ гэх нь таарахгүй. Харин япон эхтэй харьцуулсан тохиолдолд ямар ялгаа ажиглагдах вэ гэдгийг харуулах зорилгоор доогуур зураас хийсэн болно.

Ингээд уг эхийг үг нөхцөл бүрээр нь оноосон хадмал орчуулгатайгаар дахин танилцуулъя.

Фүрү-икэ я кавазү тоби-комү мизү но ото
(хуучин-цөөрөм... мэлхий үсрэн-орох ус-ны чимээ)

¹¹¹ А. Долин <http://www.stihi.ru/2010/11/21/7950> visited 16/05/2013

¹¹² Г.Аюурзана (2000). “Зуслангаас үүдсэн хайкуны тэмдэглэл”, Японы яруу найраг. УБ., 2005. 112-р тал

¹¹³ В.Маркова <http://lara-awgust.dreamwidth.org/17238.html> visited 16/05/2013

¹¹⁴ Г.Аюурзана. “Япон яруу найраг дахь зэн-буддизмын сэтгэлгээ”, Японы утга зохиолын симпозиум. УБ., 2005. 61-р тал

¹¹⁵ Г.Аюурзана. “Япон яруу найраг дахь зэн-буддизмын сэтгэлгээ”, Японы утга зохиолын симпозиум. УБ., 2005. 61-р тал

Одоо англи хэлнээс дам орчуулсан бас нэг жишээг авч үзье. Мөн л Башоогийн шүлэг.

Н.Төвшинзаяа¹¹⁶-гийн орчуулга:

Бясалгахуйяа
Элдэв зүйлийн дүрс
Интоорын цэцэгс болж тодормуй.¹¹⁷

Англи эх нь:

calling to mind
all manner of things
cherry blossoms¹¹⁸

Уг эхийг хадмал орчуулгатай үзвэл,

Сама-зама но кото оmoi-дасү сакүра ка на
(зүйл-зүйл-ийн явдал санагд-уулах сакүра юу даа)

Англи хэлнээс орчуулах нь уг эхээсээ ихээхэн ялгаатай болж байгааг энэ жишээнээс төвөггүйхэн харж болох байна.

(2) Монгол хаикүгийн орчуулга

Монгол хэл дээр зохиосон хаикүг одоогийн байдлаар шууд англи болон япон хэл дээр орчуулж байгаа нь тодорхой бөгөөд энэ удаа дам орчуулгад гарч буй эхээсээ зөрүүтэй жишээг танилцуулъя.

Үржин Хүрэлбаатарын нэгэн хаикүгийн орчуулга англи хэлээр дамжин япон хэлнээ буухдаа ямар болсон талаар авч үзье.

Эхлээд англи орчуулга:

The voice of Heaven is far away
and the women are stepping out,
pounding the dark grass.¹¹⁹

Үүнийг япон хэл рүү дараах байдлаар орчуулаад “World Haiku” сэтгүүлд тавьсан байгаа юм.

Тэнгокү но коэ харүка

¹¹⁶ “Хязгаараас цааш” хаикү клубын гишүүн

¹¹⁷ <http://www.simplyhaiku.com/SHv7n1/features/Kai.html> visited30/04/2013

¹¹⁸ орчуулагч нь тодорхойгүй. Н.Төвшинзаяа <http://tsagaanharatsai.blogmn.net/91608/haiku-sonirhogchdod:-.html> visited30/04/2013

¹¹⁹ орчуулагч нь тодорхойгүй

http://www.worldhaiku.net/poetry/urjin_khurelbaatar_mongol/urjin_khurelbaatar.htm visited12/05/2013

(Диваажин-гийн дуу хол)

Онна-ра ва сото ни дэтэ
(Эм - с бээр гадн-аа гарч)

Күраи күса татаки-цүбүсү¹²⁰
(Бараан өвс нүдэж-бяцална.)

Тэгвэл эх хаикү нь ямар байсан болохыг харцгаая.

Хөх өвсийг хэмхчин
Тэнгэрийн дуу холдоно
Бүсгүй гиншинэ¹²¹

Дам орчуулсан нь эх шүлгээсээ ямар их ялгаатай, өөр утга санаатай болсныг харж болно.

Дээр жишээ татсан орчуулгуудаас ажиглахад япон эхийг нь уншиж ойлгоогүй нөхцөлд өөр хэлнээс дам орчуулах нь яавч эх зохиолоосоо зөрүүтэй болж байна. Япон хэлнээс шууд монгол хэл рүү буулгахад хэцүү байдаг хаикү шүлгийг тэр тусмаа өөр онцлогтой европ зүгийн хэлнээс орчуулна гэдэг боломжгүй мэт санагдана.

4. Монгол хаикү

Монголчуудын хаикү зохиох оролдлого мөн л Б.Явуухулангаас эхтэй. Түүний дараагаар Б.Лхагвасүрэн, Б.Галсанхүү, Д.Отгонсүрэн гээд дурдвал багагүй тоо гарна. Ялангуяа сүүлийн үед шүлэг яруу найраг сонирхогч залуус хаикү шүлгийг ихэд сонирхож, зохион бичих болсон байна. Бас хаикү шүлэгчдийн бүлэг¹²² хүртэл байгуулан дэлхийн хаикү шүлэгч нартай холбоо тогтоон тэмцээн уралдаанд оролцохын хамтаар цахим сэтгүүл ажиллуулах, тэрчлэн хаикү шүлгийн түүвэр гаргах хэмжээнд очсон байх ажээ. Түүгээр тогтохгүй хаикү шүлгээс үүдэлтэй шинэ төрлийн шүлэг хүртэл зохион бичих болжээ.

Уран зохиолын “Бишүби” клубын тэргүүн Т.Эрдэнэцогтын хаикү гэнэ.

Нисэж буй шувуу
Унаж буй навч мэт
Намрын бороо...¹²³

Гэтэл бүр бишүби шүлэг гэсэн төрөл зүйл гарсан бололтой байна.

¹²⁰ Нацуиши Бан-я http://www.worldhaiku.net/poetry/urjin_khurelbaatar_mongol/urjin_khurelbaatar.htm visited12/05/2013

¹²¹ U.Khurelbaatar http://www.worldhaiku.net/poetry/urjin_khurelbaatar_mongol/urjin_khurelbaatar.htm visited12/05/2013

¹²² “Хязгаараас цааш” хаикү клуб <http://shortformpoetryofmongolia.blogspot.com/> visited12/05/2013

¹²³ Т.Эрдэнэцогт. <http://bishubi.miniih.com/> visited30/05/2013

С.Оюунтөгсийн бишүби шүлэг

Болжморын жиргээн
Тодоос тод.
Би сарыг хүлээнэ¹²⁴

Мөн хаикү шүлгийн “Хязгаараас цааш” гэдэг клубын гишүүн А.Содхүүгийн хайц хэмээх шүлэг бас байх ажээ.

Уулс үүлс, навчис
Өлмий доор
Өө би сая бурхан болжээ¹²⁵

Тэрчлэн бас “Хэний ч Илэрхийлээгүй Яруу Найраг”-ийн толгой үсгүүдээс бүтсэн хиян шүлэг гэж байна. Д.Нямдоржийн хиян шүлэг.

Дэргэдэх горхины чимээ
сарны гэрэл дамжсаар
дэрэнд ирж шингэнэ.¹²⁶

Энэ мэтчлэн 3-н мөрт шүлгүүд гарсан нь осолдохгүй хаикү шүлгийн нөлөө байх нь тодорхой. Мөн эдгээр нь хаикү шүлгийн хэм хэмжээнд баригдалгүй бичих бололцоотой ажээ. Улирлын үг хэрэглэх шаардлагагүй, үеийн хэмнэлийг барих албагүй¹²⁷.

Гэхдээ иймэрхүү шинэ төрөл зүйл бий болгон бичихийг буруушаахгүй ч нэг л юм дутуу орхигдсон мэт санагдана.

Анхлан танилцаж, цаашид шинэ төрөл бий болгох санаагаа авсан хаикү шүлгээрээ тууштай бичиж, монгол хаикүг төгөлдөр болгох тал дээр хэр зүтгэсэн юм бол, нэг бол П.Батхуягийн “Хайку бол ханз соёлын том гаргалгаа, Алтай язгуурын залгамал хэлээр хайку бичихгүй.¹²⁸” гэсэн шиг монгол хаикү бичих боломжгүйг олж мэдсэн юм болов уу, гэхчлэн асуумаар. Мэдээж өөрсдийнхөө бичснийг хаикү хэмээн нэрлээд байгаа шүлэгчид бий. Харамсалтай нь хаикүгийн талаарх ойлголт дутмаг болох нь харагдана. Зарим нэг хүний шүүмжилдэг шиг монгол хаикү заавал байх албагүй боловч монгол хаикү байх бололцоотой эсэхэд хариулт өгөхийн тулд монгол хаикү зохион бичих ихээхэн оролдлого чармайлт гаргаж үзсэн байх ёстой болов уу. Тэгэхдээ хаикү шүлгийн хэм хэмжээ, онцлогийг гаргахын тулд наана нь тогтож шийдсэн байх ёстой асуудлууд бас бийсэн.

¹²⁴ Д.Батбаяр. <http://mangarman.blogspot.com/2010/01/e-vvv.html> visited 01/12/2014

¹²⁵ А.Содхүү. “http://tsagaanharaatsai.blog.banjig.net/post.php?post_id=113585” visited 15/05/2013

¹²⁶ С.Дулам. “Мэдэж мэдрэшгүйг мэдрэх Хиян шүлгийн эрин айсуу”

<http://news.niigem.mn/content/26218.shtml> visited 15/05/2013

¹²⁷ А.Содхүү. http://tsagaanharaatsai.blog.banjig.net/post.php?post_id=113585 visited 15/05/2013

¹²⁸ П.Батхуяг. http://momotiimee.blogspot.com/2011/11/blog-post_30.html visited 15/05/2013

5. Дүгнэлт

Монголд хаикү шүлгийг сонирхох явдал улам бүр нэмэгдэж байгаа боловч хаикүгийн талаарх ойлголт мэдлэг нь тэр бүр зөв гэж хэлэх боломжгүй юм. Иймд хаикүгийн тухай үнэн зөвөөр тайлбарласан ном, гарын авлага шаардлагатай.

Хаикүгийн тухайд сонгодог хаикү, орчин үеийн хаикү, дэлхийн хаикү гэхчилэн олон янзын хэв шинжтэй болж байгаа талаар мэдээлэл дутмаг байна.

Хаикүгийн орчуулгын тухайд гэвэл наанадаж орчуулгад баримтлах журмын талаар сайтар хэлэлцэж тогтох нь зүйтэй болов уу. Ялангуяа монгол-япон хэлний ижил төсөөтэй шинж чанарыг харгалзсан орчуулах арга барилыг бий болгох шаардлагатай байна.

Ингэхдээ хоёр хэлний хэлзүйн онцлогийг харгалзан аль болох хэлбэрийг хадгалж орчуулах нь зүйтэй болов уу. Жишээ нь: хаикүгийн бүтцийн дагуу өгүүлбэрээр таслах газар нь таслаж байх гэх мэт.

Мөн тухайн хаикүг зохиох болсон цаад учир шалтгааны талаар боломжит хэмжээгээр тайлбар зүүлт хийх.

Бусад хэлнээс дам орчуулах бол аль болох эхтэй нь харьцуулан үзэж байх.

Монгол хэлээр хаикү зохиохын тухайд тогтсон дүрэмтэй байвал ямар вэ? Үүнд жишээлбэл, товч тодорхой байх, үгийн тоог хамгийн багаар барих, илүүц үг нурушихгүй байх.

Англи хэлний хаикүд баримталдаг шигээр 17 үед барих оролдлого хийх. Харин ингэхдээ үеийг хэрхэн тогтох вэ гэдэг дээр бодолцох, сайтар зөвшилцөх нь чухал юм. Одоогийн кирилл үсгийн дүрмээр үеийг тодорхойлох уу гэвэл тийм бус ч байж болох мэт. Дуудлагын асуудал байгаа юм. Хэмнэл алдагдуулахгүйн тулд яавал зохихыг судалж үзэх шаардлагатай.

Хэлбэр бүтцийн тал дээр хэлэлцэж монгол хаикүд хамгийн тохирох хэлбэрийг сонгон төгөлдөршүүлэхийг чармайх нь бас чухал. 3-н мөрөөр бичих нь дэлхийн олон орны орчуулгын зарчимтай нийцэж байх тул тэр зарчмыг нь барих хэрэгтэй.

Улирлын үг заавал оруулах. Ингэхдээ монголын онцлогтой үгсийг гаргаж ирэх хэрэгтэй бөгөөд энэ талаар эрэл хайгуул хийх, япон болон дэлхийн улирлын үгний талаар ойлголттой байх нь зүйд нийцэх юм.

Кирэ буюу таслалтай байх. Хаикү нь ихэвчлэн хоёр хэсгээс бүтдэг тул тэр зарчмыг баримтлах. Энэхүү таслалын үүргийг зөв ойлгох шаардлагатай ба таслалыг хэрэглэснээр хаикүгийн гол онцлог болох уншигчдад төсөөлөн бодох боломжийг олгох юм.

Номзүй

- Г.Аюурзана. “Зуслангаас үүдсэн хайкүны тэмдэглэл”, Дурлалгүй ертөнцийн блюз тэргүүтэн хүүрнэл зохиолууд. УБ.,2002.
- Г.Аюурзана. “Япон яруу найраг дахь зэн-буддизмын сэтгэлгээ”, Японы утга зохиолын симпозиум.УБ.,2005.
- Д.Болдбаатар. “Японы яруу найраг”. УБ.,2005.
- Т.Болдбаатар. “Япон үгийг монгол кирилл үсгээр галиглах нь”, “Япон судлал” сэтгүүл №1, УБ., 2007. 101-109-р тал
- А.А.Долин.”Мацуо Басе”, Стихи проза.Санкт-Петербург.2002
- Кимүра Аяко. “Яруу найрагч Такүбокү ба япон шүлгийн онцлог”, Ил товчоо сонин.УБ.,1998.10.15-10.24.№32/304/
- Ж.Лхагваа. “Японы яруу найраг”.УБ.,1974.
- Д.Мандах. “Японы сонгодог яруу найргийн орчуулгын асуудалд -Хайкү шүлгийн орчуулгын жишээн дээр-”.УБ.,2010.
- В.Н.Маркова.“Басё. Стихи”, Художественная литература.Москва.1985.
- Г.Мэнд-Ооёо. “Монгол хөрсөнд соёолж буй япон яруу найраг”, Японы утга зохиолын симпозиум.УБ.,2005. 54-56-р тал
- Д.Одонхорлоо. “Зохист аялгуу ” сонин.УБ.,1987.
- Б.Сэржав. “Дорно дахины судлалын асуудал” сэтгүүл.УБ.,1990.№1.136-р тал
- С.Хүрэлбаатар. “Алгаа хазах мэт адармаатай хайкүгийн орчуулга”, Японы яруу найраг. УБ.,2005. 118-119-р тал
- Д.Цэдэв. “Японы хайку, монгол яруу найрагийн ертөнц”, Японы утга зохиолын симпозиум.УБ.,2005. 33-39-р тал
- М.Шагдарсүрэн. “Япон хайкү”.УБ.,2007.
- Б.Энэбиш. “Японы яруу найраг”. УБ.,2005. 103-105-р тал
- Б.Явуухулан. “Японы хайку хэмээх сонгодог яруу найргаас”, Цог сэтгүүл.УБ.,1966. №1.
- R.H.Blyth. “Haiku” Vol.3 Summer-Autumn, Tokyo, The Hokuseido Press, 1991
- Judy Kendal. “Observations on the difficulties of translation”, Kanazawa University Press, 1996
- Lingji Han, Toyoaki Watanuki. “Formalism consideration of Haiku translating into Chinese”, University of Tsukuba Press, 2010
- Ota Seiko. “Considerations behind the translation of Haiku into Spanish” 龍谷大学国際センター研究年報20号. 2011. 89-100p
- Stephen Wolfe. “Toward Basho’s zen poetics: the history and significance of Basho’s autumn crow haiku” 龍谷大学国際センター研究年報15号. 2006. 141-160p
- 太田かほり『海外俳句における季語—「白夜」と「花野」』文京学院大学外国語学部文京学院短期大学紀要（6）2007. 195-214p
- 高橋悦男 『Five and Seven and Five —Richard RightのHaiku—』早稲田社会科学総合研究 第2巻第2号. 2002. 191-206p

”Хязгаараас цааш” хаикү клубын блог

<http://www.simplyhaiku.com/SHv7n1/features/Kai.html> visited30/04/2013

Н.Төвшинзаяа. ”Цагаан хараацай” блог

<http://tsagaanharaatsai.blogmn.net/91608/haiku-sonirhogchdod:-.html>
visited30/04/2013

Нацуиши Бан-я. ”Дэлхийн хаикү” вэб сайт

http://www.worldhaiku.net/poetry/urjin_khurelbaatar_mongol/urjin_khurelbaatar.htm
visited12/05/2013

Т.Эрдэнэцогт. ”Бишүби” бүлгийн блог

<http://bishubi.miniih.com/> visited30/05/2013

Д.Батбаяр. монгол хайкүгийн нэгэн жишээ

<http://mangarman.blogspot.com/2010/01/e-vvv.html> visited 01/12/2014

А.Содхүү. монгол хайкүгийн нэгэн жишээ

http://tsagaanharaatsai.blog.banjig.net/post.php?post_id=113585 visited15/05/2013

С.Дулам. “Мэдэж мэдрэшгүйг мэдрэх Хиян шүлгийн эрин айсуу”

<http://news.niigem.mn/content/26218.shtml> visited15/05/2013

П.Батхуяг. “Хэлбэр бол хэлбэр харин юугаараа ялгаатай гэж...” шүүмж

http://momotiimee.blogspot.com/2011/11/blog-post_30.html visited15/05/2013

Hartwell, Michael 『俳句の翻訳と英語圏の日本についての見方』

http://www.cmu.edu/dietrich/modlang/docs/polyglot/S2008/michael_hartwell.pdf
visited16/05/2013

要旨: 本稿ではまずモンゴルにおいて俳句がどのように紹介されてきたかを概観した上でモンゴル語への翻訳例を取り上げ、直訳と重訳の違いを原文と照合し、考察する。さらにモンゴル語で創作された俳句の日本語訳を重訳の危険性と言う角度からとらえてみる。

近年モンゴルで俳句に対する関心が高まりつつある中、モンゴル俳句をはじめ俳句に影響を受けた新ジャンルの詩も生まれてきている。ハイツ・ヒヤンと言った詩がそれである。本稿でもこれらに若干触れることにする。

最後に俳句をモンゴル語に翻訳し、モンゴル語で創作するにあたって留意すべき点を提唱する。

МНТ-Ы АН АМЬТАН, ЖИГҮҮРТЭН ШУВУУНЫ НЭР БҮХИЙ ХҮНИЙ НЭРИЙН ФРАНЦ ОРЧУУЛГА

Н. Мөнх¹²⁹ (МУИС. ШУС)

Товч агуулга: Бид МНТ-ы 1994 оны франц орчуулгыг нэгбүрчлэн шүүж үзэхэд нийт 52 хүний нэрийн франц орчуулга нь ан амьтан, жигүүртэн шувууны нэр зааж байгаа бөгөөд эдгээр нэрийг дараахий байдлаар ангиллаж болно:

- *Тотем нэр. Үүнд Бүри, Чоно, Марал хэмээх нэрс хамаарах аж.*
- *Бэлэгдэл нэр. Арслан, Буха мэт хүчтэй эс бөгөөс Начин, Шонхор мэт авхаалжтай болох г.м. бэлэгшээж өгдөг нэрс.*
- *Цээр /хамгаалсан/ нэр: Хүчүгүр*
- *Төрсний дараа хамгийн түрүүнд харсан амьтны нэр буюу англиар fortuitous or open-names гэж хувааж болдог байна.*

Бид өгүүлэгтээ эдгээр нэрсийн орчуулга франц хэлний хүн нэрлэх ёсонд хэр таарч байгаа талаар судлаж зарим нэг нэрийн орчуулгад санлаа дэвшүүлсэн.

Түлхүүр үг: ан амьтан, жигүүртэн, хүний нэр, орчуулга

Монголын нууц товчоо” нь монголын ард түмний чухал дурсгал бичиг бөгөөд үе үеийн эрдэмтэн судлаачдын судлагдахуун болсоор ирсэн. Тус туурвилыг монгол хэл, утга зохиол, түүх, соёл, шашин шүтлэг, угсаатны зүй, ертөнцийг үзэх үзэл г. м. олон талаас нь судласаар байгаа.

“Монголын нууц товчоо”-той холбоотой судлагаа шинжилгээний ажил, бүтээл олон хэл дээр хэдэн зуугаараа хэвлэгдэн гарсан. “Монголын нууц товчоо” нь монгол хэл дээрхи / Ц. Дамдинсүрэн, Т. Дашцэдэн, Б. Сумъяабаатар, Ш. Чоймаа г.м./ хөрвүүлэг, орчуулга, тайлбар, галигаас гадна одоо мэдэгдэж байгаагаар 20 гаруй хэлнээ орчуулаад байна¹³⁰.

“Монголын нууц товчоо”-г франц хэлээр хоёр удаа орчуулжээ. Эхнийх нь Поль Пеллиогийн 1949 онд хэвлэгдсэн ” *HISTOIRE SECRETE DES MONGOLS, Restitution du texte mongol et traduction française des chapitres I à VI*” хэмээх бүрэн бус 181 зүйл бүхий орчуулга. Хоёр дахи нь Мари-Доминик Эвен, Родика Поп нарын 1994 онд хэвлэгдсэн ” *HISTOIRE SECRETE DES MONGOLS, Chronique mongole du XIII^e siècle* “ хэмээх бүтээл юм. Мөн үүний сацуу А. Мостаэрт гуайн *Монголын нууц товчооны зарим хэсгийн тухайд*, П. Пеллио

¹²⁹ МУИС, ШУС, ХУС-ын европ хэлний тэнхим, докторант

¹³⁰ Ё. Жанчив, Дундад үеийн монгол хэлний судлал, Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл, УБ, 2011, х. 57-71

Igor de Rachewiltz, The secret history of the Mongols, A Mongolian Epic Chronicle of the Thirteenth Century, Vol. I, pp. XXII-XXIX

болон Луи Амби нарын хамтарсан *Чингис хааны байлдан дагуулалтын түүх*¹³¹ гэх мэт томоохон судлагааны бүтээлүүд байдаг байна.

Мари-Доминик Эвен, Родика Поп нарын МНТ-ны франц орчуулга нь оноосон нэр тэр дундаа хүний нэрийг орчуулснаараа нэн онцлог юм. Сайхь орчуулгад 412 хүний нэр гардгаас 280 нэр буюу 67,9% -ийг бүрэн, 57 нэр буюу 13,5% хагас, 77 нэр буюу 18,6% -ийг орчуулалгүй галиглах, үсгэчилэх зарчмаар буулгасан байдаг¹³².

I. АН АМЬТНЫ НЭР БҮХИЙ ХҮНИЙ НЭРИЙН ФРАНЦ ОРЧУУЛГА

МНТ-д ан амьтны нэрээс үүссэн хүний нэр нилээд байдаг бөгөөд ан, амьтны утга бүхий нэрийн орчуулга 40, жигүүртэн шувууны нэр бүхий орчуулга 12 байна. Нийт 52 нэр байгаа нь МНТ-ы нийт нэрийн 12,6% эзэлдэг. Үүнд нэг талаас Чоно, Марал, Буга зэрэг зэрлэг амьтны нэр байхын сацуу Буха, Ухуна мэтийн гэрийн тэжээвэр амьтны нэрс ч байдаг. Энэ хэсэгт тусд нь авч үзэх өөр нэгэн бүлэг нэр бол Тогруу, Начин г.м. шувууны нэрээс үүдэлтэй хүний нэрс юм. Үүний зэрэгцээ Арслан хэмээх Монголд байхгүй амьтны нэр ч байна. Зарим судлаачдын үзэж байгаагаар эдгээр нэрсийг дараахи хэдэн бүлэгт хувааж болох аж:

- Тотем нэр. Үүнд Бүри, Чоно, Марал хэмээх нэрс хамаарах аж.
- Бэлэгдэл нэр. Арслан, Буха мэт хүчтэй эс бөгөөс Начин, Шонхор мэт авхаалжтай болох г.м. бэлэгшээж өгдөг нэрс.
- Цээр /хамгаалсан/ нэр: Хүчүгүр
- Төрсний дараа хамгийн түрүүнд харсан амьтны нэр буюу англиар *fortuitous or omen-names* гэж хувааж болдог байна.

Чоно буюу **Loup**. Франц хэлнээ Loup гэдэг нэр байдаг байна: Loup Servat. Мөн INSEE буюу францын статистик албан интсрнэт сайтаас үзэхэд нийт 4096 хүн Loup гэдэг овогтой байна.

Бидний олж тогтоосноор МНТ-ны франц орчуулгад Чоно буюу Loup хэмээх үг орсон нэр 4 байна:

а. Бөртэ Чоно /孛兒帖赤那- boertie chi na/ буюу Loup Bleu хэмээх нэр 1-р зүйлд гардаг. Францаар орчуулсныг үгчлэн буулгаваас хөх чоно хэмээх утга илэрхийлж байна. Франц хэлнээ Loup Bleu гэдэг хүний нэр байдаггүй ч

Энэ нэрийн тухайд судлаачид нэг мөр болоогүй байгаа учир нь зарим нь эл нэрийг хүний нэр гэж үзэж байхад Д'Оссон, Х. Пэрлээ г.м./ зарим үүнийг тотем нэр гэж үздэг /Ш. Бира, С. Ю. Неклюдов г.м./. Жишээ нь И. де Рахевильц - Бөртэ чоно /Хөх чоно/ гэдэг нь угтаа монгол болон түрэг эртний домогт хүний нэр бус тотем нэр байсан боловч хожуу явсаар хүний нэр болж хувирсан нь монголчууд амьтадын нэрийг хүний нэр болгож хэрэглэдэгтэй нь холбоотой байж магад гэж бичсэн байна. Гэтэл Мари-Доминик Эвен, Родика Поп нар

¹³¹ P. Pelliot et Louis Hambis, *Histoire des campagnes de Gengis Khan*. Cheng-wou ts'in-tcheng lou.

¹³² Т. Сая-Эрдэнэ, *МНТ-ы хүний нэрийн зүйлийн франц орчуулгад хийсэн ажиглалт судлагаа* магистрын зэрэг горилсон бүтээл, УБ., 2006

монголчууд чоныг эртний өвөг дээдэс хэмээн үзэж тахидаг хэдий ч энэ нь чоно гэдэг амьтан биш харин монголчуудын эртний өвөг дээдсийн оноосон нэр байж болох талтай. Иймд эл тохиолдолд чоно гэдэг нь монгол хүн хайртай хүүдээ өгсөн нэр, эс бөгөөс тухайн хүний ухааны цар хүрээг заасан хүний хоч хэмээн ойлгох хэрэгтэй болов уу. *börte* гэдэг үгийн тухайд эл үг нь өнөөг хүртэл мал амьтны зүсэм заасаар ирсэн: “хөх туяатай цагаан эс бөгөөс саарал” мөн “толботой” гэсэн утга тус тус илтгэдэг байна гэж бичсэн байх жишээтэй.

б. Бүри /不里- bu li/ буюу Loup эл нэр 270, 274, 275, 276-р зүйлд тус тус гардаг. Францаар орчуулсныг үгчлэн буулгаваас чоно хэмээх утга илэрхийлж байна. Франц хэлнээ ийм нэр байдаг байна.

в. Бүри Булчиру /不里不勒赤魯 - bu li bu le chi lu / буюу Loup-le-Musclé - эл нэр 40-р зүйлд гардаг. Францаар орчуулсныг үгчлэн буулгаваас Loup- чоно, le Musclé- хүч чадалтай, булчинлаг, шөрмөслөг хэмээх утга илэрхийлж байна. Энэ орчуулгын тухайд Loup гэдэг нь нэр le Musclé гэдэг нь хоч нэр мэт харагдаж байна.

г. Бүри бөх /不里孛闊 - bu li bo kuo/ буюу Loup-le-Lutteur хэмээх нэр 50, 131, 140-р зүйлд тус тус гардаг. Францаар орчуулсныг үгчлэн буулгаваас Loup-чоно, le Lutteur- бөх хэмээх утга илэрхийлж байна. Энэ орчуулгын тухайд Loup гэдэг нь нэр нь le-Lutteur гэдэг нь хоч, мэргэжил, цол гуншин заасан үг мэт харагдаж байна.

Марал буюу **Biche**. Францаар орчуулсныг үгчлэн буулгаваас Марал (эм буга) хэмээх утга илтгэж байна. Интернэт эх сурвалжаас үзэхнээ Марал гэдэг нэр зөвхөн Монголд төдийгүй Иран, Сири, Азейрбаджан г.м. улсад байдаг бөгөөд энэ нь дандаа эмэгтэй хүний нэр байна. Сонирхуулхад францын статистик хорооны нийтэлсэн мэдээнээс үзэхнээ өнөөгийн байдлаар Франц улсад Maral гэдэг нэртэй 12 хүн бүртгэгдсэн байна¹³³. Тэр ч байтугай Израильд Ayala буюу Марал гэсэн эмэгтэй хүний нэр байдаг байна. Нэрийн толь, интернэт эх сурвалжаас үзэхэд франц хэлнээ ч Biche гэдэг нэр байх боломжтой хэдий ч ийм нэртэй хүн байдаггүй байна¹³⁴. Ийм овог ч байдаг байна. Өөрөөр хэлбэл дээрх орчуулга франц хэлний хүний нэршлийн хэм хэмжээнд нийцэж байна хэмээн бид үзлээ.

Мөн МНТ-д Марал буюу Biche гэдэг нэр хоёр байдаг байна:

а. **Марал** /馬刺勒 - ma la le/ буюу **Biche** эл нэр 202-р зүйлд гардаг. Францаар орчуулсныг үгчлэн буулгаваас Марал (эм буга) хэмээх утга илтгэж байна.

б. **Гуа-Марал** /豁埃馬蘭 - huo ai ma lan/ буюу **Biche Fauve** эл нэр 1-р зүйлд гардаг. qo'ai гэдэг үгийг тухайд кирилл үсгээр хөрвүүлэхдээ Гоо, Гуа, Хоо хэмээн янз янзаар буулгажээ. Р. Поп, М.-Д. Эвен нарын тухайд qo'ai maral хэмээх нэрийг Bishe-Fauve буюу “Ухаа марал” гэж орчуулсан байна, өөрөөр

¹³³ Францад төрсөн хүмүүс /2014 оны байдлаар/

¹³⁴ INSEE

хэлбэл тэд эл үгийг нангиад тайлбар орчуулгыг баримтлан “гоё, сайхан” гэдэг утгаар нь бус “ухаа” хэмээх өнгө зүсэм гэж үзсэн байна.

Бух буюу **Taureau, Taurin, Taurillon, Yak**. Бид МНТ-ы франц орчуулгаас эдгээр үг орсон 10 нэр оллоо. Үүнээс үзэхнээ тухайн үед Буха хэмээх нэр нилээд дэлгэрсэн байжээ. Интернэт эх сурвалжаас үзэхнээ франц хэлнээ ийм овог байдаг байна. Харин **Yak** хэмээх овог, нэр франц хэлнээ байдаггүй бөгөөд энэ нь тухайн улсад сарлаг байдаггүйтэй холбоотой болов уу. Эдгээр овог нь мэргэжил, газрын нэр, биеийн онцлогоос үүдэн үүссэн байна.

а. Бухату салжи буюу **Taurin le Tors** /不合秃撒勒只 - bu he tu sa le zhi/ эл нэр 17, 19, 23, 42 зүйлд гардаг байна. Францаар орчуулсныг угчилбээс Taurin – бухны /тэмдэг нэр/, Tors – мушгисан, эрчилсэн гэсэн утга тус тус илтгэж байгаа бөгөөд франц хэлнээ ийм нэр байдаггүй байна.

б. Буха Төмөр буюу **Taureau le Fer** /不花帖木兒 bù - huā - tiě - mù - ér/ эл нэр МНТ-ы 177-р зүйлд гардаг. Taureau, Fer гэсэн овог франц хэлнээ байдаг авч Taureau le Fer гэдэг нэр, овог франц хэлнээ байдаггүй байна. Францаар орчуулсныг угчилбээс Taureau – бух, le Fer гэдэг нь төмөр хэмээх үг бөгөөд франц хэлнээ ийн тодорхой ялгац хэрэглэж хүний овог¹³⁵ болон хоч үүсгэдэг байна. Франц хүний овог нь үндсэн таван гарвалитай байдаг¹³⁶: 1. хүний нэрээс үүссэн – Martine- Lamartine; 2. Газарзүйн онцлог болон байршилтай холбоотой- Fayette – Lafayette; 3. Мэргэжил, албан тушаал заасан үгээс үүссэн – Lenoble, Lemaire г.м. 4. Ураг төрлийн холбоо заасан үгээс үүссэн – Lepère, Lainé г.м. 5. Гадаад төрх, биеийн онцлогтой холбогдолтой үгээс үүссэн – Leblond, Legrand г.м¹³⁷. Эл нэрийн тухайд дүгнэхэд орчуулгыг шууд үгийн утгаар утгачилж орчуулсан бөгөөд эл **орчуулга нь франц хэлний хүний нэршлийн хэм хэмжээнд таарч байна.**

в. Жали Буха буюу **Flamme le Taureau** /札鄰不合 - zha lin bu he / эл нэр 58, 141-р зүйлд гардаг. И де Рахевильц эл нэрийн утгыг “Гал [=уур хилэнтэй, хүчирхэг] бух” гэж буулгаад *jalin* гэдэг нь *yalin* “гал” гэсэн утгатай гэжээ. Гэтэл Безе эл нэрийг “заль” хэмээн буулгасан байдаг байна. Францаар орчуулсныг угчилбээс Flamme- гал, дөл; дур хүсэл; le Taureau – бух гэсэн утга илтгэж байна. Франц хэлнээ яг ийм хэлбэртэй овог нэр байдаггүй байна.

г. Хорибуха буюу **Vingt le Taureau** /豁里不花 - huo li bu hua / эл нэр 59-р зүйлд гардаг байна. Францаар орчуулсныг угчилбээс Vingt – хорь /тоо/, le Taureau бух гэсэн утга тус тус илтгэж байна. Vingt гэдэг овог франц хэлнээ байдаг бөгөөд үндэсний статистик мэдээний албанаас гаргасан мэдээнд эл нэр түгсэн байдлаараа 22371 байр эзэлдэг байна.

д. Хунан буюу **Taurillon** /忽難 - hu nan // эл нэр 122, 177, 202, 210, 216, 243-р зүйлд гардаг байна. Бичвэрээс үзэхэд Хунан нэртэй 2 хүн байна: нэг нь

¹³⁵ Овгийг хоч нэрээс үүссэн хэмээн үздэг байна бөгөөд зарим хэлэнд **овог** хэмээх үг нь хоч гэдэг үгтэй утга нэг байх нь ч бий – cognomen (латин хэлнээ), surname (англи хэлнээ) г.м.

¹³⁶ Котляр Наталья Александровна, ЭТИМОЛОГИЧЕСКИЕ КЛАССЫ ФРАНЦУЗСКИХ ФАМИЛИЙ В ИСТОРИЧЕСКОМ РАЗВИТИИ, Московский Институт Иностранных Языков, ЭШӨ

¹³⁷ Зөвхөн тодорхой ялгац бүхий жишээ оруулсан болно

Генигес овгийн Хунан, нөгөө нь Тайчиуд овгийн Хунан. Францаар орчуулсныг үгчилбээс Taurillon - бух гэсэн утга тус тус илтгэж байна. И де Рахевильц бусад судлаачдын нэгэн адил эл нэрийг “гунан” буюу “гурван настай бух/үхэр” гэж буулгасан байна. франц хэлнээ ийм овог байдаг байна.

е. **Буха** буюу **Taureau** /不合- bu he / эл нэр 137, 226, 227, 234, 239 зүйлд гардаг. Францаар орчуулсныг үгчилбээс **Taureau** – бух. Франц хэлнээ ийм овог мөн байдаг байна.

ж. **Бухатай** буюу **Taurin** /不合台 - bu he tai / эл нэр 168 зүйлд гардаг. Францаар орчуулсныг үгчилбээс Taurin – бух, бухны гэсэн утга илтгэж байна. Франц хэлнээ ийм овог мөн байдаг байна.

з. **Дөрибөхө**/Дөрибуха/ буюу **Dori le Taureau** /朵里不合 - duo li bu he/ эл нэр 202 зүйлд гардаг. Эл нэрийг хагас орчуулсан байна: Дөри – галиглаж бөхө/буха гэдгийг Taureau хэмээн орчуулсан байна. Франц хэлнээ ийм овог, нэр байдаггүй байна.

е. **Худус** буюу **Yak** /忽都思- hu du si / эл нэр 120, 202 зүйлд гардаг. Францаар орчуулсныг үгчилбээс Yak – сарлаг гэсэн утга илтгэж байна. Франц хэлнээ ийм овог, нэр байдаггүй ч лалын шашинтай африк цагаач дунд Yak гэсэн нэр бүртгэгдсэн байдаг байна.

ё. **Худус-халчан** буюу **Yak le Chauve** /忽都 - hu du / эл нэр 191 зүйлд гардаг. Францаар орчуулсныг үгчилбээс Yak – сарлаг, Chauve - халзан гэсэн утга илтгэж байна. Франц хэлнээ ийм овог байдаггүй байна.

Нохой буюу **chien, molosse**. Бид МНТ-ны франц орчуулгаас ийм гурван нэр оллоо. Интернэт эх сурвалжаас үзэхнээ францад Chien гэдэг овог байдаг бөгөөд өнөөгийн байдлаар нийт 104 ийм овогтой хүн янз бүрийн нийгмийн сүлжээнд бүртгэлтэй байдаг байна¹³⁸. Сонирхуулахад Корсик арал дээр Cagnazzo буюу итали "cane" буюу нохой гэдгээс үүссэн нэр, овог байдаг, энэ нэрийг өөр нэгэн хувилбар нь Cagnazzi. Molosse буюу хоточ /хасар/ нохой гэсэн овог ч мөн байдаг бөгөөд эдгээр овог нь эртний грек уламжлалтай бөгөөд Μολοσσοί, Molossoi хэмээх хүний нэрээс үүдэлтэй¹³⁹. Иймд доорхи гурван нэрийн орчуулгыг франц хүний нэрийн хэм хэмжээнд таарч байна гэж үзэж болно.

а. **Алахчит** буюу **Chien Pie** /阿刺黑亦惕 - a la hei yi ti/. Эл нэр 169-р зүйлд гардаг байна. Орчуулагчилд эл нэрийг шууд утгачилсан байна – Алаг гэдгийг Pie /1. шаазгай, 2. алаг/ гэж орчуулсан бөгөөд чит гэдгийг түрэг ит буюу нохой гэж ойлгон chien /нохой/ гэж орчуулсан байна. Энэ нь И. Де Рахевильц эл нэрийг “Spotted Dog” буюу алаг /толботой/ нохой¹⁴⁰ гэж тайлбарласан мөн

¹³⁸ <http://www.geneanet.org/>

¹³⁹ Эпирын хаан, Ахилл баатрын ач хүү. Хожуу удмын /овгийн/ нэр болсон бөгөөд өнөөг хүртэл ийм нэртэй газар байдаг байна.

¹⁴⁰ И. де Рахевильц - Alaqud гэж бичсэн нь бичээчийн алдаа бөгөөд зөв хувилбар нь Alay Id. Тэр ч байтугай Alay Nidün гэдэг нэр алдаатай бөгөөд утгаа энэ нь Alay Id гэдэг нэрэнд –n авиа болон харьяалахын тийн ялгалын –ün залгасан гэж үзжээ. ¹⁴⁰ Igor de Rachewiltz, The Secret History of the Mongols, A Mongolian Epic Chronicle of the XIII Century, Volume I, Brill Leiden-Boston, 2004, p.661

Лигетийн тайлбарыг дагсан бололтой. Гэтэл Хаэниш эл нэрийг Alaqcit гэж уншсан бөгөөд түүний үзэж байгаагаар Alaqcit гэдэг нь Alaq хэмээх нэрэнд – cit¹⁴¹ дагавар залгасан байна. Кливз эл нэрийг Alagh Yid гэж тайлж уншсан байна¹⁴².

б. **Зүчи Хасар** буюу **Hôte le Molosse** /拙赤合撒兒- zhuo chi he sa er/ эл нэр 60, 76, 77, 79, 96, 99, 104, 105, 107, 120, 124, 130, 137, 161, 183, 184, 195, 242-245 зүйлд тус тус гардаг байна. Энэ нэрийг мөн утгачилж Зүчи гэдгийг Hôte /зочин/, Хасар гэдгийг Molosse гэж орчуулсан нь И. де Рахевильцын утгачилсантай дүйж байна /"Guest", "the name of a kind of wild dog"/ байна.

в. **Архай Хасар** буюу **Arqai le Molosse** /阿兒孩合撒兒巴剌 a er hai he sa er/ эл нэр 120, 124, 127, 177, 181, 183, 158, 191, 192, 226, 230, 234, 252 зүйлд тус тус гардаг байна. Эл нэрийг Ц. Дамдинсүрэн гуай эл нэрийг 1. Архай Хасар – Бала гэж нэгтгэжээ, 2. “Сэцэ-Домог, Архай Хасар--Бала, хоёул хөвүүнээ дагуулж ирэв¹⁴³” гэж бичсэн байна. Гэтэл эх болон бусад судлаачидын орчуулга, хөрвүүлэг зэргээс үзэхнээ Архай Хасар, Бала гэдэг нь 2 тусдаа хүний нэр бөгөөд энэ хоёр хоёул Сэцэ Домогийн хөвүүд байна.

Буга буюу **Cerf**. МНТ-ны франц орчуулгад эл үг орсон нэр хоёр байна. Францад Cerf гэдэг нэр байдаггүй ч ийм овог нилээд дэлгэрсэн байдаг байна жишээ нь 2015 оны францын гоо бүсгүйн тэргүйн шагналтыг Camille Cerf гэдэг байна. Мөн өрнөдийн зарим нэр нь **буга** гэсэн утгатай байдаг: Oscar гэдэг ирланд гаралтай нэрийн Os гэдэг нь буга, саги - хайртай гэсэн утгатай¹⁴⁴ байх жишээтэй. **Иймд эдгээр нэрийн орчуулга нь франц хэлний хэм хэмжээнд нийцэж байна гэж бид үзлээ.**

а. **Буха Хатаги** буюу **Cerf le Dur** /不忽合荅吉 - bu hu he ta ji / эл нэр 17, 19, 23, 30, 32, 33, 42 зүйлд тус тус гардаг. Францаар орчуулсныг үгчилбээс Cerf – буга, le Dur- хатуу гэсэн утгатай байна. Эл тохиолдолд Буха хэмээх нэрийг хятад үсгээр бичсэн эхэд 不忽 буюу bu hu /буга?/ гэж бичсэн атал Буха буюу Бух гэдэг үгийг 不合 / bu he/ гэж бичсэн байна иймд орчуулагчид зөв хувилбараар нь орчуулсан байх талтай.

б. **Элхудар** буюу **Cerf de l'Union** /額勒忽秃兒 - e le hu tu er/ эл нэр 152-р зүйлд гардаг бөгөөд франц орчуулгыг үгчилбээс Cerf – Буга, de l'Union- Хамтын гэсэн утга илтгэж байна. Эл нэр түрэг гаралтай (?) бөгөөд орчуулагчид зөв орчуулсан байна гэж бид дүгнэж байна.

Бодончар мунхаг буюу **Sanglier le Simplet** /孛端察兒蒙合黑- bo duan cha er he hei / болон **Мэгүүжин сүүлт** буюу **Queue de Laie** /篋古真薛兀勒圖 - mie gu zhen xue wu le tu/.

¹⁴¹ Орд. эм хүйсийн нэр үүсгэх –jit дагавар

¹⁴² Франц орчуулгад зөв хувилбарыг сонгож орчуулсан болов уу. Гэхдээ Ордос аялгууна *алаг* хэмээх үг “нохой” гэсэн утга заадаг байна. Иймд мо. “нохой”+тү. “нохой” гэж байж ч болох тайлтай бөгөөд монгол нэрлэх ёсонд ийм үзэгдэл байдаг байна: Энх-Амгалан, Мөнх-Чимид, Бадамцэцэг г.м.

¹⁴³ Ц. Дамдинсүрэн, МНТ, УБ, 1996, х.65

¹⁴⁴ <http://www.aufeminin.com/w/prenom/p639/albin.html>

а. Бодончар мунхагийн тухайд эл нэр МНТ-ы 17, 19, 23, 24, 28-30, 32-35, 37, 38, 40-44-р зүйлд гардаг байна. Францаар орчуулсныг үгчилбээс Sanglier-бодон, le Simplet- 1. гэнэн 2. Мунхаг гэсэн утга илтгэж байна. И де Рахевильц эл нэрийг *bodon* буюу бодон хэмээх нэр үгэд *ĉar* хэмээх дагавар залгаж үүсэн нэр гэж үзэж байгаатай нь дийлэнхи судлаач санал нэг байна. – *ĉar* дагаварын тухайд Н. Поппе эл дагаварыг хүний нэрэнд ордог дагавар бөгөөд доромж утгатай нэр үг болон тэмдэг нэрээс багасагсан утгатай тэмдэг нэр үүсгэдэг дагавар хэмээн тодорхойлжээ¹⁴⁵. Sanglier гэдгийн тухайд францад ийм хүний овог байдаг байна, тэр ч байтугай өрнийн зарим улс оронд “бодон” хэмээх утга илтгэдэг нэрс ч байдгийг энд жишээлэн авч үзвээс: Evrard / eber + hard “хүчтэй” /, Ebbe, Ebbel г.м. герман нэрс eber “бодон” гэдгээс үүсэн байна, Vanba хэмээх ирланд нэрийн утга нь ч мөн “бодон”, орос Кабанов /бодон/ г.м.

б. **Queue de Laie** буюу **Мэгүүжин сүүлт** эл нэр 132-134-р зүйлд гардаг байна. францаар орчуулсныг үгчилбээс Queue – сүүл, Laie-мэгж гэсэн утга тус тус илтгэж байна.

Мангудай буюу **L'Ogre** /忙忽台- mang hu tai / эл нэр 46, 278-р зүйлд тус тус гардаг бөгөөд 46-р зүйлд Начин баатрын хүү, 278 –р зүйлд мянгатын ноён байна. Эл нэрийн тухайд mangu- хэмээх үгэнд –daï дагавар залгаж үүссэн бөгөөд Н. Поппегийн үзсэнээр –daï дагавар нь овгийн нэрээс үүссэн эрэгтэй хүний нэрэнд ордог мөн тухайн овгийнх гэсэн утга заадаг байна. Уг дагавар нь багасагсан эхрийлсэн утга илтгэдэг байна. Ogre гэдэг нэр бид олоогүй ч эл үг нь хүний хоч болох нь элбэг байдаг бөгөөд ийм овог францад байдаг бөгөөд интернэт бүртгэлээс үзэхнээ өнөөгийн байдлаар францад ийм овогтой 97 хүн байдаг байна¹⁴⁶. Иймд эл орчуулга зөв болжээ гэж бид үзэж байна.

Хүчүгүр буюу **Souris des Bouleaux** /窟出沽兒 - ku chu gu er /, Найманы **Буйруг** хан буюу **Roi Commandant des Souris des Bouleaux** /不亦鲁黑罕 - bu yi lu hei han /. Souris des Bouleaux гэдгийг монгол хэлнээ хөрвүүлвээс – хусны хулгана, хүчгэр гэсэн утга илтгэдэг байна. франц хэлнээ Souris болон Bouleaux гэсэн тус тусдаа овог байдаг авч яг эл хэлбэрээрээ овог, нэр байдаггүй байна.

а. **Хүчүгүр** буюу **Souris des Bouleaux** /窟出沽兒 - ku chu gu er /. Эл нэр 120, 124, 202, 223 зүйлд гардаг байна. Орчуулагчид эл нэрийн *хүчгэр* хэмээн тайлж ийн орчуулсан байна.

б. Найманы **Буйруг** хан буюу **Roi Commandant des Souris des Bouleaux**. Эл нэр 150, 152, 167, 177-р зүйлд гардаг. Орчуулгыг үгчилэн орчуулбаас: Roi Commandant – удирдагч, хан, Souris des Bouleaux - хусны хулгана, хүчгэр. Эл тохиолдолд des Souris des Bouleaux гэдэг нь найманы нэг овгийн нэр байна.

Хучар бэхи буюу **Bélier le Bey** /忽察兒別乞 - hu cha er bie qi /. Эл нэр 122, 127, 142, 153, 166, 174, 179-181, 246, 255-р зүйлд гардаг. Францаар орчуулсныг үгчилбээс Bélier – хуц, le Bey – бэхи. Франц хэлнээ Bélier гэдэг овог байдаг. Үүнээс гадна оноосон нэрийг өмнө нь ийн орчуулж байсан жишээ байна: *Le*

¹⁴⁵ N. Poppe, *Ural-Altaische Jahrbücher, Band 47, Wiesbaden 1975*, ss.161-167

¹⁴⁶ <http://www.journaldesfemmes.com/nom-de-famille/nom/162720/ogre.shtml>

*courant nous repret encore et nous jeta sur le quai adjacent, le quai du palais Belier Bey, alors habitée par le sultan*¹⁴⁷. Иймд энэ орчуулга зөв болсон гэж бид үзэж байна.

Адхираг буюу **Mouflon** /阿惕乞刺黑- a ti qi la hei /. Эл нэр 238-р зүйлд гардаг бөгөөд олон сурвалжид эл нэрийг өөр өөрөөр тэмдэглэсэн байдаг байна. Рашид ад Дин эл нэрийг *Alp-Üniik* /*Alp-Ütüik*/ (?), МНТ –д *At kiraq*, Пеллио эл нэрийг *At buiruq*, Алтан иовчид Абирха г.м. хэмээн тус тус тэмдэглэжээ. Франц орчуулгыг үгчилбээс – аргал хэмээх утга илтгэж байна гэтэл И. де Рахевильц эл нэрийг түрэг *adyiraq* “young stallion” буюу “азарган үрээ” хэмээх үгээс үүссэн гэж үзэж байгаа бөгөөд хэрэв эл тайлбарыг баримтлаваас эл нэрийг франц хэлнээ Etalon гэж орчуулваас зохилтой.

Халиу буюу **Loutre**. **Жауридайн Халиудар** буюу **Je'üriyen Loutre** /合里兀答兒 - he li wu ta er /. **Бужир** буюу **Loutre Mâle** /不只兒- bu zhi er/. Франц хэлнээ ийм овог байдаг байна.

а. **Жауридайн Халиудар** буюу **Je'üriyen Loutre** /合里兀答兒 - he li wu ta er /. Эл нэр 183-185 зүйлд гардаг. Францаар орчуулсныг үгчилбээс Loutre – халиу. Н. Поппе 合里兀 – he li wu гэдгийг 1. Халиу, 2. Халиун /зүс/ хэмээн тайлбарласан бөгөөд Халиудар нэрийн утгын тухайд халиун зүс гэж үзжээ иймд Н. Поппегийн тайлбарыг баримтлаж орчуулваас – Bai гэж орчуулах байжээ.

б. **Бужир** буюу **Loutre Mâle** /不只兒- bu zhi er/. Эл нэр 202 –р зүйлд гардаг. Эл нэрийг шууд утгачилан орчуулжээ.

Булуган буюу **Zibeline** /不魯罕- bu lu han /. Эл нэр 202-р зүйлд гардаг. Францаар орчуулсныг үгчилбээс Булга гэсэн утга илтгэж байна. Франц хэлнээ ийм овог байдаг байна.

Буту хүргэн буюу **Chamelon le Gendre** /不圖 - bu tu /. Эл нэр 120, 202-р зүйлд гардаг. И. де Рахевильц эл нэрийг бусад нангиад сурвалжаас шүүн Butu бус Botu хэмээн тайлж унших нь зүйтэй хэмээн үзжээ. Франц орчуулгыг үгчилбээс Chamelon – ботго хэмээх утга илтгэж байна. Франц хэлнээ ийм овог, нэр байдаггүй байна, гэхдээ францын цагаачид дунд Aboubakar буюу “ботго” хэмээх араб гаралтай нэр нилээд дэлгэрсэн байдаг байна.

Арслан хаан буюу **Roi Lion** /阿兒思蘭罕 - a er si lan han / эл нэр 235-р зүйлд гардаг байна. Орчуулагчид нэрийг шууд утгачилж орчуулжээ. И. де Рахевильц үүнийг нэр бус цол байж магад гэж үзжээ. Ер нь “Арслан” гэсэн утгатай нэр нилээд түгсэн байдаг байна: Арслан, Сэнгэ, Лев, Leon, Lionel г.м. Франц хэлнээ ч Lion хэмээх нэр, овог байдаг байна. Сонирхуулахад оросын алдарт зохиолч Лев Николаевич Толстой хэмээх нэрийг франц хэлнээ Léon Tolstoi, испаниар León Tolstói г.м. орчуулсан байдаг байна.

Ухуна буюу **Bouc** /兀忽納 - wu hu na / эл нэр 254-р зүйлд гардаг. Орчуулагчид эл нэрийг шууд утгачилж орчуулсан бөгөөд франц хэлнээ ийм ховор овог байдаг бөгөөд тархацаараа 397474 байр эзэлдэг байна.

¹⁴⁷ Adolphus Slade, *La Turquie, la Grèce et Malte*, Paris, 1838

Гүрбэсү буюу **Saurienne** /古兒別速- gu er bie su / эл нэр 189, 194, 196-р зүйлд гардаг байна. Францаар орчуулсныг үгчилбээс “гүрвэл” гэсэн утгатай бөгөөд И. де Рахевильц эл нэрийн утгыг мөн “гүрвэл” байж магад хэмээн үзжээ. Францад ийм овог, нэр байдаг бөгөөд хүний нэрийн сайтаас үзэхнээ 1890 оноос хойш 17 хүн ийн нэрлэгдсэн байна.

Элжгэдэй буюу **L'Âne** /額勒只格歹- e le zhi ge dai / эл нэр 229, 275, 278-р зүйлд гардаг. Орчуулагчид эл нэрийг шууд утгачилж орчуулсан байна. Ц. Дамдинсүрэн гуай эл нэрийг хоёр өөр янзаар галигласан байна: Элжгэн /Ц. Дамдинсүхэн, МНТ, УБ, 1976, т. 232/, Элжгэдэй /Ц. Дамдинсүхэн, МНТ, УБ, 1976, т. 235/. Бид нилээд хайсан боловч франц хэлнээ ийм овог нэр олсонгүй, тухайн үг нь гол төлөв хоч болдог бөгөөд “зөрүүд” гэсэн утга илтгэдэг байна. Морь, унага г.м. утга илтгэдэг нэрс. Эдгээр нэрс нь дандаа тухайн морины онцлог шинж, өнгө зүс зэргийг тусгадаг байна.

а. **Тайчар** буюу **Poulain** /給察兒 - dai cha er /. Эл нэр 128, 129, 201-р зүйлд гардаг байна. Францаар орчуулсныг үгчилбээс “унага”. Францад ийм овог байдаг бөгөөд 1890 оноос хойш нийт 21693 хүн ийм овог авсан бөгөөд тархацаараа 175-р байр эзэлдэг байна.

б. **Хонхордай** буюу **Poulain Alezan** /晃豁兒台- huang huo er tai / Эл нэр 277, 278-р зүйлд гардаг. Францаар орчуулсныг үгчилбээс Poulain – унага, Alezan-зээрд гэсэн утга илтгэж байна. Франц хэлнээ ийм овог, нэр байдаггүй байна.

в. **Дамачи** буюу **Coureur** /塔馬赤- ta ma chi /. Эл нэр 202-р зүйлд гардаг. Францаар орчуулсныг үгчилбээс “уясан морь” /уралдааны морь/ гэсэн утга илтгэж байна. Францад ийм овог байдаг байна.

г. **Тобсаха** буюу **Cheval Arabe** /脫卜撒合- tuo bu sa he/ Эл нэр 202-р зүйлд гардаг. Францаар орчуулсныг үгчилбээс “араб морь” – “араб угшлын морь” гэсэн утгатай байна. Францад ийм овог, нэр байдаггүй байна.

д. **Ажинай** буюу **Pur-sang** /阿只乃- a zhi nai /. Эл нэр 202-р зүйлд гардаг. Францаар орчуулсныг үгчилбээс “ажнай хүлэг” – “цэвэр цусны хүлэг” гэсэн утга илтгэж байна. Франц хэлнээ ийм овог, нэр байдаггүй байна.

II. ЖИГҮҮРТЭН, ШУВУУНЫ УТГА ЗААСАН ХҮНИЙ НЭРИЙН ФРАНЦ ОРЧУУЛГА

Тогруу буюу **Grue** хэмээх үг орсон нэрс. МНТ франц орчуулганд ийм нэр 3 байна. Францчуудын тухайд гэвээс ийм овог нилээд дэлгэрсэн байдаг бөгөөд Жан Тости хэмээх франц нэр судлаачийн бичсэнээр анх урт хөлтэй, өндөр туранхай хүмүүсийг ийн хочилдог байсан бөгөөд аажимдаа энэ нь овог болон хувирчээ. Францад өнөөгийн байдлөөр 451 хүн ийм овогтой байгаа бөгөөд дийлэнхи нь францын баруун-өмнөд хэсэгт оршин суудаг гэж INSEE буюу францын үндэстний статистик хорооны мэдээнд бүртгэгдсэн байна.

а. **Хачиун-Тохураун** буюу **Duret la Grue** /合赤溫脫忽刺溫- he chi wen tuo hu la wen/ Эл нэр 120, 124-р зүйлд гардаг. Францаар орчуулсныг үгчилбээс Duret – хатуу, la Grue-тогруу хэмээх утга илтгэж байна.

б. **Хархай-Тохураун** буюу **Mélèze la Grue** /合刺孩脫忽刺温- he la hai tuo hu la wen /. Эл нэр 120, 124 –р зүйлд гардаг. Францаар орчуулсныг монгол хэлнээ хөрвүүлвээс **Mélèze** – хар мод, **la Grue** – тогруу.

в. **Харалдай-Тохураун** буюу **Noiraud la Grue** /哈蘭勒歹脫忽刺温- ha lan le dai tuo hu la wen/. Эл нэр 120, 124 –р зүйлд гардаг. Францаар орчуулсныг монгол хэлнээ хөрвүүлвээс **Noiraud** – хар /өнгө/, **la Grue** – тогруу.

Тоорил буюу **Gerfaut** хэмээх нэр. Бид МНТ-ны франц орчуулгыг шүүж үзээд 3 ийм нэр оллоо: **Gerfaut** – **Тоорил** /Ван хан/, **Gerfaut le Mince** - Нарин-тоорил, **Gerfaut des Astucieux** - **Сөггэдэй Тоорил**. Бид хэд хэдэн францын цахим хуудас, нийтийн сүлжээг шүүж үзээд ийм овог болон нэртэй хүмүүс байдгийг олж мэдлээ.

а. **Gerfaut** – **Тоорил** /Ван хан/. Эл нэр МНТ-д олонтаа гардаг бөгөөд францаар орчуулсныг монголчилвоос **Gerfaut** – шонхор гэсэн утга илтгэж байна. И. де Рахевильц эл нэрийг уйгуур гаралтай үг бөгөөд “bird of prey” буюу “махчин шувуу” гэсэн утгатай хэмээн тайлбарласнаас үзэхнээ эл нэр нь яг “шонхор” гэсэн утга илтгээгүй аж, гэхдээ орчуулагчид эл нэрийг франц хэлний хэм хэмжээнд тааруулан маш сайн орчуулсан гэж үзэж байна.

б. **Нарин-тоорил** буюу **Gerfaut le Mince** /納鄰脫幹鄰勒- na lin tuo wo lin le /. Эл нэр 218-р зүйлд гардаг. Францаар орчуулсныг үгчилбээс **Gerfaut** – шонхор, **le Mince** – туранхай.

в. **Сөггэдэй Тоорил** буюу **Gerfaut des Astucieux** /雪格額台脫幹鄰勒- xue ge e tai tuo wo lin le/. Эл нэр 166, 180, 181-р зүйлд гардаг. Францаар орчуулсныг үгчилбээс **Gerfaut** – шонхор, **des Astucieux** – зальтай, овжин гэсэн утга илтгэж байна. Лу. Алтан товчид эл хэсгийг өөрөөр буулгаж 2 өөр хүн болгосон байна: ... *гахай жилийн хавар Жамуха, Алтан, Хучар, Хартахидай, Өвөгжин Онгин, Сүхэгэдэй, Тоорил, Хачигун бэхи, эд болон нэгэн зетэн болж, ...*

Начин баатар буюу **Crécerelle le Preux** /納臣把阿禿兒- na chen ba a er tu /. Эл нэр 45, 46 -р зүйлд гардаг. Францаар орчуулсныг үгчилбээс **Crécerelle** – начин шонхор, **le Preux**-баатар гэсэн утга илтгэж байна. Франц хүний нэрийн цахим хуудас, нэрийн бүртгэлээс бид ийм нэр олж чадаагүй ч олон нийтийн цахим сүлжээнд ийм овогтой хүн байгааг оллоо /www.facebook.com/

Байшинхор догшин буюу **Riche Faucon le Terrible** /伯升豁兒多申 - bo sheng huo er duo shen /. Эл нэр 47 -р зүйлд гардаг. Францаар орчуулсныг үгчилбээс **Riche** – баян, **Faucon**-шонхор, **le Terrible** – догшин, аймшигтай гэсэн утга илтгэж байна. Эдгээр нь тус тусдаа овог, нэр болдог. И. де Рахевильц эл нэрийн утгыг “As Fierce (or Cruel) as the Rich (bay = түрэг “баян”) **Gerfalcon** (šingqor = мо. шонхор)” гэж тайлбарласан бөгөөд үүнийг баримталваас францаар **Faucon** бус **Gerfaut** гэж орчуулж болох талтай. Л. Безе, “Some Turkic Personal Names in the Secret History of the Mongols” хэмээх өгүүлэгтээ эл нэрийг өөрөөр тайлбарласан хэмээн судлаачидын бүтээлээс олж уншсан боловч харамсалтай нь өгүүлэгийг нь олж чадсангүй.

Хөхөчү буюу **Mésange Bleue**. МНТ-ы франц орчуулгад ийм нэр 3 байна: **Mésange Bleue** – **Хөхөчү**, **Mésange Bleue le Renard** – **Хөхөчү-Хирсаан**, **Хөхөчү**

тэв тэнгэр буюу **Mésange Bleue le Très Céleste**. Францаар **Mésange Bleue** гэдэг нь “хөх бух” гэсэн утгатай. Францад **Mésange Bleue**, **Mésange** гэсэн овог байдаг байна.

а. **Хөхөчү** буюу **Mésange Bleue** /бэсүдийн нутагт олдсон хүү/. Эл нэр 119, 138, 202, 214, 243, 244-р зүйлд гардаг. Эл нэр нилээд олон давтамжтай бөгөөд И. де Рахевильц эл нэрийг **kököcü** хэмээн галигласан авч 202-р зүйлд **kökö-cos** хэмээн галиглаж харин Алтан Товчид **Хөхөчү** гэж байсан авч 202-р зүйлд **Хөхэчос** хэмээн бичжээ. Гэхдээ эхний хувилбар нь зөв болов уу.

б. **Хөхөчү** буюу **Mésange Bleue** /Сэнгүмийн агтач/. Эл нэр 188-р зүйлд гардаг бөгөөд нэмэлт тайлбарыг А. Мостаэрт *Монголын нууц товчооны зарим хэсгийн тухайд* гэдгийг үзнэ үү.

в. **Mésange Bleue le Renard** буюу **Хөхөчү – Хирсаан**. Эл нэр 180-р зүйлд гардаг. Францаар орчуулсныг үгчилбээс **Mésange Bleue** -“хөх бух”, **le Renard** – шар үнэг гэсэн утга илтгэх бөгөөд хярсыг францаар **renard corsac** гэдэг бөгөөд эл нэрийн үгийн утгыг баримтлаваас **Mésange Bleue le Corsac** гэж орчуулж болох талтай.

г. **Хөхөчү тэв тэнгэр** буюу **Mésange Bleue le Très Céleste** /闊闊出帖卜騰格理- **kuo kuo chu tie bu teng ge li**/. Эл нэр 45, 46 -р зүйлд гардаг. Францаар орчуулсныг монголчилвоос **Mésange Bleue** – хөх бух, **le Très Céleste** – тэнгэрлэг, ариун, гэгээн гэсэн утга илтгэж байна.

Хуйханаг баатар буюу **Busard le Preux** /古亦古捏克 把阿秃兒- **gu yi gu nie ke ba a tu er** / Эл нэр 247 -р зүйлд гардаг. Францаар орчуулсныг монголчилвоос **Busard**-сар /шувуу/, **le Preux** – баатар гэсэн утга илтгэж байна. Монголч эрдэмтэн Мураками эл үгийг түрэг гаралтай бөгөөд “a mouse catching hawk, a bustard” буюу “хулгана барьдаг харцага, сар” хэмээх утга илтгэдэг гэж тайлбарлажээ.

Abstract: *We studied French translation of The Secret History of the Mongols and we found 52 people's names meaning animals and birds. Those names could be classified as*

- *Totemic names*
- *Symbolic names*
- *Protecting names*
- *Fortuitous or omen names.*

We tried to observe how these names translation correspond to French anthropology and we suggested some translations.

НОМЗҮЙ

1. Marie-Dominique Even, Rodica Pop, *Histoire Secrète des Mongols*, Saint-Amand, 1994
2. Paul Pelliot, *Histoire secrète des Mongols*, Paris, 1949
3. И. де Рахевильц, *The Secret History of the Mongols*, 1972
4. Ц. Дамдинсүрэн, *МНТ*, УБ, 1996
5. Лувсанданзан, *Алтан товч*, УБ, 2006
6. Ш. Чоймаа, *Монголын Нууц Товчоон*, УБ, 2006
7. www.nciku.com
8. <http://dic.mart.mn/online-dictionary/>
9. Ё. Жанчив, *Дундад үеийн монгол хэлний судлал*, Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл, УБ, 2011, х. 57-71
10. P. Pelliot et Louis Hambis, *Histoire des campagnes de Gengis Khan*. Cheng-wou ts'in-tcheng lou.
11. Т. Сая-Эрдэнэ, *МНТ-ы хүний нэрийн зүйлийн франц орчуулгад хийсэн ажиглалт судлагаа* магистрын зэрэг горилсон бүтээл, УБ., 2006
12. Котляр Наталья Александровна, ЭТИМОЛОГИЧЕСКИЕ КЛАССЫ ФРАНЦУЗСКИХ ФАМИЛИЙ В ИСТОРИЧЕСКОМ РАЗВИТИИ, Московский Институт Иностранных Языков, ЭШӨ
13. <http://www.aufeminin.com/w/prenom/p639/albin.html>
14. N. Poppe, *Ural-Altaische Jahrbücher, Band 47, Wiesbaden* 1975, ss.161-167
15. Л. Болд, *Орчин цагийн монгол хэлний дагавар*, УБ, 1986
16. V. Rybatzki, *From animal to name, remarks on the semantics of Middle Mongolian personal names*, Helsinki. academia.edu

“МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООН” ДАХЬ НЭГЭН ШҮЛГИЙН ТҮРК ОРЧУУЛГЫН ТУХАЙ

Н.Гэрэлмаа¹⁴⁸ (МУИС, ШУС)
Фатма Албаярак¹⁴⁹ (МУИС, ШУС)

Товч утга: “Монголын нууц товчоон”-ыг орчин цагийн түрк хэлнээ профессор Ахмет Темир 1942 онд анх орчуулсан бөгөөд үүнээс бараг 70-аад жилийн дараа судлаач Мехмет Левент Каяа хоёр дахь орчуулгыг гаргасан байна. Монголчуудын түүхэнд холбогдох энэхүү зохиолд монгол хэлний шүлэглэсэн, уран яруу үг хэллэгийг арвин ашигласан байдаг. Яруу найргийн мөр бадгуудыг дээрхи хоёр түрк орчуулгад харилцан адилгүй буулгасан байх бөгөөд утгын зөрүүтэй хийгээд андуу ташаа ухаарсан зарим үг хэллэгийг уул эхтэй нь харьцуулан тодруулсан болно.

Түлхүүр үг: Монголын нууц товчоон, түрк орчуулга

“Монголын нууц товчоо”-нд монголчуудын эрт үеийн түүхийг товчоолон өгүүлэхдээ энгийн үгээр өгүүлж болох хэрэг явдалыг уран тансаг найруулгаар, ёгт далд утгатай, онч мэргэн үг хэллэг ашиглан яруу найргийн өнгө аястайгаар илэрхийлсэн байдгаараа монголын уран зохиолын дээж бүтээлд зүй ёсоор тооцогддог билээ.

Академич Ц.Дамдинсүрэн энэхүү бүтээлийн найруулга, зохиомжийн онцлог шинжийг тодорхойлохдоо “...Тэр цагийн ардын дуу, цэцэн үг, шүлэглэлийг өргөн ашигласан байна ... Хүний яриа ба хэлсэн үгс нь их төлөв шүлэг байна ... Энэхүү зохиолд эртний монгол хэлний үг холбох найруулах хийгээд шүлэглэсэн, үргэлжилсэн зохиолын жишээ бүрэн гарсан байна” хэмээжээ¹⁵⁰.

“Монголын нууц товчоон” нь нэг мөр нь 2-5 үгээс бүтсэн, нийт 1200 гаруй мөр шүлэг, уран яруу хэллэгийг багтаасан байна¹⁵¹.

“Монголын нууц товчоон”-ыг орчин цагийн түрк хэлнээ анх Түркийн эрдэмтэн Ахмет Темир 1942 онд орчуулан гаргасан бөгөөд хожим 1986, 1995, 2010 онд тус тус дахин хэвлэгдсэн байна. Тэрбээр энэхүү орчуулгаа үйлдэхдээ проф. Хэйнишийн герман орчуулга, Козиний орос орчуулгыг эх хэрэглэгдэхүүн болгон ашигласан байна. Удиртгал хэсэг, судалгааны тойм, эргэлзээтэй үг хэллэгийн тайлбар, газар усны нэр, хүний нэр, цол хэргэм зэрэг оноосон нэрийн тайлбар, үгийн хэлхээ зэргийг нэмж үйлдсэнээрээ эрдэм шинжилгээ, судалгааны

¹⁴⁸ МУИС, ШУС, ХУС-ын ази судлалын тэнхимийн багш

¹⁴⁹ МУИС, ШУС, ХУС-ын ази судлалын тэнхимийн зочин багш

¹⁵⁰ Ц.Дамдинсүрэн, Монголын нууц товчоо, Дөрөв дэх хэвлэл, Улаанбаатар, 1980, тал.8

¹⁵¹ Нууц товчоо, Уран үгсийн цоморлиг, Улаанбаатар, 2005, тал.3

ач холбогдолтой болжээ. Түүний дараа Түркийн эрдэмтэн Мехмет Левент Каяа 2011 онд МНТ-ыг орчин цагийн түркээр орчуулан хэвлүүлжээ. Тэрбээр Ц.Дамдинсүрэнгийн кирилл эхийг гол хэрэглэгдэхүүн болгосон бөгөөд монгол, түрк хоёр хэлний авиазүйн онцлогийг харгалзан үзэж ялангуяа шүлэглэсэн хэсэгүүдийн яруу найргийн хэмнэл, уг найруулгыг алдагдуулахгүйг хичээсэн байна. Энэхүү орчуулгыг хянасан доктор Экрэм Калан номын өмнөх үгт өмнө нь гарсан Ахмет Темирийн орчуулгаас ялгарах онцлог талыг дурдахдаа дараахи мэт тэмдэглэсэн байдаг.

“...Merhum hocamız Prof. Dr. Ahmet Temir’in Haenisch’in Almanca ve Kozin’in Rusça tercümelerinden yararlanarak, Moğolca aktarma metinden yapmış olduğu Moğolların Gizli Tarihi tercümesi ilk ve çok erken tarihte yapılmış olması bakımından önemlidir. Fakat Ahmet Temir, Modern Moğolcanın dil özellikleri konusunda yeterince bilgi sahibi olmamasından olsa gerek, Moğolca asıllı kelimeleri farklı şekilde yorumlamış, yazım ve telaffuz şekillerini de pek çok yerde yanlış vermiştir. Ayrıca Rusça ve Almanca tercümelerde bazen yanlış tercihlerde bulunmuş olması sonucunda eserin tercümesinde bazı sıkıntılar ortaya çıkmıştır. Bu nedenle de(eserin) Moğolların Gizli Tarihçesi adıyla Moğolca orijinal adına da uygun olarak yeniden tercüme edilerek yayımlanması ihtiyacı duyulmuştur”¹⁵²

(“Проф. Ахмет Темир Хэйнишийн герман орчуулга хийгээд Козиний орос орчуулгад тулгуурлан анх удаа орчин цагийн түркээр орчуулсан билээ. Гэвч энэхүү орчуулга нь харьцангуй эрт үед гарсан, орчин цагийн монгол хэлний онцлогийг тэр бүр харгалзан үзээгүй, түүнчлэн монгол хэлний эртний үг хэллэгүүдийг өөр байдлаар буулгах гэх мэт зарим алдаа мадаг гаргасан байна. Мөн герман болон орос орчуулгад гарсан зөрүүтэй зүйлийг тэр хэвээр орчуулсан байх талтай. Иймээс бид МНТ-ны орчин цагийн монгол хэлээрхи эхийг гол хэрэглэгдэхүүн болгож түрк хэлнээ орчуулахыг чухалчилсан болно”) гэжээ.

Түркийн эрдэмтэн профессор Осман Фикри Серткаая “Türkiye ve Mongolistik”(Түрк улс хийгээд монгол судлал) хэмээх өгүүлэлдээ “Moğolların Gizli Tarihçesi çevirisi üzerine”(“Монголын нууц товчоон”-ы орчуулгын тухайд), “Türkiye’de Mongolist var mı?”(Түрк улсад монгол судлаач байна уу?), “Ülkemiz üniversitelerinde niçin Moğol Kültürü bölümü yok?”(Манай улсын их дээд сургуулиудад яагаад Монгол соёлын тэнхим үгүй байна вэ?) гэсэн 3 дэд сэдвийг хөндөж тавьжээ. Тэрбээр энэхүү өгүүлэлдээ “Монголын нууц товчоон”-ы дээрхи хоёр түрк орчуулгыг харьцуулан үзээд нийт 282 зүйлээс 112 зүйлд гарсан орчуулгын зөрүүтэй хэсгийг сонгон авч үзэж, үүнээс 10 жишээг тухайлан тайлбарласан байна¹⁵³.

Судлаачид зохиолын “Монголын нууц товчоон” хэмээх нэр нь Мин улсын үед хятад хүнд монгол хэл сургах зорилгоор ханз үсгээр монгол хэлээр галиглан тэмдэглэсэн эхэд нэмж бичсэн нэр хэмээн үздэг бөгөөд уул монгол

¹⁵² Mehmet Levent Kaya, Moğolların Gizli Tarihçesi, İstanbul, 2011, s.10

¹⁵³ Osman Fikri Sertkaya, “Türkiye ve Mongolistik. 1) Moğolların Gizli Tarihçesi çevirisi üzerine. 2) Türkiye’de Mongolist var mı? 3) Ülkemiz üniversitelerinde niçin Moğol Kültürü bölümü yok?”, Gazi Türkiyat, Türklük Bilimi Araştırmaları Dergisi, 11, Güz, 2012, Ankara, 2012, s. 1-10.

эхэд байхгүй юм. Энэхүү нэрийн бүтэц дэх “товчоон” гэх үгийг түрк оруулгад профессор Ахмет Темир “tarih”, харин Мехмет Левент Каяа “tarihçe” хэмээн харилцан адилгүй буулгасан байна. Уул хоёр үгийн утгын ялгааг сурвалжилан үзвэл түрк хэлний тайлбар тольд:

1. *tarih- toplumları, milletleri, kuruluşları etkileyen hareketlerden doğan, daha önceki ve sonraki olaylarla bağlantılarını, karşılıklı etkilenmeleri, her milletin kurduğu medeniyeti inceleyen bilim*(улс үндэстэн хийгээд байгууллага, бүлэгүүдэд холбогдох үйл хэргийг эрт үе болон ирээдүйн холбоо хамааралд нь харьцуулан авч үзэж судалдаг шинжлэх ухаан)

2. *tarihçe – Bir olay ve nesnenin özet olarak yazılmış tarihi*(Аливаа үйл хэргийг товч байдлаар бичсэн түүх)¹⁵⁴ хэмээн тэмдэглэсэн байна. “tarih”(түүх) гэдэг нь араб гаралтай үг бөгөөд харин “-çe” бүтээвэр нь перс хэлний “багасгасан, товчилсон” гэх утга нэмж илтгэдэг дагавар болно. Ийн үзвэл түрк хэлний “tarihçe” гэх үг “товч түүх” хэмээсэн утгатай болно.

Монгол хэлний “товчоон” хэмээх нь “Түүхэн үйл явдлыг нарийн тодорхой хэлхэж бичсэн зохиол”¹⁵⁵ болно.

Бид энэхүү өгүүлэлдээ “Монголын нууц товчоон”-д гарах нэгэн шүлэглэсэн хэсгийг сонгон авч орчин цагийн түрк орчуулгыг монгол эхтэй нь харьцуулан ялгаатай хийгээд ташаа буулгасан зарим үг хэллэгийн утгыг тодруулахыг зорьсон болно.

“Монголын нууц товчоон”-ы 137-р зүйлд Жалайрын Гүүн-Ува Мухали, Буха хоёр хөвүүнээ Чингис хаанд уулзуулж өгүүлэхдээ дараахи мэт ам өчигийг өгчээ.

... bosoqa-yin cinu	Босгын чинь
bo'ol boltuqai	Боол болтугай
bosoqa-daca cinu bulji'asu	Босгоноос чинь булзваас
borbi inu hoqtul	Борвийг нь огтол
e'üten-nece cinu	Үүдний чинь
emcū bo'ol boltuqai	Өмч боол болтугай
e'üten-nece cinu heyiljü'esü	Үүднээс чинь ийлбээс
eliget anu etkejü getkün ¹⁵⁶	Элгийг нь этгэж гээгтүн. ¹⁵⁷

Мөн, уул зүйлд Жалайрын Чулуун хайч Түнгэ, Хаши хоёр хөвүүдээ Чингис хаанд уулзуулж дараахи мэт өгүүлжээ.

...altan bosoqa cinu sakiju atuqai ke'en ökba bi
altan bosoqa-daca cinu anggida odu'asu
ami inu tasulju getkün
örgen e'üten ergüjü öktügei ke'en ökba bi

¹⁵⁴ Türkçe sözlük, Türk Dil Kurumu yayınları, 11.baskı, Ankara, 2011, s.2270-2271

¹⁵⁵ Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, Нэмж дэлгэрүүлсэн хоёрдугаар хэвлэл, Улаанбаатар, 2013, тал. 732

¹⁵⁶ Index to the Secret History of the Mongols. by Igor de Rachewiltz, 1972, pp.59

¹⁵⁷ Монголын нууц товчоон, Шинээр хөрвүүлж буулгаж, тайлбар хийсэн Ш.Чоймаа, Улаанбаатар, 2006, тал.80

örgen e'üten-nece cinu ö'ere odu'asu
öre inü miderejü getkin...¹⁵⁸

Алтан босгыг чинь сахиж байтугай хэмээн өгөв би
Алтан босгоноос чинь ангид одвоос
Амийг нь тасалж гээгтүн.
Өргөн үүдийг чинь өргөж өгтүгэй хэмээн өгөв би
Өргөн үүднээс чинь өөр одвоос
Өрийг нь нядалж гээгтүн¹⁵⁹

Дээрхи шүлэглэсэн хэсгийн түрк орчуулга дараахи мэт буй.

Ахмет Темир:

Bunlar senin eşiğinde	Эд нар чиний босгонд
Kulun olsunlar	Боол болог
Eşiğinden	Босгоноос чинь
Uzaklaşırlarsa,	Холдвоос
Ökçelerini* kes	Өсгийг нь хэрч
Bunlar senin	Эд нар чиний
Hizmetçin olsunlar	Үйлчлэгч болог
Kapını	Хаалгыг чинь
Terkederlerse	Хаяваас
Kebetlerini*	Элгийг нь
Kes	Хэрч

Altın eşiğini beklesinler	Алтан босгыг чинь сахиг
Diye bunları sana veriyorum.	Гэж эд нарыг чамд өгье
Altın eşiğinden	Алтан босгоноос чинь
Uzaklaşırlarsa,	Холдвоос
Hayatlarına son ver	Амийг нь эцэслүүл
Geniş kapını yükseltsinler * (açsinlar)	Өргөн хаалгыг чинь өргөг(нээг)
Diye bunları sana veriyorum	Гэж эд нарыг чамд өгье
Geniş kapını	Өргөн хаалгыг чинь
Terkederlerse,	Орхивоос
Kalplerini ayaklarıyla çiğne *	Зүрхийг нь хөлөөрөө дэвс

Тайлбар:

* Монгол эх дээрхи “борви” хэмээхийг “ökçe”(өсгий) гэж утга өөр буулгасан байна.

* kebet гэх үгийг орчин цагийн түрк хэлний тайлбар толиудад тэмдэглэсэн нь үгүй бөгөөд осман түрк хэлний толь бичигт “элэг” гэсэн утгатай гэжээ¹⁶⁰.

* монгол эх дэх “өргөх” гэх үйлийг түрк хэлнээ “yükseltmek” хэмээн үгчлэн буулгасан хэдий ч “үүд өргөх” буюу монголчуудын эсгий үүдийг дээш

¹⁵⁸ Index to the Secret History of the Mongols. by Igor de Rachewiltz, 1972, pp.59

¹⁵⁹ Монголын нууц товчоон, Шинээр хөрвүүлж буулгаж, тайлбар хийсэн Ш.Чоймаа, Улаанбаатар, 2006, тал.80-81.

¹⁶⁰ Kâmûs-ı Türkî ş.sami, Çağrı Yayınları, İstanbul, 2001, s.2411

өргөх, сөхөх гэсэн уул утга нь түрк сэтгэлгээнд зөв буухгүй тул “açmak”(нээх, онгойлгох) гэсэн үгийг давхар хадаж өгчээ.

* “Kalplerini ayaklarınla çiğne”(зүрхийг нь хөлөөрөө дэвс) гэх хэллэгээр “өр зүрхийг нь дэвсэл, гишгэч” гэсэн шууд утгаар орсон бололтой, энэ мэт өвөрмөц хэлц тэмдэглээгүй байна.

Мехмет Левент Каяа:

Eşiğinin	Босгоны чинь
Kulu olsun	Боол болог
Eşiğinden	Босгоноос чинь
Kaçıp uzaklaşırsa	Зугатан холдвоос
Baldırını kes	Борвийг нь огтол
Serpmenin*	Хөшигний чинь
Eşyası olsun	Өмч болог
Serpmeden	Хөшигнөөс чинь
Kaçıp giderse	Зугатан явбаас
Ciğerini yak!*	Элгий нь шатаа

Altın eşiğini	Алтан босгыг чинь
Daima gözetlesin	Ашид хараг(хамгаалаг)
Altın eşiğinden	Алтан босгоноос чинь
Ayrılıp gidecek olursa	Салан явах болвоос
Canını kesip al	Амийг нь таслан ав
Geniş serpmeni	Өргөн хөшигийг чинь
Kaldırıversin	Сөхөж өгөг
Geniş serpmenden	Өргөн хөшигнөөс чинь
Başka yöne giderse	Өөр зүг явбаас
Borcunu alıp öldür*	Өр(зээл)-ийг нь аваад үхүүл

Тайлбар:

* Монгол эх дэх “үүд” гэхийг тэрбээр “serpme” хэмээх үгээр орчуулсан байна. Энэхүү үгийг түрк хэлний аман аялгууны толь бичигт “бүтээлэг, хөшиг, гивлүүр” гэсэн утгатай болохыг тэмдэглэжээ¹⁶¹ Орчин цагийн түрк хэлэнд “sermek”(өлгөх, дэлгэх, тархаах) гэх үйл үг байгаа хэдий ч энэ мэт “serpme” гэсэн нэр үг үүссэн нь үгүй байна. Утгын хувьд ч яг таг тохирохгүй байгаа юм. Монгол гэрийн эсгий үүдийг ийн буулгасан аж.

* “ciğerini yak”(элгийг нь шатаа) гэх хэллэгээр “зовоон тарчлаах” гэсэн утгыг илтгэжээ.

* Монгол хэлний “өр зүрх” хэмээхийг “borç” буюу “өр шир” хэмээн ташаа ухаарчээ. Энэ нь кирилл эхийг баримтлан орчуулсан тул ийнхүү бичлэг ижил, утга өөр хоёр үгийг үл ялгасан бололтой.

Бид “Монголын нууц товчоон”-д гарах нэгэн шүлэглэсэн хэсгийн түрк орчуулгуудыг харьцуулан авч үзүүлээ. Энэ мэт орчуулгын зөрүүтэй хэсгийг

¹⁶¹ Türkiye’de halk ağzından derleme sözlüğü, Cild, X, TDK, Ankara, 1978, S.3592

тухайлан тайлбарлаж монгол эх дэх уул утгыг нь тодруулах, ялангуяа шүлэглэсэн, ёгтолсон, далд утгатай хэлц, хэллэгүүдийн орчуулгыг нягтлан үзэх нь дараа дараагийн орчуулгад тустай зүйл болно хэмээн санана.

“Монголын нууц товчоон”-ы түрк орчуулгууд нь гол хэрэглэгдэхүүн болгон сонгосон эхийн хувьд харилцан адилгүй, түүнчлэн анх хэвлэгдэн гарсан он цаг нь ч хол зөрүүтэй байгаа болно.

Бидний тухайлан авч үзсэн шүлэглэсэн хэсгийн 2 орчуулгыг харьцуулан үзвэл проф. Ахмет Темир мөр тус бүрийн утга агуулгыг нэгтгэн авч үзсэн учир зарим үг хэллэгийг орхигдуулах, ойролцоо утгатай үгсийг нэг үгээр буулгах гэх мэт байдал ажиглагдлаа. Ж: огтлох, эмтлэх – *kesmek*, хаалга, үүд – *kapı* гэх мэт. Үүнээс үүдэн мөрийн доторхи үгсийн харьцаа алдагдаж зарим мөр ердөө ганц үгтэй болсон байна.

Харин Мехмет Левэнтийн орчуулгад үг тус бүрийн утгыг анхааран үзэж ойролцоо утгатай үгсийг аль болох өөр үгсээр буулгахыг хичээсэн бололтой. Ж: булзах, ийлэх, ангид одох, өөр одох- утга ялган орчуулжээ.

Иймээс нэг үгийг олон дахин давтахаас зайлсхийж, мөрийн доторхи үгийн тоо харьцангуй тэгш болсон байна. Энэ нь хэлний зүйн хувьд ижил төстэй хэлнээс орчуулсан нь ч нөлөөлсөн байх талтай.

Resume

The first translation of “Secret History of Mongols” which is an important work of Mongol literature created as epic and known that it has been translated into many languages in many countries until our day from its discovery has been translated into Turkish by Ahmet Temir in 1942, second one by Mehmet Levent Kaya in 2011.

We have compared the poem sample consisted of mixing the prose and poem we choose from “Secret history of Mongols” in terms of points to take into consideration in translations of the poems. We have determined in this comparison that synonymous words do not vary in the translation of Ahmet Temir on the other hand Mehmet Levent Kaya has used it in the various ways saving the harmony in the poem. When we compare and contrast in terms of other points it is said that both of translations have been different and both of them include mistakes but in fact Mehmet Levent Kaya depends on Mongolian in a tighter way. Also, a conspicuous factor is that Ahmet Temir pays attention the truth in terms of the meaning but does not pay attention the truth in terms of rhythm factor on the other hand Levent Kaya sticks to poetical factors but made minor meaning mistakes.

Номзүй


Гаадамба Ш, Монголын нууц товчоо, Улаанбаатар, 1990

Дамдинсүрэн Ц., Монголын нууц товчоо, Дөрөв дэх хэвлэл, Улаанбаатар, 1990


Дашцэдэн Т, Монголын нууц товчоо, Улаанбаатар, 1985

- Монголын нууц товчоо, Шинээр хөрвүүлж буулгаж тайлбар хийсэн, Ш.Чоймаа, Улаанбаатар, 2006
- Нууц товчоо, Уран үгсийн цоморлиг, Улаанбаатар, 2005
- Цэвэл Я., Монгол хэлний товч тайлбар толь, Нэмж дэлгэрүүлсэн хоёрдугаар хэвлэл, Улаанбаатар, 2013
- Ahmet Temir, Moğolların gizli tarihi, Ankara, 1995
- Kâmûs-ı Türkî ş.samî, Çağrı Yayınları, İstanbul, 2001
- Index to the Secret History of the Mongols. by I.de Rachewiltz, 1972
- Mehmet Levent Kaya, Moğolların Gizli Tarihçesi, İstanbul, 2011
- Osman Fikri Sertkaya, “Türkiye ve Mongolistik. 1) Moğolların Gizli Tarihçesi çevirisi üzerine. 2) Türkiye’de Mongolist var mı? 3) Ülkemiz üniversitelerinde niçin Moğol Kültürü bölümü yok?”, Gazi Türkiyat, Türklük Bilimi Araştırmaları Dergisi, 11, Güz, 2012, Ankara, 2012
- Türkçe sözlük, Türk dil kurumu, Ankara, 2005
- Türkiye’de halk ağzından derleme sözlüğü, Cild, X, TDK, Ankara, 1978

Хавсралт:



Prof. Ahmet Temir, Moğolların Gizli Tarihi <Yazılışı: 1240>, I, Tercüme”, Türk Tarih Kurumu, Ankara, 1942.(300 тал), Дахин хэвлэгдсэн он: 1986, 1995, 2010.



Mehmet Levent Kaya, Moğolların Gizli Tarihçesi, Kabalcı Yayınevi, İstanbul,
2011.(251 тал)

**ON THE TURKISH TRANSLATION OF THE POEMS IN
“SECRET HISTORY OF MONGOLS”**

N.GERELMAA
FATMA ALBAYRAK

МОНГОЛ ХЭЛНЭЭ ОРЧУУЛАГДСАН ТҮРКИЙН УРАН ЗОХИОЛЫН ТУХАЙ

Б.Азжая¹⁶² (МУИС, ШУС)

Товч утга: Түркийн уран зохиолын шилдэг бүтээлүүдээс монгол хэлнээ XX зууны дунд үеэс орчуулагдаж эхэлсэн боловч эдгээр нь орос болон бусад хэлнээс дам орчуулж байсан ажээ. Харин 2012 онд түрк хэлнээс монгол хэлнээ шууд орчуулгын бүтээл хэвлэгдсэн байна. Тиймээс эдүгээ шинэ үеийн чадварлаг орчуулагч нарыг бэлтгэн гаргах нийгэм болоод цаг үеийн шаардлага байгааг тэмдэглүүштэй.

Түлхүүр үг: Түркийн уран зохиол, яруу найраг, монгол орчуулга

Нэрт орчуулагч, судлаач Г.Аким гуай “...дуун хөрвүүлээчин гадаад үг өгүүлбэрийн бэрх утгыг төдийгүй эх хэлнийхээ үг өгүүлбэрийн ч бэрх утгыг тайлдаг ажаам. Тийнхүү бэрх утгыг мэдэн чадагч аваас их өтгөс Ринчен гүүш мөн авай.”¹⁶³ хэмээн дурсан бичсэн байдаг билээ. Үнэхээр л их өтгөс Б.Ринчен гуай л түрк утга зохиолоос монгол хэлнээ анх орчуулсан ажээ.

Тэрбээр Назим Хикмэтийн Таранта Бабууд бичсэн захиа, Арван тавны дурсгал, Гяндангаас бичсэн захидал, Зоя, Зүрх минь, Зүрх минь энд биш шүү, Өлбөрч байсан тав хоногт, Өнөөх л зүрх, Өнөөх л тархи, Поль Робсонд Хорьдугаар мөчлөг зэрэг¹⁶⁴ шүлгүүдийг орчуулсан байна.

Харин яруу найрагч, орчуулагч М.Цэдэндорж мөн л Назим Хикмэтийн Габриел Перн, Тоо, Тэр хүний хоёр сантиметрээс хэдэн метр хүртэл зэрэг шүлгүүдийг орчуулж байжээ. Мөн яруу найрагч Г.Аюурзана нэгэн шүлгийг орчуулан “Дэлхийн сонгомол яруу найраг” хэмээх бүтээлдээ хэвлүүлжээ¹⁶⁵.

Түркийн яруу найрагчдаас яагаад зөвхөн Назим Хикмэтийн шүлгүүд монгол хэлнээ орчуулагдсаныг ихэнх судлаачид түүний “Коммунист” үзэлтэй нь холбон тайлбарладаг. Учир нь дээрх орчуулгууд бүгд нь дам буюу орос хэлнээс монгол хэлнээ буулгасан байдаг ажээ.

Тиймээс саяханыг хүртэл бид Түркийн яруу найргийн амт шимтийг эх хэлнээс нь шууд буулгасан орчуулгаас үзэх боломжгүй байлаа. 2012 онд яруу найрагч, орчуулагч Д.Мөнхтөр “Түркийн яруу найргийн дээжис-I” хэмээх бүтээлдээ хорьдугаар зууны үеийн найман найрагчийн бүтээлээс орчуулан хэвлүүлсэн байна.

¹⁶²МУИС, ШУС, ХУС-ын Ази судлалын тэнхим, доктор, дэд профессор

¹⁶³Ринчен, Марк Твений минь махы нь идэж дээ(Орчуулгын тухай),Эмхтгэн эрхэлж оршлыг бичсэн

Г.Аким, УБ., 1991, тал. 3

¹⁶⁴Ринчен, Марк Твений минь махы нь идэж дээ(Орчуулгын тухай), Эмхтгэн эрхэлж оршлыг бичсэн

Г.Аким, УБ., 1991, тал. 227

¹⁶⁵Түркийн яруу найргийн дээжис -1, орч.Д.Мөнхтөр, УБ., 2012, тал.36

Энэхүү бүтээл нь түрк хэлнээс монгол хэлнээ шууд орчуулсан анхны бүтээл болохын хамт мөн ондоо “Алтан өд” шагналыг хүртжээ.

Түүний орчуулга маш нямбай болсон нь олон зүйлээс тодорхой харагдана. Тухайлбал: Нэжип Фаазыл Кысаюрэк-ийн “Хөшөө” хэмээх шүлэгт¹⁶⁶:

Artık o silinen bir hatıradır

Bir ıssız bahçenin uzaklarında

Үгчилбэл:

Тэр нэгэнт арчигдан буй дурсамж юм

Нэгэн эзэнгүй цэцэрлэгийн цаахантаа

Алс энэ цэцэрлэгийн хаа нэгтээ

Арчигдан нэгэнт одож буй дурсамж юм тэр.

Дээрх хоёрхон мөр зөвхөн яруу найрагч хүн л цаад эхийн утга санаа төдийгүй амт шимтийг тааруулан тохируулсан гайхалтай орчуулга хийдэг болохыг бидэнд харуулна.

Орхаан Вэли Канык-ийн “Истанбулыг чагнана би” хэмээх шүлгийг Монгол улс болон БНТУ-лс хооронд дипломат харилцаа тогтоосны 45 жилийн ойд зориулан гаргасан National Times News сэтгүүлийн 2014 оны тусгай дугаарын 78-р талд:

Нүдээ тас аниад Истанбулыг би чагнана

Нөмгөн салхи үл мэдэг сэвшинэ

Навчис мөчиртөө чимээгүйхэн сэрчигнэнэ

Алсад ус түгээгүүрийн хонх хаа нэг сонсогдоно

Ахиад л би Истанбулыг амьсгаа даран чагнана...

хэмээн орчуулсан байна. Харамсалтай нь бид тус шүлгийг орчуулсан хүнийг олж чадсангүй. Магадгүй тус сэтгүүлийн нэгэн сэтгүүлч орчуулсан болов уу. Гэтэл Д.Мөнхтөр гуай тус мөрүүдийг:

Истанбулыг чагнана би, нүдээ аниастай

Эхлээд зөөлөн салхи сэвэлзэж

Моддын навчис үл мэдэг сэрчигнэнэ

Холоо, тээр холд

Ус зөөгчдийн үл тасрах хангир жингэр дуун

Истанбулыг чагнана би, нүдээ аниастай

хэмээн орчуулсан байна. Ийм яруу тансаг бэлээхэн орчуулга байсаар атал утга болон логикийн алдаа бүхий орчуулгыг сэтгүүлд тавих шаардлага байсан уу.

Тиймээс ч Д.Мөнхтөр-ийн энэхүү бүтээл нь Түркийн төдийгүй дэлхийн яруу найргийг дам бус шууд орчуулан хүргэх нь уншигчдад хичнээн чухал болохыг харуулсан бодит бүтээл болсон.

Түркийн уран зохиолоос зөвхөн яруу найргийн орчуулга л ийм чамлахаар бага хэмжээнд байгаа биш юм. Үргэлжилсэн үгийн бүтээлүүдийг ч орчуулж уншигч олноо хүргэх зайлшгүй шаардлагатай байна.

¹⁶⁶Түркийн яруу найргийн дээжис -1, орч.Д.Мөнхтөр, УБ., 2012, тал.62



Хэдий тийм боловч сүүлийн жилүүдэд сургалт, зөвлөлгөө, хэвлэлийн “Эмпати” төвөөс 200 орчим орчуулгын ном хэвлүүлснээс ихэнх нь бага, дунд сургуулийн сурагчидад зориулсан сурах бичиг, үлгэр, хувь хүний хөгжлийн болон танин мэдэхүйн бүтээлүүд байна. Өмнө дурдсан Д.Мөнхтөрийн орчуулгыг ч тус хэвлэлийн газраас эрхлэн хэвлүүлсэн болохыг дашрамд тэмдэглэе.

Б.Ринчен гуай шүлгийн орчуулгын талаар “үеийн тоо хэмжээгий нь андахгүй буулгахад уг эх зохиолд тэр тоо хэмжээ бүхий үеэр бүтсэн шад тутам өргөлттэй, өргөлтгүй үеийн найруулга зохион байгуулалт ямар байна гэж судлан таньж, шинжин олоод монгол хэлнээ түүний нь буулгах ёстой....өргөлтийн оронд урт эгшиг, өргөлтгүй үед ерийн эгшигт үе хэрэглэвэл цаад эх зохиолын шүлэг болгон хэрэглэсэн хэмжээний зарчим журмыг ширхэгийн зөрүүгүйгээр монгол хэлнээ буулган найруулж болох байна.” хэмээсэн ньөөрийн ажиглалт судалгааныхаа дүнд монгол уншигчдад тухайн хэлний онцлог болоод яруу найргийн амт шимтийг бүрэн мэдрэх боломжийг орчуулагч бээр хэрхэн хүргэх арга замыг нээж өгсөн байна.



Тиймээс ч бид үе үеийн орчуулагч нарын гүйцэтгэсээр ирсэн хүндхэн тэрхүү үүргийг хүндэтгэн үзэж шинэ үеийн чадварлаг орчуулагч нарыг бэлтгэн гаргах нийгэм болоод цаг үеийн шаардлага байгааг өгүүлэх юун.

ON THE TURKISH LITERATURE WORKS TRANSLATED INTO MONGOLIAN

The distinguished works of Turkish literature have been began to be translated into Mongolian upward in the midst of twentieth century but the translations at issue have been translated from second languages such as Russian but not directly Turkish. The translation of belles-lettres which directly translated into Mongolian from Turkish have been based on the last decades. For the first time the best known examples of contemporary Turkish poem called as the new period of Turkish literature by a Mongolian poet have been published as Mongolian. For this reason it is extremely important to train the translators who demonstrate the beauty of Turkish literature and the property of Turkish.



ОРЧУУЛГЫН ШҮҮМЖ СУДЛАЛ



**“Алтан бөлзөг зүүсэн
Арван мойног хуруу”-ны паян
/Ц.Дамдинсүрэнгийн шүлэг орчуулах эрдэм/**

Хатагин Г.Аким¹⁶⁷

Алтан бөлзөг зүүсэн
Арван мойног хуруугаар
Аягач хүүхний үсийг

Атгаж аваад зодож байна... гэж Пушкиний “Алтан загасаны үлгэр”-т нэг уран бадаг буй. Гэвч үүнийг түр үл өгүүлэн өгүүлэхэд “Ямарваа шүлэгт, ямарваа уран зохиолд хүний сэтгэлийг хөдөлгөх чадал бий. Энэ нь уран зохиолын гол сүнс болно...Энэ сэтгэлийг хөдөлгөх чадлыг эрхбиш орчуулах хэрэгтэй...энэ сэтгэлийг хөдөлгөх чадлыг орчуулж эс чадвал амьд морийг үхсэн мориор арилжсантай адил” гэж Ц.Дамдинсүрэн гүүш айлджээ. Европ зүгийн хэлнээс шүлэг орчуулах онолын үндсийг тавигчдын нэгийхээ хувиар тэрвээр шүлэг орчуулах талаар нэлээд зүйлийг хэлж байсан байдаг боловч түүний онолын амин сүнс нь чухам энэ гэж би боддог. Дуун хөрвүүлсэн шүлэг найргийг нь үзэж байхад энэ л зарчмаа баримталсан нь харагддаг. Сэтгэлийг хөдөлгөх чадал гэж юу юм бэ? Үүнийг би тайлбарлах гэж цэцэрхэх бус, 1740-өөд оны эхээр “мэргэд гарахын орон нэрт тогтоосон дагиг оршвой”-г зохиосон монгол гүүш нарын амаар хэлүүлсү. Тэдний өгүүлсэн нь: “Бас бус үг хийгээд муутгахын үг ба гайхахын үг хийгээд уйтгарлахын үг ба аюухын үг мэтэс дүр нь монголын хэлэн дүр хотолд алдаршсан бөгөөд их чадалт сэтгэлийг хөдөлгөн чадахуйг учир дур хүрсэн үгээр орчуулагдахуй” гэжээ. Энэ л үүднээс молхи би Дамдинсүрэн аругайн уран орчуулгын туршлагыг задлах гэж оролдсу.

Намайг задлах гэж оролдохоос аль өмнө Дамдинсүрэн өөрийгөө задалжээ. Өгүүлсү. Бидний үеийнхний цээжилсэн нэг үлгэр бий. Монгол үлгэр шиг. Тэр юун буй. Оросоор бол “Сказка о рыбаке и рыбке” буюу үгчилбэл “Загасчин ба загасны тухай үлгэр”. Дамдинсүрэн гуайн орчуулгаар бол “Алтан загасны үлгэр”. Энэ тухай Дамдинсүрэн ву хэлж вэ. нээрээ, Да багштнаас давж гарч хэлнэ гэж хаашаа харсан юм байх вэ.

“Би юу ч нэмэж хасалгүй, яг үгчлэн орчуулах гэж оролдов. Тэгээд энэ орчуулгаа монгол хүнд уншиж өгөхөд миний орчуулга тэдэнд сонин биш байв” гэж Дамдинсүрэн өгүүлжээ. Тэгээд орчуулгаа яаж “сонин” болгов оо? “Би ч энэ үлгэрийг монгол хүн монгол үлгэр шигээ хүлээж авахуйцаар орчуулахыг зорьсон билээ” гэж уг асуултад өөрөө хариулжээ.

“Сказка о рыбаке и рыбке” үлгэрийн

¹⁶⁷ Нэрт дуун хөрвүүлэгч, доктор, профессор

У самого синего моря... гэсэн ганц өгүүлбэрийг

Хөрст алтан дэлхийн

Хөвөө хязгаар нутагт

Хөх цэнхэр далайн

Эрэг ирмэг газарт гэсэн дөрвөн мөр болгосон байна. “У самого синего моря” гэдэг нь маш хол гэсэн санаа юм. Ухаа нь, манайхан үлгэртээ маш эрт гэдгийг

Сүн далай шалбааг байхад

Сүмбэр уулыг дов байхад гэж шүлэглэн илэрхийлдэг. Энэ л аргыг баримтлан Дамдинсүрэн маш хол, газрын мухарт гэсэн санааг нь гаргасан байна.

Ер, уг үлгэр бол Дани үлгэр юм. Гримм ах дүү хоёр үүнийг боловсруулан өөрсдийн зохиосон үлгэр шиг болгосон бол Пушкин үүнийг орос хэлээр шүлэглэн орос үлгэр болгосон юм. Тэгвэл Дамдинсүрэн түүнийг монголоороо гайхалтай шүлэглэн, монгол хөрсөнд идээшүүлж, “монгол хүн монгол үлгэр шигээ хүлээж авахуйцаар орчуулах” гэсэн зорилгодоо бардаагаар хүрсэн юм. “Хэдийгээр би Пушкиний “Алтан загасны үлгэр”-ийн яг үгчилсэн орчуулга хийгээгүй боловч уран сайхны хэлний дүрслэгдэхүүний нь хувьд түүнийг огтхон ч бууруулаагүй гэж боддог... Ингэхлээр түүнийг үгчилсэн орчуулга биш, “монголчилсон”, зохиомжилсон орчуулга гэх нь зохимжтой биз. Ингэх нь сайн уу муу юу гэж асууваас би сайн муу гэж эрс тууштай хариулж чадахгүй” гэж даруухан өгүүлжээ. Тэгвэл уншигч би сайн гэж дүгнэнэ. Яагаад гэвэл орчуулгын онолд уншигчаа бодох гэсэн нэгэн зарчим буй. Тэгвэл Дамдинсүрэн монгол уншигчаа бодсон байна.

“Би Пушкиний 10 орчим шүлэг найраглалыг орчуулсан. Эд бүгдээрээ “Алтан загасны үлгэр” шиг чөлөөт орчуулга биш” гэж дараахан нь хэлжээ. Харин энд Дамдинсүрэн гуайн хэлсэнтэй санал нийлэмгүй байна. Учир нь орчуулгын онолд “чөлөөт орчуулга” гэж гаднын ахуйг яг өөрийн болгохыг хэлдэг. Тухайлбал, далайг тал, загасчныг малчин болгох жишээтэй. Тэгвэл Дамдинсүрэн тэгсэнгүй, далай нь далай чигээрээ, загасчин нь загасчин хэвээрээ байна. Ингэхлээр энэ нь чөлөөт орчуулга биш, харин өөрийнх нь хэлснээр дуурайлган зохиомжилсон орчуулга байна.

“Олег цэцний дуулал” ч ийм орчуулга гэдгийг хэлэх хэрэгтэй.

Тэгвэл Лермонтовын “Далбаа” шүлгийн орчуулгыг авч үзье.

Белеет парус одинокий

В тумане море голубом!

Что ищет он в стране далёкой?

Что кинул он в краю родном?...

Хөх далайн цэнхэр мананд

Хөлгийн дарвуул ганцаар уайрч

Ахуй нутгаа юунд орхиж

Алс газар юуг эрэв

Энд “цэнхэр” гэдэг үг л нэмэгдэж оржээ. Бусад нь бол үг үгээрээ шахуу буусан байна. Чингэхдээ хамгийн гол нь энэ нь үг үгээр буусан мөртлөө шүлэг

болсон байна. Өөрөөр хэлбэл хэлбэр нь буусан атлаа шүлэг болсон байна. Тэр бүү хэл яруу асуулт (/юунд орхиж, юуг эрэв/) гэдэг өгүүлбэрзүйн уран маягийг ч гаргасан байна. Дамдинсүрэн өөртөө үг, утга, урлагийг буулгах гэсэн гурамсан шаардлага тавьдаг байсан тухайгаа өгүүлсэн нь бий. Тэгвэл энэ шүлэгт энэ гурав яахын аргагүй буусан байна гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл, хэлбэр, агуулга, ур чадал энэ гурав гурвуул буужээ. “Зарим тохиолдолд агуулга хэлбэр (утга, өвөрмөц найруулга)-ийн хооронд ноцтой зөрчил үүсдэг, иймд аль нэгийг нь огоорохоос өөр аргагүй болдог” гэж Ю.Найда Л.Танкокийг ишлэн бичсэн байна. Гэтэл энд Дамдинсүрэн аль алийг нь буулгаж чадсан байна. Энэ бүхнээс нэг юм анзаарагдаж байна. Дамдинсүрэн орчуулж байгаа зохиолчдынхоо өвөрмөц найруулгыг онцгой мэдэрдэг байжээ. Өөрөөр хэлбэл, орчуулгадаа туулийг (“Олег цэцний дуулал”) тууль, үлгэрийг (“Алтан загасны үлгэр”) үлгэр, шүлгийг (“Далбаа”) шүлэг болгож чаддаг байжээ. Дамдинсүрэн яруу найргийн зүйлийг орчуулахдаа хоёр арга хэрэглэж байсан байна. Нэгд, цаад шүлгийн утгыг аваад эхэд байхгүй үг нэмэх зэргээр өөрөө уран шүлэглэх, хоёрт, хэлбэрийг нь хадгалаад ур чадлыг нь гаргах ийм хоёр арга харагддаг байжээ. Энд энэ хоёр аргыг бие даасан бүтээл дээр дагнаж хэрэглэсэн байх юм. Тэгвэл нэг хүний нэг зохиолд ч энэ хоёр аргаа давхар хэрэглэсэн нь тааралдаж байна.

Үүнд Түвдийн 6-р Далай лам Цанъянжамцын “Янагийн дуулал”-ын орчуулгаас гурван бадгийг жишээ болгож үзье. Би түвд хэл мэдэхгүй. Гэвч нэг англи орчуулга, Л.Савицкийн орчуулсан орос орчуулга над байна.

Англиар эхний бадгийг сийрүүлбэл:

From the mountain peaks in the east

The silvery moon has peeped out

And the face of that young maiden

Has gradually appeared in my mind

Орос орчуулгыг сийрүүлбэл:

Из-за восточных горных вершин

Белая ясная луна появляется

Юной девушки лицо

[Мне] чудится, чудится

Дамдинсүрэнгийн орчуулсан нь:

Зүйтэй сайхан цагаан саран

Зүүн уулын цаанаас ургана

Зүстэй сайхан охины царай

Зүрхний дунд үргэлж ургана

Энд англиар “silvery” буюу “мөнгөлөг” гэдгийг “зүйтэй сайхан”, “young maiden” буюу “залуу бүсгүй” гэснийг “зүстэй сайхан” гэснээс өөр юм нэмсэнгүй. Е нь бол үг үгээрээ л байна. Гэтэл оросоор бол “белая яснас луна” гэсэн нь Дамдинсүрэнгийнхтэй бүр дөхөж очиж байна. Оросоор ч “залуу бүсгүй” гэсэн байна. Дамдинсүрэн “зүстэй сайхан” гэдэг үгийг яагаад нэмэв ээ? Толгой холбохын тулд л аргагүйдэн энэ хоёр үгийг хэрэглэв үү? Ургуулан бодсу. “Maiden” гэдэг англи үг нь нөхөрт гараагүй хүнийг хэлдэг байна. Орос “девушка” нь бас л нөхөрт гараагүй хүнийг хэлнэ. Тэгвэл гоо сайхны онцгой мэдрэмж

бүхий яруу найрагчийн сэтгэл зүрхэнд байн байн ургаад байгаа залуу бүсгүй ямар зүс царайтай байх вэ? үзэсгэлэнтэй л байж таарна. Дамдинсүрэн энэ л утгыг тодруулах үүднээс “зүстэй сайхан” гэсэн үгсийг нэмжээ. Толгой холбох нь түүнд дайвар болж өгчээ. Иймээс энэ бадгийг үгэнд нь бариулсан боловч шүлэглэж чадсан байна. Тэгвэл огт өөрөөр орчуулсан нэг бадаг авсу.

Англиар бол:

When I live at Potala

I am rig-hdsin-m Tshan-dbyangs-rgya-mtsho

When I stay at Lhasa sity below

I am Dang-bzan-dbng-po the libertine

Оросоор бол:

В Потала жил [я в то] время

[Был я] Ригдзин Цанъянжамц

В Нижней Лхасе бывал [я] когда

[Был я] прелюбодей Данзан Бангпо

Одоо түвдээс доктор Л.Хүрэлбаатарын хийсэн хадмал орчуулгыг сонирхуулъя.

Бодада дор оршихын цагт

Ригзин Цанъянжамц

Лхасын хороонд суухын цагт

Садар танхай нэгэн

Энэ гурван орчуулгыг зэрэгцүүлэн үзвэл англи, орос, монгол орчуулгын аль алинд нь бадгийн хоёрдох мөрийг түвдээр нь тавьжээ. Харин дөрөвдүгээр мөрөнд англи, орос нь Данзан Бангпо үгийн хажууд libertine, прелюбодей /”садар”/ гэсэн тодотголыг хийж өгсөн байна. Хүрэлбаатарын орчуулгад түвд үг нь байхгүй, харин садар танхай нэгэн гэсэн байна.

Тэгвэл Дамдинсүрэнгийн орчуулсан нь:

Тансаг Бодалын дотоод оронд

Тарнийг бясалгасан Цанъянжамц

Тагтат Лхасын гадаад байшинд

Тачаалыг бясалгасан танхай банди...

Түвд судлаач доктор Л.Хүрэлбаатар тайлбарлахдаа: “Төвд эхэд “дотоод орон” “гадаад байшин”, “тарнийг бясалгасан”, “тачаалыг бясалгасан” гэдэг үг хэллэг огтхон ч байхгүй атал, эсрэг харшийн хэлбэрээр нь санааг уран хурц гаргахын үүднээс “тасаг Бодалын дотоод ордон”, “тагтат Лхасын гадаад байшин” хоёрын, хоёр эрс тэс ялгаатай орон орчныг “тарнийг бясалгах”, “тачаалыг бясалгах” хоёрын хоёр эсрэг тэсрэг ялгаатай үйл үйлдвэрийг нэгэн ламын явдал дээр зангидснаараа зохиолчийн битүү далд санааг орчуулгынхаа уран чадвараар улам бүр ил нут болгон нөхөж гаргасан байна” гэж онож дүгнэсэн байна. Ерөөс Цанъянжамцын энэ дуулал бүхэлдээ шахам арга билгийн шүтэлцээ, өнөөгийнхөөр хэлбэл эсрэг тэсрэгийн нэгдэл, бүр хар үгээр хэлбэл болох болохгүйн сүлжилдээн дээр цогцолсон юм. Энэ л арга билгийн шүтэлцээний онцлогийг дуун хөрвүүлэгч орчуулгадаа гаргах учиртай байсан. Орчуулгач

гаргаж үнэхээр чадсныг судлаач ажиглан тэмдэглэсэн байна. Үүнийг улам бататгах үүднээс

The lama's face which I try to meditate upon

Does not appear in my mind

The lover's face which I do not meditate

Appears in my mind clear and distinct...

Залбирах ёстой багшийн царай

Зальхай сэтгэлд бүрэлзээд байна

Залбирах ёсгүй бүсгүйн царай

Заавал сэтгэл дүрэлзээд байна...

Энэ орчуулгаас бясалгаж залбирах ёстой ёсгүйн туйлыг лам бүсгүй хоёроор угшуулсан уран чадал ургаж гарсан байна гэж хэлж болно. Чингэхдээ “ёстой”, “ёсгүй”, “багшийн”, “бүсгүйн”, “бүрэлзээд”, “дүрэлзээд” гэж авиа ижилсүүлэн, дотоод холбоцоор цохилттой болгох, “царай”, “царай”, “байна”, “байна” гэж сүүл сөөлжүүлэн холбох, “залбирах”, “зальхай”, “залбирах”, “заавал” гэж толгой холбох зэрэг монгол шүлгийн айзам үүсгэх хэд хэдэн аргыг давхар хэрэглэсэн байна.

Миний бие энд нэгэнт яруу найргийн сэтгэлийг хөдөлгөх чадварыг орчуулгад буулгах тухай ярьж байгаа болохоор Пушкиний “Омтгойрон, гудамжны үймээнд явавч” шүлгийн авианы давталтын тухай дурдмаар санагдаад болдоггүй. Энэ тухайтад “Орчуулгын санг уудлах” номонд ч, мөн Дамдинсүрэнгийн 95 насны ойгоор тавьсан “нэгэн шүлгийн орчуулганд хийсэн ажилглалт” илтгэлд ч дурдаж байсан. Чухамхүү энэ шүлгийн хөгжмийг Дамдинсүрэн хэрхэн буулгасан бэ? Шүлгийн хөгжим нь юунд байсан вэ. Оросын нэрт орчуулагч, орчуулгын онолч К.Чуковский уг шүлгийн хөгжмийг “у” “ю” авиаг давтсанд байна гэж үзжээ. Эдгээр авиаг орос хүмүүс “тунигийн авиа” (тухайлбал, Ломоносов) гэж нэрлэх нь бий.

Шүлгийн нэгдүгээр бадгийг сийрүүлбэл:

Брожу ли я вдоль улиц шумных /у-3/

Вхожу ль во многолюдный храм /у, ю-2/

Сижу ль меж юношей безумных /у, ю, у-3/

Я передаюсь моим мечтам /ю-1/

Чуковский бичихдээ: “нэг испани яруу найрагч Пушкиний энэ шүлгийг эх хэлээрээ орчуулжээ гэж бодъё. Шүлгийн хэлбэр агуулгатайгаа салшгүй холбоотой байдаг учир орчуулагч орчуулгадаа авианы энэ давталтыг гаргах үүрэгтэй болно. Гэтэл испани хэлэнд орос хэлнийх шиг “жу” (брожу, вхожу, сижу) авиагаар төгссөн үйл үг байхгүй юм. Испани хэлэнд безумный, многолюдный, шумный гэсэн үгсийн алинд нь ч ийм авиа байхгүй. Иймээс орчуулагч яруу найрагч яаж ч оролдлоо гээд бүтэлэй юм болохгүй. Санаанд багтамгүй юм болоод орчуулагч энэ хөгжмийг гаргаж чаддаг юм аа гэсэн испани хүний чихэнд “у” авиа орос хүнийхээс огт өөрөөр сонсогддог учир орчуулга нь төдий л дүйж бас чадахгүй юм” гэжээ. Тэгвэл монгол хэлэнд?! Сонин нь, гуних, гутрах, гутах, уйтгарлах, уйлах, ухилах, уйдах гээд сэтгэлийн

хөдөлгөөний саар талыг заасан нэлээд үгс “у” авиатай байх юм. Гэвч Дамдинсүрэнгийн орчуулга ямар болж вэ?

Омтгойрон гудамжны үймээнд явавч /у, ү-2/

Олны хуралдсан сүмд оровч /у, ү-2/

Ойворгон зулуучуудын дунд суувч /у-4/

Осолдохгүй нэгэн зүйлд санааширна /у, ү-2/

Орос хэлний “у” авиа монгол хэлний “ү”, “ү” хоёр авианы дунддурхи нэгэн авиагаар дуудагддаг, монгол хэлний энэ хоёр авианы дуудлага орос “у” авианы дуудлагад аль нэг хэмжээгээр ордог гэж тоймлоод уул хоёр авиа орчуулгад ямар байдалтай орсныг бэлхнээ ажиглаж болно. Одоо бидний харж байгаа орос үсгээр бол орос шүлэгт нийт “у”, “ю” авиа 39, орчуулгад “у”, “ү” авиа 44 орсон байна. Дамдинсүрэн энэ шүлгийг монгол бичгээр орчуулсан болов уу гэж бодож байгаа юм. Тухайлахад “Үүл” шүлгийг монгол бичгээр орчуулж, “Шинэ толь”-ийн 1937 оны 2-рт нийтлүүлсэн байна. Хэрэв уг шүлгийг монгол бичгээр орчуулсан бол байдал бүр өөр болно.

.....
.....
.....
.....

Ухаа нь, энэ бадгийн эхний мөрөнд “у”, “ү” авиа 7, хоёрдугаар мөрөнд 5, гуравдугаар мөрөнд 7, эцсийн мөрөнд 4 орсон байх жишээтэй.

Тэр байтугай испани хэлтний яагаад ч буулгаж үл чадах “жу”-г Дамдинсүрэн эрхбиш төстэй “чу” авиагаар гаргасан нь дээрхээс харагдаж байна. Дамдинсүрэн авиа давтахыг орчуулгааа хөгжимлөг, эгшиглэнтэй болгох гол аргын нэг гэж үзэж байсан юм. Тэр тухайгаа бичихдээ: “...С.Маршакийн “муурын байшин”-г орчуулахдаа...уг эхдээ байхгүй шүлгийн зарим чимгийг нэмж хэрэглэсэн удаа бий. Энэ бол шүлгийн мөрний доторхи үгийн үе давталт болно. Жишээ нь:

Урт сахалт ухна гуай

Хурц эвэрт эхнэртэйгээ

Улсын түрүүнд ирээд

Суудлын түрүүнд суулаа

Үүний доторхи “урт сахалт”, “хурц эвэрт”, “улсын түрүүнд”, “суудлын түрүүнд” гэсэн нь мөрний доторх үе давталт болно” гэжээ.

Тэгвээс оросыг нь сонирхуулья.

К богатой кошке гость пришел

Известный в городе козел

С женой седой и строгой

Козою длиннорогой

Энэ бадагт үнэхээр авианы давталт байна. Ийм жишээ гэвэл

Ставенке резные

Окна расписные...

Орчуулга нь:

Эрээн мяраан цонхтой

*Эрэвгэр сэрэвгэр хайстай...*Авиа ижилсүүлэх аргаар шүлэглэн орчуулсан ийм жишээ олон тул тэр бүхнийг дурдалгүйгээр харин Маршакийн энэ зохиолд амьтны дуугарах дууг дуурайлгаж авиа давтсан газар нэлээд буйг хэрхэн буулгасныг сонирхуулъя.

Тухайлбал:

М-м-моё почтенье кошка

Пром-м-мокли м-мы немножко гэж ямааны майлах авиаг дуурайлгажээ.Тэгвэл Дамдинсүрэн

М-муур эгч гуай м-минь

М-муухай бороонд дайрагдлаа гэж мөн л ямааны майлах дууг дуурайлгасан байна.

Ах, куда ты удались?

Кукареку! Куд-куда?

Энд оросоор тахианы дуугарахыг *кудахтатъ* гэж хэлдгээс үүсгэн куд-куда гэдэг авиа давтан наадсан нь харагдаж байна. Тэгвэл Дамдинсүрэн

Горьдлого байна уу, го го го

Голоод явчихав уу, го го го гэж тэр давталтыг буулгасан байна.

Мяу-мяу! Ночь спустилась

Блещет первая звезда гэсэн муурын авиаг

Орой шөнө болоход мяо мяо

Од мичид түгэхэд мяо мяо гэх зэргээр орчуулсан байна.

Дамдинсүрэн “Миний орос хэлнээс орчуулсан бүх бүтээл дотроос Маршакийн “муурын байшин” овоо болсон гэж хувьдаа боддог. Монгол орчуулга нь уг зохиолынхоо орос эхтэй бүх талаараа таарч тохирч байгаа юм”// гэж нэг бичсэн бол дээр өгүүснээр “уг эхэд байхгүй шүлгийн зарим чимгийг нэмсэн”-ээ эргээд хүлээсэн байдаг. Зөвхөн нэмээд ч зогсоогүй хассан зүйл ч байгааг энэ хэдэн жишээнээс үзэж болно. Нэмсэн тухайтад Дамдинсүрэнгийн өөрийнх нь хэлсэн дээр “Горьдлого байна уу, голоод явчихав уу” зэрэг үг нэмэн үйлдснийг цухас дурдаад хасан үйлдсэнийг нь бас өгүүлсү. “К богатой кошке гость пришел Известный в городе...”, “седой и строгой козой” гэсэн үгс ор тас орхигджээ. “Мэргэдгарахын оронд” “Зарим дур түвд хэлний ёсоор орчуулбаас монголүсэг дүр асар илүү үлдэж, утгын хувийг халхлах мэт ч олон буйн тул түүн дүр инү утга дур гэм үл болохуй бээр үгсийг огоорч болох бөгөөд зарим үе дүр үгсийг өчүүхэн эс нэмбээс утгын чадал үл бүрдэх мэт ч ушбуйн тул түүний утгыг тодорхойлох дур туст...үг өчүүхэн нэмэж орчуулагдахуй” гэж өгүүлсэн нь буй. Ухаа нь, энд “первая звезда” гэдэг үгийн *первая* гэдгийг хасчээ. Гэтэл энэ үгийн утгыг монгол “түгэх” гэдэг үгэнд шингээчихсэн байгаа юм. Ийнхүү шүлэглэх урлахын үүднээс утгыг шингээх аргыг нэлээд хэрэглэсэн нь харагддаг. “Алтан загасны үлгэрт”-г

Гучин жил тэнэж

Дөчин жил суув гэсэн өгүүлбэр буй. Нэг судлаач (хэнийг би санахгүй байна) Дамдинсүрэнгээс “энэ чинь нийлээд далан жил болчихож байгаа биш үү?”

гэж асуухад өөдөөс нь “гучин жил чинь дөчдөө багтчихаж байгаа юм аа” гэж жогтойхон хариулсан гэдэг. Ийнхүү Дамдинсүрэн “МГО”-нд заасан нэмэх, огоорох зарчим буюу өнөөгийн нэр томъёогоор нэмж хасах зарчмыг бүтээлчээр хэрэглэж байсны жишээ юм. Дамдинсүрэн дуртайяа уг эхийн үгсийг хасаж байсан бус чухамхүү шүлэглэхэд нь саад болоод байсан бөгөөд утганд гэм үл болох үгийг хасаж, утга тодруулах үүднээс бас нэмж байсан бнщайна. “Эхээс холдох тусам эхэд ойртоно” гэж Гоголийн хэлсэн үг бий. Жишээлбэл,

Горьдлого байна уу го го го

Голоод явчихав уу го го го гэдэг нь эхээс нэлээд холдсон мэт үзэгдэнэ. Гэвч онгироо азарган тахианы араншинг үүнээс илүү гаргана гэдэг хэцүү. Ингэснээрээ харин ч эхдээ ойртож байгаа юм.

Гадаадын орчуулгын онолчид “эрчмээр нь дүйлгэх” /америк Ю.Найда/, “үүргээр нь дүйлгэх” /орос А.Швейцар/ гэсэн хоёр нэр томъёо гаргаж ирсэн билээ. Тэд уг нэр томъёогоо тайлбарлахдаа, эх хэл дээр байгаа зохиолыг хүн уншаад инээж байвал орчуулгыг уншсан хүн мөн л инээж байх, эх хэл дээр байгаа зохиолыг хүн уншаад уйлж байвал орчуулгыг уншсан хүн мөн л уйлж байх учиртай гэжээ. Өөрөөр хэлбэл тэр зохиолын уншигчийн сэтгэлийг хөдөлгөх эрчимийг нь, үүргийг нь дүйлгэнэ гэсэн үг. Тэгвэл Дамдинсүрэн “Алтан загасны үлгэр”-ийг орчуулсан тухайгй бичихдээ: “Анх удаа яг үг утгыг буулгаж орчуулаад, таньдаг хэдэн хүнд уншиж өгөв. Гэвч тэр орчуулга сонсогчдын сонирхлыг татаж чадахгүй, тэдний ухаан сэтгэлд буухгүй байх шиг санагдлаа. Тэгэхлээр нь энэ орчуулганд нэг дутагдал байна гэж мэдлээ. Ямар дутагдал байна байна вэ гэвэл би Пушкиний зохиолын уг утгыг орчуулсан боловч уран чадварыг монгол хэлэнд буулгаж чадсангүй. Тийм учраас сонсогчдын сэтгэлийг татаж чадахгүй байна гэж ойлголоо...А.С.Пушкиний зохиолыг орос хэлэн дээр уншихад ямар шиг уран сайхан сонсогддог вэ, мөн тэрчлэн монгол хэлэн дээр уншихад тийм уран сайхан сонсогдохоор хийх хэрэгтэй гэж шийдлээ...” гэжээ. Миний бие хоёр жилийн өмнө “Монгол шүлгийн айзам үүсгүүрийг орчуулгын онолын үүднээс тодорхойлох оролдлого” гэсэн бяцхан илтгэлдээ: “Орчуулгын онолч, шүлэг судлаач нар өргөлтгүй шүлгийг өргөлттэй болгох гэж үйлээ үэж, монгол шүлгээ европын хэлний “прокрустын ор”-онд тааруулах гэж тамаа цайж байсанд орвол монгол шүлгийн айзам үүсгэдэг, дээр өгүүлсэнчилэн, үеийн тоог тэнцүүлэх, улмаар толгой холбох, сүүл холбох, авиа ижилсүүлэх, эн зэрэгцүүлэх, хөгжмийг буулгах, өгүүлбэр зүйн уран маягийг гаргах гээд өдий төдий аргыг судалж, орчуулагчид нь энэ л аргаар шүлгээ орчуулж байвал монголын яруу найраг гадаадын сайхан шүлэг найргаар баяжихсандаа. Өөрөөр хэлбэл монгол яруу найргийг саванд нь, дорно дахины ай саванд авч үзье ээ” гэж бичсэн билээ. Монгол хэл өргөлтгүй, иймээс монгол шүлэг өргөлттө шүлэг байж таарахгүй гэдгийг олон мэргэдийн айлдснаас санаа аван урьд хэд хэдэн удаа (“Орчуулгын санг уудлахад”, “Монгол шүлгийн айзам үүсгүүрийг орчуулгын онолын үүднээс тодорхойлох оролдлого” зэрэг) дурдсан тул энд давтан нуршихыг цээрэллээ. Дамдинсүрэн ч Пушкиний шүлгийн өргөлтийг буулгах тухайтад ганц үг дурссангүй. Харин “Монгол

өнөөгийн одоогийн шүлэг их төлөв эхнээс адаг хүртэл нэг хэмжээгээр зохиогдоно” гэх буюу “Миний санахад орос шүлгийн урлах бүх арга техникийг хэрэглэж бичсэн Маршакийн шүлгийг монголоор орчуулахдаа монгол шүлгийн урлах бүх арга техникийг хэрэглэх нь зүйтэй гэж үзэв” // гэж бичсэн нь буй. Иймд монгол шүлгийг доно дахины ай саванд үзэх нь зүйтэй гэсэн молхи миний санаа зөв гэж бодох боллоо. Энэ бол дээр өгүүлсэн “эрчмээр нь дүйлгэх”, “үүргээр дүйлгэх” үзэл баримтлал мөн байна.

Илтгэлийнхээ эхэнд “алтан бөлзөг зүүсэн арван мойног хуруу”-ны бадгийг дурдаад орхисон. Дамдинсүрэн бичихдээ: “Алтан бөлзөг зүүсэн эмгэний гарын тухай Пушкин бичсэн байхад би

Алтан бөлзөг зүүсэн

Арван мойног хуруу гэж “мойног хуруу”-г нэмээд оруулчихсан байгаа юм” гэж өөрөө мэдэлгүй оруулчихсан байснаар бичжээ. Аливаа зохиолыг онгодоор бичдэг байх. Энэ үлгэрийг Дамдинсүрэн онгодоор орчуулсан нь мэдээж. Чингэхлээр өөрөө мэдэлгүй шүлэглэсэн байх нь.

Ингэж нэмэхийг нэмж, хасахыг хасаж шүлэглэх нь “сайн уу, муу юу” гэж асууваас сайн муу гэж эрс тууштай хариулж чадахгүй гэж өөрөө даруухан бичсэн нь бий. Тэгвэл “алтан бөлзөг зүүсэн арван мойног хуруу” нь ханаж цаддаггүй, харгис дээрэнгүй эмгэнийг нүдэнд үзэгдтэл, чихэнд сонсогдтол дүрслэхэд гайхалтай тус болжээ гэж нэг уншигчийнх нь хувьд миний бие бахдан хэлмээр байна. Ийнхүү үүргээр дүйлгэж чадсанд л дуун хөрвүүлэгчийн, яруу найрагчийн билиг танхай нь оршном бус уу. Ийм үзэлтийг манай эртний орчуулагчид ч баримталж байсан байна. Тухайлбал, “Үзье гэвэл “Үлгэрийн далай”, сонсьё гэвэл “Субашид”, уйлъя гэвэл “Ушаандар”, инээе гэвэл “Ил Данди”, уярая гэвэл “Саран хөхөө”-г унш” гэж ухаант түмэн маань ам дамжуулан шагшсаар иржээ. Ингэхлээр Ушаандарыг уйлахуйц, Ил Дандийг инээхүйц, Саран хөхөөний туужийг уярахуйц, Субашидыг сонсголон яруу дуун хөрвүүлсэн нь илт байна. Өөрөөр хэлбэл, инээдийг инээдээр, уйтгарыг уйтгараар нь орчуулж чадаж байсан байна.

Хүмүүний сэтгэлийг хөдөлгөн эс чадваас

Хөнгөн бийрийг хөшиж юу хиймуй гэж алдарт романч Инжинашийн дуун алдсныг ч дурсмаар байна аа. Энэ аугаа дуун хөрвүүлэгч, дуун туурвигч нарынхаа шийрийг хатаасан Дамдинсүрэнгийн “сэтгэлийг хөдөлгөх чадлыг орчуулах” үзлийг “арван мойног хуруу” нэмэгдсэн паянгаар дамжуулан өгүүлэхэд ийм байна. Тэрвээр уг үзэлтийг товойлгон тавиад зорьсондоо хүрч байсныг батлах гэж энд молхи би оролдлоо. Батлан чадаагүй аваас өршөөх ажааму.

Анхааран чагнасанд баярлалаа.

Ашигласан ном зохиол

1. Ц.Дамдинсүрэн. **Намтрын хуудсаас**. Эмхэтгэсэн Р.Отгонбаатар. 1990
2. Ц.Дамдинсүрэн. **Түүвэр зохиол**. Эмхтгэсэн Д.Цэдэв. 1969
3. Ц.Дамдинсүрэн. **Олег цэцний орчуулгын тайлбар**. “Орчуулах эрдэм” эмхтгэл. Ред. Д.Цэдэв. 1972
4. **Мэргэд гарахын орон**. /Монгол бичгээр/ Үндэсний хэвлэлийн хороо. 1988
5. Цаньян Джамцо. **Песни, приятные для слуха. Издание текста, перевод с тибетского, исследование и комментарий Л.С.Савицкого**. М., 1983
6. Tshan'yang Gya'tso. **Love Songs**. Татуулж авсан эх.
7. А.С.Пушкин. **Сказки**. М., 2006
8. Лермонтов. **Собрание сочинения в четырех томах**. Л., 1979
9. С.Маршак. **Сказки, песни, загадки**. М., 1957
10. Л.Хүрэлбаатар. **Доно дахины яруу найргийн монгол орчуулгын уламжлал**. “Яруу найргийн орчуулгын түлхүүр” эмхэтгэл, 2006
11. Г.Аким. **Монгол шүлгийн айзам үүсгүүрийг орчуулгын онолын үүднээс тодорхойлох оролдлого**. “Яруу найргийн орчуулгын түлхүүр” эмхэтгэл. 2006
12. Ю.А.Найда. **К науке переводить. Вопросы теории перевода в заобужной лингвистике**. 1978

«РОЛАН(Д)Ы(Н) ДУУЛАЛ»-ЫН МОНГОЛ ОРЧУУЛГЫН ТУХАЙД

Г. Буяаннэмэх¹⁶⁸ (МУИС, ШУС)

Товч утга: Энэ өгүүлэлд «Ролан(д)ын дуулал»-ын эх гар бичмэлийн талаар судлагааг тоймлон дурдав. Мөн үг бүтээлийн нэр, монгол орчуулгын эх, орчуулгын ажиглалт, шүлгийн бадаглал, мөр, нугалбар, үг, үеийн бүтэц зэрэгт хийсэн ажиглалт, зарим нэг хэсгийн орчуулга, дүйцэлийн талаар авч үзэв.

Түлхүүр үг: эх бичиг, нэр, бадаглал, шад, үе, орчуулга

Франц түмний уранзохиолын дээж, аян дайны сэдэвт баатарлаг тууль «Ролан(д)ын дуулал»-ыг 778 онд Пиренейн уулсын Ронсеваль хавцалд болсон франц-испанийн тулалдаанаас улбаалан 1087-1095 оны үед зохиогдсон гэж үздэг байна. Уг дуулалын бүх гар бичмэл, хувилбарууд «Турольдийн өгүүлсэн түүх энэ хүрээд тасалдлаа» гэж төгсдөг авч эдүгээ зохиогч нь тодорхойгүй хэмээх ажээ.

Судлаач Жозеф Бедье (Joseph Bédier), Жан Дюфурне (Jean Dufournet) нар сайхь бүтээлийн 8 эх гар бичмэл, 12 гаруй хувилбар бий хэмээн үзсэн байна. Эдгээрийг дурдвас 1. Оксфордын гар бичмэл (O), 2. Венецийн Ариун Марк сүмийн номын сангийн франц хөмрөгийн IV (V⁴), 3. 1150 оноос хойш үеийн хэмнэлт бичвэрүүд: Мөн эндэхийн VII (V⁷) гар бичмэл, Шато Ру хотын номын сангийн (C), Парисын Үндэсний номын сангийн франц хөмрөгийн 860 дугаарт гар бичмэл (P), Лион хотын номын сангийн 894 дугаарт гар бичмэл (L), Кембрижийн Тринити Коллежийн (T), 4. Поп Конрадын 1131-1133 оны «Ruolandes Liet» (K), 5. 1230-1250 оны үеийн Karlamagnussaga (n); 6. XIV зууны Галлийн хувилбар, 7. XIV зууны үеийн англи хувилбар, 8. Нидерландын хувилбар зэрэг болно. [6:51-52]

Эдгээрээс Оксфордын¹⁶⁹ 291 бадаглалт 4002 шадтай франц хэлээрхи эх бичвэрийг хамгийн бүрэн хувилбар хэмээдэг байна. Гэсэн хэдийвээр энэхүү эх бичвэр мэр сэр мадагтай, орхисон мөр бүхий байсныг бусад гар бичмэлтэй харьцуулан засчээ.

XIV зууны үеийн гар бичмэлд тулгуурласан Венецийн эх бичвэр франц хэлээр авч итали үг, хэллэг ихтэй 6012 мөр шүлэгтэй ажээ.

XIII-XIV зууны үеийн бичээч, сийрүүлэгчид яруу найргийн нугалбар, холбоц, айзамд зохицуулан адал явдал, янаг хайр, уран сэтгэмжээр утгыг нь

¹⁶⁸ МУИС, ШУС, ХУС-ын европ судлалын тэнхим, доктор, профессор

¹⁶⁹ XII зууны дунд үед аялгуу нь эс мэдэгдэх эхээс хуулбарласан гар бичмэл бөгөөд тусгай фонд болгох нөхцлөөр Оксфордын Их сургуульд гар бичмэлүүдээ бэлэглэсэн Дигбигийн хөмрөгийн 23-рт байдаг ажээ. [1:143]

дэлгэрүүлэн баяжуулсан тул Венецийн Ариун Марк сүм, Парис, Лион, Кембрижийн эх бичвэр тус бүр 8000 гаруй мөр шүлэгтэй. [1:142]

Дээрхээс үзвэл «Роландын дуулал»-ын эх бичвэрийн 4002-8000 мөр шүлэгтэй хэд хэдэн хувилбар байх ажээ.

Үүний зэрэгцээ Норвегийн соён гэгээрүүлэгч Хакон хааны зарлигаар 1240 онд гаргасан *Их Карл* гэсэн зүйвэрт хувилбар, утга агуулга нь ихэд өөрчлөгдсөн испани хувилбар, *Испанид довтолсон нь*¹⁷⁰, *Гвеноны урвалт* / *Carmen de prodicione Guenonis*, *Их Карл ба Роландын түүх* / *Historia Karoli Magni et Rotholandi* гэсэн латин хэлээрх XII зууны дунд үеийн хоёр туурвил, Сэргэн мандалтын үеийн Италийн яруу найрагчдын бүтээл, тухайлбал Пульчигийн Хүчирхэг Морганте/ *Morgante Maggiore* (1485), М. Боярдогийн *Роландын хайр* / *Orlando Innamorato* (1494), Л. Ариостогийн Догшин Орланд / *Orlando Furioso* (1516) гэхчилэн олон хувилбар өрнөдөд гарсан байна.

«Роландын дуулал» (La chanson de Roland) –ын гар бичмэлийг анх 1832 онд Хааны номын сангаас Анри Монэн (Henri Monin) олсон гэх бөгөөд Ф. Мишель (Francisque? Michel) Английн Оксфордын номын санд хадгалагдаж байсан гар бичмэлд үндэслэн 1837 онд эхний хэвлэлийг гаргасан ажээ.

Уг бүтээлийн олон хэвлэл 1850 оноос эхлэн бүгд *La chanson de Roland* нэртэйгээр гардаг болжээ. [6:375]

Аугаа Карл буюу Францын Шарлемань хаан 778 онд Испанид довтлон жил гаруй үргэлжилсэн аян дайны түүхээс сэдэвлэсэн «Роландын дуулал»-д 1. Испанийн Сарагос балгадын лал шашинт Марсиль хаан бэлэг сэлт барин бууж өгөхөөр хуурмаглан элч ирүүлсэний хариуд элчээр тохоогдсондоо хорсон бухимдсан Хааны хүргэн дүү, Роландын хойт эцэг Ганелон гүн Роландын амь насыг бүрэлгэхээр дайсантайгаа үгсэн урваж байгаа; 2. Ронсеваль хавцал дахи хүч тэнцвэргүй аюумшигт тулаан, Роланд, Оливье нарын үхэл; 3. Шарлемань хаантан зээ дүү Роландынхоо өшөөг авч сарацин нарыг бут ниргэн газар орныг нь эзлэн авч амьд үлдэгсэдийг нь загалмайтны шашинд оруулж байгаа; 4. Урван тэрслэгч Ганелон гүнийг шүүн таслаад яллан шийтгэсэн үйл явдлыг тод томруун, уран яруу өгүүлдэг.

«La chanson de Roland»-ыг монгол хэлнээ Х. Пэрлээ гуай орчуулж, *Орчуулгын сүүлд бичих ориил үг мануу* гэсэн шүлэглэсэн төгсгөлийн үг, түүх болон хэл уранзохиолын тайлбартайгаар «Роланд баатрын тууж»¹⁷¹ нэрээр 1969 онд хэвлүүлжээ.

¹⁷⁰ Уг бүтээл XIV зууны эхний хагаст Италид гарсан бөгөөд зохиогч нь тодорхойгүй. *ibid*.

¹⁷¹ *La chanson* гэдэг үгийг Х. Пэрлээ аугай яагаад «тууж» хэмээн буулгасан юм бол гэдэг бодол төрөн үгийн утгыг нягтлаваас : *Chanson* II poème épique du Moyen Age, divisé en laisses – épopée - дундат зууны үеийн бадаглаж шүлэглэсэн тууль- их туульс [12: 394a], орос орчуулгын **Песнь, -и**... 2. Глава эпической поэмы. // В составе названий некоторых произведений народного эпоса. *Песнь о Роланде* ... [8:113в], **Песнь, -и** ... (устар.). 1. То же, что песня. «П. о вещем Олеге» Пушкина. 2. Глава поэмы. [12:454б], **тууж**... хүүрнэн өгүүлэх үргэлжилсэн зохиолын нэг төрөл ... [10:2085a.], **дуулал**- Айзам цохилго даган нийцсэн зохих тооны үгсээс бүрэлдсэн нэг зүйлийн зохиолын хэлбэр [10:759a], **дууль**- Уянга туульсын зохиолын нэгэн төрлийн нэр, эмгэнэлт баатарлаг, баатарлаг эмгэнэлт аястай үйл явдал бүхий шүлэг, домогт шүлэглэл [10: 760б], **дууль-баллада** [10:79б], **баллада**- дууль, домогт шүлэглэл [Ц.Д. Орос монгол толь, УБ., 1982, 20a], **ballade f.** - ... 2. *Petit poème de forme régulière, composé de trois couplets ou plus* ... 3 түүнээс дээш бадагтай богино шүлэг; 3. *Poème de forme libre, d'un genre familier ou légendaire.* ... - чөлөөт хэлбэртэй ердийн эс бөгөөс домгийн төрлийн шүлэглэл [13: 213b] гэсэн байна. Иймээс, нэгтэйгүүр уг

Ийн монголчилохдоо Фердинанд Георгиевич де Ла Бартын¹⁷² «Песнь о Роланде» гэсэн 1937, 1958 оны хэвлэл (цаашид ФБ37,58), И.Н. Голенищев-Кутузов, Ю.В. Корнеев, А. А. Смирнов, Г. А. Стратановский нар хэвлэлийн эхийг бэлтгэн 1964 онд хэвлүүлсэн орос орчуулга (ГК64), «La Chanson de Roland» гэсэн 1913 (Ch13), 1965 (Ch65) хоёр франц нийт 5 орчуулгад тулгуурлан орос хэлээс монголчилсон байна.

1913 онд хэвлэгдсэн франц орчуулгыг эс олсон учраас эртний франц хэлээс орчин цагийн франц хэлнээ орчуулж, тайлбар бичсэн Жан Дюфурнегийн 1993 онд хэвлүүлсэн франц хувилбар (Д93) хийгээд Ю. В. Корнеевийн 1976 оны орос орчуулгыг (К76) лавлах хэрэглэгдэхүүнээр ашиглав.

Эдгээр орчуулгын хэмжээг бадаглал, мөрийн тоогоор гаргаж үзвээс ФБ37- 297 бадаглалт 4065 мөр, ФБ58-291 бадаглалт 4002 мөр, ГК 64-290 бадаглал, 4002 мөр, Ch65- 291 бадаглал, Д93- 291 бадаглал, 4002 мөр, К76-290 бадаглал, 4002 мөр шүлэгтэй байна. Х. Пэрлээ (П69) гуайн орчуулга 291 бадаглал 5814 шад бүхий байна.

Ийнхүү гурван хэлээрх орчуулгууд 290, 291, 297 бадаглалтай байгаа нь чухам ямар эх сурвалж, бичвэрийг ашигласантай холбоотой бол, бадаглал дахи мөрийн тоо франц, орос орчуулгад 5¹⁷³-аас - 35 (228) –ын хооронд, монгол орчуулга 8¹⁷⁴ -аас 52 мөрийн хооронд хэлбэлзэж харилцан адилгүй байгаагийн зэрэгцээ гурван хэлний орчуулга¹⁷⁵ хийгээд орос монгол орчуулгад¹⁷⁶ мөрийн тоо тэнцүү цөөвтөр бадаглал байх нь эх бичвэрээс гадна тухай тухайн хэлний шүлэглэх зарчим, орчуулагчийн арга барил, ур чадвараас хамааралтай нь мэдээж билээ.

Монгол орчуулгын тухайд франц, орос орчуулгын 2 нугалбарт нэг мөрийг толгой, сүүл холбосон 1 нугалбарт хоёр мөрөөр буулгаснаас мөрийн тоо нэмэгдсэнийг 7-р бадаглал дахи

Ch65, Д93 ... les freins sont en or, les selles enchâssées d'argent гэсэн 2 нугалбарт 3-р мөрийг

ФБ37,58-д ... На них уздечки были золотые,

А седла все литого серебра, ... гэж 2 мөрөөр,

П69-д ... Бүгээн зүстэй луусууд нь,

Бүгдээр алтан хазаартай.

Эрвээлж эмээл бүхэн нь

Эрдэнийн мөнгөн чимэгтэй... гэж 3 үгтэй нэг нугалбарт 4 мөрөөр;

бүтээлийг *la ballade de...*(... –ын дууль) бус, харин *la chanson de ...* (-ын дуулал) хэмээн нэрлэсээр ирсэн, нөгөөтэйгүүр сайхь бүтээлийн төрөл зүйл, утга агуулга, хэлбэр зохиомж дуулал лугаа нийцээж буй учир **Ролан(д)ын дуулал** гэдгээр нь энд авлаа.

¹⁷² Фердинанд Георгиевич де Ла Барт гүн (1870-1915) Өрнөдийн уранзохиолын түүхч, «Роландын дуулал»-ыг 1897 онд орос хэлээр орчуулж, Пушкиний нэрэмжит шагнал авчээ. *Литературная энциклопедия*, Т. 6, 1932, стб. 9

¹⁷³ Д93, ФБ37,58-ын 26, 51, 60, 63, 213-т.

¹⁷⁴ П69 –ийн 21, 22, 25, 26, 45, 46, 101, 102, 121, 182, 191, 220, 271, 283, 285-д.

¹⁷⁵ Ch65, Д93, К76, П69-д: 211 (6), 121, 182, 220, 271 (8), 203, 286 (10), 215, 236 (12), 33 (16), 43 (17) мөртэй.

¹⁷⁶ ФБ37,58 болон П69-д: 25, 46, 285 (8), 221, 249 (10), 259 (12), 284 (14), 170, 263 (16), 243 (18), 128, 179 (20) шадтай байна.

8-р бадаглалд франц, орос орчуулгын 26 мөрийг 52 мөрөөр монголчилсоноос:

Ch65, Д93-д L'empereur se montre joyeux et gai
Cordes est prise et ses murailles en pièces;
de ses perrières il a abattu les tours ...

ФБ37,58-д Могучий Карл и радостен и светел
Взял Кордову он, стены разгромил,
На землю он поверг твердыни башен ...

гэсэн франц, орос орчуулгын тус бүр хоёр нугалбарт гурван мөрийг

П69 Хүчит Карл хаан тан
Хөхүүн тааламжтай байсан нь
Балгад Кордыг эзлээд
Баталсан хэрмий нь эвдлээд,
Өндөр цамхагий нь нурааж
Өлөн товрог болгосон байлаа.

гэхчилэн нэг нугалбарт 6 мөрөөр толгой холбон орчуулсан;

87-р бадаглалын

Ch65, Д93-д Roland est vaillant et Olivier est sage
tous deux sont de merveilleux vassaux ...

ФБ37,58-д Мудр Оливьер, а граф Роланд бесстрашен
Известны оба доблестью своею ... (88-д) гэсэн франц орос
орчуулгын тус бүр хоёр мөрийг

П69-д Оливьер баатар мэргэн ухаантай
Роланд баатар аймшиггүй зоригтой
Хос баатар гавъяа зүтгэлээрээ
Хорвоод цуутай болсон байлаа.

хэмээн 4 шадаар орчуулсан зэргээр жишээлэн авлаа. Бидний тооцоолсноор нэг нугалбарт 3 үгтэй мөр¹⁷⁷ л гэхэд 618 байгааг зарим бадаглалаас харж болно.

Франц, орос орчуулгын утгыг өчүүхэн ч сэвтээлгүй, уран яруу шүлэглэн буулга-сан Пэрлээтэний орчуулах арга барилаас суралцах, судлах хэн хүнд хэрэг болуужин гээд ... монгол шүлэгт *үеийн тоо онцын рольгүй, үгийн тоо чухал* (Ч. Чимэд)..., монгол шүлэг бол *мөр, үеийн тоог чандлан бичдэг силлабин (үеийн) шүлгийн зарчимтай*... (Д. Цэрэнсодном) ... [14:134] хэмээснээс улбаалан мөрийн тоо харилцан адилгүй хориод бадгийг түүвэрлэн сонгож монгол, франц, орос орчуулгын мөрийн доторхи нугалбар буюу хэмнэлийн бөлөг (groupe rythmique), үгийн тоо, үе, хэмнэлийг тулган үзээд үеийн бүтцийг чадан ядан гаргасанаа 1-р бадаглалаар¹⁷⁸ жишээлэн орчуулгын ард тэмдэглэн орууллаа.¹⁷⁹

Ch65, D93

1 Charles le roi, notre grand empereur 2 4/6 5 ∪∪∪- / ∪∪∪∪∪-

¹⁷⁷ П69-ийн 136,163,180, 185, 199, 213, 228, 281 г.м.

¹⁷⁸ Нэгд, монгол орчуулгын 291 бадаглалаас 67.2% нь дундажаар 4-5 үгтэй шадтай байгаа, хоёрт, түүвэрлэсэн бадгийн анализ, ерөнхий ажиглалтаас үүдэн Х. Пэрлээ гуай Ф. де Ла Бартын орчуулгыг голлон баримталсан байх талтай хэмээн эхний бадаглалыг энд жишээлэн авав.

¹⁷⁹ Шад дахи нугалбарыг / , өргөлтөт үеийг -, өргөлтгүй үеийг ∪ гэж тэмдэглэлээ.

2 sept ans tout plein est resté en Espagne.	2	4/6	6	uuu- / uuuuu-
3 Jusqu'à la mer il a conquis les hautes terres ;	2	4/6	6	uuu- / uuuuu-
4 il n'est château qui devant lui résiste,	2	4/6	7	uuu- / uuuuu-
5 mur ni cité qui restent à forcer,	2	4/6	6	uuu- / uuuuu-
6 hors Saragosse qui est sur une montagne.	2	4/6	6	uuu- / uuuuu-
7 Le roi Marsile la tient, qui n'aime pas Dieu;	2	6/6	7	uuuuu- / uuuuu-
8 Il sert Mahomet et invoque Apollin:	2	5/7	6	uuuu- / uuuuuu-
9 il ne peut empêcher le malheur de l'atteindre.	2	6/6	6	uuuuu- / uuuuu-

Эл 9 мөрийг үеийн бүтцээр нь авч үзвээс эр, эм холбоц сэлгэсэн бадранга өлмийт¹⁸⁰ хэмжээтэй байна. Энэ нь франц хэлний үгийн өргөлт хэмнэлийн бөлгийн эцсийн үедээ шилждэг өгүүлбэрзүйн шинжтэй, өргөлтөт үеийн эгшгийн **онө** өргөлтгүй үеийнхээсээ нэг дахин урт дуудагдаг лугаа тохирч байна.

ФБ37.58

1 Державный Карл, наш славный император	2	4/7	5	u-u- / u-uuu-u
2 Семь долгих лет в Испании сражался:	2	4/7	5	u-u- / u-uuu-u
3 И до моря вся горная страна	2	4/6	5	uu-u / u-uu-
4 В его руках; сдалися Карлу замки,	2	4/7	5	u-u- / u-u-u-u
5 Разбиты башни, грады покорились,	2	5/6	4	u-u-u / -uuu-u
6 И стены их рассыпались во прах.	2	4/6	5	u-uu / u-uuu-
7 Лишь не взял Карл Великий Сарагоссы	2	7/4	5	-u-uu-u / uu-u
8 Что на горе стояла: царь Марсиль	2	7/4	5	-uu-u-u / -u-u
9 Владеет ею; в бога он не верит,	2	5/6	5	u-u-u / -u-u-u
10 Он Аполлину служит, Мухамеду	2	7/4	4	uuu-u-u / uu-u
11 Но близок час гибели его.	2	4/6	5	u-u- / u-uuu-
Аой!	1	2		

ГК64, К76

1 Король наш Карл, великий император,	2	4/7	5	u-u- / u-uuu-u
2 Провоевал семь лет в стране испанской,	2	6/5	5	uuu-u- / u-u-u
3 Весь этот горный край до моря занял,	2	6/5	6	- -u-u- / u-u-u
4 Взял приступом все города и замки,	2	4/7	6	u-uu / uuu-u-u
5 Поверг их стены и разрушил башни.	2	5/6	6	u-u-u / uu-u-u
6 Не сдали только Сарагосу мавры.	2	5/6	5	uu--u / uu-u-u
7 Марсиль-нехристь там царит всевластно,	2	5/6	5	u-u-u / uu-u-u
8 Читит Магомета, Аполлена славит,	2	5/6	4	-uu-u / uu-u-u
9 Но не уйдет он от господней кары.	2	5/6	6	-uu-u / uu-u-u

Эдгээр орос орчуулгын шад бүрт ерөнхийдөө өргөлтгүй, өргөлтөт үе дараалсан, нэг бол сэлгэсэн дөрвөөс таван өлмийт ямб¹⁸¹ хэмжээст шүлэглэл гэхээр байна.

¹⁸⁰ IV бадранга өлмий: /‘ ‘ ‘- / -н тайлбарыг үзэх [8:71]

¹⁸¹ орос бичвэрийн тухайд ямб гэдгийг өргөлтөт, өргөлтгүй үеийн бүтцээр нь авсан болно. Грек гарвалитай эл үгийг францаар *iambe*, англиар *iamb* гэж бичнэ.

П69

1	Эзэнлиг Карл, алдарт манай хаан	2	4/5	5
2	Эспан газарт долоон жил дайтаж,	2	4/5	5
3	Тэнгис хүртэлх хамаг уулын орныг	2	4/6	5
4	Тэр хаан гартаа оруулсан билээ.	2	4/5	5
5	Балгад шилтгээн Карлд эзлэгдэж,	2	4/4	4
6	Бат цамхаг хэмхрэнхэн унаад	2	3/5	4
7	Тойрсон хэрэм нь бутранхан нураад	2	4/5	4
8	Тоосон товрог болоод хэвтэцгээнэ.	2	4/6	4
9	Хадан уулын оргилд л оршдог	2	4/4	4
10	Хаан Марсильин эзлэнхэн суудаг	2	4/5	4
11	Аугаа иххэн Сарагос балгасыг	2	4/6	4
12	Авч эзлээгүй л байж, Карл хаан.	2	5/2	5
13	Хаан Марсильи загалмайтны шажинд	2	4/5	4
14	Хайр сүжиг ердөө л байдаггүй байж,	2	3/6	5
15	Амь үрэгдэх цаг нь ойртон ирэвч	2	5/4	5
16	Аполлин Мухаммед хоёртоо л сүсэглэнэ.	2	8/4	4
	Хур-рай!	1	2	1

Хэл хэлний шүлэглэх ёсон харилцан адилгүй хэмээн үздэг авч гурван хэлний эдгээр орчуулгаас ажиглавал шад нь 2 нугалбар бүхий ойролцоогоор 10 үет ихэнхдээ 5 үгтэй байгаа нь нэн сонирхолтой бөгөөд цаашид нарийвчлан үзүүштэй санагдана.

Монгол орчуулгын 1-р бадаглалд франц, орос орчуулгын дөрвөн мөрийг нугалбараар нь хуваан найм, хоёр мөрийг хамтатган гурван мөр болгоод цаад хэлний шүлэглэх ёсонд баригдалгүй, монгол шүлгийн янзаар хослон толгой холбож 16 мөрөөр орчуулсан нь утга агуулгыг оносон үгээр бүрэн, яруу тод буулгасан байна. Энд ... оргилд л ..., ... хоёртоо л ... гэж сул үг л-ийг онцлон ялгаж тодотгох, –хан² бүтээврийг хэмхрэнхэн, бутранхан, эзлэнхэн ... хэмээн эрчимжүүлэх хийгээд баймж утгаар хэрэглэсэн нь оновчтой агаад тухайн мөр дэхи үеийн тоо, хэмжээнд тохирсон байна. Энэ нь тохиолдлын байж болох ч Д. Цэрэнсодном гуайн санаа оноог батласан нэгэн жишээ болно.

Ch65, D93-82

Olivier dit : / J'ai vu les païens.

Jamais nul homme sur terre /n'en vit plus.

Devant nous / ils sont cent mille avec boucliers... хоёр нугалбарт 4-5-6 үгтэй,
10-10-12 үет эм холбоц бүхий бадранги өлмийт,

ФБ37.58- 83

Испанских мавров / видел я так много,

Как ни один из смертных /не видал!

Пред нами /их не менее ста тысяч... хоёр нугалбарт 6-5-7 үг бүхий
11-10-10 үет ямб,

ГК64, К76-82

Промолвил Оливье:/ Идут враги

Я в жизни не видал /такой толпы,
Сто тысяч мавров там: /при каждом щит ... хоёр нугалбарт, 4-5-7 үгтэй,
10-10-10 үет ямб хэмжээст франц орос хэлний орчуулгын тус бүр гурван мөрийг
П69 82

Үхэлт хүн /нэгэн ч удаа
Үзээгүй /олон маурыг харлаа.
Манай өмнө байгаа/ тэд нар
Магад /бумаас цөөнгүй байлаа. ... гэж 7-9-8-8 үет 4 үгтэй дөрвөн шадыг
толгой, сүүл холбон буулгасан нь эхний жишээтэй ойролцоо байна.

Ийнхүү франц, орос орчуулгын бадаглал, шад, үеийн хэмжээст
баригдалгүй монгол шүлгийн ёсыг баримтлан эх хэлнийхээ шавхагдашгүй
баялаг үгийн сангаас ширээн дээжилж уг бүтээлийг монголчилсон Пэрлээ
абугайн орчуулгыг шимтэн үзэхүйд ажигласан ганц нэгхэн зүйлийг энд дурдасу.

Тухайлбал, 8-р бадаглалын (33-36-р шад)

...Шадарчууд цагаан торгон ширдэг дээр

Шагай наадан сууцгааж байлаа.

Нас ахиж ухаан суусан нь

Наадаж бүгдээр шатар тавилаа. ... гэдэгт **шагай наадах** хэмээн
монголчилсоныг лавлахад ФБ37, 58-д **играют в кости**..., ГК64-д ... другие **в**
зернь играют ¹⁸² за столом, Ch65, D93-т ... **jouent aux tables et aux échecs** ... гэж
байлаа. Хар цагаан хоёр талтай жижиг ясан хавтгай орхиж бооцоотой тоглодог
байсан тоглоомын нэрийг болох хэмжээгээрээ эрэн хайгаад олсонгүй, онооход
тун ярвигтай байна. Иймээс монгол хүний ахуй амьдрал, сэтгэлгээнд нийцүүлэн
шагай гэдгээр авсан бололтой.

185-ын (5-6-р шад)

... Гэгээн **лха** тэнгэр хааны толгойд

Гэрэлтэн шөнөжингөө байгаад ...

... **Архангел** встал у Карла в головах ... (Ch65, D93)

... L'**ange** reste toute la nuit à son chevet. (ФБ37,58)

Загалмайтны шашинтны тухайд нэг бол **сахиусан тэнгэр** гэж орчуулах
эс бөгөөс **Архангел** гэдгээр буулгаваас зохилтой. Ер нь наанадаж гэхэд шашны
гурван том урсгалын сахил санваартны нэрээс эхлээд л орчуулж оноон
буулгахад бэрхшээлтэй байдаг учир энэ талын судлагаа, зүйлчилсэн толь хийх
шаардлагатай байна.

27-р бадаглалын (7-8 мөр)

... **Ташенбрюн** нэрт хүлэг мориндоо

Тавхийтэл мордоод авлаа Ганилон ...

... На **Ташебруна**, на скакуна вскочил ... (ФБ37,58)

... Sur **Tachebrun** son destrier il est monté ... (Ch65, D93)

гэж гурван хэлний орчуулгад байна. Энэ үгийг **толбот хүрэн** гэж
буулгаж толгой холбоход шадын бүтцийг эвдэхээргүй мэт бодогдоно.

¹⁸² Зернь-азартная игра в небольшие косточки с белой и черной сторонами, носящие то же название.
ru.wikipedia.org/wiki

108-р бадаглалын (1,2-р шад)

... Жерин гүн **Сореле** нэрт моринд мордож

Жерьер гүн **Пассе-серфе** нэрт морио унаж ...

... Le comte Gérin monte le cheval **Sorel**

et son compagnon Gérier **Passecerf** ... (Ch65, D93)

... На скакуне Сореле граф Жерен

И граф Жерье на быстром Пассе-Жерфе ... (ФБ37,58)

Адууны **зээрд** зүсмийг **sorel** гэдэг. **Passecerf** нь «зээр гүйцэх» маш хурдан гэсэн утгатай. Бид хурдан хүлгээ салхин (зээрд ...) г.м. нэрлэдэг уламжлалтай боловч энэ тухайд зүсэм нь тодорхой бус тул Пассе-серф гэж буулгахаас өөр боломжгүй мэт.

63-р бадаглал (3,4-р шад)

... Хайрт **ач хөвгүүн** минь чамайг

Хагас өмөг цэрэгтэйгээ үлдээе ...

Могучий Карл позвал к себе Роланда:

Оставлю я тебе, **племянник** милый,

Своих дружин великих половину, - (ФБ37,58)

L'empereur s'adresse à **son neveu** Roland

Seigneur, cher **neveu**, vous le savez bien:

je vous laisserai la moitié de mes troupes; (Ch65, D93)

Төрсөн ах,эгч, дүүгийн хүүг франц хэлнээ **neveu** оросоор **племянник** гэдэг бөгөөд ах, эрэгтэй дүүгийн хүүг монгол хүний эшийн нэрд ач (дүү), эгч, дүү охины хүү бол зээ (дүү) гэдэг. Охин дүүгийнх нь хүү Ролан(д) Карл хааны ач бус **зээ** (дүү) болно.

92-р бадаглал (17)

... «**Монжой!**» уриаг нэгэн удаа сонсогч

Мохошгүй гавъяа зүтгэл гэж мэдлээ. ...

... A les entendre clamer «**Monjoie**»,

on aurait pu se rappeler ce qu'est la vaillance ... Ch65, D93)

... Кто раз слышал «**Монжой!**»

Тот знал, что значить доблесть и отвага! (ФБ37,58)

Орчин цагийн франц хэлний авиа дуудлагаар бол **Монжуа** гэмээр.

Дээр өгүүлснийг нэгтгэвээс

1. «Роландын дуулал»- ын франц, орос хэлээрхи олон орчуулгаас 291 бадаглалт 4002 шадтай орчуулгыг Оксфордын эх бичвэрийг баримталсан орчуулга гэж үзэж болох юм.
2. Ерөнхий ажиглалт хийгээд түүвэрлэн тулгасан хориод бадаглалаас үзэхэд Х. Пэрлээ гуай франц хоёр, орос гурван орчуулгыг харьцуулан, орос хэлээс монголчилохдоо ФБ37, 58-г голдуу баримтлан орчуулсан байна.
3. Франц, орос орчуулгын хоёр нугалбарт нэг шадыг хоёр, хоёр шадыг утгаар нь гурван мөр болгон монгол шүлгийн ёсоор толгой, сүүл холбон буулгасанаас монгол орчуулга 5814 шадтай байна.

4. Франц, орос орчуулгын шад нь арваас арван хоёр үе бүхий 4-5 өлмийт ямб хэмжээст шүлгийг үеийн тоог тэнцүүлэн монгол хэлний шүлэглэх ёсоор толгой, сүүл холбон монголчилсон.
5. Монгол хэлний шавхагдашгүй баялаг үгийн сангаас ширээн дээжилж уг бүтээлийн утга агуулгыг эс сэвтээн зарим газар нь монгол ахуй амьдрал, монгол хүний сэтгэлгээнд нийцүүлэн, яруу уянгалагаар монголчилсон Пэрлээ абугайн орчуулга нь суралцах, судлах зүйл ихтэй сайн орчуулга болжээ.
6. Орчуулгад шашны сахил санваарын нэр томъёолыг зөв оноон буулгах асуудал нэн бэрхшээлтэй байдаг учир шашин судлал, хэлний мэргэжилтэн нар хамтран нэр томъёоны толь гаргах шаардлагатай гэж үзэж байна.

Summary

In this article, by comparing Mongolian version of the “Roland’s singing”- a heroic epic, translated by Kh. Perlee from Russian into Mongolian and published in 1969, with Russian and French versions, I have partially considered strophic lines, caesura, word and syllabic structures and equivalency of translations of chosen parts. Through taking some examples from his work, I intend to show that Mongolian version has consisted of five thousand eight hundred fourteen lines as the translator Kh.Perlee translated one line with two caesura in Russian and French versions into Mongolian in three lines, but two lines in Russian and French versions into Mongolian in three lines according to meaning. Moreover, he equalized syllabic numbers in Mongolian version while translating the lines composed of twelve syllables with four or five iambic feet. According to Mongolian versifying tradition, he richly used alliterations and rhymes in his translation. In conclusion, I’d like to say that he lyrically translated the epic in accordance with Mongolian way of life and reference Mongolians’ mentality not distorting meaning of it in some parts. This translation can be a good for any literary translators.

Ашигласан номзүй:

1. АН СССР, *Песнь о Роланде*, Старофранцузский героический эпос, Издание подготовили: И. Н. Голенищев-Кутузов, Ю. В. Корнеев, А. А. Смирнов, Г. А. Стратоновский, Изд-во Наука, Москва-Ленинград, 1964.
2. *Песнь о Роланде*, Перевод со старофранцузского Ф. Г. де Ла Барта, изд-во «Художественная литература», 1937.
3. *Песнь о Роланде*, Перевод Ю. В. Корнеева, изд-во «Художественная литература», 1976.
4. *Роланд баатрын тууж*, монголчилсон Х. Пэрлээ, Сүхбаатарын нэрэмжит Хэвлэлийн комбинат, УБ., 1969.
5. *La Chanson de Roland*, I-II, laisses 1 à 291 par Guillaume Picot, Larousse, Paris, 1965.
6. *La Chanson de Roland*, Texte présenté, traduit et commenté par Jean Dufournet, GF Flammarion, Paris, 1993.

7. Буяннэмэх С., *Уран зохиолын зүйлийг хэрхэн зохиох сэдэв, Нэг. шүлгийн тухай*, Уран үгсийн чуулган 1928, УБ., 2013, т. 18-23.
8. Галбаатар Д., *Уран зохиол- онол, түүх, шүүмжлэл, Нэвтэрхий толь*, УБ., 2012.
9. АН СССР, Институт русского языка, *Словарь русского языка*, Том III, Москва, Русский язык, 1983.
10. Монгол улсын ШУА, Хэл зохиолын хүрээлэн, *Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь*, боть II, IV, УБ., 2008.
11. Монгол улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, Орос улсын ШУА-ийн Хэлшинжлэлийн хүрээлэн, *Монгол орос дэлгэрэнгүй их толь*, II боть, Москва, 2001.
12. С. И. Ожегов, *Словарь русского языка*, Москва, Русский язык, 1981.
13. Paul Robert, *Le nouveau Petit Robert, dictionnaire alphabétique et analogique de la langue française*, Le Robert, 2008.
14. Шархүү А., *А. С. Пушкиний шүлгээс Д. Нацагдорж орчуулсан нь*, ХИС, Орчуулах эрдмийг эрхэм болгохуй, УБ., 2014, т. 132-140.

ЗОХИСТ АЯЛГУУНЫ ОНОЛ БА МОНГОЛ ОРЧУУЛГА

(төвдөч Ч.Алтангэрэлийн орчуулгын жишээн дээр)

Д.Бүрнээ¹⁸³ (МУИС, ШУС)

Товч агуулга: *Зохист аялгууны онолыг судалж, төвд хэлээр бүтээлээ туурвисан монгол эрдэмтдийн тухай хэд хэдэн цуврал өгүүлэл, ном бичсэн төвдөч эрдэмтэн Ч.Алтангэрэлийн орчуулах ур чадварын тухай энэ өгүүлэлд авч үзэх юм. Тодруулбал, Дандины "Зохист аялгууны толь"-ийн хоёрдугаар бөлөг болох утгын чимгийг судалж, жишээ шүлэг бичсэн Зая бандид Лувсанпэрэнлэйн зохиолоос Ч.Алтангэрэл орчуулсан тухай өгүүлнэ. Зая бандид Лувсанпэрэнлэй (1642-1715) 200 гаруй бадаг шүлгээс бүрдэх "Эсруагийн хөвгүүнийг баясгах дуун эгишг" хэмээх бүтээлээ утгын гучин таван чимгийн чухам ямар чимгээр бичсэнээ зааж тэмдэглээгүй билээ. Тийм учраас Ч.Алтангэрэлийн "Дүр төгөлдөр чимэг"-ийн орчуулга хэмээн тодорхойлсон шүлэг Дандины дурдсан чимгийн орчуулга мөн эсэхийг харьцуулан үзэв. Мөн Ч.Алтангэрэлийн орчуулгын уран сайхны онцлогийг тэмдэглэхийн таширамд тус орчуулгын хоёр зүйл эхийг зэрэгцүүлэн үзэж, ялгаа зөрөөг ажиглав.*

Түлхүүр үг: *зохист аялгууны онол, Зая бандид Лувсанпэрэнлэйн төвд хэлээр бичсэн жишээ шүлэг, дүр төгөлдөр чимэг, монгол орчуулга*

Эртний энэтхэгийн алдарт яруу найрагч бөгөөд яруу найргийн онолч Дандины МЭ-ий 7 дугаар зууны үед бичсэн "Зохист аялгууны толь" хэмээх бүтээлийг төвдүүд санскрит хэлнээс 13 дүгээр зууны үеэс орчуулж тайлбар бичсэн бол монголчууд тус бүтээлийг эх хэлнээ орчуулсан нь 18 дугаар зуун гэж үздэг. Энэ нь тус онолыг монголчууд зөвхөн энэ үеэс мэдэж байсан гэсэн хэрэг биш юм. Төвд хэлнээс ном судар орчуулсан уламжлалаас үзвэл бүр 13-14 зууны үеэс энэхүү онолыг мэдэж, тус онолын арга зарчимаар шүлэг зохиол бичиж байжээ¹⁸⁴.

Төвд хэл дундад зууны үед монголчуудын эрдэм номын хэл болж байсан учир тус хэлийг монголчууд сайтар сурч эзэмшин, зохиол бүтээлээ төвд хэлээр бичих болсон нь эдүгээ олон боть зохиол хүрч байна. Д.Гомбожав төвд хэлээр зохиолоо бичиж байсан 200 гаруй эрдэмтнийг тоочсон байдгийг бид мэднэ. Эдгээр эрдэмтдийн дотор зохист аялгууг судалж, тус онолын дагуу шүлэг бичиж байсан болон тусгайлан тайлбар бичсэн эрдэмтэн ч цөөнгүй байгаа билээ.

Зохист аялгууны онолын бүтээлүүд ихэнхдээ төвд хэлээр уламжилж ирсэн учраас тэдгээрийг судалж олны хүртээл болгох талаар хичээл зүтгэл гаргаж

¹⁸³ МУИС, ШУС, ХУС, доктор, профессор

¹⁸⁴ Ш. Бира, "Кавьядарша" Дандина в Монголии, - Литературные связи Монголии, Москва, 1981, стр.183.

байсан эрдэмтдийн нэг бол төвдөч Ч.Алтангэрэл юм. Тэр бээр Д.Цэрэнсодномтой хамтарч Турфаны цуглуулгаар уламжилж ирсэн дурсгалыг судалж, цуврал өгүүлэл бичсэнээс гадна зохист аялгууг судалж байсан монгол эрдэмтдийн бүтээлийн талаар тоймлон өгүүлж, "Монгол зохиолчдын төвдөөр бичсэн бүтээл" хэмээх хоёр дэвтэр зохиолыг туурвижээ¹⁸⁵. Тус бүтээлдээ Цахар гэвш Лувсанчүлтэм, Агваанхайдав, Ишданзанванжил, Данзанравжаа нарын намтар болон төвд хэлээр бичсэн бүтээлийн талаар тоймлон өгүүлж, түүвэрлэн орчуулжээ. Ч.Алтангэрэлийн бүтээлийн талаар тусгайлан авч үзсэн зүйл одоогоор гараагүй байна. Тиймээс бид энэхүү өгүүлэлдээ зохист аялгууны онолыг судалсан халхын Зая бандид Лувсанпэрэнлэйн (1642-1715) бүтээлийг төвдөч Ч.Алтангэрэл судалж орчуулсан туршлагаас өгүүлэх юм.

Төвдөч Ч.Алтангэрэл "Дандины зохист аялгууны толийн монгол тайлбарын тухай"¹⁸⁶ хэмээх өгүүлэлдээ Зая бандид Лувсанпэрэнлэй, Жамьянгарав нарын зохист аялгууны онолыг судалж, утгын гучин таван чимгийн онолын дагуу төвд хэлээр бичсэн жишээ шүлгээс түүвэрлэн, монголчилсон байна. Зая бандид Лувсанпэрэнлэйн зохист аялгууны онолыг судалж бичсэн бүтээл бол "Утгын гучин таван чимгийн үлгэр өгүүлэхүй Эсэрваагийн хөвгүүнийг баясгах дуун эгшиг" хэмээх нэртэй¹⁸⁷. Тус бүтээл "Зохист аялгууны толь"-ийн хоёрдугаар бүлэг болох утгын гучин таван чимгийг судалж бичсэн жишээ шүлэг юм. Зая бандид Лувсанпэрэнлэйн бичсэн утгын гучин таван чимгийн жишээ шүлгээс Ч.Алтангэрэл арван наймдугаар дүр төгөлдөр чимгийн жишээ шүлгийг судалж орчуулсан байна. Зая бандид өөрийн зохиолыг утгын гучин таван чимгийн жишээ шүлэг гэж нэрлэж, хоёр зуу гаруй бадаг шүлэг бичсэн боловч тухайн шүлгүүд ямар чимгийн жишээ шүлэг болохыг ялган зааж тэмдэглээгүй. Ч.Алтангэрэл энэ тухайд бичсэн нь "Лувсанпэрэнлэй энэ зохиолдоо зүүлт, нэмэлт тайлбар хийгээгүй учир, ямар шүлэг нь Дандины "Зохист аялгууны толь"-ийн" чухам аль чимгийн ямар ялгалд тохиохыг тодруулан оноох нь бэрхтэй бөгөөд энэ хувьдаа тусгай судалгаа шаардаж буй бүтээл юм" гэжээ¹⁸⁸. Үнэхээр Зая бандидын бичсэн шүлгүүдийг орчуулахад зайлшгүй ямар чимгийн шүлэг болохыг Дандины бичсэн шүлэг, төвд эрдэмтдийн бичсэн шүлэг болон тайлбартай харьцуулж үзүүштэй юм¹⁸⁹.

Дандины "Зохист аялгууны толь"-ийн онол ёсоор дүр төгөлдөр чимэг найман хувилбартай. Эдгээр нь *үзүүрхэх дүр, догшин дүр, баатрын дүр, нигүүлсэхийн дүр, үзэмжгүй муухай дүр, инээдмийн дүр, гайхамшигт дүр,*

¹⁸⁵ Ч.Алтангэрэл, *Монгол зохиолчдын төвдөөр бичсэн бүтээл*, I дүгээр дэвтэр (Ц.Лувсанчүлтэм, Л.Агваанхайдав, Н.Ишданзанванжил), редактор Ц.Дамдинсүрэн, УБ., 1967, *Монгол зохиолчдын төвдөөр бичсэн бүтээл*, II дугаар дэвтэр (Д.Равжаа) УБ., 1968.

¹⁸⁶ Ч.Алтангэрэл, *Дандины зохист аялгууны толийн монгол тайлбарын тухай*, ОУМЭ-ийн II их хурал, I боть, УБ., 1973, 43-48

¹⁸⁷ *Don rgyan so lnga'i dper brjod tshangs sras dgyes pa'i glu dbyangs*, төвд барын судар, 17 хуудас.

¹⁸⁸ *Монголын уран зохиолын тойм*, редактор Ц.Дамдинсүрэн, УБ., 1977, 607.

¹⁸⁹ Д.Бүрнээ, *Зая бандид Лувсанпэрэнлэйн дүрстийн чимгээр бичсэн шүлгийн онцлог*, - Эрдэнэ Зая бандид Лувсанпэрэнлэйн мэндэлсний 360 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл, Улаанбаатар, 2002, 57-63 тал; *Зая бандид Лувсанпэрэнлэйн бүтээлийн тухайд*, Монгол Судлалын Эрдэм шинжилгээний бичиг, Боть XIX (193), МУИС, МХСС, Улаанбаатар, 2003, 125-132 тал; Зая бандид Лувсанпэрэнлэйн "Утгын гучин таван чимгийн үлгэр өгүүлэхүй" зохиолын орчуулгаас, - Утгын гучин таван чимгийн яруу эгшиг, УБ., 2012, 36-67.

аймшигт дүрийн чимэг болно. Зая бандидын дүр төгөлдөр чимгээр бичсэн шүлгийг Дандины бичсэн шүлэгтэй харьцуулж үзэхэд дүр дүрслэлийг илэрхийлсэн арга маяг нь таарч байна. Өөрөөр хэлбэл, Ч.Алтангэрэл Зая бандидын шүлгийг *дүр төгөлдөр чимгийн* жишээ шүлэг гэж зөв тодорхойлсон байна. Зарим жишээн дээр тайлбарлая.

Үзүүрхэх дүр төгөлдөр чимэг

Яруу найрагч Дандин энэ чимгээр "Үхвээ хэмээсэнд Авиндаа тэр, би мөнхүү чанадад төрөлдөө түүн лүгээ нөхцөхийн тулд үхмүй энэ төрөлдөө хэрхэж би түүнийг олно" гэж бичжээ¹⁹⁰. Энэ шүлгийн төвд тайлбараас үзвэл хааны хайртай хатныг түшмэд нь нууж "хатан тань нас нөгчлөө" гэхэд хаан маш их сэтгэлээр унаж, харамсан гашуудаж, амьд явах хүсэлгүй болно. Хатантайгаа хойт төрөлдөө л учран золгоё хэмээн амиа юүтгэхийг хүртэл завдана. Харин хатантай нь уулзуулахад хаан машид баясаж, үзүүрхэх¹⁹¹ дүртэй болж байна. Өөрөөр хэлбэл, хайртай хатнаа нас барсан гэж гашуудаж байтал амьд мэнд байгааг нь хараад хаан машид баясан цэнгэж буй дүр байдлыг Дандин дүрслэн харуулжээ¹⁹².

Зая бандид Лувсанпэрэнлэй энэ чимгээр бичсэн нь:

drag yas yon tan gyis phyug mkhas pa nams
blo gros som nyi mtha' dag rab sel zhing
nam dpyod lhag par 'phel mkhas legs bshad sgra
thos pas bzhin ras 'dzum dkar dbang med 'phro

Зая бандид төвд шүлгийн зарчмыг баримталж есөн үе тэнцүүлэн шүлгэлснийг үгчилж орчуулбал:

Хэмжээлшгүй эрдмээр баян мэргэд
Оюуны эргэлзээ бүхнийг сайтар арилгах бөгөөд
Тийн шинжлэлийг үлэмж арвижуулах мэргэд сайн номлолын дууныг
Сонссоноор царайд цагаан мишээл эрхгүй сацарна

Ч.Алтангэрэл энэ бадгийг орчуулсан нь:

Эрдмээр хязгааргүй баялаг мэргэд
Эргэлзэх сэжиг даяарыг арилгаад
Эрдэмтний сайн номлолыг судлахаар
Эрхэмлэн сонссоноор мишээх нь тодорно

Ч.Алтангэрэл монгол шүлгийн зарчимаар толгой холбохоос гадна үгийн тоогоор айзмыг тэнцүүлэн орчуулжээ. Нөгөөтэйгүүр, "царайд цагаан мишээл сацарна" гэснийг "эрхэмлэн сонссоноор мишээх нь тодорно" хэмээн "цагаан мишээл" гэж үгчлэн орчуулалгүй "эрхэмлэн сонсох" гэсэн холбоо үгээр утгыг оновчтой илэрхийлжээ. "Эргэлзээ бүхнийг" гэлгүй "сэжиг даяарыг" гэж хөрвүүлсэн нь мэргэдийн эрдмийн цар хүрээг товойлгон гаргахын сацуу хамаг эндүүрэл сэжгийг арилгаж, сайн номлолыг судлана гэсэн санааг тодорхой

¹⁹⁰ Дандины зохист аялгууны толь, шинэчилсэн орчуулга, тайлбарыг үйлдсэн Ш.Бира, Х.Гаадан, О.Сүхбаатар, УБ., 1981, 100 дугаар тал.

¹⁹¹ Үзүүрхэх гэдэг үг бол төвд хэлний "sgeg pa" хэмээх үгийн орчуулга бөгөөд "Мэргэд гарахын орон толь"-д "цэнгэхүй, гоо", Ю.Н.Рерихийн тольд "задирать нос, гордиться (с оттенком кокетства), кокетничать, быть кокетливой" гэжээ.

¹⁹² *Dung dkar blo bsang 'phrin las, snyan ngag la 'jug tshul tshig rgyan rig pa'i sgo 'byed*, 1987, 381-382.

гаргасан хэрэг юм. *Үзүүрхэх дүр төгөлдөр чимгийн* энэ жишээ шүлэгт эрдэм ухааны чанад хязгаарт хүрсэн мэргэд юм үзэгдлийн мөн чанарыг танин мэдэж, эндүүрч будилах, эргэлзэж тээнэгэлзэхийн хязгаараас гэтэлж, баясан мишээх нь хотол түмний нүднээ илхэн хэмээжээ. Өөрөөр хэлбэл "эрдэмтэн хүн ном үзээд, утгыг сайтар ойлгон баясаж байгааг гоё үзэсгэлэн үзүүрхэг дүрээр"¹⁹³ үзүүлсэн буюу эрдэмтэн мэргэд сурч мэдсэндээ сэтгэл ханахгүй, улам ихийг сурч, сэтгэлийн цэнгэлийг эдэлж буйг дүрсэлсэн байна.

Догшин дүр төгөлдөр чимэг

Хэрэглэх заалтын дайсныг гэсгээхийн тулд
Хилэнгийн эрхтэн хялайн харж соёогоо ярзайн
Хэнхдэгтээ сүртэй аймшигт чанга хүрхрэн
Хэрчих намнах элдэв мэс барьсан дүрс үзүүлнэ

"Бурханы сургаалыг сахина хэмээн ам авсан догшид"-ын ширүүн дүрийг харуулсан энэ шүлгээ Ч.Алтангэрэл "х" авиагаар толгой холбон шүлгэлжээ. Ингэхдээ догшин сахиусын "хялайн харсан", "сүртэй хүрхэрсэн", "мэс барьсан" аймшигт ширүүн дүрийг харуулахын тулд "хэрчих намнах", "сүртэй аймшигт" зэрэг хоршоо үг, "ярзай-", "хүрхрэ-" зэрэг үйл үгийг нөхцөлдүүлэн холбох нөхцөлөөр сөөлжүүлэн, сүүл холбон найруулжээ. 1973 онд хэвлүүлсэн "Дандины зохист аялгууны толийн монгол тайлбарын тухай" хэмээх өгүүлэлдээ Ч.Алтангэрэл Зая бандидын бичсэн *догшин дүр төгөлдөр чимгийн* жишээ болгож, хоёр бадаг шүлэг орчуулсан бол "Монголын уран зохиолын тойм"-ын хоёрдугаар дэвтэрт бичсэн "Монгол зохиолчдын төвдөөр бичсэн бүтээл" өгүүлэлдээ нэг бадгийг нь хассан байна. Энэ хассан бадаг нь:

Бүх бага хаадыг эрхэндээ оруулаагүй
Бүрэн төгс хүч учрал бүрдээгүй
Бүүрэлхэж дөрвөн аймгийн өвгөөр дайсныг дараагүй би
Бүхний эрхт эзэн хэр мэт болох

Энэ хассан бадгийг *догшин дүр төгөлдөр чимгээр* Зая бандидын бичсэн шүлгийн үргэлжлэл гэж үзэж болмоор байна. "Бүх", "бүрэн", "бүүрэлхэж", "бүхний" зэрэг "б" авиагаар толгой холбон бичсэн энэ шүлэгт өмнөх шүлгийн санааг үргэлжлүүлж, бурханы шашныг сахин хамгаалах догшин сахиус хүчтэй боловч "бүх бага хаадыг" эрхэндээ оруулаагүй, "бүрэн төгс учрал бүрдээгүй" учир бүхний эзэн байж чадахгүй гэдэг санааг баталж нотлох өнгө аясаар бичжээ.

Баатрын дүр төгөлдөр чимэг

mthu rtsal stobs kyis phrogs pa ma yin zhing
zang zing 'byor bas bslus par ma byas la
gzhan las brkus min thos pas nyer phyug pa'i
mgon khyod dran dbang yongs kyi gtsug na 'gying
Эрийн¹⁹⁴ чадал хүчээр булаагаагүй

¹⁹³ Ч.Алтангэрэл, *Монгол зохиолчдын төвдөөр бичсэн бүтээл*, - Монгол зохиолчдын төвдөөр бичсэн бүтээл II, 1977, 607 дугаар тал.

¹⁹⁴ Ч.Алтангэрэл дүр төгөлдөр чимгээр бичсэн шүлгээ хоёр удаа хэвлүүлсэн бөгөөд сүүлийн хэвлэлд зарим үг, хэллэгийг зассан байна. Тиймээс ямар үгийг нэмсэн буюу зассаныг харьцуулахын тулд "Дандины

Эд таваарын баялгаар мэхлээгүй
Ил бус хулгайлаагүй, сонссоноор баялаг
Итгэл та даяар мэргэдийн зулайд хээмсэрлэнэ

Энд "чадал хүч", "эд таваар" гэсэн хоршоо үгээр холбон найруулахын зэрэгцээ "булаагаагүй", "мэхлээгүй", "хулгайлаагүй" зэрэг үгсийг шадын төгсгөл, дунд сүүл холбохоос гадна "хүчээр", "баялгаар" гэсэн хоёр үгийг үйлдэхийн тийн ялгалын нөхцөлөөр зэрэгцүүлэн холбожээ. Түүнчлэн шадыг хос хосоор нь толгой холбохын зэрэгцээ, "дурдлын эрхт" (тө: dran dbang) хэмээх илт өгүүлэх нэрийг ерийн "мэргэн" гэсэн үгээр хөрвүүлжээ. Баатрын дүр төгөлдөр чимгээр бичсэн шүлэгтээ Зая бандид догшин ширүүн авиртай, бусдыг хууран мэхэлж, хөрөнгө зөөрийг булаан, хүчин чадалтайгаа гайхуулан сайрхагч хүмүүн хүчтэй буюу, эс бөгөөс эрдэм номыг судалж, номч мэргэдийн сургаал зааврыг сонсож оюун билгээ хурцлан суух мэргэд хүчтэй юу хэмээн харьцуулж, "итгэл ивээл" болсон гэгээн мэргэд хамаг мэргэдийн оройн чимэг болох учир чухам баатрын шинжийг илтгэж "даяар мэргэдийн зулайд хээмсэрлэнэ" хэмээн шүлгэлжээ. Ч.Алтангэрэл төвд эхийн "gying" хэмээх үгийг "хээмсэрлэнэ" гэж буулгажээ. "Төвд-монгол толь" бичигт энэ үгийг "хэрхийх, сайрхах, бардах ихэрхэх" гэж буй. Өөрөөр хэлбэл, эрдэмтэн мэргэдээс дуулж сонсохыг эрхэм болгосон ихэс дээдэс л мэргэдийн оройн чимэг болж, сайрхан бардамнах эрхтэй хэмээн шүлгэлснийг Ч.Алтангэрэл уран сайхан орчуулжээ.

Үзэмжгүй муухай дүр төгөлдөр чимэг

zas la lhag par srid pa'I bshed pa 'gas
dbyar dus rul pa'I dri mnam rab 'thul zhing
'bu srin rab tu 'khol ba'I sha rjen la
rab dgas lce yis ldag cing 'bad de za

Идээнд үлэмж хурыцсан зарим яргачин

Ид зун цагт өт нь арзганасан

Илжирч өмхөрсөн үнэртэй махыг

Идэхээр дурлан долоож баясах мэт

Энэ бадгийг "и" эгшгээр толгой холбон орчуулахдаа "илжирч өмхөрсөн", "дурлан долоох" зэрэг хоршоо үг, "хурыцсан", "арзганасан", "өмхөрсөн" зэрэг үгийг шадын завсар хооронд сүүл холбож, хэлний зүй, үгсийн сангийн хувиргалын аргыг оновтой хэрэглэсэн байна. Дандины янаг амрагийн сэдвээр бичсэн, Зая бандидын шашин ном, гүн ухааны сэдвээр бичсэн шүлгүүдийг харьцуулж, энэтхэг болон монгол хүний гоо сайхны үзэл баримтлалыг ажиглах боломжтой байна. Тухайлбал, аливаа сайн сайхан, муу муухай, эр зоригтой, баяр баясгалантай, хошин инээдтэй болон аймшигтай зүйлийн талаарх Зая бандидын үзэл бодлыг авч үзвэл энэ ертөнцөд хамгийн жигшүүртэй муу муухай зүйл бол бусдын амийг хөнөөх, амьтны амийг таслах явдал буюу бие, хэл, сэтгэлээр үйлдэх нүгэл юм. Тиймээс халуун зун шинэхэн төхөөрсөн нойтон мах

зохист аялгууны толийн монгол тайлбарын тухай" хэмээх 1973 оны өгүүлэлд орсон орчуулгыг 1973 оны эх, харин 1977 оны "Монголын уран зохиолын тойм"-ын II-т бичсэн "Монгол зохиолчдын төвдөөр бичсэн бүтээл" өгүүлэлд орсон орчуулгыг 1977 оны эх гэж тус тус нэрлэж, тус хоёр эхийн ялгаа зөрөөг тэмдэглэв. 1973 оны эхэд "эр" гэж бичжээ.

дээр өт хорхой арзганаж, үнэр танар нь дур гутам бөгөөд түүнд хурьцан шунаж, "дурлан долоож" буй дүр байдлыг зэвүүцэн жигших өнгө аясаар илэрхийлжээ.

Гайхамшигийн дүр төгөлдөр чимэг

Зая бандид Лувсанпэрэнлэй тус чимгээр бичсэн шүлэгтээ мунхаг сэтгэлийг ариусган билгийн нүдийг нээн өгч, бодь мөрийн замаар хөтлөх мэргэн багшийн эш онолын сургаал гайхамшигтай бөгөөд тэрхүү сургаалыг сонсох хувьтай шавь нар бүр ч их гайхалтай гэж бичсэнийг Алтангэрэл орчуулсан нь:

lung rtogs yon tan rab rdzogs mgon khyod kyi
sku yis mig la dga' ston rab ster zhing
gsung gis mi shes blo mun sel ba dang
thugs kyis bu ltar brtse ba'I skal ba bdag

Аливаа эш онолын эрдэм төгс итгэл таны

Ариун биеэр нүдний баяр баясгалан үүсэн

Айлдсан зарлигаар оюуны харанхуй арилан

Асрах сэтгэлээр нь энэрэгдсэн аз хувьтай миний буян гайхамшиг¹⁹⁵

хэмээн "а" үсгээр толгой холбон орчуулжээ. Үүнд "эш онол", "баяр баясгалан", "аз хувь" зэрэг хоршоо үгээр найруулахдаа мэргэн багштай учран золгож, баяр баясгалан төрдөг, зарлиг сургаалыг сонсож оюуны харанхуй арилдаг, асрал авралыг эгээрэн олвол энэрэл нигүүлсэлийг нь хүртдэг учир, буяны садан багшийн хайр халамжийг олсон аливаа хүмүүн хувь хишигтэй хэмээн тунхаглан бичсэн санааг Ч.Алтангэрэл утга төгөлдөр хөрвүүлжээ.

Инээдмийн дүр төгөлдөр чимэг

Сурч мэдсэн зүйлээр хомс бага боловч олон мэргэдийн дунд дуугаа өндөрсгөн сайрхан бардамнагч хүмүүнийг гэгээн мэргэд үзэж элэглэн шоолно хэмээн Зая бандид бичсэнийг Ч.Алтангэрэл орчуулсан нь:

rgya chen thos pas phyug par khas che'i khyod
zab mo'I chos gling bgros tshe smra ba bcad
mu cor gtam la skang sang sgrog pa ni
gzur gnas blo ldan mthong tshe gad mo shor

Агуу сонссоны баялгаар бардам¹⁹⁶ та

Асар гүн онол хэлэлцэх цагт¹⁹⁷ өгүүлэх нь мухардан

Турьгүй чалчихдаа¹⁹⁸ дуугаа өндөрлөдгий чинь

Тунгалаг хянуур оюут үзээд инээд алдвай¹⁹⁹ гэж орчуулжээ.

Үүнд "чалчих", "өгүүлэх", "хэлэлцэх" зэрэг ойролцоо утгатай үг, "тунгалаг хянуур" хэмээх хоршоо үг, "мухарда-", "дуугаа өндөрлө-" хэмээх эсрэг утгатай үгийг хам сэдвийн дотор хоршин холбон орчуулсан байна.

Ийнхүү Дандины "Зохист аялгууны толь"-ийн утгын гучин таван чимгийн арван наймдугаар чимэг болох *дүр төгөлдөр чимэгт* баярлан бахадсан, хайрлан энэрсэн, жигшин зэвүүцсэн, шоглон хошигносон, айн цочсон зэрэг сэтгэлийн

¹⁹⁵ 1973 оны эхэд "Аз хувьтай миний олсон буян гайхамшиг" гэжээ.

¹⁹⁶ 1973 оны эхэд "бардамнах" гэжээ.

¹⁹⁷ 1973 оны эхэд "цаг" гэж буй.

¹⁹⁸ 1973 оны эхэд "чалчаанд" гэж буй.

¹⁹⁹ 1973 оны эхэд "алдана" гэж буй.

олон өнгө аясыг илэрхийлсэн байх бөгөөд монголын соён гийгүүлэгч, эрдэмтэн Зая бандид Лувсанпэрэнлэй Дандины яруу найргийн онолыг бүтээлчээр хэрэглэж, шашин номын гүн утга агуулгатай шүлгийг төвд хэлээр бичжээ.

Зая бандидын бичсэн шүлгийг Ч.Алтангэрэл орчуулахдаа Дандины зохист аялгууны онолыг судалсан бөгөөд Зая бандид Лувсанпэрэнлэйн төвд шүлгийн зарчимаар үе тэнцүүлэн шүлгэлснийг монгол шүлгийн толгой холбох, сүүл холбох, хоршоо холбоо үгийг хэрэглэх аргаар уран сайхан хөрвүүлжээ.

Ном зүй

1. *Дандины зохист аялгууны толь*, шинэчилсэн орчуулга, тайлбарыг үйлдсэн Ш.Бира, Х.Гаадан, О.Сүхбаатар, УБ., 1981.
2. *Don rgyan so lnga'i dper brjod tshangs sras dgyes pa'i glu dbyangs*, төвд барын судар
3. *Dung dkar blo bsang 'phrin las, snyan ngag la 'jug tshul tshig rgyan rig pa'i sgo 'byed*, mtsho sngon mi rigs dpe skrun khang, 1987.
4. Ч.Алтангэрэл, *Монгол зохиолчдын төвдөөр бичсэн бүтээл*, - Монголын уран зохиолын тойм"-ын II дугаар боть, УБ., 1977.
5. Ч.Алтангэрэл, *Монгол зохиолчдын төвдөөр бичсэн бүтээл*, I дүгээр дэвтэр (Ц.Лувсанчүлтэм, Л.Агваанхайдав, Н.Ишданзанванжил), редактор Ц.Дамдинсүрэн, УБ., 1967
6. Ч.Алтангэрэл, *Монгол зохиолчдын төвдөөр бичсэн бүтээл*, II дугаар дэвтэр (Д.Равжаа) УБ., 1968.
7. Ч.Алтангэрэл, *Дандины зохист аялгууны толийн монгол тайлбарын тухай*, ОУМЭ-ийн II их хурал, I боть, УБ., 1973, 43-48
8. Ш. Бира, *"Кавьядарша" Дандина в Монголии*, - Литературные связи Монголии, Москва, 1981.
9. А.Шархүү, *Туурвил зүй, орчуулга судлалын зарим асуудал*, УБ 2011.
10. Д.Бүрнээ, *Зая бандид Лувсанпэрэнлэйн дүрстийн чимгээр бичсэн шүлгийн онцлог*, - Эрдэнэ Зая бандид Лувсанпэрэнлэйн мэндэлсний 360 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл, Улаанбаатар, 2002, 57-63 тал.
11. Д.Бүрнээ, *Зая бандид Лувсанпэрэнлэйн бүтээлийн тухайд*, Монгол Судлалын Эрдэм шинжилгээний бичиг, Боть XIX (193), МУИС, МХСС, Улаанбаатар, 2003, 125-132.
12. Д.Бүрнээ, *Зая бандид Лувсанпэрэнлэйн "Утгын гучин таван чимгийн үлгэр өгүүлэхүй" зохиолын орчуулгаас*, - Утгын гучин таван чимгийн яруу эгшиг, УБ., 2012, 36-67.
13. Д.Бүрнээ, Д.Энхтөр, *Уламжлалт орчуулгын судлалд*, УБ 2003.

Резюме

Тибетолог Ч.Алтангэрэл написал ряд интересных статей о трудах монгольских поэтов, написавших свои труды на тибетском языке. Перу Ч.Алтангэрэла также принадлежат две книги о тибетоязычных художественных произведениях монголов, которые являются настольной книгой тибетологов, монголоведов нашего времени. В данной статье автор рассматривает переводческую деятельность Ч.Алтангэрэла, а именно перевод примеров из "восемнадцатого смыслового украшения" из произведения Зая пандиты Лувсанпэрэнлэя, которая называется "Радостное пение сына Брахмы". Оно было написано на основе изучения тридцати пяти смысловых украшений из "Кавьядарши" Дандина. Восемнадцатое украшение называется "Побуждающее чувство" (тиб. nyams ldan, мон. дүр төгөлдөр чимэг) и имеет восемь разновидностей. Зая пандита в своей поэме не указывает к какому именно украшению принадлежат его стихи, поэтому автор статьи ставит цель определить разновидность данных стихов. На основе сличения перевода Ч.Алтангэрэла с вышеупомянутым "украшением" из "Кавьядарши" автор считает, что перевод Ч.Алтангэрэла действительно является примером к смысловому украшению "Побуждающее чувство". Далее автор статьи делает вывод, что Ч.Алтангэрэл удачно использовав аллитерацию, рифмы монгольского стихосложения, красочные словосочетания (мон. хоршоо үг) сумел выразить все те оттенки радости и вдохновения, бесстрашия и смелости, ненависти и удивления в поэзии Зая пандиты.

ХАЙНРИХ ХАЙНЕГИЙН ЛОРЕЛАЙ ШҮЛГИЙГ МОНГОЛ ХЭЛНЭЭ ОРЧУУЛСАН НЬ

А.Цэрэнчулуун²⁰⁰

Товч агуулга: Хайнрих Хайне 1824 онд Лорелай хэмээх алдарт шүлгээ бичсэн бөгөөд 1837 онд Фридрих Зихлер уг шүлэгт ая зохиосноор герман ард түмний дуулах дуртай дууны нэг болжээ.

Хайнрих Хайне энэ шүлгээ нэгэн домгоос үндэслэн герман шүлгийн түгээмэл бүтэц жирмийн сүлжээ маягаар хос хосоор нь салаавчлан сүүл холбож бичсэн байдаг юм. Хайнрих Хайне “лорелай” шүлгийнхээ нэг гурав, хоёр дөрөвдүгээр шадыг адил төгсгөлтэй бичжээ. Энэ шүлгийг дэлхийн олон хэлэнд орчуулсан байдаг бол монгол хэлнээ ч дөрвөн хүн хөрвүүлжээ. Энэхүү өгүүллээр эдгээр орчуулгыг судалж үзэхийг хичээлээ. Ингэхийн тулд Хайнегийн шүлгийн эхийг нэг бүрчлэн үгчлэн буулгав. Мөн энэ шүлэгт орсон үгсийг жагсаагаад орчуулагч бүр хэрхэн монголчилсныг зэрэгцүүлэн харуулж, орчуулагч бүрийн хэрхэн монголчилсныг үзүүлэхийг зорилоо.

Түлхүүр үгс: Үгчилж, утгачилж, галиглаж орчуулах зарчим, шүлэг, үг сонголт, домог, Хайнрих Хайне, Лорелай, байц өндөр, хадан хясаа, онгоц, далайчин, давалгаа, лусын охин дагина, жаргах наран, толгой холбох, сүүл холбох, жирмийн сүлжээ маягаар салаавчлан сүүл холбох, Пфальц гүн, алтан сам, алтан гоёл, хонгор шар үс.

Хайнрих Хайнегийн талаар товчхон



Хайнрих Хайне 1797 онд Германы Дюссельдорф хотод еврей гаралтай нэгэн гэр бүлд төрөөд 1856 онд Францын Парис хотод талийгаач болжээ.

Тэр бээр XX зууны Германы нэрт яруу найрагч, зохиолч, сэтгүүлч байлаа.

1831 онд тэр бээр Парис руу нүүн суурьшаад, амьдралынхаа сүүлчийн хагасыг тэнд өнгөрүүлсэн боловч төрсөн нутгаа насан эцэслэтлээ санасаар байжээ.

“Дюссельдорф бол үнэхээр сайхан, алс холоос би энэ хотыг үргэлж санах юм. Тохиолдлоор би тэнд төрсөн гэж бодоход юутай сайхан. Шууд л нутаг руугаа очмоор санагддаг. Нутаг гэдэг маань, би эхээс унасан Болькерштрассен дахь байшин юм шүү дээ.” хэмээн тэр бичсэн байдаг. *Heinrich Heine.*

²⁰⁰ Орчуулагч, судлаач

Лорелайн байц өндөр

Юнескогийн дэлхийн өвд хосгүй үзэсгэлэнт газраар бүртгэлтэй **Лорелай** хэмээх байц өндөр Райн мөрний дотогш тохойрсон буланд байдаг. Далайн төвшнөөс дээш 193,14 метрт орших энэ үзэсгэлэнт сайхан газрыг үзэхээр жил бүр олон мянган жуулчин очдог ажгуу. Лорелайн тухай янз бүрийн хүмүүсийн бичсэн олон янзын шүлэг байдаг.



“Лорелай” дагинын домог

Аль эрт нэгэн цагт,алс тэртээ Герман орны Райн мөрний байц хясаан дээр **Лорелай** хэмээх лусын нэгэн охин дагина хааяа нэг харагддаг байж гэнэ. Тэр дагина хадан хясааны ирмэг дээр суугаад хань ижлээ мөрөөдөнхөн, намирсан хонгор шаргал үсээ алтанхан самаараа самнанхан, алтан гоёлоо гялалзууланхан саатдаг байжээ.Харсан хүн болгоны хайр хүрмээр тэр бүсгүй, хамаг амьтан уяртал дуулдаг байж гэнэ.

Зарим далайчин дуунд нь уяран түүнийг ширтэн явсаар эрчлэн ирэх давалгаанд цохиулан элгэн хад мөргөн сүйрч, онгоцтой хүнтэйгээ ор сураггүй алга болдог байсан гэнэ. Харин тэр дагина далайчдад туйлаас сайн байсан юмсанжээ. Далайчид үзэсгэлэнт дагинын тухай уулзсан болгондоо ярьж, төдхөн хавийн хүмүүс дагинын тухай мэддэг болсон гэдэг. Пфальцын гүнгийн хүү тэр бүсгүйн тухай олж сонсоод, үнэн худлыг мэдэхээр, тэдгээр далайчны нэгийг дагуулаад хясааны доогуур очиж гэнэ. Дагина ч харагдаж гэнэ. Хясаан дээрээ суугаад алтран гялалзах хонгор шар үсээ самнаж байв гэнэ, нөгөө сайхан дуугаа ч аялж гарч, гүнтэний хүү ч харсан даруйдаа л дурлаж орхиж, тэгээд нөгөө далайчиндаа эрэг рүү үтэр түргэн хүрэхийг тушааж дээ. Эрэгт тулж очоод залуу эр яаран буух гээд хальтран цүнхээлд унаж орхижээ. Түрүүнд нь олон хүн үгүй болсон тэр л газар гүнтний хүү ч бас алга болжээ. Пфальц гүн энэ мэдээг дуулаад уур омог нь шатаж, цэргүүдээ тийш илгээн: **“тэр золигийн эмийг амьд, үхсэн алин боловч авчирч надад өг!”** хэмээн тушааж гэнэ. Тэд нь ч тэр оройдоо хясаанд авираад дагинад тулж очиж гэнэ. Бүсгүй ялдамхнаар мишээн:”**хаанахын хэн гэгч хүмүүс вэ? Явдал учир юу вэ?**” хэмээн асууж гэнэ. Харин тэдний нэг нь хахир хүйтэн дуугаар: **“Гай бусын эм чи, манай гүнд уй гашуун учрууллаа. Одоо чи өөрөө Райн мөрний усанд үйж үх!”** гэж хашгирчээ. Дагина инээмсэглээд хуван эрхиэрээ даллан: **“Аав аа, аав аа! Алив охиндоо, асар түргэн хоёр цагаан хүлэг явуулна уу, охин нь давалгаа хөлөглөн даруй очих хэрэгтэй боллоо”** гэв. Үгээ ч хэлж дуусаагүй байтал Райн мөрний дээгүүр хоёр их давалгаа эрчлэн хуйлраад гүнжийн байгаа хясааг нөмрөн авав гэнэ. Гүнж ч тэр даруйдаа харах бараагүй, хайх мөргүй алга болсон юм гэдэг. Түүнээс хойш гүнжийг харсан үзсэн хүн үгүй гэнэ.

Энэ домгоос үндэслэн **Хайнрих Хайне**“**Лорелай**” хэмээх алдарт шүлэг бичсэн нь 1824 онд анх удаа нийтлэгджээ. 1837 онд **Фридрих Зихлер** уг шүлгэнд ая зохиосон нь ардын дуу мэт түгжээ.

Лорелайн шүлэгтээ Хайнрих Хайнегийн сонгосон үгс

Märchen	Үлгэр, домог
der Gipfel des Berges	Уулын орой
Jungfrau	Онгон бүсгүй
Gold'nes Geschmeide	Алтан гоёл
Gold'ne Kamme	Алтан сам
wundersame	гайхалтай
Melodei	Аялгуу, уянга
Schiffer	Онгоцны ахмад, далайчин, завьчин
Schiffe	Онгоц
Wilder Wehe	Асар хүчтэй
Felsenriffe	Дэвээ хад, хадан хясаа
Wellen	давалгаа
Kahn	Сэлүүрт завь
Singen	дуулах
Loreley	Лорелай
Хайнрих Хайнегийн шүлгийг үгчлэн орчуулбал:	
Loreley	Лорелай
Герман эх:	Үгчилсэн орчуулга:
Ich weiß nicht, was soll es bedeuten,	Яагаад ийм гунигтай байгаа,
Dass ich so traurig bin,	Ямар учиртай болохыг би мэдэхгүй юм
Ein Märchen aus uralten Zeiten,	Балар эртний нэгэн үлгэр
Das kommt mir nicht aus dem Sinn.	Бодол санаанаас салахгүй юм.
Die Luft ist kühl und es dunkelt,	Оройн сэрүүн орж, харуй бүрий боллоо.
Und ruhig fließt der Rhein;	Райн мөрөн намуухан урсана.
Der Gipfel des Berges funkelt,	Жаргах нарны туяанд
Im Abendsonnenschein.	Уулын орой гялалзаж харагдана.
Die schönste Jungfrau sitzet	Тэр дээр үзэсгэлэнт охин дагина суух нь
Dort oben wunderbar,	Үнэхээр гайхалтай харагдана.
Ihr gold'nes Geschmeide blitzet,	Алтангоёл нь гялалзана.
Sie kämmt ihr goldenes Haar,	Хонгор шар үсээ намируулна.
	Алтан самаар самнаж байна.
Sie kämmt es mit goldenem Kamme,	Үсээ самнангаа дуу аялна
Und singt ein Lied dabei;	Үнэхээр гайхалтай
Das hat eine wundersame,	Үлэмж хүчтэй аялгуу эгшиглэнэ.
Gewalt'ge Melodey.	
Den Schiffer im kleinen Schiffe,	Далайчны жаахан онгоцыг
Ergreift es mit wildem Weh;	Давалгаа хүчтэй нөмөрлөө.
Er schaut nicht die Felsenriffe,	Дээш (дагиныг) ширтэн явсаар далайч
Er schaut nur hinauf in die Höh'.	хүү
Ich glaube, die Wellen verschlingen	хадан хясааг ч анзаарсангүй.
Am Ende Schiffer und Kahn,	далайчин, онгоц хоёрыг
	давалгаа залгиж орхилоо, хөөрхий.

Und das hat mit ihrem Singen,
Die Loreley getan.

Лорелейн аялах дуул
Лавтай ийм юм болголоо, эвий.

Шүлэгт орсон үг, өгүүлбэр бүрийг энэ үгчилсэн орчуулгаараа гаргахыг хичээлээ.

Лорелей шүлгийн бүтцийг судлан үзвэл:

Жирмийн сүлжээ маягаар хос хосоор салаавчлан сүүл холбожээ.

Герман шүлгийн төгсгөлийн энэ хэлбэрийг монгол орчуулгандаа баримтлан буулгах аваас Хайнегийн шүлгийн бүтцийг монгол уншигчиддаа мэдүүлж, уншигч маань герман шүлгийн талаар бат ойлгоцтой болох биз ээ.

Үгийн сонголт, дүйцүүлгийг шинжвээс:

Эх зохиолд	Б.Явуухулангийн орчуулганд	Д.Чимэддоржийн орчуулганд	Н.Лувсандоржийн орчуулганд
Уулын орой	шовх уулс	Сэрвийн үзэгдэх уулсын оргил	оргил
Онгон охин	хань ижилгүй бүсгүй	Ижилгүй сайхан залуу дагина	Ариг сайхан үзэсгэлэнт бүсгүй
Алтан сам	үнэт эрдэнийн сам	Эрдэнийн сам	-
Алтан гоёл,	-	-	Үнэт чимэг зүүлт
Алтан шар үс	өсгий шүргэсэн хонгор үс	Илдэн гялгар алтан үсээ, гэзгээ	Алтан шаргал гэзгээ, Алтан шаргал үсээ
Түүний дуулах дуу гайхалтай, хүчтэй	шидэт дуугаар бүхнийг даллана	Эрээд олдошгүй гайхалтай бөгөөд Амьтныг учраах шидтэй ажээ.	Аялгуу эгшиг ... агуу
жаахан онгоцтой далайчин	өвчүүн завьтай усчин хархүү	Бяцхан завьтай нэг хархүү	Жижиг завьтай хархүү
Хадан хясаа	эргэн хясаа	Биржгэр хад	Хад цохио
Лорелейн дуу л ийм байдалд хүргэв	Ид шидээрээ Лорелей хөнөөв.	Лорелейн дуулахад Хууртан автагдсаны харгай байлгүй	Лорелейн дуулсан дуунаас Лавтай болсон гэж би бодлоо

Дуунд уяраад бодолд автан байснаа давалгаанд цохиулан сэрэв гэсэн уран санаа оруулсан нь улам ч сэтгэлд буухаар болсон шиг.

Лорелайг манай нэрт яруу найрагч Б. Явуухулан орос хэлнээс дам орчуулсан нь:

Ich weiß nicht, was soll es bedeuten,
Dass ich so traurig bin,
Ein Märchen aus uralten Zeiten,
Das kommt mir nicht aus dem Sinn.

Die Luft ist kühl und es dunkelt,
Und ruhig fließt der Rhein;
Der Gipfel des Berges funkelt,
Im Abendsonnenschein.

Die schönste Jungfrau sitzet
Dort oben wunderbar,
Ihr gold'nes Geschmeide blitzet,
Sie kämmt ihr goldenes Haar,

Sie kämmt es mit goldenem Kamme,
Und singt ein Lied dabei;
Das hat eine wundersame,
Gewalt'ge Melodey.

Den Schiffer im kleinen Schiffe,
Ergreift es mit wildem Weh;
Er schaut nicht die Felsenriffe,
Er schaut nur hinauf in die Höh'.

Ich glaube, die Wellen verschlingen
Am Ende Schiffer und Kahn,
Und das hat mit ihrem Singen,
Die Loreley getan.

Юунаас болоод сэтгэл түгшиж
Юундаа ингэж би **гунив**.
Эртний домгийг эргэн санаж
Элэг эмтрэн уйтгарт **автав**.

Үдэш оройн сэрүү унаж
Үүлгэр чимээгүйд гол **мяралзана**
Шингэх наранд Рейн дээгүүр
Шовх уулс улайран **сүүхийнэ**.

Ижил ханьгүй үзэсгэлэнт бүсгүй
Элгэн хясааны өвөрт **сууна**
Өсгий шүүрсэн хонгор үсээ
Үнэт эрдэнийн самаар **самнана**.

Ухаа хонгор үсээ самнахдаа
Уярам сайхнаар хүүхэн **дуулна**
Солонгорон хадах шидэт дуугаараа
Сонссон бүхнийг даллан **дуудна**

Өвчүүн завьтай усчин хархүү
Өндрийн оройг ширтэн **сэрэв**
Эргэн хясаанд тулан очиж
Эгэлгүй төрсөн бүсгүйг **харав**

Элгэн хясааны эргүүлэгт цөөрөм
Эвхрэн уурлаж завийг **соров**
Элээ, элээ гэж! Усчин хархүүг
Ид шидээрээ Лорелей **хөнөөв**.
Б.Явуухулан монголчлов

Лорелайг шүлгийг анх Б. Явуухулан гуай орос хэлнээс дам орчуулахдаа монгол шүлгийн зарчмаар толгой холбож, зохиогчийн шүлэглэлийн хэлбэрийг хатуу баримтлан чадварлагаар салаавчлан сүүл холбосон нь харагдаж байна.

Лорелайг орчуулагч Д. Чимэддорж орос хэлнээс дам орчуулсан нь:

Ich weiß nicht, was soll es bedeuten,
Dass ich so traurig bin,
Ein Märchen aus uralten Zeiten,
Das kommt mir nicht aus dem Sinn.

Die Luft ist kühl und es dunkelt,
Und ruhig fließt der Rhein;
Der Gipfel des Berges funkelt,
Im Abendsonnenschein.

Яагаад би гуниглан байдгаа
Бодоод бодоод **олохгүй юм**
Язуур цагийн нэгэн үлгэр л
Бодол санаанаас **гарахгүй юм**

Сэрүүн амьсгалтай үдэш болж
Рейн мөрөн алгуур **урснам**
Сэрвийн үзэгдэх уулсын оргил
Оройн наранд улайран **харагданам**

Die schönste Jungfrau sitzet
Dort oben wunderbar,
Ihr gold'nes Geschmeide blitzet,
Sie kämmt ihr goldenes Haar,

Sie kämmt es mit goldenem Kamme,
Und singt ein Lied dabei;
Das hat eine wundersame,
Gewalt'ge Melodey.

Den Schiffer im kleinen Schiffe,
Ergreift es mit wildem Weh;
Er schaut nicht die Felsenriffe,
Er schaut nur hinauf in die Höh'.

Ich glaube, die Wellen verschlingen
Am Ende Schiffer und Kahn,
Und das hat mit ihrem Singen,
Die Loreley getan.

Ижилгүй сайхан залуу дагина
Өндөр дээр суух нь юутай **сонин**
Илдэн гялгар алтан үсээ
Самнан суух нь юутай **тодхон**

Эрдэнийн самаар гэзгээ самнан
Аялан хөвүүлэх дууны сайхан
Эрээд олдошгүй гайхалтай бөгөөд
Амьтныг учраах шидтэй ажээ.

Бяцхан завьтай нэг хархүү
Уйтгартайхан сэлж явахдаа
Биржгэр хадыг ч эс анзааран
Уг хүүхнийг л салахгүй ширтэнэ.

Тэрхэн завь эзэнтэйгээ хоёулаа
Хуйлрах долгионд хамагдсан **байлгүй**
Тэр явдал Лорелейн дуулахад
Хууртан автагдсаны харгай **байлгүй**
Д. Чимэддорж монголчлов

Д. Чимэддорж герман хэлний салаавчлан сүүл холбосон байдлыг орчуулгын эхний хэсэгтээ баримтласан бол бүхэл орчуулгынхаа туршид шүлгийн толгойг ч салаавчлан холбосон нь Хайнегийн шүлгийн бүтцийг давхар давхар харуулж чаджээ. Дээрх хоёр орчуулагч орос эхээс орчуулсан орос дуудлагаар Хейнрих Хейне, Лорелей хэмээн бичжээ.

Лорелайг Н.Лувсандорж герман хэлнээс шууд орчуулсан нь:

Ich weiß nicht, was soll es bedeuten,
Dass ich so traurig bin,
Ein Märchen aus uralten Zeiten,
Das kommt mir nicht aus dem Sinn.

Die Luft ist kühl und es dunkelt,
Und ruhig fließt der Rhein;
Der Gipfel des Berges funkelt,
Im Abendsonnenschein.

Die schönste Jungfrau sitzet
Dort oben wunderbar,
Ihr gold'nes Geschmeide blitzet,
Sie kämmt ihr goldenes Haar,

Sie kämmt es mit goldenem Kamme,
Und singt ein Lied dabei;

Уйтгарт автан суухын
Учрыг ер олохгүй юм
Урьд цагиын нэг үлгэр
Ухаан бодлоос салахгүй юм.

Орой болж, агаар сэрүүсээд
Райн мөрөн намуухан урсана
Шингэх нарны сүүлчийн туяа
Шижиr өнгөөр оргилд гялалзана.

Ариг сайхан үзэсгэлэнт бүсгүй
Өндөр хясааны оройд суугаад
Алтан шаргал гэзгээ самнаж
Үнэт чимэг зүүлтээ гялалзуулна.

Алтан шаргал үсээ самнангаа
Ая дуугаа өргөн байлаа

Das hat eine wundersame,
Gewalt'ge Melodey.

Den Schiffer im kleinen Schiffe,
Ergreift es mit wildem Weh;
Er schaut nicht die Felsenriffe,
Er schaut nur hinauf in die Höh'.

Ich glaube, die Wellen verschlingen
Am Ende Schiffer und Kahn,
Und das hat mit ihrem Singen,
Die Loreley getan.

Аялгуу эгшиг нь үнэхээр
Анхаарч сонсмоор агуу байлаа.

Жижиг завьтай хархүү
Жигтэй ихээр уяраад
Хад цохиог хайхарсангүй
Харуулдаж дээшээ ширтлээ

Хархүү завь хоёрыг
Хамаж одлоо, долгион
Лорелайн дуулсан дуунаас
Лавтай болсон гэж би бодлоо
Н. Лувсандорж монголов

Герман хэлнээс шууд орчуулсан Н. Лувсандорж уг шүлгийг бүхэлд нь монгол шүлгийн зарчмаар толгой холбоод шүлгийн төгсгөлийгэхлээд салаавчлан сүүл холбож байснаа төгсгөлийн хэсэгт зөвхөн толгой холбон бичжээ.

Энэ бүхнийг судалсны эцэст өчүүхэн миний бие ч аймшиггүй зориг гарган Хайнегийн энэ алдарт шүлгийг монголчлохыг оролдлоо.

Die Loreley

(Heinrich Heine, 1797 – 1856)

Ich weiß nicht, was soll es bedeuten,
Dass ich so traurig bin,
Ein Märchen aus uralten Zeiten,
Das kommt mir nicht aus dem Sinn.

Die Luft ist kühl und es dunkelt,
Und ruhig fließt der Rhein;
Der Gipfel des Berges funkelt,
Im Abendsonnenschein.

Die schönste Jungfrau sitzet
Dort oben wunderbar,
Ihr gold'nes Geschmeide blitzet,
Sie kämmt ihr goldenes Haar,
Sie kämmt es mit goldenem Kamme,
Und singt ein Lied dabei;
Das hat eine wundersame,
Gewalt'ge Melodey.

Den Schiffer im kleinen Schiffe,
Ergreift es mit wildem Weh;
Er schaut nicht die Felsenriffe,
Er schaut nur hinauf in die Höh'.

Лорелай

(Хайнрих Хайне, 1797-1856)

Буурал эртний нэгэн үлгэр
Бодол санаанаас минь гарахгүй юм.
Уйтгар гуниг цээжээр дүүрэн
Учрыг хэлж би мэдэхгүй юм.

Жавар унаж, үдэш боллоо,
Райн мөрөн мяралзан урсана.
жаргах наран уулын оройд туслаа
Оргил нь тэгээд улайран харагдана.

Харц булаам охин дагина
Харуул харан суух нь бахдалтай.
Хонгор шар үсээ самнана
Хосгүй гоёл гялалзах нь гайхалтай.

Алтан сам нь нүд гялбуулна.
Аялгуут дуу нь сонор мялаана.
Тэндээс тэр гайхалтай дуулна
Тэнгэрийн дор уянгалан сонсдоно.

Далайчин эрийн завь хөвсөөр
Далбилзтлаа давалгаанд цохиуллаа.
Уулын оройгтэр ширтэн явсаар
Урд нь тулгарсан хясааг эс анцаарлаа.

Ich glaube, die Wellen verschlingen
Am Ende Schiffer und Kahn,
Und das hat mit ihrem Singen,
Die Loreley getan.

Давалгаа эрчлэн хуйлраад
Далайчныг завьтай нь хөмрөх дэгээ.
Лорелайн дуу сэтгэлийг нь
үймрүүлээд
Залуу далайчныг авч одох дэгээ.

А. Цэрэнчулуун монголчлов

Яруу найраг гэдэг үгсийн эрдэнийг сонгон хэлхэж, уран санааг цөөн үгэнд багтаан утга төгс, яруу сайхнаар гаргасан байх тул яруу найргийг орчуулахдаа ганц ч үг, утга санааг гээж, орхигдуулж болохгүй, бас шүлгийн бүтцийг хадгалж, монгол орчуулгадаа харуулах ёстой гэдэг зарчмыг баримтлах нь зүйтэй мэт санагдана.

Яруу найргийг хэрхэн орчуулах талаар ардын уран зохиолч Ц. Дамдинсүрэн гуай “Олег цэцэний дуулал”-ыг хэрхэн орчуулснаа тайлагнан бичсэн байдаг нь орчуулагч нарт үнэтэй гарын авлага болдог билээ.

Яруу найргийн зохиолыг орчуулахдаа анхаарвал зохих зүйлийн талаар их эрдэмтэн, зохиолч, орчуулагч Б. Ринчен гуай ийн бичжээ.

“Баян элбэг үгтэй зохиолыг монгол болгохдоо маш баян монгол хэлнийхээ үгсийн сангийн эрднээс цаад зохиолын сайхан үгтэй чадал санаа эн чацуу үг хэрэглэхээс гадна, бас уг зохиогч нь цаад хэлнийхээ үгийн сангаас сонгон хэрэглэсэн үг нь судрын хэлний үг байвал, монгол судрын хэлнээс түүнтэй дүйх сайхан үг сонгон олж, номын хэлнээс хэрэглэсэн үг байвал, монгол номын хэлний зохих үгнээс шигшин шилэн сонгож хэрэглээд бичгийн хэлний үг хэрэглэсэн байвал монгол бичгийн хэлний үг хэрэглэж, хар үг хэрэглэсэн газар, мөн түүнтэй амт санаа дүйх хар үг тэнсэн олж хэрэглээд, эх зохиолын хуучин үгийг нь монгол хэлнийхээ хуучин үгээр тааруулаад уншигчийнхаа Дүгийг баяжуулан мэдлэгийг нь агуу болгохын үүднээс тайлбар зүүлт зүүх газар нь зүүн тайлбарлаж, оюуны нь амыг нээж өгөх хэрэгтэй байна.”²⁰¹

Яруу найргийн төрлийг орчуулахдаа орчуулгын үндсэн зарчим болох үгчлэх, утгачлах, галиглах зарчмыг баримтлан үг, утгыг нарийн гаргахын зэрэгцээ, нэг орны соёлыг нөгөө нөгөө орны соёлд буулгах хийгээд орчуулга нь **яруу найртай, утга төгс, мэдэхүйеэ хялбар** байх ёстой гэдэг монголчуудын орчуулгын алтан зарчмыг хангаж ажиллах хэрэгтэй нь зүйн хэрэг.

Яруу найргийг орчуулахдаа найрагчийншилж сонгосон эх зохиолын үг бүрийг орхигдуулж, гээгдүүлэлгүй, санаа бүрийг хадгалан орчуулах шаардлагатай. Түүнээс гадна шүлгийн өвөрмөц шинж болох толгой, сүүл холбосон байдлыг анхааран чухам яаж сүүл холбосон, хос хосоор нь, эсвэл нэг гурав, хоёр дөрөвдүгээр мөрийг салаавчлан жирмийн сүлжээ маягаар, эсвэл нэг хоёр, гурав дөрөвдүгээр мөрийг хос хосоор нь хошмоглон холбосон байдлыг орчуулгандаа гаргахыг зорих аваас яруу найрагчийн эх хэлэн дээрх шүлгийн бүтцийг уншигчдадаа таниулах болой.

²⁰¹Б.Ринчен Шүлэг орчуулах эрдэм

Хайнрих Хайнегийн шүлгийг орчуулсан дээрх гурван орчуулагч зохиогчийн сонгосон үгсийг монгол хэлэнд янз бүрээр буулгажээ. Мөн “**олон модонд толгой эргээд ойг нь ажигласангүй**” гэгчээр уянгын халилдаа автаад зарим үгийг орхигдуулсан, бас хэт нутагшуулаад соёлын ялгааг бүрхэгдүүлсэн тал ч ажиглагдлаа. Намирсан үс гэхийг өсгий хүрсэн гээгтэй гэх жишээтэй.

Дүгнэлт:

Соёлын орчуулга европ хүн задгай, намирсан үсийг гоёд, харин монгол хүн өсгийгөө хүрсэн урт хар гэзгийг гоёд тооцдог болой. Намирсан задгай шар үсийг өсгийгөө шүргэсэн урт хар гэзэг гээд буулгачихвал уг зохиолыг хэт нутагшуулаад герман соёлын ялгааг уншигчид мэдэхгүй талтай.

Яруу найргийг орчуулахдаа үгчлэх, утгачлах, галиглах, дуриан шүлэглэх зарчмыг чанд баримтлан нутагшуулах, ондоошуулах бодлогыг зөв гарган шаардлагатай бол зүүлт хийн тайлбарлаж ч болох мэт санагдлаа. Аль нэг гадаад хэлийг гаргуут эзэмшсэн дурын хүн орчуулга хийж чадахгүй, харин төрөлх хэлээ, ялангуяа бичгийн хэл, ардын аман зохиолын үг хэллэгийг сайн мэддэг байж, орчуулгыг сайн хийх чадвартай болох мэт санагдана. Тухайн цаг үеийн байдлаас, ихэнх сэхээтэн маань ЗХУ-д боловсрол эзэмшиж байсан тул нэгэн үеийн турш европын уран зохиолыг орос хэлээр дамжуулан монгол уншигчиддаа хүргэж байсан билээ. Хэдийгээр орос хэлэнд сайн орчуулсан шүлгийг манай яруу найрагчид орос хэлнээс гаргуут сайн орчуулж байсан боловч зарим үгийг орос дуудлагаар бичиж байжээ. Тухайлбал “лорелай” гэхийг “лорелей”, “Хайнрих Хайне” гэсэн нэрийг “Хейнрих Хейне” гэж ташаа галиглах жишээтэй.

Одоо нэгэнт цаг өөр болж, манай хүмүүс олон оронд сурах бүрэн боломжтой болсон тул яруу найргийг аль болох эх зохиолоос нь орчуулах нь зүйтэй юм. Харин сайн орчуулагч болохын тул төрөлх хэлээ сайн эзэмших, босгоо монгол бичгээр бичсэн өвөг дээдсийн бичгийн өв их соёлоос хүртэх хэрэгтэй ажээ.

Ашигласан эх хэрэглэгдэхүүн:

- Gedichte von Goethe, Schiller... Nazagdorsh, Galsan
- Г.Аким, Яруу үгт, утга сайт бичиг
- Ш.Марсар, Орос яруу найраг дахь угсаа-соёлын нэрийн холбогдолтой зүйлийг орчуулах тухайд
- А.Цэрэнчулуун, Нэр томъёог оновчтой хэрэглэх нь сайн орчуулгын нэг үндэс
- Г. Элдэв –Очир, Буруу орчуулгаас үүдсэн буруу нэршилийн асуудал
- Ш.Сүрэнжав, Хятадын эртний сонгодог шүлгийн орчуулгын зарим асуудалд
- Н.Оюунзаяа, Монголын орчуулгын онолын уламжлал

- М.Чимэдцэеэ, “Улсыг засах жараахай шарах хоёр адилхан” Харин амархан уу? Хэцүү юү?
- Ц.Дамдинсүрэн, Олег цэцний орчуулгын тайлбар
- Б.Ринчен, Шүлэг орчуулах эрдэм
- А.Шархүү, Яруу найргийн орчуулгад шүлгийн ур хийцийг нь дамжуулах асуудалд
- Г.Элдэв-Очир, Соёлын утгыг орчуулах арга зам
- Н.Нансалмаа, Соёл хоорондын харилцаа ба орчуулга
- Г.Сайнбаяр, Үндэсний онцлогтой үг хэллэгийн орчуулгын асуудалд
- Д.Ундрах, Монголын түүхэнд холбогдох нэгэн баримт бичгийн орчуулгын тухайд
- Ш.Чоймааа, Монгол бичгийн хэлний орчуулга
- М.Чимэдцэеэ, Соёл хийгээд орчуулга
- Орчуулга зүй сэтгүүл № 1, № 2, № 3
- Орчуулга, хэлмэрчлэхүйн тухай бусад материал
- Google. De
- Google. Mn

Б.ЯВУУХУЛАНГИЙН “ТУУЛЫН ШУГУЙ” ШҮЛГИЙН АНГЛИ БОЛОН ОРОС ОРЧУУЛГЫН УТГА ДҮЙЛГЭЦ

Н.Оюун-Ундраа²⁰² (МУИС, ШУС)

Н.Оюунзаяа²⁰³ (МУИС, ШУС)

Товч утга: Энэхүү өгүүлэлдээ Бэгзийн Явуухулангийн “Туулын шугуй” алдартай шүлгийн эхийг Саймоны англи орчуулга, Карпунины орос орчуулгатай жишиж тулгасан болно. Уг шүлгийн англи болон орос орчуулгыг монгол эх шүлэгтэй нь тулгаж задлан шинжилснээр монголоос англи руу орчуулах орчуулгын онолын зарчмын асуудлыг боловсруулах, практик үйл ажиллагааг сайжруулахад тус дөхөм үзүүлэх зорилготой юм.

Түлхүүр үгс: Утга зохиолын орчуулагч, орчуулгын онол, орчуулгын алдаа оноо, утга дүйлгэц, үг оноолт, уран яруу хэрэглүүр

Б.Явуухулангийн уран бүтээлд “Хүн төрөлхтөний оюуны урлагийн мөнхийн сэдэв болсон хайр дурлал, онгон сэтгэлийн дуулал нэгэн томоохон бүрэлдэхүүнт хэсэг болж байдаг”¹ –ийн тод жишээ бол “Туулын шугуй” шүлэг билээ.

Найрагчийн алдартай энэ шүлгийг “Туяа” сэтгүүлийн 1960 оны гуравдугаарт анх хэвлэж байжээ. Хэл бичгийн ухааны дэд эрдэмтэн Д.Ёндон энэ шүлэгт гарах “мөнгөн аяга шиг гар” гэсэн адитгалын талаар “...аяга гар хоёр гадна талаасаа төсөөгүй боловч ус устгах “үүргийн” нь талаас зарчмын хувьд адилтгаж болох тул уран сайхны үүднээс амжилттай адилтгал болжээ. Цааш нь “мөнхийн усыг уусан юм шиг танхил чамтай амьдрахсан” гэж уянгын баатрын эрхэм нандин хүслийг илэрхийлэхдээ нийтийн мэдэх домог үлгэрийн (мифология) ойлголтыг (мөнхийн ус) ашигласнаар уг шүлэгт бүр ч эрч нэмсэн байна”² гэж бичсэн байдаг.

БНСЧСУ-ын Братислав хотод словак хэлээр хэвлэсэн шүлгийн түүврийг энэ нэрээр хэвлэн гаргажээ. Шүлгийн бадгийн шадын тоогоор уг шүлэг нь дөрөвт шүлэг буюу катрен бөгөөд “монгол яруу найрагт маш эртнээс энэ дөрөвт шүлэг шүлгийн бадаглалын гол зүйл болж иржээ”³. Харин Саймон 2009 онд англи хэл рүү орчуулан “Mongolian verse, the collected poems of BegziinYavuuhan” (Монгол шүлэг, Бэгзийн Явуухулангийн түүвэр шүлэг) номдоо хэвлүүлэн гаргасан байна. Одоошүлгийн эхийг англи орчуулгатай нь тулгаж үзье. Энэ нь уг шүлгийн англи орчуулгын хоёр дахь хувилбар нь юм.

Шүлгийн эхний бадаг буюу

²⁰² МУИС, ШУС, ГХСТөвийн багш, докторант

²⁰³ МУИС, ШУС, ХУС-ын европ судлалын тэнхим, докторант

Туулайн гүйдэл шиг салхинд

Туулын шугуй найгана.

Уулын согоо шиг хүүхэнд

Хайрын сэтгэл дасна.- гэсэн мөрийг Саймон,

In the wind like the running of hares,

Sways the spinney on the Tuul,

And a loving mind becomes accustomed to the girls,

They are like mountain deer – гэж орчуулжээ. Хэрвээ эдгээр мөрийг

МОНГОЛЧИЛБОЛ,

Туулайн гүйлт шиг салхинд

Туул голын шугуй найгана

Дурласан бодол охидуудад дасна

Тэр охид маань яг уулын буга шиг – гэсэн үг юм.

“Туулайн гүйдэл шиг салхи” гэсэн уран дүрслэлийг Саймон туулайн гүйлт шиг салхи буюу the running of hares⁴ гэж утгачилан орчуулжээ. Энэ үг оноолт нь утгын хувьд сайн дүйцэж байна гэж хэлж болохоор байна. Б.Явуухулан гуай шүлэгтээ салхиний хурдыг туулайн гүйдэлтэй зүйрлэж хэлсэн бол англи хэлэнд ч мөн адил энэ зүйрлэлтэй утга дүйцэхүйц, бас л туулайтай холбон салхийг дүрсэлсэн сонгодог зүйрлэл байдаг байна. Айсан туулай шиг салхи буюу the wind like a scared rabbit⁵ гэж хэлдэг байна. Гэхдээ шүлгийн эхийг хадгалах, манай үндэстний сэтгэлгээний ялгаатай, онцлог талыг илтгэн харуулах мөн англи хэлэнд шүлгийн эхэд байгаа тэр чигээр нь буулгахад ойлгомжтой байгаа учраас the wind like a rabbit’s hop буюу туулайн дэгдэлт (харайлт) шиг салхи гэж орчуулахад буруудаад байх зүйлгүй мэт.

Ийм нийлэмж үгийн утга нь шалтгаан болон үүсэх дагалдалын холбоотой байдаг. Манай монгол хэлэнд шууд үр дагалдалаар илэрхийлсэн байхад англи хэлэнд шалтгаанаар нь дүрслэн хэлжээ. Өөрөөр хэлбэл айсан туулай дэгдээд алга болох нь ойлгомжтой юм.

Уулын согоо шиг хүүхэн –гэсэн уран дүрслэлийг They (the girls) are like mountain deer буюу тэр охид маань яг уулын буга шиг гэж оноосон байна. Согооуг нь буга гэдэг амьтны эм хүйстэйг нь хэлдэг байтал Саймон яагаад ч юм охидыг эр бугатай зүйрлэн хэлсэн нь хүйсний хувьд ч тэр гоо сайхны тал дээр ч тэр огт авцалдахгүй оноолт болжээ. Уг нь англиар согоог doe гэж хэлдэг. Ер нь согоо гэдэг амьтнаар оросууд бүсгүй хүний гуалиг бие галбир эсвэл шалмаг хурдан шинж чанарыг зүйрлэж хэлдэг бол францчууд сайхан бүсгүйг согоотой зүйрлэдэгжээ.

Мөн хайрын сэтгэл гэдэг хоршоо үгийг дурласан бодол (оюун санаа) гэж оноосон нь бас л хачирхалтай санагдаж байна. Яагаад сэтгэл гэдэг үгийг заавал бодол (оюун ухаанаар) адил утгатай болгон орчуулсныг үг оноолтын хувьд оновчтой болсон гэж хэлэх аргагүй байна.

Хайр гэдэг сэтгэл болохоос ухаан биш. Харин хайрын сэтгэл дасна гэсэн мөрийг a loving mind becomes accustomed to the girls буюу дасах гэдэг үгийг becomes accustomed to гэж оноожээ. Үгийн сангийн шууд утгаараа энэ үгс нь дасах, зохицох гэсэн үг мөн боловч энэ тохиолдолд заавал иймэрхүү хэтэрхий

өргөн дэлгэр нийтлэг хэрэглэгддэг, жижүүрийн үгсийн оронд арай өөр үгээр, энэ утгыг илүү сайхан гаргаж чадах, хүний хайр дурлалын эмзэг нарийн мэдрэмжтэй холбоотой утга зохиолын хэрэглээний үгээр оноож болох мэт санагдана. Ийм утга бүхий үгс англи хэлэнд маш олон байдаг.

Ер нь англи хэлэнд зөвхөн хайрлах дурлах мэдрэмжтэй холбоотой боловч утга болон хэрэглээний хувьд нарийн ялгаатай, хайрын хүч эхэндээ сул юм уу хүчтэй, цаг хугацааны хувьд богино юм уу урт удаан хугацааны турш үргэлжилсэн, түр зуурын сонирхол шохоорхол, ая талтай байх, таалагдах, таалж эхлэх, сэтгэл татагдах, дур булаах, сэтгэл алдрах, дурлах, сэтгэл дасах, цагийн эрхээр дасан дурлах, сэтгэлийн жолоо алдрах, хөл алдан гүйх, унаж үхэх, араас нь гүйх, дурлалын гал юмуу оч асах юмуу бадрах, галзууртлаа дурлах, ухаан сүнсгүй дурлах, дурлалдаа шатах, дурлалдаа сохрох, мансуурах, нүдний цөцгий мэт хайрлан хамгаалах, нандигнах, шүтэн бишрэх, урхидах, илбэдэх, (санаатай) дурлуулах, эргүүлэх, сээтэгнэх, өдөх, хоргоох гэх мэт утга санааг илэрхийлсэн хуучирсан болон орчин цагийн хэрэглээний зөвхөн зөвхөн үйл үг гэхэд зуу гаруй байна.⁶

Тэгэхдээ дээрхи үгсээс энэ тохиолдолд хамгийн сайн тохирох үг нь дасан дурлах гэдэг утга бүхийнийлэмж үгс болох *wrapped up in*⁷ байж болно.

Одоо харин Г.Карпунин⁸ энэ шүлгийн эхний бадагийг яаж орчуулсныг эх шүлэгтэй нь тулгаж үзье.

Эхний бадгийг Карпунин,

Птичьи веселые речи,

Ласковые ветерки...

Наши далекие встречи

В роце у Толы-реки.

Милая, только отказом

Ты мое сердце не рань.

Вот оно замерло разом,

Как боязливая лань – буюу монгол хэлнээ орчуулбал,

Шувууны хөгжилтэй шулганаан

Ялдам сэвэлзүүр салхи

Туул голын шугуй дахь

Бидний эртний уулзалтууд

Хонгор минь, татгалзаж л

Зүрхийг минь битгий шархлуул

Үргэмхий согоо шиг

Зүрх минь яг зогсох гээд байна – гэсэн байна.

Түүний орос орчуулгын энэ хувилбарыг “Туулын шугуй” шүлгийн орчуулга гэж хэлэхэд үнэхээр бэрхтэй ажээ. Осолтгүй л, Туулын шугуйд болсон ч юм шиг, болж байгаа ч юм шиг үйл явдлын тухай өгүүлж байвч, эх шүлгийн гол утга санаатай дүйцэх ганц ч мөр үүнд алга байна. Мөн эх шүлгийн нэг бадаг нь дөрвөн мөрөөс бүтсэн катрен шүлэг байсан боловч Карпунины орос орчуулгад хоёр дахин их мөр буюу найман мөр болон сунжирчээ.

Хоёрдугаар бадаг буюу,

Хээрийн салхинд Туул минь

Тахийн зоо шиг бидэрлэнэ.

Хайрын хүчинд сэтгэл минь

Тэнгэрийн заадас шиг гэрэлтэнэ –гэсэн мөрийг Саймон,

Speckled in the strong winds,

My Tuul is like a wild takhi,

And my mind shines like the horizon

With the power of love –буюу монголчилбол,

Хүчтэй салхинд бидэртэн

Миний Туул яг зэрлэг тахь шиг

Хайрын хүчинд миний бодол

Тэнгэрийн заадас шиг гэрэлтэнэ –гэж англи хэлнээ орчуулжээ.

Дээрхи орчуулгаас харахад эхний мөрөнд байгаа *хээрийн салхийг* Саймон хүчтэй салхи, гуравдугаар мөрөнд байнаа *сэтгэл* гэдэг үгийг мөн л mind буюу оюун бодол гэсэн утгатай болгон өөрчилжээ. Харин эхний хоёр мөрийн утга нь *Хүчтэй салхинд бидэртэн, Миний Туул яг зэрлэг тахь шиг байна* болж хувирсан байна. Өөрөөр хэлбэл, эх шүлэгт Туул голын бидэрлэхийг тахийн зоотой зүйрлэсэн бол орчуулган дээрээ тахийн зоо гэдэг утга нь гээгдэн шууд тахьтай зүйрлэн орчуулжээ. Уг нь энэ дүрслэлийг to speckle like the spines of a takhi гэж буулгаж болно. Мөн тахь гэдэг амьтан уулаасаа зэрлэг тул wild гэдэг үг илүүц болсон байна. Гурав болон дөрөвдүгээр мөрний тухайд сэтгэл гэдэг үгийн оноолт л байж боломгүй эсрэг утгаараа ончгүй оноогдсон л болохоос бусад үгийг шууд үгсийн сангийн утгаар нь оноож, эх шүлгийн утгыг ч мөн гажуудалгүй яг л тэр хэвээр нь буулгаж чадсан байна.

Карпунин энэ бадгийг,

Не проживу ни минуты

Я без тебя под луной.

Милая, ну почему ты

Так поступаешь со мной!

Солнце вдали догорает,

Вьются туманов дымки.

Сердце мое замирает

В роце у Толы-реки –буюу хэрвээ эдгээр мөрийг монгол руу

орчуулбал,

Саран дор би чамгүйгээр

Нэг мөч ч амьдарч чадахгүй

Хонгор минь, чи яагаад

Надтай ингээж харьцана вэ!

Алсад нар шингээж байна,

Манан будан хуйларч байна.

Туул голын шугуйд

Зүрх минь яг зогсох гээд байна –гэсэн байна.

Түүний орчуулга хэлбэр дүйлгэцийн хувьд эх шүлгийнхээс хоёр дахин урт болж сунжрахдаа утгын хувьд ч тэр эх шүлэгт огт байхгүй шинэ санаа түрэн

орж иржээ. Өөрөөр хэлбэл, орчуулгад зайлшгүй баримталбал зохих эх шүлгийн гол утга санаа ул мөргүй устаж, цоо шинэ шүлгийн бадаг орос хэл дээр бичигджээ гэж хэлэхээс өөр аргагүй байна.

Гуравдугаар бадаг буюу,

Гүнзгий амьсгаа авмаар

Тал шиг бүсгүй чи юм

Гүнд нь хангинах дууны

Эгшиг нь миний сэтгэл юм –гэсэн мөрийг Саймон,

You are a woman like the steppe,

You would breathe deeply,

And my mind is a song's

Melody, ringing in the depth –буюу монгол руу орчуулбал,

Чи бол тал шиг бүсгүй

Чи гүнзгий амьсгаа авдаг.

Гүнд нь цуурайтах дууны аялгуу нь

Миний бодол юм –гэсэн байна. Орчуулгаас харахад эх шүлгийн эхний хоёр мөрөнд байгаа гүнзгий амьсгаа авмаар, тал шиг бүсгүйг шууд тал газартай нь бүсгүйг адилтган, тиймээс л тэр бүсгүй нь гүнзгий амьсгаа авдаг гэсэн утгатай болгон, эх шүлгийн санааг гуйвуулж орчуулжээ. Уг нь шүлгийн зохиогч эдгээр мөрөөрөө хайртай бүсгүйнхээ гоо сайхныг шүүрс алдам гэсэн далд утгаар илэрхийлж байгаа болов уу. Өөрөөр хэлбэл гүнзгий амьсгаа авмаар байгаа “хүн” нь дурласан хархүү нь болохоос сайхан бүсгүй нь өөрөө биш юм.

Харин сүүлийн хоёр мөрний утга, сэтгэл гэдэг үгийг л *my mind* буюу оюун бодол болгож орчуулснаас өөрөөр эх шүлгийн утгыг гажуудуулсан зүйл огт алга байна. Мөн цуурайтах гэдэг үгийг *to ring* буюу утга зохиолын хэллэгээр дуу нь хадах, хангинах гэдэг үгээр оноосон нь тун оновчтой болжээ. Энэ бадгийг Карпунин яаж орос хэл рүү орчуулсан болохыг эхтэй нь тулгаж үзье. Тэрээр энэ бадгийг,

Ты превзошла красою

Все луговые цветы,

Только, увя, добротою

Не отличаешься ты.

Солнце вдали догорает,

Вьются туманов дымки.

Сердце мое замирает

В роце у Толы-реки –буюу монголчилбол,

Гоо үзэсгэлэнгээрээ чи

Нугын бүх цэцэгсийг ч хол давжээ.

Гэвч харамсалтай нь чи

Сайхан сэтгэлээрээ ялгарсангүй.

Алсад нар шингээж байна.

Манан будан хуйларч байна.

Туул голын шугуйд

Зүрх минь зогсох гээд байна—гэж орчуулсан байна.

Өөрөөр хэлбэл, Карпунины энэ бадгийн орчуулга нь мөн л бусад бадгуудыг орчуулсантай яг адил эх шүлгийн утгыг үндсээр нь өөрчлөн өөрөө зохиож бичжээ.

Ер нь сайн орчуулагч хүн сайн уран бүтээлч байдаг болохоор хэлбэрийн хувьд эх шүлгийн хэлбэрт баригдалгүй орчуулах тохиолдол байдаг. Үүний нэгэн тод жишээ нь академич Ц.Дамдинсүрэн гуайн орчуулсан “Олег цэцний дуулал” юм. Ц.Дамдинсүрэн гуай энэ орчуулгынхаа талаар “миний санаанд үгийг нэмж хасах гайгүй хэрэг, утгыг нэмж хасвал гэмтэй хэрэг. Үг ба өгүүлбэрт халдаж болно, гол утгад халдаж болохгүй” гэж үзээд “Олег цэцний дуулал”-ын хэв журмыг яаж орчуулснаа тайлбарлажээ. “Монголын ямар шүлгээр орчуулахаа шийдэхийн тулд нэгэнтэйгүүр орос эх шүлгийг хянан үзэж аль тохирохыг нь шилж олох хэрэгтэй байсан” гэж тайлбарласан нь гадаад хэлнээс шүлэг орчуулахад хоёр хэлний шүлгийн тогтолцоог харьцуулан судлахын чухлыг өгүүлсэн зарчмын чухал ач холбогдолтой тайлбар юм.

Орчуулагч уншигдах байдлыг нь ажиглаад “уншихад амархан, хоолойд саатахгүй гарч байна” –гэсэн дүгнэлт хийгээд энэ байдлыг хадгалж орчуулах нь чухал гээд “хөнгөн амархан шүлэг болгохын тулд нэг талаас мөрийг богино болгох, нөгөө талаас утгыг бүрэн орчуулахын тулд мөрийг урт болгох хэрэгтэй” гэж үзсэн байна.

Ингээд “нэг мөрийг хоёр болговол нэг талаас шүлэг богино хөнгөн болохоос гадна утгын багтац уужим болно” –гэсэн дүгнэлт хийгээд эл зарчмаар орчуулснаа тайлбарлажээ. Нэг ёсондоо нэг мөрийг хоёр болгож, мөр бүрд гурван үгээр орчуулсан байдаг байна.⁹

Гэхдээ ийнхүү орчуулахдаа эх шүлгийн гол утга санааг хэвээр нь хадгалж буулгадаг. Түүнээс биш эх шүлгийн гол утга санаанд халдаж өөрийн дур зоргоор өөрчлөн гуйвуулах өсгүй билээ.

Дөрөвдүгээр бадаг буюу,

Мөнгөн аяга шиг гараас чинь

Туулын уснаас амсах юмсан.

Мөнхийн усыг уусан юм шиг

Танхил чамтай амьдрахсан –гэсэн мөрүүдийг Саймон,

I would taste the waters of the Tuul

From your hand, like a silver cup,

And I would live with you, you who are fragile

As though drinking the waters of eternity –буюу монголчилбол,

Мөнгөн аяга шиг гараас чинь

Туулын усыг би амсмаар байна.

Мөнхийн усыг уусан юм шиг

Эмзэгхэн чамтай хамт амьдармаар байна –гэж орчуулжээ.

Эхний мөрөнд байгаа Туулын усыг the waters of the Tuul гэж усыг олон тоон дээр бичсэн байна. Ер нь англи хэлэнд ус юм уу шингэн зүйлийг ширхэгчлэн тоолдоггүй, савалсан саваар юм уу литрээр хэмжиж шингэний хэмжээг тодорхойлдог. Гэхдээ тодорхой нэг гол мөрөн, нуур далайн усыг waters гэж ялангуяа утга зохиолын орчуулгад олон тоон дээр бичдэг. *Мөнгөн аяга шиг*

гар гэдэг уран дүрслэлийг *From your hand, like a silver cup* буюу Мөнгөн аяга шиг гар (өрөөсөн) гэж орчуулсан байна. Уг нь энэ уран дүрслэлийн утга нь логик талаараа чгэсэн бүсгүй хоёр гараа хумбайлган нийлүүлж байж мөнгөн аяга шиг бөөрөнхий хэлбэртэй болгох гэсэн санаа юм. Орчуулагч энэ мөрийн утгыг сайн ойлгоогүйгээс ийм алдааг хийсэн байна. Түүнээс биш өрөөсөн гар дангаараа мөнгөн аяга шиг гүйцэд бөөрөнхий дугуй хэлбэрийг үүсгэх ямар ч аргагүй, тэр тусмаа *cup* нь сэнжтэй юм уу сэнжгүй гонзгой аягыг хэлдэг. Тиймээс аягыг *cup* бус *bowl* гэж орчуулсан бол монгол мөнгөн аяганы хэлбэртэй илүү адилхан болох байсан.

Гуравдугаар мөр буюу мөнхийн усыг уусан юм шиг гэсэн мөрийн үгийн сангийн шууд утгаар нь орчуулсан учраас эх шүлгийн утгатай яв цав таарч байна. Гэхдээ ийнхүү орчуулснаараа англи хэлэндээ гаж буруу ойлгогдох эсвэл үл ойлгогдох зүйл огт байхгүй учраас оновчтой сайн орчуулсан гэж үзэж бүрнээ болох юм.

Харин хамгийн сүүлчийн мөр буюу *Танхил чамтай амьдрахсан* гэсэн мөрийг *I would live with you, you who are fragile* буюу Эмзэгхэн чамтай би хамт амьдармаар байна гэж орчуулсан нь хэдийгээр утгын хувьд ойролцоо юм шиг боловч шүлгийн шадын урын тал дээр үлбэгэр сул, хэт сунжирч, хэмнэл алдагдан бусад мөрнөөсөө сондгойрсон байна.

Ерөөс танхил гэдэг үгийг эмзэгхэн, бяцхан, хөөрхөн сайхан бие галбиртай юм уу царайтай гэсэн утгатай *fragile* гэдэг үг сонгон оноосон нь утгын хувьд гажих зүйлгүй тохирч байгаа мэт боловч энэ тодотгож байгаа тэмдэг нэрийг хэл зүйн дүрмийн дагуу байршлын хувьд шууд тухайн бүсгүй хүний өмнө тавьж *fragile you* гэсэн хоршоо үг үүсгэж болдоггүйд л хамаг учир оршино. Ер нь англи хэлэнд биеийн төлөөний үгийг тэмдэг нэрээр тодотгож бичиж болдоггүй. Тиймээс бүхэл бүтэн тодотгол гишүүн өгүүлбэр оруулж ирж бичсэнээс уг мөр хэт их сунжирчээ. Гэтэл үнэн хэрэгтээ заавал ийм сунжруу найруулгаар бичих шаардлага огт байхгүй юм.

Англи хэлэнд танхил чамтай гэсэн утгатай ойролцоо утгаар хонгор минь, янаг минь, хайрт минь гэсэн утга бүхий *my sweetheart, my baby, my love* гэх үгсээр орчуулчихаж болохгүй зүйл огт байхгүй мэт санагдана. Яагаад гэвэл эдгээр үгсийн аль алинд нь энхрийлж хайрласан, өхөөрдөж эрхлүүлсэн, өнгө аяс бүгд л агуулагдаж байна. Эсвэл, *you, the fragile one*—буюу чи, эмзэгхэн хөөрхөн нэгэн—гэж найруулж бичиж бас болно. Тэгвэл энэ шад хэлбэр дүйлгэцийн хувьд бусад шадтайгаа адил хэмнэлтэй, нэг хэмжээнд байж чадах байсан болов уу.

Харин Карпунин энэ бадгийг,

Сладкая в речке водица,

Нету подобной в других.

Славная, дай же напиток

Мне из ладоней твоих!

Солнце вдали догорает,

Вьются туманов дымки.

Сердце мое замирает

В роце у Толы-реки—буюу монголчилбол,

Голын амтат ус

Үүнтэй адил нь хаана ч байхгүй

Хонгор минь алганаасаа

Энэ уснаас уулгуулаач

Алсад нар шингэж байна.

Манан будан хуйларч байна.

Туул голын шугуйд

Зүрх минь яг зогсох гээд байна –гэж орчуулсан байна.

Бусад бадгуудын орчуулгатай харьцуулбал энэ бадагт ямартаа ч эх шүлгийн утгатай ойролцоо дөхүүдүү хоёр мөр орж ирж байна. Гурав болон дөрөвдүгээр мөр дээр *Хайрт минь чи алганаасаа энэ усыг уулгаач* буюу гарнаас ус уух гэсэн санааг гаргасан байна.

Бусад мөрийн утга нь эх шүлгийн утгаас дэндүү хол байна. Мөн эх шүлэг дээр эхний бадагийг тавдугаар бадаг болгон давтаж хайрцагладаг. Гэтэл Карпунин эхний бадгийг үүнтэй адил зүгээр нэг давтсангүй, харин эхний дөрвөн мөрийг өөрийнхөө бичсэн эхний дөрвөн мөрийн утгаас огт өөр болгон өөрчилж, харин дараах дөрвөн мөрийн эхний хоёр мөр нь эхний бадгийн мөрүүдтэй ойролцоо утгатай боловч арай өөр маягаар илэрхийлж зөвхөн гурав болон дөрөв дэх мөрийг л сүүлчийн бадгийн төгсгөлд давтаж оруулсан байна.

Тэрээр энэ бадгаа,

Милая, там, где упали

Светлые капли воды,

Дети весной побежали

И зашумели сады.

Птичьи доносятся речи,

И шелестят ветерки

Наши далекие встречи

В роще у Толы-реки –буюу монголчилбол,

Хонгор минь усны гэрэлт дусал

Унасан тэр газарт

Хавар хүүхдүүд гүйлдэж

Цэцэрлэг шуугилаа

Шувууны шулганаан сонсдож байна.

Салхи сэржигнэж байна.

Туул голын шугуй дах

Бидний эртний уулзалтууд –гэж зохиомжлон бичжээ.

Б. Явуухулан “Яруу найргийн орчуулгад эрхэмлэвэл зохих дөрвөн зүйл бий.

- а) Санааг тод буулгах
- б) Дүр зураглалын өвөрмөцийг хадгалах
- в) Шүлгийн аяс хөгжмийг хадгалах
- д) Шүлгийн хэлбэрийг хадгалах хэрэгтэй. Би шүлэг оруулахдаа үүнийг баримталдаг. Сонет хэмээх арвандөрвөн мөртийг гучинхоёр мөр болгон орчуулсан гэдэг яриа бий. “Рубаи” гэдэг дөрвөн мөртийг найман мөр болгож болохгүй. Цагаан шүлгийг ч

гэсэн мөрийг ньгээлгүй, нэмэлгүй орчуулах хэрэгтэй. Хэрвээ орчуулагч өөрийн дураар загнавал зохиогч нь зохиолоо эргээд танихгүйд хүрнэ.”¹⁰ гэж нэгэнтээ хэлжээ. Тэгвэл тэрвээр Г. Карпунин өөрийнх нь “Туулын шугуй” шүлгийг орос хэл дээр хэрхэн орчуулсаныг олж уншаад шүлгээ мөн эсэхэд эргэлзэж, таньж ядах байсан байхдаа л гэж өөрийн эрхгүй бодогдоно.

ДҮГНЭЛТ

Англи орчуулга нь орос орчуулгыг бодвол эхтэйгээ илүү ойр болсон боловч орчуулгын уран сайхны талаасаа учир дутагдалтай байгаа нь хэт үгчлэх хандлага давамгайлж байсантай холбоотой бөгөөд үүгээр ч үл барам шүлгийн шадын хэмнэл доголдолтой, мөн ташаа ойлгож орчуулсан зүйлс, оновчгүй зүйрлэл ч уг орчуулгад гарч ирж байна. Орос орчуулга нь эх шүлгийн утгаас дэндүү хол байгаа нь орос орчуулагч нь өөрөө монгол хэл мэдэхгүй, зөвхөн орос хэлтэй монгол хүмүүсийн тааруухан хийсэн хадмал орчуулга баримтлан орчуулж байснаас улбаатай болов уу. Тиймээс орос орчуулга нь эх шүлгийн орчуулга бус харин тухайн орчуулагчийн зохиомжилсон шинэ шүлэг болжээ гэж үзэж байна. Харин шүлгийн утга дүйлгэцийг үл хэрэгсэн, зөвхөн хэлбэр дүйлгэцийн талаас нь авч үзвэл Карпунин Саймоныг бодвол төрөлхийн шүлгийн мэдрэмжтэй, авьяаслаг уран бүтээлч болох нь зохиомжлон бичсэн шүлгийн шадын жигд нугалбар, гишгэдэл алдаагүй тэгш хэмнэл, айзамлаг сүүл холбоц, сүүл холбоцыг мөр сөөлжүүлсэн зэргээс харахад илт байна.

Ишлэл, зүүлт

¹ Б. Явуухулан Түүвэр зохиол, УБ., 1985 он, хуудас 501-502

² Яруу найргийнуран чадварын асуудалд, “Монголын утга зохиолын судлал шүүмжлэл” УБ., 1981 он, хуудас 88-89 дэх тал

³ С. Дулам, Ц. Хасбаатар, “Уран зохиолын онолын үүд”, УБ., 1980 он, хуудас 188

⁴ Simon Wickham Smith, *Mongolian verse, the collected poems of BegziinYavuuhan*, УБ., 2009

⁵ *Thesaurus*

⁶ *Thesaurus*

⁷ *Thesaurus*

⁸ Из Монгольской поэзии XX века, М., 1981

⁹ Ц. Сүхбаатар –Шүлгийн орчуулгыг шүнишлэе, УБ., 2006 он, хуудас 6-7

¹⁰ Орчуулах эрдэм I, УБ., 1972 он, хуудас 119

¹¹ Н. Оюун-Ундраа, Н. Оюунзаяа, *Сувдан дуслын хэлхээс-I*, УБ., 2008 он, хуудас 54-55

Ашигласан ном

- 1.Б. Явуухулан, Түүвэр зохиол, УБ., 1985 он
2. Яруу найргийн уран чадварын асуудалд, “Монголын утга зохиолын судлал шүүмжлэл” УБ., 1981 он
3. С. Дулам, Ц. Хасбаатар, “Уран зохиолын онолын үүд”, УБ., 1980 он
4. Simon Wickham Smith, Mongolian verse, the collected poems of Begziin Yavuuhulan, УБ., 2009
5. Thesaurus
- 6.Из Монгольской поэзии XX века, М., 1981
7. Ц. Сүхбаатар –Шүлгийн орчуулгыг шүнишгэлэе, УБ., 2006 он
8. Орчуулах эрдэм I, УБ., 1972 он
9. Н. Оюун-Ундраа, Н. Оюунзаяа, Сувдан дуслын хэлхээс-I, УБ., 2008 он

Summary

In this article, the author compared Mongolian original of the well-known poem “Where was I born” of BegziinYavuukhulan to English translation by Simon Wickham Smith and Russian translation by L.Bukina. Comparing only third, fourth and fifth stanzas of the poem, she touched upon some critical points of their work while mentioning their advantages as the same time and suggested some possible versions of translations of those literary work.

ХАВСРАЛТ:

Туулын шугуй

Translated by N.Oyun-Undraa

The grove of the Tuul

*In the wind like a rabbit's hop
The grove of the Tuul is swaying.
In the dame like a mountain doe
My loving heart is wrapped up.
In the wind of the wild, the Tuul
Speckles like the spines of a takhi.
With the power of love, my poor soul
Gleams like the horizon of sky.
You are a dame like the steppe
To be willingly taken a deep breath.
My soul is the music of the song
That's echoing in the depth of it.
I'd love to sip the water of the Tuul*

*From your hands like a silver bowl.
I'd like to live with you, my sweetheart
As if I drank the waters of eternity.
In the wind like a rabbit's hop
The grove of the Tuul is swaying.
In the dame like a mountain's doe
My loving heart is wrapped up*

НЭГЭН ШҮЛГИЙН ДӨРВӨН ОРЧУУЛГЫГ ШҮҮН ТУНГААХАД

М.Амартайван²⁰⁴ (UBU их сургууль)

Түлхүүр үг: солонгос шүлэг, монгол орчуулга, шүлгийн орчуулга, орчуулгын харьцуулал, орчуулга ба эх

МУ, БНСУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосноос хойш хорь гаруй жил улиран өнгөрчээ. Энэхүү хугацаанд хоёр орны улс төр, эдийн засаг, нийгэм соёлын харилцаанд багагүй ахиц дэвшил гарсан билээ. Ялангуяа солонгос хэлнээс монголоор, монгол хэлнээс солонгосоор гуравдагч хэл дамжилгүйгээр зохиол бүтээл орчуулцгааж эхэлсэн нь тун олзуурхууштай. Монгол хэлнээс “Монголын нууц товчоо”, “Гэсэр”, “Жангар”-аас эхлээд “Тунгалаг тамир” роман, “Учиртай гурван толгой”, орчин үеийн зохиол бүтээлээс Г.Аюурзанын “Цасны роман”, “Бөөгийн домог”, мөн Б.Лхагвасүрэнгийн шүлгийн түүвэр “Шад шүлэг хуулаагүй яваа шүү” нэрээр орчуулагдан солонгос уншигчдын гарт очжээ. Үүнээс гадна цөөнгүй ном бий. Харин солонгос хэлнээс “Хон Гилдон нэрт шастир”, “Чүнхянг бүсгүйн домог”, “Солонгос үндэстний үлгэр домог”, “Солонгосын шилдэг өгүүллэгийн дээжис”, “Одой хүний хөөргөсөн бяцхан бөмбөлөг”, “Манай ангийн овгор”, “Би бол чи юм” гээд чамгүй жагсаалт болохоор зохиол бүтээл монгол хэлээр орчуулагдан хэвлэгджээ.

Монголын шүлгээс И Анна²⁰⁵, Квон Сонхүн²⁰⁶ нар орчуулж солонгосын яруу найргийн сэтгүүлд хэвлүүлж танилцуулж байсан бол солонгос шүлгийн хэд хэдэн түүвэр монголоор орчуулагдсанаас Квон Сонхүн, Д.Дамба нарын орчуулсан “Солонгосын орчин цагийн шүлэг (тэргүүн дэвтэр) (2005)”, “Орчин цагийн Солонгосын шүлэг (дэд дэвтэр) (2007)”, И Аннагийн орчуулсан “Солонгосын шилдэг тавин шүлэг” (2006) түүврийг онцлон дурдъя. Харин нэг зохиолчийн түүврээс Ким Суволын шүлгийн түүвэр Д.Нармандахын орчуулгаар “Агарууны цэцэг (2010)” нэртэй хэвлэгдсэн байна. Квон Сонхүн бичихдээ эхний түүвэрт 39 шүлэг, дэд дэвтэртээ 49 шүлгийг хөрвүүлэн өргөн барьж байна гэсэн бол, Д.Нармандах яруу найрагч Ким Суволын Солонгост хэвлэгдсэн шүлгийн түүврээс түүвэрлэн хөрвүүлээ гэсэн байна. Орчуулгын түүвэрт дугаарласнаас нь үзвэл тэрээр Ким Суволын 46 шүлгийг орчуулжээ.

²⁰⁴ UBU их сургууль, багш

²⁰⁵ Орчуулгын түүвэрт И Ан На гэж галигласан байгаа.

²⁰⁶ Орчуулгын түүвэрт Квон Сон Хүн гэж галигласан байгаа.

Солонгосын орчин үеийн яруу найрагт хүндтэй байр эзэлдэг яруу найрагч Ким Суво(1902-1934)-ын Жиндаллэ²⁰⁷ цэцэг гэдэг шүлгийг мэдэхгүй солонгос хүн гэж бараг байхгүй. Шүлгийн солонгос эхийг дор сийрүүлэв.

진달래꽃

김소월

나 보기가 역겨워
가실 때에는
말없이 고이 보내 드리오리다.

영변(寧邊)에 약산(藥山)
진달래꽃
아름 따다 가실 길에 뿌리오리다.

가시는 걸음 걸음
놓인 그 꽃을
사뿐히 즈려 밟고 가시옵소서.

나 보기가 역겨워
가실 때에는
죽어도 아니 눈물 흘리오리다.

Энэ шүлгийг солонгосоор мэдэх монгол хүн ч олширч байгаагийн сацуу хэд хэдэн хүний орчуулгаар монголчуудад танил болж байгаа тул тэдгээр орчуулгад утга санаа хэр буусан, солонгос эх шүлгийнх нь онцлогийг сайтар тусгасан эсэх талаар эргэн харах цаг болсон санагдлаа. Иймд уг шүлгийн дөрвөн орчуулгыг уншаад, орчуулгыг нь шүүн тунгаая.

Хурц улаан цэцэг

Даль цэцэг²⁰⁸

Ким Со Вөл

Ким Су Вол(1902-1935)

Намайг харахаас дургүй чинь хурдэг болохоор
Нааш гэхгүй дуугүй л явуулъя.

Намайг хараад үзэн ядаж
Явахад тань
Дув дуугүйхэн явуулъя аа

Йөнбөний Ягсан уулын хурц улаан цэцэгээс
Тэвэр тэврээр аян замд чинь цацна.

Ёнбён нутгийн Яг ууланд
Даль цэцгийг

Алхам алхамдаа тэр бутарсан цэцгийг
Аажим аажим гишгээд яваарай.

Тэвэр тэврээр түүж явах замдаа цацалъя
аа

Намайг харахаас дургүй чинь хурдэг болохоор
Наана чинь яасан ч, би хамар шархирахгүй.

Алтан тутамд
Тавигдсан тэрхүү цэцгийг

²⁰⁷ Энэ цэцгийн нэрийн тухай тусгайлан өгүүлнэ.

- Орчуулагч “Даль цэцэг” гэсэн үгийг зүүлт тайлбараар “жиндаллай” гэж бас бичсэн байна.

Солонгосын орчин цагийн шүлэг (тэргүүн дэвтэр), Квон Сон Хүн, Д.Дамба орч., УБ, 2007, 19-р тал

Аяар аяар гишгэн яваарай
Намайг хараад үзэн ядаж
Явахад тань
Үхсэн байлаа ч нулимс унагахгүй ээ.

Солонгосын шилдэг тавин шүлэг²⁰⁹, И Ан На орч., УБ дээд сургууль, Солонгос судлалын төв, 2006, 8-р тал

Агарууны цэцэг

Намайг хараад
Нүүр буруулан явахад тань
Нэг ч үг хэлэлгүй үдэж өгье дөө
Ён голын эрэг, Яг уулын
Жиндальлэ(агарууны) цэцэгсийг
Тэвэр тэврээр
Явах замд тань
Яруухан дурсгал болгон дэвсэж өгье дөө
Алхам бүрт тааралдах тэрхүү цэцэгсийг
Алгуур алгуур гишгэлэн яваарай
Намайг хараад
Нүүр буруулан явсан болохоор
Насан эцэслэсэн ч нулимс унагахгүй ээ.

Солонгос хэлнээс дуун хөрвүүлсэн
Д.Нармандах, найруулан зассан Д.Наваан

Улаан ягаан цэцэг

Харц буруулаад явахад тань
Харамлахгүй таныгаа явуулна.

Тэнгэрийн доорх уулнаас
Тэвэр дүүрэн цэцэг түүгээд
Одох зам дээр тань
Олбог мэт дэвсье.

Урагилах бүрт тань таарах
Улаан ягаан цэцэгсийг
Зөөлөн гэгч нь гишгэлээд
Зүглэсэн чигтээ яв даа.

Нүүр буруулаад явахад тань
Нулимсаа яасан ч урсгахгүй, би.

Орчуулсан М.Амартайван

Эхний орчуулгын тухайд түүврийн эхэнд²¹⁰ “Солонгос хэлнээс орчуулж хэвлэлд бэлтгэсэн Квон Сон Хүн, Д. Дамба” гэснээс үзвэл цуг орчуулсан бололтой. Гэхдээ энд товчлон Квон Сонхүнийн орчуулга гэх болно. Түүнчлэн түүврийн “Танилцуулга” хэсэгт Д.Дамба “... солонгос хэлний үг найруулгын өвөрмөц бүтцэд баригдалгүй монгол хэлний үг, үгийн сангийн шидээр уянгалаг найруулах, оноох, дүйлгэхийг хичээсэн болно” гэсэн байна. Иймд нэлээд утгачилж орчуулсан байж болзошгүйг анхааръя. Харин орчуулагч И Анна 2002 онд монголын яруу найрагчдын шүлгүүдээс түүвэрлэн солонгосоор орчуулж “Монголын орчин үеийн шүлгийн цоморлиг” нэрээр хэвлүүлж байсан бөгөөд, энэ удаа солонгос шүлгийг монгол уншигчдад хүргэхээр сэтгэл шулуудаж, “Аливаа шүлэгт тухайн улс үндэстний оюун сэтгэхүй, ухамсар, зан заншил, сэтгэлгээний өвөрмөц онцлог бүрэн шингэсэн байдаг. Яруу найраг шүлгийг орчуулж хэвлүүлэх нь хүн хүнээ, нэг улс үндэстэн нөгөө улс үндэстнээ улам илүү ойлгож ойртоход сайн дөхөм зууч болно... Яруу найргаар дамжуулан хоёр үндэстний тал бүрийн харилцаа улам илүү элгэмсэг хайр хүндэтгэлийн халуун

²⁰⁹ Хянан тохиолдуулсан Д.Сумъяа

²¹⁰ Квон Сон Хүн, Д.Дамба, Солонгосын орчин цагийн шүлэг (тэргүүн дэвтэр), УБ, 2007

сэтгэлийн харилцаагаар хөгжсөөсэй гэж хүсч байна”²¹¹ гэжээ. Ийнхүү орчуулагч нарын үгийг дурдсаны учир гэвэл солонгос шүлгийн утга санааг бүрэн дүүрэн буулгаж орчуулах гэсэн чин хүсэлтэй байжээ гэдгийг харуулах гэснийх билээ.

Солонгос орчин цагийн шүлгийг ойлгохын тулд, орчуулагч Квон Сонхүн орчуулгын түүвэртээ *“Солонгосын орчин цагийн шүлэгт японы түрэмгийлэл(1910-1945), Солонгосын дайн(1950-1953), түүнчлэн хагас зууны турш дарангуйлалд туйлдан шаналсан ард түмний зовлон зүдгүүр, шаналал дунд соёолсон ариун хайр, аз жаргалтай шинэ амьдралыг мөрөөдсөн чин хүслийг тэр чигээр нь буулган дүрсэлсэн байдаг”*²¹² гэж тайлбарласныг уншихад илүүдэхгүй биз ээ.

Орчуулсан он цагийг авч үзвэл Квон Сонхүн, И Анна нар 2000 он гаргаад, Д.Нармандах, М.Амартайван нар 1990-ээд оны сүүлээр орчуулжээ. Гэхдээ эдгээр орчуулагч нэг нэгнийхээ орчуулгыг уншиж, засаж дэлгэрүүлсэн гэж болохгүй бөгөөд, тус тусдаа орчуулсан ажээ.

Дээр дурдсан шүлгийн түүврүүдэд хэвлэгдсэн орчуулгууд бүгд солонгос эхтэйгээ байгаа нь эхтэй нь тулгаж үзэх хүмүүст ихээхэн тустай болжээ. Харин Д.Нармандахын орчуулсан түүвэрт солонгос эхийн бадгийн хооронд сул мөр үлдээгээгүй нь эх шүлгийн хэлбэрийг алдагдуулсан тул харамсалтай санагдана. Орчуулгадаа ч бадгийг сул мөрөөр зааглалгүй, шүлгийн төгсгөлд ганц цэг тавьж, нэг л өгүүлбэр байгаа мэт бичсэн байна. Дөрвөн орчуулгаас эх шүлгийн хэлбэрийг хамгийн сайн хадгалсан нь И Аннагийн орчуулга юм.

Ц.Дамдинсүрэн нэгэнтээ, *дэлхий дахинаа ихэд алдаршсан гурван зүйлийн шүлэг буйн дотор франц, польш зэрэг хэлний шүлэгт шүлгийн мөрийн доторх эгшигийн тоог тэнцүүлнэ. Үүнд урт эгшиг, богино эгшиг гэж ялгаварлахгүй*²¹³ гэжээ. Солонгос шүлгийг ч энэ ангилалд багтааж болмоор санагдана. Солонгос үсгээр ерөнхийдөө урт эгшиг тэмдэглэдэггүй бөгөөд, уртаар дуудах зарим нэг үг, үе байх боловч өргөлт байхгүй. Иймд шүлэг найрагт нэг шатад орсон үгийн тоо, үг бүтсэн үеийн тоо чухал үүрэгтэйгээс гадна түргэн удаан дуудаж элдэв өнгө аясыг илэрхийлдэг.

Шүлгийн хэлбэр хэмжээг үзвэл Ким Суволын энэ шүлэг солонгосын ардын дууны айзам хэмнэлийг хадгалсан шүлэг бөгөөд, нэг шаддаа 7 юм уу 5 үе бүхий 3 өлмийт шүлэг юм. Бас эхний болон эцсийн бадгийн эхний хоёр шад давтагдаж, нэг хоёр дөрөвдүгээр бадаг сүүл холбосон байна. Шүлгийн өлмийг ташуу зураасаар, 3 дахь өлмийг давхар ташуу зураасаар, харин үеийг хаалтанд тоогоор тэмдэглэж үзүүлбэл:

²¹¹ Солонгосын шилдэг тавин шүлэг, И Ан На орч., УБ дээд сургууль, Солонгос судлалын төв, 2006, Оршил

²¹² Квон Сон Хүн, Д.Дамба, Орчин цагийн Солонгосын шүлэг (дэд дэвтэр), УБ, 2007, 173-р тал.

Солонгос хэлнээс орчуулан хэвлэлд бэлтгэсэн Квон Сон Хүн, Д. Дамба, хянан тохиолдуулсан Б.Дулмаа. Энэ хоёр дахь түүвэрт солонгос шүлгүүдийг “төрсөн нутаг, хайр сэтгэл, эх орон” гэсэн бүлгүүдэд хуваан танилцуулснаараа шинэлэг болжээ.

²¹³ Ц.Дамдинсүрэн, Олег цэцний орчуулгын тайлбар, Орчуулах Эрдэм-2, УБ, 1972, 58-90-р тал

① 나 보기가/ 역겨워/(7)

가실 때에는/(5)

말없이/ 고이 보내/(7) 드리우리다.// (5)

③ 가시는 / 걸음 걸음/(7)

놓인 그 꽃을/(5)

사뿐히/ 즈려 밟고 /(7) 가시옵소서.// (5)

② 영변에/ 약산/(5)

진달래꽃/(4)

아름따다/ 가실 길에/ (8=7) 뿌리우리다.// (5)

④ 나 보기가/ 역겨워/(7)

가실 때에는/(5)

죽어도/ 아니 눈물/(7) 흘리우리다.// (5)

Хоёрдугаар бадаг 5 ба 4, 8 ба 5 гэсэн үетэй байгаа боловч солонгост шүлэгт ганц хоёр үеийн зөрүү зөвшөөрөгддөг. Учир юу гэвэл 5 үеийг 7 үе, 4 үеийг 5 үе, 8 үеийг 7 үетэй мэт уншсанаар хайртыгаа явуулж байгаа бүсгүйн сэтгэлийг тод томруун илэрхийлсэн гэж үздэг. Шүлэгт хайртыгаа харамлахгүй явуулна гэж өгүүлж байгаа ч бүсгүйн сэтгэл үнэндээ явуулахыг хүсэхгүй байгаа. Иймд хоёрдугаар бадгийн эхний хоёр шадыг сунжруулж дуудсанаар хайртаа явуулахгүй юм сан гэсэн санаа, харин гурав дахь шадын эхний хоёр өлмийг түргэн дуудсанаар яаран одож байгаа хайртынх нь алхааг дүрсэлж өгүүлэгчийн харууслыг улам тодотгосон гэж тайлбарладаг.

Б.Ринчен шүлэг орчуулах эрдмийн талаар “Монгол орчуулгад европын сүүл холбосныг толгой холбож ч болно. Тэгэхдээ эх шүлгийн сүүл холбосон журмы нь бас монгол уншигчдаа толилуулан уг яруу найрагчийн тэр холбох онцлогийг нь гээн хаялгүй, яруу найргийн бас нэг арга барил нь болох тул түүний нь үзүүлж, зохиолын онцлог сониныг нэвтрүүлэх хэрэгтэй... Уншигч олонд европ зүгийн шүлгийг монголоор орчуулахад, ямар ямар зохион байгуулалт хэмжээ журам байдгаас гол тоймтой хэдэн зүйлийг таниулах нь шүлгийн орчуулга үзээд, ямар шаардлага орчуулагчид тавих ёстой вэ гэдгээ мэдэхэд нь хэрэгтэй бас муу орчуулгыг хаахын нэг зүйл болно...”²¹⁴ гэж өгүүлсэн байдгаас үзвэл гадаад шүлгийг эх хэлнээ орчуулахдаа уг гадаад шүлгийн бүтэц, хэмжээ зэрэг хэлбэрийн талыг бас орхигдуулж болохгүй ажээ. Тэгээд ч “Олег цэцний дуулал гэх мэтийн орчуулга аятайхан мэт үзэгдэх боловч олон улсын орчуулгын зарчмын үүднээс үзэхэд цаад зохиогчийн санаа нь байхаас шүлгийн зохион байгуулалт, бүтэц нь байхгүй санаанаас бусад нь цөм орчуулагчийн өөрийн зохиол бөгөөд уг зохиолчид падгүй зүйл болжээ”²¹⁵ гэж хатуухан дүгнэсэн нь бий.

Үүнээс үзвэл Ким Суволын шүлгийн бүхий л онцлогийг тусган харуулахад бэрх байлаа гэхэд тоймтой хэдийг нь буюу шүлгийн бадаг ба шадын хэлбэр, сүүл холбоцыг тусган орчуулах боломжтой бөгөөд, орчуулагч И Анна чухамхүү ингэж орчуулж чаджээ. Бадаг шадын хэлбэрийг хадгалж, эхний бадгийг “явуулъя аа”, хоёр дахийг “цацалъя аа”, дөрөв дэхийг “унагахгүй ээ” гэж төгсгөсөн байна. Харин эхний гурван бадгийг цэглэж төгсгөсөн бол илүү сайн байж дээ гэж бодогдоно.

²¹⁴ Б.Ринчен, Шүлэг орчуулах эрдэм, Орчуулах Эрдэм-2, УБ, 1972, 91-99-р тал

²¹⁵ Дээрх өгүүлэл

За одоо шүлгийн агуулга, зарим үг хэллэгийг хэрхэн орчуулсныг үзье.

Цэцгийн нэр: Жиндаллэ

Шүлгийн дөрвөн орчуулгад шүлгийн нэрийг “Хурц улаан цэцэг”, “Улаан ягаан цэцэг”, “Даль цэцэг”, “Агарууны цэцэг” гэж дөрвөн янзаар орчуулсан байна. Даль цэцэг үү, агарууны цэцэг үү? Хурц улаан уу, улаан ягаан уу? Хөлөнбуйр хотод Хурц улаан цэцгийн баяр 5-р сард болдог ажээ²¹⁶. Энэ хурц улаан цэцэг нь жиндаллэ боловч ягаан өнгөтэй байгааг сайтаар нь зочлоод гэрэл зургаас харж болно. Тэгэхээр Өвөр Монголд хурц улаан цэцэг гэдэг байлаа гэхэд Монгол Улсын иргэд “хурц улаан” гэхээр ув улаан, час улааныг л төсөөлөх нь гарцаагүй. Намар хурц улаан болдог юм болов уу гээд зураг сэлтээс үзэхэд зөвхөн навч нь улайдаг ажээ.

Жиндаллэ цэцгийг ургамлын тольд юу гэж тайлбарласныг үзье.

Солонгосын Эх хэлний хүрээлэнгийн Солонгос хэлний дэлгэрэнгүй тайлбар толь бичигт²¹⁷: *Жиндаллэгийн овгийн навчит сөөг. 2-3м өндөр, 4-р сард улаан ягаан дэлбээ нь навчнаас түрүүлж ургадаг. Үр жимс нь 10-р сард боловсорч гүйцдэг. Уулын энгэр газар ургана. Солонгос, Япон, Хятад, Монголд тархсан. (Rhododendron mucronulatum)*

Солонгосын портал сайт Нэйвер нэвтэрхий тольд²¹⁸: *Салхитай сүүдэр газар бага зэрэг хатааж эмчилгээнд хэрэглэнэ. Цэцгийн дохиур бага зэрэг хорттой учир тасдаж хаях хэрэгтэй. Ericaceae-гийн овог, Латин нэр нь Rhododendron mucronulatum Turcz. var. Mucronulatum, Цэцэглэх үе 4-р сарын эх. 50-2,000м өндөр уулын энгэрт зонхилон ургадаг. 4-р сарын эхээр навч нь ургахаас өмнө хурц ягаан, хааяа бүдэг улаан ягаан дэлбээ дэлбээлдэг онцлогтой. Голдоч нь 3-4.5см орчим болдог гэсэн байгаа бол,*

М.Шагдарсүрэн, Ургамлын толь(латин-орос-монгол), УБ, 2010²¹⁹ -д: *Ericaceae DS тэрэлжгэнэтэн, Rhododendron L. Тэрэлж, Rhododendron mucronulatum угтуул тэрэлж*

Ж.Батхүү, Ч.Санчир нар, Монгол орны ашигт ургамлын зурагт лавлах, УБ, 2003²²⁰ -д: *Ericaceae Далийн овог, Rhododendron aduricum L. Дагуур тэрэлж, Орон нутгийн нэр: даль, далийн ягаан, тэрэлж, сурнаг, Түвэд нэр: da-lis(даль), Үндсэн шинж: Цэцэг хурц, ягаан, голдочоороо 2.5-4 см, навчлахаасаа өмнө дэлгэрнэ. Шилбэ нь үсэрхэг 10 дохиуртай. Цэцэглэж үрлэх хугацаа: 4-5-р сар, Тархац: Хөвсгөл, Хэнтий, Хангайн тойрог гэжээ.*

²¹⁶ <http://zmyhw.gov.cn/> Дундад Монголын найрамдлын сүлжээ

²¹⁷ 표준국어대사전 <http://stdweb2.korean.go.kr/> Солонгос хэлний дэлгэрэнгүй тайлбар толь бичиг

²¹⁸ <http://terms.naver.com/> [네이버 지식백과] 진달래(약초도감 2010.7.5, (주) 백사)

²¹⁹ Монгол гадаадын нийт 135 овог, 951 төрөл, 3262 зүйл, үүнээс 107 гадаадын төрлийг хамруулсан бөгөөд орос, монгол, нэрийн бүгд хэлхээсийг тэдгээр хэлний цагаан толгойн үсгээр толгойлж толийн ард хадаж оруулсан нэр томъёоны толь. Ургамлын монгол нэрийг урьд өмнө хэвлэгдсэн монголын болон гадаадын эрдэмтдийн толь бичгийг сайтар нягтлан ашиглажээ.

²²⁰ 227 зүйл эмийн ургамлын нэрийг оруулжээ. Ургамлын латин ба монгол нэр, орон нутгийн нэр, түвэд нэр, үндсэн шинж, цэцэглэж үрлэх хугацаа, тархалт, ургах газрын орчин нөхцөл, химийн найрлага, эмийн түүхий эд, монголын болон дорно дахины уламжлалт анагаах ухаанд хэрэглэх нь гэсэн дарааллаар товч, тодорхой өгүүлэхийг зорьсон байна.

Нэг овогт олон цэцэг ургамал багтдаг учраас тухайн тольд орсон цөөн хэдэн нэрээр баримжаалахаасаа латин нэр томъёогоор буюу шинжлэх ухааны нэр томъёогоор хөөж үзэх нь илүү үнэнд ойр болно. Тэгэхээр жиндаллэгийн латин нэр *Rhododendron mucronulatum*. Үүнтэй дүйж байгаа монгол нэр нь “угтуул тэрэлж” болж таарлаа. Гэхдээ энэ нь далийн овгийн цэцэг бөгөөд, орон нутагт даль, далийн ягаан, тэрэлж гэж нэрлэдгийг харгалзвал “Даль цэцэг” гэсэн нэр зөв ажээ.

Харин Д.Нармандахын орчуулсан “агаруу”-г Ж.Батхүү, Ч.Санчир нар, Монгол орны ашигт ургамлын зурагт лавлах 2, УБ, 2005²²¹-д: *Cupressaceae Агарууны овог, Juniperus sabina L. Хонин арц, Орон нутгийн нэр: арц, Түвэд нэр: shugtser(шүгцэр), Үндсэн шинж: Газраар зулж дэвсэн ургадаг, үнсэн саарал холмостой, мөнх ногоон сөөг* гэж тайлбарлажээ. Иймд агаруу бол яавч биш боллоо.

Газар усны нэр: Ёнбөнийн Ягсань уул

Орчуулагч нар энэ нэрийг “Ёнбөний Ягсан уул”, “Ёнбөн нутгийн Яг уул”, “Ён голын эрэг, Яг уул” гэж орчуулжээ. Энд галиглах аргын зөрүүг эс тооцон өгүүлбэл, Ёнбөн *영변군(寧邊郡)* бол Умард Пён-ань мужийн зүүн өмнөд орших Ёнбөн-гүн(гүн нь Монголын “сум”-тай дүйх засаг захиргааны нэгж) юм. Ким Суволын шүлэгт гарч байгаа Ёнбөнийн Ягсань ууланд хавар цагт жиндаллэ цэцэг дэлгэрч уул хадыг бүрхдэг ажээ. Яруу найрагч Ким Суво Пён-ань мужид төржээ. Харин Д.Нармандахын Ён гол гэж орчуулсан нь Ён-ган *영강(穎江)* буюу Умард Гёнсан мужийг дамнан урсдаг голтой андуурсан бололтой. Газрын нэрийг нягтлаагүйгээс ийм алдаа гаргажээ. Ён голын эрэг гэх бол Ёнган-бён *영강변* гэх учиртай.

“Яг уул”, “Ягсан уул” гэсэн хоёр хувилбарын тухайд миний ажсанаар нэг үет уул, гол, дүүргийн солонгос нэрийн ард орсон “уул, гол, дүүрэг” гэсэн утгатай солонгос үг “-сань, -ган, -гү”-г хэвээр залгаж хэлээд монгол хэлний “уул, гол, дүүрэг” гэж үгээр тодотгох нь зүйтэй мэт санагдана. Тухайлбал Яг уул гэхээр “яг уул шиг” гэсэн утгатай болчих вий гээд Ягсань уул гэвэл, Нам уул гэхээр “намхан уул” гэх ухагдах вий гээд Намсань уул гэвэл монгол хэлтнүүдэд илүү түргэн, зөв ойлгогдох болов уу. Гэхдээ Яг уул, Нам уул гэх нь буруу гэж үзэж болохгүй.

Толгой холбоц ба илүү үг

Ц.Дамдинсүрэн монгол шүлгийн онцлогийг өгүүлэхдээ, “Монголын одоо цагийн шүлгийг үзвэл толгой холбох, хэмжээг тохируулах хоёрыг үндэс болгоно. Бас мөр зэрэгцүүлэх гэдэг нэгэн чухал зүйл бий. Гэвч толгойг холбохгүй, хэмжээг эрхэмлэх ба хэмжээг эрхэмлэхгүй толгой холбон зохиож болно. Энэ хоёулыг хайхрахгүй, гагцхүү мөр зэрэгцүүлэх ёсыг үндэслэн зохиож бас болох

²²¹ Энэ номд 210 зүйл ургамлыг оруулжээ.

мэт. Хэрэв энэ гурван зүйлийн алиныг ч хэрэглэхгүй шүлэг зохиох юм бол ийм зохиолыг шүлэг гэж нэрийдэх баримтгүй болно”²²² гэсэн байдаг.

Дээрх дөрвөн орчуулгыг үзэхэд И Анна толгой холболгүй, сүүл холбосон бол бусад нь бүрэн ба хагас толгой холбож орчуулжээ. Толгой холбоц төдийлөн хэрэглэдэггүй солонгос шүлгийг монгол уншигчид зориулж монгол шүлгийн ёсоор толгой холбож орчуулахыг буруутгаж болохгүй боловч зарим талаар эх шүлгийг хэлбэр хэмнэлийг эвдэх нь зохисгүй байж болох юм. Гэвч Ц.Дамдинсүрэн “Ямарваа шүлэгт, ямарваа утга зохиолд хүний сэтгэлийг хөдөлгөх чадал бий. Энэ нь уран зохиолын гол сүнс болно... Энэ сэтгэлийг хөдөлгөх чадлыг нь эрхбиш орчуулах хэрэгтэй. Шүлгийн үг өгүүлбэр ба хэв журмыг хэдийгээр нарийн нягт орчуулж чадавч энэ сэтгэлийг хөдөлгөх чадлыг орчуулж эс чадвал амьд мориог үхсэн мориор арилжсантай адил болно”²²³ гэж өгүүлсэн нь нэгэнт монгол хүн унших учраас монгол хүнд шүлэг гэж ухагдахаар, утгыг голлож сэтгэл хөдөлгөх чадлыг нь гаргахад илүү анхаарах буруу биш гэсэн үг юм.

Нөгөөтээгүүр толгой холбосноор эх шүлэгт байхгүй үг хэллэг нэмэгдэж, үг хэллэгийн түвшинд үндсэн утгаас зарим үед нэлээд холдож байгаа тал байна. Тухайлбал, Нармандахын орчуулгад “Явах замд тань Яруухан дурсгал болгон...” гэжээ. Энд “яруухан дурсгал болгон” гэсэн хэллэг эхэд огт байхгүй. Харин миний бие оюутан байхдаа уг шүлгийг орчуулсан бөгөөд, шүлгийн нэрээс гадна шүлэгт гарч байгаа газар усны нэрийг өөр үгээр илэрхийлсэн билээ. Жишээ нь, “даль цэцэг”-ийг солонгос англи, англи монгол толиос дамжуулж харахад “азали” гэж гадаад үг гарч ирсэн, нь шүлгийн нэр болгоход тохиромжгүй гэж үзэж цэцгийн өнгөөр төлөөлүүлж илэрхийлсэн бөгөөд, “Ёнбёнийн Ягсан уул” гэснийг тэр чигээр нь орчуулахад монгол уншигчдын сэтгэл хөдөлгөх чадал буурах вий гэж эмээж “тэнгэрийн доорх уул” болгон орчуулсан юм. Тэгээд зогсохгүй “одох зам дээр тань” гэсэн мөрийг сондгойруулах гэж “олбог мэт” гэсэн илүү үг нэмж, “зөөлөн гэгч нь гишгэлээд” гэсэн мөртэй хослуулж “зүглэсэн чигтээ” гэж нэмж орчуулсан. Бас шүлгийн эхний болон сүүлийн бадгийн эхний мөр эх шүлэгтээ ижил боловч толгой холбохын тулд эхний бадагт “харц буруулаад одоход” гээд, харин сүүлийн бадагт “нүүр буруулаад явахад” гэж утгын хол зөрүүгүй өөр илэрхийлэл ашигласан. Тус орчуулгад толгой холбосноос үүдэн шүлгийн үндсэн хэлбэр алдагдсан мэт харагдавч мөрүүдийг,

Харц буруулаад явахад тань / Харамлахгүй / Таныгаа явуулна.

Тэнгэрийн доорх уулнаас тэвэр дүүрэн / Цэцэг түүгээд / Одох зам дээр тань олбог мэт дэвсье.

Урагшлах бүрт тань таарах / Улаан ягаан цэцэгсийг / Зөөлөн гэгч нь гишгэлээд зүглэсэн чигтээ яв даа.

Нүүр буруулаад явахад тань / Нулимсаа яасан ч / Урсгахгүй, би.

²²² Ц.Дамдинсүрэн, Олег цэцний орчуулгын тайлбар, Орчуулах Эрдэм-2, УБ, 1972, 58-90-р тал

²²³ Дээрх өгүүлэл

гэж хуваавал эх шүлгийн хэлбэрийг ерөнхийдөө хадгалсан мэт харагдахаар байна. Адагт нь “би” үг нэмснээр төгсгөлийг хатуу болгохгүй, эхний бадагтай хэмнэл тааруулахыг хичээсэн билээ.

Оновчгүй үг хэллэг

Хоёр дахь бадгийн нэг ижил илэрхийллийг монголоор орчуулахдаа Квон Сонхүн “аян замд чинь цацна”, И Анна “явах замдаа цацалъя” гэсэн бол Нармандах “явах замд тань дэвсэж өгье” гэжээ. Солонгос шүлэгтээ хүндэтгэл хэрэглэсэн байгаа учраас “чинь” гэхээсээ “тань” гэх нь зүйтэй. Түүнчлэн “явах замдаа” биш “явах замд тань” гэсэн утгатай байгаа. Явж байгаа хүнийг хүндэтгэн хандаж байгааг бодвол “цацах” биш “дэвсэх” нь арай дээр болов уу.

Гурав дахь бадгаас И Аннагийн орчуулгад эх шүлгийн үгийг махчилж “тавигдсан цэцэг” гэж орчуулсан нь тун зохимжгүй болжээ.

Шүлгийн эцсийн мөрөнд солонгосоороо бол “үхсэн ч нулимс урсахгүй” мөн боловч “хэрхэвч нулимс унагахгүй” гэсэн санаа. “Үхсэн ч” гэсэн илэрхийлэл И Аннагийн орчуулгын гоо сайхныг гутааж уу гэлтэй. Энэ мөрийг Квон Сонхүн “хамар шархираахгүй” гэсэн байна. Монгол хүн “хамар шархирахгүй” гэхээс “хамар шархираахгүй” гэж ярьж бичдэггүй санагдана. Тэгээд ч энэ илэрхийлэл нэг л тохиромжгүй. Харин Нармандах “насан эцэслэсэн ч нулимс унагахгүй” гэсэн нь бас л эвгүй болжээ. Учир юун гэвэл эмэгтэй хүн, тэр тусмаа өөрийгөө “насан эцэслэсэн ч” гэж хэлэхгүй шүү дээ.

За ингээд дөрвөн орчуулгыг эхтэй нь тулгаж, зарим талаар хооронд нь харьцуулж үзлээ. Тус өгүүлэлд солонгос шүлгийн дөрвөн орчуулгын талаар өгүүлэхдээ тэр нь сайн, энэ нь муу гэж үнэлж дүгнэхээс илүү орчуулагч болгон өөр өөрийн арга барилаар орчуулж байгааг уншигч олон анхаарах хэрэгтэйн сацуу орчуулагч нарын хувьд шүлгийн үг илэрхийллийн утгыг анхаараад утга бүхий хэлбэрийг эвдэх биш, бас утга бүхий хэлбэрийг хадгалж байгаа нь гээд үг илэрхийллийн утгыг холдуулж хөндийрүүлэлгүй аль алийг тэнцүүхэн гаргаж эх шүлгийн сэтгэл хөдөлгөх чадварыг орчуулгад ч аль болох бүрэн тусгахын төлөө оюун бодлоо шавхаж, ур чадвараа сайжруулахыг хичээн мэрийх нь зүйтэй болов уу, санаа авах зүйл байваас аваасай гэж бодсон юм.

Солонгос шүлгийг монголоор орчуулж байгаа нийтлэг хандлагыг ажиглахад хэлбэрийг монголжуулах аястай байгаа тул М.Саруул-Эрдэнэ “Сонирхолтой хэл шинжлэл” номдоо *“Үнэнч эхнэр дээр үү, сайхан эхнэр дээр үү? Ямар зорилгоор орчуулж байгаагаасаа шалтгаалаад, давс хужрыг нь тааруулсхийгээд л хөрвүүлэх хэрэгтэй болов уу. Үлгэрлэвэл “үнэнч эхнэрээ жаахан будаад гоодчих” нь л шилдэг сонголт бололтой... Гэтэл сайхан монгол үг олж оноох гэж байж “будгийг нь ихдүүлээд” бүр танихын аргагүй юм болгочих гэм бий*²²⁴” гэснийг санаж шүлгийн орчуулгад үг утгыг харгалзахаас гадна уянга хэмнэл буюу шүлгийг шүлэг болгож, сэтгэлийг хөдөлгөгч хүчийг

²²⁴ М.Саруул-Эрдэнэ, Сонирхолтой хэл шинжлэл, Блүүмингтон, 2006, “Үгийн өвгөн утгын таяганд дулдуйдмой (Хэл шинжлэл ба орчуулгын онол)” хэсэгт

бас шингээж тусгахыг хичээх нь туйлын чухал болохыг эцэст нь улиглан давтъя.

Resume

Kim Sowol(1902-1934) is a Korean poet, whose most famous poem is “Azaleas”. There is an alternative translations are presented by some translators of this poem. Did they translate the meaning of poem exactly or did they reflected the form of this poem? It is hard to say one of this translation is good and others are bad. We have to know the translator’s knowledge and ability is not same and translation technique is different. But it is required translation have to include poem’s meaning and reflect poem’s form also.

Ашигласан ном:

Солонгосын орчин цагийн шүлэг (тэргүүн дэвтэр), Квон Сон Хүн, Д.Дамба орч., УБ, 2005, 18-р талд эх, 19-р талд орчуулга

Орчин цагийн Солонгосын шүлэг (дэд дэвтэр), Квон Сон Хүн, Д.Дамба орч., УБ, 2007

Солонгосын шилдэг тавин шүлэг, И Ан На орч., УБ дээд сургууль, Солонгос судлалын төв, 2006, 8-р талд орчуулга, эх

Ким Су Воль, Агарууны цэцэг, Д.Нармандах орч., УБ дээд сургууль, Мөнхийн үсэг, 2010, 6-р талд эх, 7-р талд орчуулга



Ж.Батхүү, Ч.Санчир нар, Монгол орны ашигт ургамлын зурагт лавлах, МУ-ын БОЯ, Жайка, УБ, 2003

Ж.Батхүү, Ч.Санчир нар, Монгол орны ашигт ургамлын зурагт лавлах 2, МУ-ын БОЯ, УБ, 2005



М.Шагдарсүрэн, Ургамлын толь(латин-орос-монгол), УБ, 2010

М.Саруул-Эрдэнэ, Сонирхолтой хэл шинжлэл, Блүүмингтон, 2006

Орчуулгазүй, дугаар 3, МУИС, Күнзийн институт, УБ, 2014



ОРЧУУЛГАЗҮЙН САН ХӨМРӨГӨӨС



ЭНЭТХЭГ ЯРУУ НАЙРГИЙН АМТ ҮНЭРИЙГ ҮЛДЭЭХСЭН ГЭЖ²²⁵...

Б.РИНЧЕН

Мянга таван зуу гаруй жилийн өмнө Энэтхэгт Галидаса гэдэг алдарт зохиолч гарч, түүний зохиол бүтээл нь одоо соёлт улс бүхний хэлэнд орчуулагдаж, дэлхийн уран зохиолын санд оржээ.

Галидасын насан төгөлдөр байсан тавдугаар зууны үес, Энэтхэгийн худалдааны хүмүүс, элдэв эрдэнэ, торго бөс, зааны соёо, элдэв үнэртэн амттан зүйлийг далбаат онгоцноо ачаад, их далайгаар аялан, баруун Европ тивд хүрч, арилжаа наймаа хийж, эртний их Ром улсын нийслэл Ром хотын ганган гоё хатагтай нар, тэр эрт дээр цагт Энэтхэгийн үнэртнээр биеэ сайхан үнэртэй болгож, Энэтхэг торго бөсийн зүйлээр чилгэр сайхан биеэ чимж байсан бол, монгол газар эртний Энэтхэгийн ховор сонин бараанаас гадна, Энэтхэгийн урлагийн зүйл, түүнийг бүтээх арга барил нь дэлгэрчээ. Эртний Ром улс хэдийн сөнөөд, гагцхүү хэл нь Европ зүгт шашин, шинжлэх ухааны зэрэг зүйлд латин хэл хэмээн XIX зууны үе хүртэл маш чухал үүрэг гүйцэтгэж ирснээр эртний Ром улсын бичиг судар зэрэг зүйлээс мянга таван зуу гаруй жилийн өмнө Энэтхэг улс, Европ, Ром улстай харилцаатай байсныг дундад эртний үес харилцаа тасарснаас хойш олж мэдсэн аваа, Монголчууд, тэр эртний харилцааг манжийн колоничлолд хүртэл, Энэтхэгийг сонирхсоор байсан тул, монголын уран зураг, уран баримал, уран цоолборлол, ардын хээ угалз, дуу хөгжим, уран зохиолд эртний Энэтхэгийн соёлтой харилцаатай байсан зүйл өдий төдий, өлзий утас, түмэн жаргалан, алхан хээ гэх зэрэг өнөөдөр ч манай ардын дунд ихэд дэлгэрч, монгол ардын хээ цгалз болсон зүйл, даруй Энэтхэг гарал үүсэлтэй бөгөөд, мянга таван зуу гаруй жил хэрэглэсээр монгол болсон, монголжсон зүйл болж, монгол ардын эртний соёлын өв уламжлалын зүйл болохоор барахгүй, монголчууд Сибирийн олон улс угсаатанд түгээн дэлгэрүүлжээ.

Энэтхэгийн бичгийн зохиол, аман зохиолоос монгол хэлэнд бууж, монгол болсон зохиол ч манай ардын аман зохиолд их бий. Энэтхэгийн яруу найргийн онол ч манай ардын аман зохиол нөлөө тусгал үзүүлсэн зүйл нарийн шинжлэн судлах монголч эрдэмтнээ хүлээсээр байгааг цухас тэмдэглэлтэй.

Бидний гарт буй бичгийн баримтаас үзвэл, арван долдугаар зууны сүүл, арван наймын эх хүртэл, Энэтхэгээс Гэснэ хааны алтан ширээний домог гэх мэт зохиолыг монгол болгож орчуулсан зүйлийг бодож үзэхэд, санскрид гэдэг Энэтхэгийн эртний бичгийн хэлийг монголчууд өрнө дахинд санскритын судалал бий болохоос хол өмнө судласаар ирсэн баримт олон гарна.

Баруун Европод Энэтхэг зохиолч Галидасын зохиолыг XVIII зууны сүүлээс орчуулан танилцацгаасан бол монгол бичгийн хүмүүс лав арван

²²⁵ Б.Ринчен “Марк Твений минь махы нь идэж дээ” эмхтгэн эрхэлсэн Г.Аким. 1991 он, 109-118 тал

дөрөвдүгээр зууны үеэс төвдөөр орчуулсан зүйлий нь үзэн сонирхож байсан гэдгийг баттай хэлж болно. Үүнд Галидасын «Үүлэн зардас» гэдэг яруу найраглалыг санскрид хэлнээс төвд хэлнээ (европоор Кашмирын гэдэг) Хачийн бандида их яруу найрагч Суманашри, төвдийн их хэлмэрч Жанчүбзэмү, Намхайсамбуу энэ гурван дуун хөрвүүлэгчид орчуулсныг тэр үеэс одоо хүртэл төвд хэл бичиг мэддэг монголчууд сонирхон үзэж, тэр үзсэнээ монголоор хэлэлцсээр ирсэн байна.

Чухам монгол бичигт «Үүлэн зардасыг» орчуулсан нь гэвэл, бидний мэдэхэд, XVIII зууны эхний хагасын сүүл хавьд төвдөөс орчуулсан нэгэн орчуулгыг Жанжаа Хутагт Ролбийдорж, Бээжинд хэвлэсэн монгол улаан шунхан Данжуурын хоёр зуун хорин тавдугаар ботид оруулжээ. Тэр данжуурт оруулсан орчуулгаас бас өөр эртний орчуулга ч байсан байж болзошгүйг Данжуурт Бодизарияавадарын эртний монгол орчуулга орсноор бодоход, Бодизарияавадарыг орчуулж байсан үеийн эртний монгол орчуулагч бичгийн эрдэмтэн, Галидасын тэр нэрт зохиолыг бас л андахгүй байсан нь мэдээж хэрэг.

Юу ч болсон, Галидасыг европ зүгийнхэн арван наймдугаар зууны сүүлээс нэрий нь сонсч, зохиолы нь европын санскридч эрдэмтний зуун алжаалаар олж сонирхсон аваас, монгол уншигч нар, тэр зохиолчийн нэрийг хүртэл бас монголоор орчуулан «Хар охин тэнгэрийн зарц» гэж нэрлэн хэлэлцэж, мөн Энэтхэг нэрий нь энэтхэг дуудлаганд их л ойрхноор Галидаса гэж нэрлэн хэлэлцэж «Үүлэн зардасыг» төвд монгол хоёр хэлээр үзэн сонирхсоор иржээ.

Орчин үеийн дэлхий дахины Энэтхэгч эрдэмтэн, санскридч эрдэмтэн цөм, эртний Энэтхэгийн дуун ухаан (оросоор лингвистика) сүрхий хөгжиж, Банини гэдэг Энэтхэгийн эртний хэл зүйчийн зохиосон хэл зүй, Дандин багшийн зохиосон яруу найргийн толь гэдэг яруу найргийн онолыг өндөр үнэлдэг үүнээ, тэр Банинийн хэлний зүй, Дандин багшийн яруу найргийн толийг монголчууд төвд монгол хоёр хэлээр үзэн судласаар хэдэн зуун жил болжээ. Үүнд: Галидасын «Үүлэн зардасын» хуучин монгол орчуулгыг үзэх хүн, Дандины яруу найргийн толийн монгол орчуулга барьж үзвэл, Энэтхэг яруу найргийн зүйрлэн дүрсэлсэн үг хэллэг зэргийг Энэтхэг яруу найраг судалдаг хуучин монгол яруу найрагч орчуулагч нар их хэрэглэж байсныг илэрхий үзэж болно. Жишээ нь, салхийг үнэр хөлөглөгч, үнэд хөлөглөгч (үнэд гэж олон үнэр гэсэн бөгөөд, ноход гэж олон нохойг, газад гэж олон газрыг хэлсэнтэй адил), зааныг хоёр уугч гэж, урдаар хошуугаараа нэг сорж, түүнийг амандаа тургижсорж уудгаар зүйрлэн нэрлэсэн нэр, уснаас төрсөн, уснаас ургасан гэж линхуя цэцгийг, зөгийг зургаан хөлт гэх зэргээр ёгт дүрслэл нэрээр зүйрлэн нэрлэсэн зүйл үлэмж бий.

Энэ дэвтэрт Данжуурын сүүлчийн шахуу ботид хэвлэсэн «Үүлэн зардас» гэдгийг тэр хэвээр нь сийрүүлэн хэвлэж, монголч эрдэмтний сонирхон үзэхэд зориулсан бөгөөд, гавж Эрдэнэпэл, монголч эрдэмтний анхдугаар их хуралд зориулан төвдөөс нь бас нэг орчуулга хийснийг хавсаргалаа. Эрдэнэпэл гуай Данжуурын тэр хуучин орчуулгыг шинжлэл судлал, монгол утга зохиолын судлалд оруулахыг санаачлан, хажуугаар нь бас өөрөө чингэж монгол судрын

үгээр дахин орчуулахдаа, нангиад (хятад) хэлнээс нөхөр Сагаражаваар бас нэг орчуулга хийлгэж хэвлэлд бэлдүүлснийг одоо нэгэн дэвтэр болгож, төвдөөс шинэ хуучин хоёр орчуулга, нангиадаас нэг орчуулга бэлдсэний дээр нь, миний бие 1943 онд Галигадаад (Оросоор Калькутта гэдэг хот) урлагийн магистр багш, хэл бичгийн ухааны доктор Гүмүдранжан Райн санскрид бангалын хэлээр нийтлэн, англи үргэлжилсэн үгийн орчуулга бадаг бүрд нь хадаж Сарадаранжан Рай тэмдэглэл хавсаргасан хэвлэлээс англи орчуулгыг баримталж, бас нэг орчуулга нэмж, Галидасын «Үүлэн зардасын» зохиолыг төвд, нангиад, англи гурван хэлнээс монгол болгосон дөрвөн монгол хувилбар орчуулгыг нэгэн дэвтэр болгож гаргалаа.

Англи үргэлжилсэн үгийн орчуулганд Энэтхэг эх зохиолын яруу найргийн зүйолэл хэллэгийг энгийн үгээр орчуулж, үнэр хөлөглөгч гэх мэтийг зүгээр салхи гэх зэргээр орчуулсан нь, Энэтхэг яруу найргийн тогтсон үгийг үл мэдэх хүнд хялбар дөхөм болгож, үг нэг бүрд түүний утгын тайлбар зүүхийг хэмнэсэн тул, монгол уншигч, англиас монгол болгосныг үзээд, төвдөөс тэр яруу найргийн нэрийг хэвээр монголчилж, түүнийг мэдэх уншигчид зориулснаас арай ойлгомжоор илүү дөхөм болох болов уу гэж үдшийн шөнөөр зав гаргаж, англиас монголчлохдоо Энэтхэг яруу найргийн зарим амт үнэрийг бас үлдээх юмсан гэж, ганц нэг газар хуучин монгол орчуулгын «Үнэр хөлөглөгч» гэх мэт нэрийг хэрэглэж, өөрийнхөө орчуулгад «Үүлэн зардас» гэж хуучин орчуулгын уламжлалыг баримталаа. Эрдэнэпэл гуай, шинэ орчуулгандаа «Үүлэн элч» гэж орчуулсан нь мөн зүгээр боловч энэ тухай би өөрийн орчуулгад урьдын орчуулагчдын уламжлал ба сонин юм гэж бодлоо.

Галидасын энэ «Үүлэн зардас» буюу «Үүлэн элч» нь санскрид буюу манайхны бас самгарди гэдэг Энэтхэгийн эртний бичгийн хэлээр «Мегадутам» гэдэг нэртэй. Төвдөөр нь манайхан «Бринжи понья» гэж дууддаг бөгөөд эл яруу найраглал янаг амраг, бат журмыг магтан дуулсан сайхан дуулал юм.

Түүнээ нэгэн ягшас гэдэг хүмүүн бус, цөлөгдөн зовж, янаг ханиасаа хагацаад, цмар зүг, хайртай амраг ханийн байгаа нутгийн чиг нүүж байгаа нэг үүл хараад, тэр үүлээр элч зару болгож, хайртай ханьдаа захиа мэдээ хүргэх гэж, амраг сэтгэлийнхээ үг захиа хэлсэн үүнд, ханиасаа хагацаан мөрөөдөгч тэр ягшас, эзэн тэнгэр Гувирaa буюу манайхан Намсрай гэдгийн зарлигаар нэгэн жилийн хугацаагаар цөлөгдөж суухдаа, үүлний умар зүг нүүн явах замыг үүгээр түүгээр, ийм тийм газраар өнгөрнө. Тэнд үлдэнэ, тэнд хононо. Тэгж хүрнэ. Тэхэд нь тэр хайртай хань нь тийм байдалтай байх бий гэж сэтгэлдээ бодсоны нь энэ яруу найраглалд үзүүлжээ. Тэхдээ Галидаса, эртний Энэтхэгийн яруу найргийн үг найруулгыг сайн мэддэгээр үл барам, энэтхэгийн бүх сонин сайхан үлгэр домог, домог судлалд гардаг зүйлийг хэрэглэж, үлгэр домогт гардаг эртний Энэтхэгийн тэнгэр сахиус, баатар зоригтон, домогийн элдэв сонин явдлыг дурдан, түүгээрээ уншигчийн сэтгэлд тийм явдалтай адил явдал, тийм баатрын тийм түүх шиг юм байна гэдэг сэтгэгдлийг төрүүлэх яруу найргийн арга хэрэглэжээ.

Зохиолд нь хэдийвээр ягшас мэтийн хүмүүн бусын зүйл гаравч, үнэндээ тэдний үйл явдал, зовлон жаргал нь яг хүмүүн төрөлхтний үйл явдал, хүний л

зовлон жаргалыг үзүүлжээ. Тэр ягшасын хайртай, тэнгэрийн ягшас охин, амраг нөхрөө хүсэн мөрөөдөхдөө, нөхрийнхөө хайртай бялзуухайтай үг хэлэлцэн, нөхрөө цөлөлгөнөөс буцаж ирэх хүртэл үлдсэн хоног хугацаагаар цэцгээр тоолон бодож суугаа нь, бас Энэтхэг эмэгтэйн ёсоор хагацан гашуудсаны тэмдэг болгож, үсээ ганц гээг болгож сүлжээд, хайртай хүн нь буцаж ирээд, хагацан салсан гашуудлын тэмдэг болсон ганц гөрлөө гэзгий нь задлаж, учран золгосны тэмдэг болгон, гашуудлыг тайлна гэж хүлээж суудаг нь, хүний л ёс шүү дээ, хайртай янаг сэтгэл, бат журамтайн л тэмдэг шүү дээ.

Эл яруу найраглалд үүлний явах зам дагуу газар орны байдлыг магтсан бадаг нь, эх орондоо хайртай тэр уран зохиолчийн эх орон, Энэтхэг нутгийнхаа сайхны нь магтсан магтаал шүү дээ.

Үүгээрээ «Үүлэн зардас» гэдэг яруу найраглал маш сонин сайхан бөгөөд, санскрид шүлгийн хэмжээ зохион байгуулалт нь:

— — — / — у у / у у у / — — у / — — у /

байдалтай боловч, би тэр хэмжээгээр нь хийж хараахан амжил болсонгүй. Эхэнд нь толгой холбон бичээд, хожим хойноо тэр бүр завдсангүй, хэвлэл ч удаашрахаас болгоомжлов. Гэвч энэ нэг зохиолыг гурван хэлнээс дөрвөн орчуулга хийснийг манай авьяас билигт яруу найрагч нар, дур сонирхол нь хөдөлж, зориг нь бадарвал, монголоороо дахин бүр чадалтай сайхнаар найруулахад нь тус дөхөм болох асан бол уу гэж горьдон, тэгвэл хуучин монгол орчуулагч нар, одоо төвд, хятад, англи гурваас хир хирээрээ орчуулсан Эрдэнэпэл, Сагаражав бид гурвын махарсан маань, оросын яруу найрагчид, европ хэлнээс Галидасын зохиолыг оросоор найруулсантай адил, монгол хэдэн орчуулгаас нийлүүлж нэг сайхан монгол найраглал болоход тус дөхөм болоосой гэж хүсэн горьдоно.

«Үүлэн зардасыг» монгол судрын үгийн орчуулганд эх гэж орчуулдаг үг, эцэг эхийн эхээс гадна, судрын хэлнээ бас эмэгтэй гэсэн утгатайг энд дурдалтай.

ХИЛЭНТ ЭЗЭН гэж Галидаса, Гүвираа буюу манайхан бас төвдөөр Намсрай гэж нэрлэдгийг өгүүлжээ. Монгол бичигт Намсрайг бас Энэтхэгээр нь Гүвираа гэдэг бөгөөд ардын аман зохиолд Найман Намсрай шиг баян гэж хэлэлцдэг зүйр үг бол, Энэтхэгийн домог судлалд (оросоор мифология), Гүвирааг умар зүгийг эзлэгч баялгийн эзэн гэдгээс үндсэлжээ. Энэтэг зураач нар, Гүвирааг ганц нүдтэй, гурван хөлтэй, найман шүдтэйгээр дүрсэлдэг, үүнд монголчууд Намсрайг эрдэнээр бөөлжигч ам цагаан хулгана гартаа барьснаар дүрсэлж, тэр эрдэнээр бөөлжигч ам цагаан хулгана гэдэг нь, европын домог судлалд «Элбэгийн эвэр» (оросоор «рог изобилия») гэж европоос орчуулдагтай утга санаа нэгтэй зүйрлэл.

ГҮНЖИЙН УГААЛД АРИУДСАН МӨРӨН гэж, Энэтхэг домогт Жанага хааны гүнж, тэр мөрөнд бие угааснаар мөрөн нь ариун болсон гэсэн домгоос иш татжээ.

РАМЫН УУЛ гэдэг нь, Рамгири ч гэж бас нэрлэдэг байсан бөгөөд одоо Нармада голын эхээр Амрагудын хавьд буй Рамагар уул гэж үздэг байна. Үүний урд тэр Рамын уулыг Нагпур хотоос хойш байдаг Рамтек уул болов уу гэж

Вильсон гэдэг хүний бодсоныг сүүлчийн энэтхэг шинжээчин арай биш гэж үзжээ.

ЭРДЭНЭСИЙН ЭЗНИЙ ДАГАГСАД гэж Намсрайн дагуул, түүний эрдэнийг сахигч ягшасыг нэрлэжээ. Энэ зохиолд янагаасаа хагацсан ягшасыг тухайлан хэлжээ.

ХОРМУСТ ТЭНГЭР гэж монголоор энэтхэгийн Индра гэдэг тэнгэрийг нэрлэдэг нэр.

ГАЛАВ ЮҮЛҮҮЛЭХ ҮҮЛС гэж усаар галав бүлүүлэх үүл байх юм гэж энэтхэг домогт гардаг Бушгаравардага гэдэг үүлний нэр.

АЛАГА ЗОРИН ЯВАХАД гэж Намсрайн оршдог Алага балгас гэдэг үлгэр домгийн хот. Намсрайн нийслэлд үүлний зорин явахыг хэлжээ.

АЯНЧНЫ ЭХНЭР үсээ сөхөн харж нөхрөө хүсэн хүлээнэм гэсэн нь, Энэтхэгт бороо ордог үес аянчин хүн гэртээ буцаж ирдэг заншилтай тул, энэ шад шүлэг, олон хоног аянд явагч нөхрөө буцаж ирэх нь гэж эмэгтэйчүүд борооны үүл хараад хүсэн горьдох сэтгэл төрөхийг хэлжээ.

АВЬСАН гэж монголоор ахын эхнэрийг нэрлэдэг нэр. Үүнд ягшас үүлийг - миний эхнэрийг ахын эхнэрийн адил хүндтэг- гэсэн санаа нэвтрүүлжээ.

ЗААДАГА бялзуухайг энэтхэг домогт ус уудаггүй, хурын дусал шүүрэн ундалдаг гэдэг ажээ.

МАНАС НУУР гэж одоогийн Манасасаравара нуур. Хималайд бий.

БҮТЭГСЭД гэж энэтхэг үлгэр домогт гардаг нэгэн зүйл хүмүүн бусын нэр. Энэтхэгээр сиддхи гэдгийг монгол судрын хэлнээ бүтэгсэд, бүтээсэн гэж их дээрээс орчуулсаар ирсэн уламжлалтай билээ.

НИШИНГҮ гэж шүүсээр нь чихэр хийдэг нэгэн зүйл ургамал. Монгол нэр нь Энэтхэг гаралтай, оросоор сахарный тростник гэдэг.

ЗҮГИЙН ЗААН гэж энэтхэг домог судлалаас монгол судрын хэлний яруу найргийн нэрд орсон зүйл. Дөрвөн зүг зовхист байдаг найман их заан бий гэж Энэтхэг домог судлалд гардаг зааныг ингэж нэрлэдэг байжээ.

ХОРМУСТЫН НУМ гэж энэтхэг яруу найрагт солонгыг нэрлэдэг бөгөөд, хоёр гичир нь шоргоолжны бүтэн үүр тулдаг гэж хэлэлцдэг байжээ.

ВИШНҮ ТЭНГЭРИЙН ҮХЭРЧИН гэж хөх өнгөт Кришна тэнгэрийг нэрлэдэг ажээ.

СЭРТЭНТЭХ гэж дурлан тачааж, наалдах байдлын нэр. Монгол үсгийн дүрмийн толь гэдэгт зохиолч Шагж – тачааж халдан өдөөх гэж товч тайлбар хийжээ. Оросоор любовный флирт, игривость пред любовником (любовницей) гэж орчуулна.

АМРАГУДА гэж Виндья нурууны зүүн талд буй уул одоо Амарганда гэдэг.

ҮХЭЛГҮЙ ЭР ЭМ ХОЁР гэж эр эм тэнгэр. Тэдний нүдээр дээрээс доошоо үүлийг харахад, дэлхийн хөхөнд хөх дусал байгаа юм шиг үзэгдэнэ гэж зүйрлэжээ.

ТООМ гэж нарийн зам, гөрөөсний замын монгол нэр. Монгол бичигт уртатгалгүй бичдэг үүнийг ярианы хэлэнд тоом гэж о-г уртаар дууддаг.

МАРГАД гэж эрдэнийн чулууны нэр. Оросоор смарагд гэдэг нь, монголын маргад гэдэгтэй энэтхэгээс гарал нэгтэй нэр.

ГУРВАН САНСАРЫН ЭЗЭН гэж Шивыг хэлжээ.

ЭЗНИЙ ХООЛОЙН АДИЛ гэсэн үүлийн хөхөмдөг өнгөтэй тул Шива тэнгэрийн хоолойтой адил гэж зүйрлэжээ. Шива тэнгэр, энэтхэг домогт, далайг бүлэхэд хор дээшээ хөвөн гарсанд олон тэнгэр, амьтныг тэр хороос авран ууж үгүй хийнэ үү гэж Шива тэнгэрийг гуйсанд тэр хоры нь залгисанд хүзүү нь хөх болсон гэдэг домогоор үүлийн өнгийг зүйрлэжээ.

ЗААНЫ НОЙТОН ШИР барьж бүжих хүслий нь хангаад гэсэн үг бол, энэтхэг домогт Шива тэнгэр, үдэш нар жаргахад алсан зааны цустай улаан шир барьж хатан лугаа бүжиглэдэг үүнд, шингэх нарны туяанд улаан өнгөтэй болсон үүлийг Шива, зааны арьс гэж андууран шүүрч бүжиглэхэд нь, хатан, тэр нялцгай ширэнд дургүй тул, үүл шүүрэн барьсанд таашаан баярлана гэсэн санаа.

СКАНДА гэж дайны тэнгэрийн нэр. Бас Гүмара ч гэдэг. Энэтхэг домогт Шива тэнгэр дуслаа галд хаясанд, тэр илч ихт дусалд галайхаан (галын хаан) тэсч ядаад, ганга мөрөнд хийсэнд Гиртиг гэж монгол сударт Энэтхэгээр нэрлэдэг бөгөөд монголоор бас Мичид одон гэдгийн зургаан дагинас, Ганга мөрний усанд орж байсан нь, тэр дуслаас зургуулан нэг нэг хүүтэй болж, хожим тэр зургаан хүү нь нийлж, тогос унасан зургаан толгойтой, арван хоёр хөлтэй Сканда тэнгэр болсон гэж домогт гардаг бөгөөд Девагирийн хавьд скандын тахилын орон сүм байдаг.

ИХ ХАРЫН ОРОН гэж Шива тэнгэрийн тахилгын сүм, Үжжайнийн хавьд байдаг. Санскридаар махагала гэдгийг монголчууд бас Их хар гэж эртнээс орчуулжээ. Маха гэж их, гала гэж хар гэсэн үг. Европ зүгт санскриды нь дагуулж махагала гэдэг.

УМА гэдэг охин тэнгэр – Шива тэнгэрийн хатан.

ШИВЫН ЦАГААН БУХ гэж Шива тэнгэрийн хөлөглөдөг Нанди гэдэг нэртэй бух.

НАЙМАН ХӨЛТ ДОГШИН БУХ гэж энэтхэг домогт гардаг үлгэрийн амьтан.

ГИНАРИ гэж энэтхэг домогт морин толгойто, хүн биетэй амьтан. Гүвираа гэдэг Намсрайн хөгжимчин юм.

БАЛИ МАНГАС гэж гурван ертөнцийг эзлэсэн мангасын хаан. Тэнгэр нар түүнээс айж, Виншү тэнгэрийг дарж өгнө үү гэж гуйсанд, Виншү тарваган хүний дүрээр очиж, тэр мангасын хаанаас гурван алхам газар гуйгаад, зөвшөөрөхөд нь, наран болж хувилаад, нэг алхангуут дэлхийн дээгүүр алхан эзлээд, хоёр алхангуут тэнгэрийг эзлээд, гурав алхахдаа мангасын хаан Балийн дээр нь гишгиж, там руу хийж дарсан гэж Энэтхэг домогт гардаг.

ШИВЫН ИНЭЭДЭМ гэж Энэтхэг маш цагааныг Шива тэнгэрийн инээдэм, намрын сар, гавар, (оросоор камфорагэдэг нь Энэтхэгийн габүра, монголоор гавар гэдгийг европ нар сунжруулан дууджээ) цан хүүрэгний цан, сувд, линхуа цэцэг, Айравада гэдэг цагаан заан, сүү, цаст Гайласа уул эдгээрийг ертөнцийн цагаан гэж хэлэлцдэг ажээ.

ИНДРАНИЛА гэдэг эрдэнийн чулуу, оросоор сапфир.

ГҮНДА ЦЭЦЭГ оросоор жасмин.

ХҮЙС гүн байдгийг энэтхэг эмэгтэй хүний маш сайхан нэг шинж гэж үздэг.

ЭСРЭН ТЭНГЭР гэдгийг оросоор бог Брама гэдэг.

Энэ модны нэрийг монгол сударт энэтхэгээс орчуулжээ. (Энэ тайлбар гаслангуй улаан мод гэдэгт хамаарагдана.)

ГАСЛАНГУЙ УЛААН МОД сайхан эмэгтэйн хөл хүрэхэд цэцэглэдэг гэдэг.

ГЭСЭР МОД, сайхан хүүхэн амандаа дарс балгаж цацахад цэцэглэдэг гэдэг домогтой.

ПИПА – хөгжмийн нэр. Оросоор лютня гэж орчуулдаг.

ШИВЫН ЗАНГ МЭДЭГЧ АМРАГИЙН ТЭНГЭР – зөгий хөвчит нумаа барин ирэхээс аюун эмээвч гэсэн нь, энэтхэг домогт амрагийн тэнгэр Шива тэнгэрийг тахил тавигийн зан үйл үйлдэж байхад үймүүлээд, Шива тэнгэр хилэгнэж, догшин нүдээр хармагц, нүдний гал нь янаг амрагийн дурлал тачаангуй хөдөлгөгч амрагийн тэнгэрийг хуйхлан шатааж орхисон. Тэгээр Шивын байгаа газар ойртохоос хулчийдаг болсон гэдэг домгоор зүйрлэн өгүүлжээ.

Амрагийн тэнгэрийг европт Амур, Купидон гэх зэргээр эртний грек ром домог судлалаас ишлэн нэрлэдэг болой.

АНЖИСЧИН БАЛАРАМА гэж энэтхэг домог судлалд Кришна тэнгэрийн бараан нөмрөгт ах байлдахдаа анжсаар зэвсэг хийдэг байжээ. Гүрү Банду хоёр эртний омгийнхныг байлдахад төвийг сахина гээд, архинд хэдий дуртай боловч, архи, Равади хатан хоёроо тэвчиж, усанд нь орваас хир хилинц нь арилдаг Саарасвади мөрний зүг зайлан одсон гэдэг.

СҮХТ РАМА гэж энэтхэг домогт хан язгууртныг өст дайсан бирман баатар, Байлдаанаа хан язгууртныг хядаж, цусаар нь таван нуур тогтоож, өвгөдөө түүгээр тахисан гэдэг домогтой бөгөөд, Банду Гүрү нарын байлдаанд банда нарт туслах гэж, Гайласа уулнаас тэр зүг яаран одохдоо уул сэтлэн гарсан гэж домогт гардаг.

ВИШНУ могойн орон дээрээс сэрэхийн үес гэж Энэтхэг домогт зуны их хурын улирлын үед Вишну тэнгэр их могой дээр хэвтэн нойрсоод, намар, хур бороо холдоход босдог гэдгээр хурын улирлыг зүйрлэн заажээ.

СРИГА буюу Шрига бялзуухай оросоор канарейка гэж нэрлэдэг бялзуухайн нэр.

Үүлэн зардас гэдэг яруу найраглалд Энэтхэг домгийн зүйлээс дурдсан зүйлийг уншигч нар, мөн эдгээр орчуулгаар дахин найруулан эвлүүлье гэх манай яруу найрагч нарт хэрэг болуузай гэж товч тайлбар хийлээ.

Жич тэмдэглэх нь, төвдөөс дахин орчуулга хийсэн Эрдэнэпэл гавж, энэ жил далан таван настай бөгөөд хуучин Далай Чойнхор вангийн хошууны хамжлагын гэрт Идэрийн голд төрсөн хүн бөгөөдтэр нутаг одоо Завхан аймгийн Их уул сумын нутаг болой.

Монгол Данжуурт «Үүлэн зардасыг» орчуулга хийсэн орчуулагч нарын намтар мэдээг хараахан нягтлан судлаж завдаагүй тул энд түр эс өгүүлэв.

СТИЛИСТИКА И ЕЕ ОТНОШЕНИЕ К ПЕРЕВОДУ

Э.Равдан²²⁶

Прежде чем как перейти к рассмотрению конкретных вопросов в плане стилистики постараемся выяснить взаимосвязь и соотношение понятий <<стилистика>>, <<сопоставительная стилистика>> и близкой к последней <<теории и практики перевода>> и уточнить границы между ними.

Анализ появившихся в последние годы преимущественно учебных пособий по стилистике отдельных языков (А. Н. Гвоздев. Очерки по стилистике русского языка. М., 1965, 3-е изд., Р. Г. Пиотровский, Очерки по грамматической стилистике французского языка, Л., 1959 2-е испр. и доп. изд., И. Р. Гальперин. Очерки по стилистике английского языка. М. 1958, Д. Отгонсурен. Монгол хэлний найруулга зүй УБ., 1975., М. Д. Кузнец, Ю. М. Скребнев, Стилистика английского языка, Л. 1960 и мн. др.) показывает, что в теоретическом плане стилистические категории общи для всех языков, и названные книги дублируют друг друга в большой мере. Ознакомившись с ними, как справедливо замечает А. В. Федоров в своей книге (<<Очерки общей и составительной стилистики >> М., <<Высшая школа>>, 1971) можно было бы даже решить, что есть одна общая стилистика, отдельные же национальные языки представляют только реализацию и конкретизацию ее категорий, единых для все этих языков. Общность проявляется прежде всего в номенклатуре и определений таких основных категорий или понятий, как стили языка, тропы пласты словарного состава и т. п. Причем гораздо больше общего сказывается при рассмотрении фактов лексики, чем грамматики. В этом очевидно сказываются развитость и дифференцированность лексики по оттенкам значений, по экспрессивным качествам выражений и функционально-речевая и экспрессивно-смысловая разграниченность грамматики в любом языке.

Понятие <<общей стилистики>> приемлемо в той мере, что и например, допустимо говорить об <<общей грамматике>>: ведь каждому языку свойственны хотя бы такие понятия, как звук, глагол, имя, предложения и др. Следовательно, некоторую общность стилистических категорий, наблюдаемую в разных языках, отнюдь нельзя объяснить <<общеевропейским психологическим складом ума>>, которому уделяет большое внимание. Ш. Балли в своей известной <<Французской стилистике>>. Эта общность связана с общелогическими категориями мышления людей, как и единство некоторых грамматических категорий для тех или иных языков независимо от их генетического рода.

Что касается национальной специфики стилистической системы конкретного языка, то приходится признавать малоэффективность работ, построенных в одноязычном плане. Выявление существенных отличий и

²²⁶ МУИС, ШУС, ХУС, ШУ-ны доктор, профессор, МУ-ын гавъяат багш

специфики явлений стилистического порядка и их определение является задачей сопоставительной стилистики.

Сопоставительно-стилистическое изучение языков в синхронном разрезе и вне зависимости от степени генетической связи, как особая исследовательская задача, возникло относительно недавно в XX веке и было представлено прежде всего трудами Ш. Балли.

Сравнивая стилистическую систему французского и немецкого языков, Балли видит задачи сопоставительной стилистики в том, чтобы сопоставлять языки и выявлять в первую очередь сходные черты, а затем качественно-количественные различия. Помимо общих, сходных черт в одном языке может быть менее выражена та или иная тенденция. Одно явление, характерное для выразительной системы одного языка, может отсутствовать в другом. Особенно много различий в природе образной речи, связанных с определенной социальной средой. Для того чтобы установить эти различия необходимо, как предлагает Ш. Балли, исследовать всю систему каждого языка в целом, т.е. проводить сопоставительные исследования на всех уровнях языка.

Иден Ш. Балли были развиты и продолжены другими представителями французской школы сопоставительной стилистики, особенно А. Мальбланом, Ж. П. Винен Ж. Дарбельне.

Первой попыткой создания систематической сопоставительной стилистики двух языков является книга А. Мальбина (*Pour une stylistique comparée du français et de l'allemand*, Paris, 1944). Сопоставительная стилистика, по мнению автора, должна распадаться на две стадии исследования: первая стадия предполагает изучение систем (как у Балли), вторая-изучение жанров и стилей двух сравниваемых языков, т. е. первоначально сопоставительная стилистика строится как чисто лингвистическая дисциплина, а затем на второй стадии исследователь ищет соответствия между лингвистическими системами исследуемых языков и их образных средств. Другими словами, на второй стадии, так как для её решения требуется привлечение не только данных поэтики и теории литературы, но и историко-литературных данных для сопоставления жанров и стилей литературно-художественных произведений.

Таким образом <<сопоставительная стилистика>>, именуемая Ш. Балли и Мальбланом, начинает отходить на второй план и больше смешиваться с задачами компаративистики, в которой сопоставление стилистических явлений не является первоочередной целью и не носит систематический характер.

Идеями работ А. Мальблана пронизано исследование Ж. П. Вине и Дарбельне, которые излагают свои принципы сопоставительной стилистики и освещают некоторые вопросы теории перевода. Авторы *Stylistique comparée du français et de l'anglais*, P, 1958, как и Мальблан, обосновываются на лингвистических концепциях Ф. Соссюра и особенно Ш. Балли. Развивая положения швейцарского лингвиста, Вине и Дарбельне подчеркивают, что если внутренняя стилистика анализирует языковые средства в свете противопоставления эффективных элементов, то межъязыковая сопоставительная стилистика исследует различия в формах выражения,

которые используют разные языки для передачи аналогичного содержания. Следовательно, основными приемами, которыми пользуются авторы, являются изучение переводов с одного исследуемого языка на другой и собственный лингвистический эксперимент. Последний позволяет выявить типичные формы выражения, употребляемые говорящими на разных языках в сходных ситуациях.

Как видим, в трудах французских стилистов сопоставительная стилистика теряет собственный объект исследования и растворяется в определенной мере, с одной стороны, в компаративистике и в теории перевода --- на другой. Упускается подчас из виду то важное, что стилистика имеет дело только с синонимическими и соотносительными элементами языка и речи. Это видно хотя бы в том, что первые две главы книги Вине и Дарбельне посвящены сопоставлению лексических и грамматических средств двух языков без учетных соотносительности.

На попытку Вине и Дарбельне свести сопоставительную стилистику к теории перевода указывал и В. Г. Гаев своей рецензии на их монографию (В.Я. 1961, № 3). Здесь он справедливо подчеркивает, что сопоставительная стилистика должна идти дальше, что ее цель---выявить тенденцию и преимущественном употреблении того или иного способа выражения в каждом из двух языков. А для этого, по Г. Гаку, необходим сопоставительно-стилистический анализ явления в обоих языках который позволит увидеть в обнаруженном расхождении стилистическую закономерность данного языка.

Смешение сопоставительной стилистики со смежными дисциплинами--- сопоставительной грамматикой и теорией перевода--- в трудах французских лингвистов непосредственно связано с характером их подхода к выяснению основного вопроса стилистики о её предмете, содержании и задачах, методологии и о месте стилистики в ряду других лингвистических дисциплин. Эти проблемы, как известно, были во многом неопределенны и неясны и в практике мирового языковедения вплоть до середины 50-х годов. Началом систематизации указанных понятий явилась дискуссия, развёрнутая в 1954 году в журнале <<Вопросы языкознания >>. Ныне же благодаря усилиям советских ученых стилистика как наука получила стороннюю систему, и упорядочены в ней вопросы кардинального характера.

Подходя с позиции советских языковедов о постановке стилистики, постараемся разграничить основные вопросы сопоставительной стилистики от других смежных лингвистических дисциплин.

Предметом исследования сопоставительной стилистики двух и более языков является стилистическая система, которая в любом языке формируется на различных языковых (аналитических) и речевых (функциональных) соотносительных элементов. Поскольку стилистика пронизывает все уровни языка и речи, исследование в сопоставительном плане может быть принята как на любом уровне языка (морфологии, синтаксиса и т. д.), так и в кругу определенного стиля и подстиля. Однако разграничение языкового и речевого аспектов в сопоставительно-стилистическом исследовании, как свидетельствует

опыт работы языковедов, менее эффективно и подчас невозможно. Поэтому, например, тидология систем изобразительных средств не может обходиться без анализа функционального стиля художественной литературы и учета и культурных традиций носителей сопоставительных языков. Другими словами, известные аспекты тесно переплетаются в ходе стилистического анализа.

Сопоставительная стилистика, базируясь на результатах сопоставительной грамматики, исчерпывает из нее необходимые себе данные. Однако, это не должно служить поводом нивелирования всяких границ между этими дисциплинами. Их различие целесообразно видеть в предмете их исследования и задачах. Сопоставительная грамматика имеет дело с фонетическими, морфологическими и синтаксическими формами выражения соответствующего содержания и ставит своей целью установить общее и специфическое в сопоставляемых языках. Сопоставительная стилистика же ограничивается, как отмеченно выше, только лишь системой синонимических и соотносительных средств, которые отличаются между собой в большей мере различными окрасками, оттенками и т. п. Одним словом, нельзя тут отождествлять язык со стилистикой, как это было сделано у Вине и Дарбельне.

Каково соотношение сопоставительной стилистики и теории перевода? Мнения, высказанные по этому вопросу, характеризуются противоречивостью, в чем мы в честности убедились в разборе концепции французских стилистов. К последней в какой-то мере примыкает мнение Г. Гачечиладзе и его учеников из грузинской школы теории перевода, которые считают сопоставительную стилистику лишь звеном между художественным языковым соответствием и призывают к созданию на ее основе так называемой <<синтетической науки о художественном переводе>>.

В концепции Г. Гачечиладзе, четко выраженной в его монографиях <<вопросы теории художественного перевода>> (Тбилиси, 1965) <<Художественный перевод и литературные взаимосвязи>> (М., 1972) иструдно заметить его попытку растворения сопоставительной стилистики теории перевода. Такое стремление автора исходит из его уподобления процесса перевода оригинальному писательскому творчеству. <<Процесс перевода на всех своих стадиях, начиная с побудительных причин и кончая той познавательной и эстетической функцией, которую выполняет в определенных исторических условиях, - пишет он, - аналогичен оригинальному творчеству. Художественный перевод есть вид художественного творчества, где оригинал выполняет функцию, аналогичную той, которую выполняет функцию для оригинального творчества живая действительность>>

Указывая на односторонность позиции представителей грузинской школы теории перевода, в частности Г. Гачиладзе. В. С. Виноградов совершенно справедливо отмечает их тенденцию, ведущую к вульгаризации марксистско-ленинского учения о познании, <<Художественная действительность подлинника и реальность – понятия разнопорядковые несоизмерные, хотя второго. Художественная действительность это отражение реального бытия, образно воплощенное писателем в словесном произведении.

Переводчик не повторяет всего процесса созидания художественного произведения, не выбирает предмет литературного изображения, не определяет темы жанра. На его долю выпадает иная задача: как можно полнее воспринять идейно-художественное содержание и форму подлинника, определить его социально историческую обусловленность и перевоплотить все воспринятое в материале другого языка, не отступая от авторского отражения действительности и ее авторской оценки>>.

Несколько иной точки зрения на соотношение сопоставительной стилистики и теории перевода придерживаются другие советские стилисты и теоретики перевода. Они (А. В. Федоров, П. В. Табахьян, Л. С. Бархударов, Э. Г. Ризель и др.) находят разграничение между этими родственными предметами в самом предмете и их задачах, указывая при этом на точки прикосновения и общность последних.

Так, А. В. Федоров обращает внимание исследователей на то, что теория перевода как лингвистическая дисциплина имеет дело прежде всего с фактами стиля: со смысловой и художественной функцией языковых элементов, выясняет функциональные соответствия, носителями которых в разных языках являются весьма далекие по своей форме лексические и грамматические явления. При этом он ссылается на Л. С. Бархударова, который видит отличие теории перевода от структурно-сопоставительного изучения языков в следующем:

<<При таком подходе существенной окажется не общность родства тех или иных языковых единиц, а исключительно их одноплановость или однопорядковость т. е. принадлежность к одному же аспекту или уровню языковой системы---грамматическому, лексическому и пр. --- при условии определенной семантической общности. Для перевода основным является адекватная передача содержания, выраженного средствами одного языка при помощи средств другого языка, стало быть, сопоставление языковых единиц в теории может производиться только на основе общности выражаемого ими содержания, иными словами --- на основе семантической или смысловой общности данных единиц>>.

Таким образом, говоря словами П. В. Табахьяна---сторонника этой концепции, если искать пути размежевания между теорией перевода и сопоставительным изучением языков, то они представляются в следующем: если в теории перевода сопоставление единиц производиться только на основе общности выражаемого содержания, то для структурно ---сопоставительного изучения языков необходима принадлежность единиц к одному уровню языковой системы.

Такая постановка сопоставительной стилистики в ряду других лингвистических дисциплин и определение ее предмета и задач ни в какой мере отрицают роли и места перевода в любом сопоставительно-типологическом, в том числе стилистическом, исследовании. Факты перевода выступают в них как средство контроля или сверения достигнутых выводов того или иного явления сопоставляемых языках. По этому поводу замечает Г. В. Колшанский:

(Соотношение субъективных и объективных факторов в языке. М., <<Наука>> 1975 с. 188)

<<Интересно отметить, что экзаменом для действительно стилистического анализа текста является практика перевода. Сама по себе переводимость текста есть нечто иное, как транспонирование некоторого инварианта из одного языка в другой с передачей всех элементов содержания исходного текста>>.

Место и роль перевода как языкового эксперимента утверждены и закреплены в сравнительном языкознании давно с самого начала его возникновения. И поэтому сопоставительную стилистику совсем не обязательно строить на материале перевода с одного языка на другой, хотя такой метод может быть оправдан в частных случаях, как об этом говорит П. В. Табахьян.

Сопоставительная стилистика прибегает к фактам перевода в той мере, что и сопоставительным данным семантики, грамматики и литературы. Анализируя стилистические системы языков, сопоставительная стилистика также пользуется сведениями из различных областей знаний: истории, этнографии, искусства и др.

Что касается отношения теории перевода к сопоставительной стилистике, то мы поддерживаем мнение тех стилистов, которые видят возможность установления лингвистических соответствий для решения переводческих проблем. Это звучит более убедительно, если в самом деле представляет собой труд переводчика в максимальном отражении всего того, что есть в подлиннике. Или же, как об этом говорит А. Д. Швейцер (Семантико-стилистические и грамматические аспекты перевода (<<Иностранные языки в школе>> № 3, 1971. Стр 14-15) : <<...воспринимая исходное сообщение на языке А., переводчик стремится воспринимать получатель на этом же языке, а создавая текст на языке Б. Воспринял его также как и получатель на языке А. Иными словами в идеале сам переводчик не должен привносить в текст сообщения своего собственного восприятия, отличного от восприятия этого сообщения тем получателем, которому было адресовано>>.

В пользу этого выступала и Е . Г. Эткинд в своей статье (Теория художественного стиля и сопоставительная стилистика --<<Теория и критика перевода>> Л., 1962 с. 28): <<Задача теории перевода--- раскрыть внутренние ресурсы таких функциональных подобий в двух сопоставляемых языках. Наука, обнаруживающая эти ресурсы должна называться сопоставительной стилистикой>>.

СТИЛИСТИЧЕСКАЯ ОРГАНИЗАЦИЯ РЕЧИ

Важнейшими единицами речи являются прежде всего слова, взаимосвязанные между собой как грамматическом, так и в стилистическом отношениях. С позиции аналитической стилистики весь словарный состав любого литературного языка членится на две разновидности. Первую из них составляют стилистические соотносительные слова и выражения, находящиеся вне условий стилистической соотносительности.

Согласно данной стилистической классификации соотносительными являются нейтральные (Н), книжные или высокие (К или В), разговорные (Р) и

просторечевые (П) слова и выражения, а за их пределами находятся непосоотносительные слова и выражения общего (О) и терминологические (Т) характера.

Стилистические признаки слов мы получаем в толковых словарях, где даются специальные пометки.

Стилистически соотносительные элементы функционируют во многих случаях в парадигматическом порядке: называться (Н) – зваться (Р) – именоваться (В), прозываться (П); жена (Н) – супруга (В) – подруга спутница жизни, дражайшая половина (Р); голова (Н), --глава (В) – башка (П); глаза (Н) – очи (В) – гляделки, буркалы (П); будущий, предстоящий (Н), - грядущий (В); раздетый (Н) – голый (Р) – нагой обнаженный (В).

Важнейшими типами сочитаемости слов в речи является их лексическая, грамматическая и стилистическая связь. Необходимо четко разграничивать эти типы сочитаемости слов: их смещение может привести к неправильному пониманию сущности норм и к неточностям в классификации речевых ошибок и т. д. Поэтому кратко охарактеризуем особенности семантической и грамматической сочетаемости.

Общая характеристика семантической сочитаемости слов в речи дака акад. В. В. Виноградовым: <<...большая часть слов и значений слов ограничена в своих связях внутренними семантическими отношениями самой языковой системы. Эти лексические значения могут проявляться лишь в связи со строго определенным кругом понятий и словесных обозначений.

...Эти ограничения создаются присущими данному языку законами связи словесных значений. Многие слова вообще не имеют свободных значений. <<Например, данными законами определилась возможность образования таких словосочетаний как страх берет, тоска берет, злость берет, смех берет, охота берет и т. д. Те же законы обусловили невозможность создания словосочетаний: радость берет, удовольствие берет, наслаждение берет >>

Отступление от исторически сложившейся лексической сочетаемости приводит к так называемым словарным ошибкам.

Степень свободы и широты грамматических связей слов обусловлена законами грамматической сочетаемости, которые проявляются, например, в возможности сочетания прилагательных с существительными, в невозможности их сочетания с глаголами и служебными частями речи.

В стилистическом отношении современная литературная речь строится из свободных и ограниченных сочетаний слов. При этом стилистика делит словосочетания на стилистически неуправляемые и стилистически управляемые.

К сочетаниям, не связанным со стилистическими законами относятся те, которые созданы из находящихся вне стилистической соотносительности слов, т. е. общих и терминологических. Например: высота давления, измерение колеблемости, алгоритмы сводимости, синтаксическая структура и т. п.

Определение и описание разновидностей стилистически свободных и стилистически ограниченных сочетаний необходимо для понимания стилистической окраски контекста, а, следовательно, и для изучения

закономерностей функционирования соотносительных элементов речи. Возможности их связи мы можем выяснять уже на уровне словосочетания

Стилистически свободная сочетаемость у нейтральных, книжных и разговорных слов осуществляется в русском литературном языке с такими единицами словаря, которые обладают или идентичной, или же неконтрастной стилистической значимостью. Так, нейтральные слова свободно сочетаются с нейтральными же, с общими словами и со специальными терминами, (Н+Н, Н+О, Н+Т). Книжные слова вступают в свободные связи с книжными, общими словами и иногда с терминами (К+О, К+К, К+Т). Для разговорных и просторечных слов свободная связь ограничена разрядами Р+О, Р+П, Р+Р.

Стилистические ограничения слов в связях обусловлены их стилистическими свойствами и прежде всего состоянием соотносительности, в котором они находятся в системе языка. Например, нейтральное слово, располагающее книжным и разговорным синонимами, не имеет свободной связи с другими книжными и разговорными словами. Таким образом, ограниченная в сочетаемости характерны для слов, обладающих стилистически контрастными свойствами.

Игнорированные стилистического ограничения приводит к стилистическим ошибкам. Однако довольно распространено встречаются намеренные нарушения этих правил особенно в художественных публицистических текстах. Но они, как правило, мотивируются общим содержанием контекста, для достижения большей выразительности. Стилистические ограничения, следовательно, не имеют характер жесткой нормы. Они условны к известной мере.

В прямой зависимости от сочетаемости слов определяется стилистическая окраска или тональности текста. Контексты, образованные из слов, относящихся к одному разряду или к нескольким стилистически неконтрастным разрядам, называются стилистически однородными и простыми. В зависимости от каких слов состоят тексты, они бывают нейтральными, книжными или разговорными. Тексты включающие стилистически ограниченные сочетание слов, называются стилистически однородными или простыми. В зависимости от каких слов состоят тексты, они бывают нейтральными, книжными или разговорными. Тексты, включающие стилистически ограниченные сочетания слов, называются стилистически неоднородными или сложными.

Анализируя стилистическую сочетаемость словарного состава текста, мы добиваемся полной стилистической схемы своего текста. При этом в случае необходимости можно преобразовывать текст или предложения в другой разряд. Возьмем предложение: Мальчик ел большую грушу. В нем имеются только нейтральные слова и одно общее слово <<груша>> (Н+Н+Н+О). Заменяя нейтральные слова их соотносительными элементами, например, разговорными <<Мальчишка упатал большую грушу>> Р+Р+Р+О, мы добиваемся разговорной окраски всего предложения.